

**ОРСОЫН
ТҮҮХИЙН
100
ӨГҮҮЛЛЭГ**



Оросын түүхийн 100 өгүүллэг
Зохиолч: Сергей Алексеев
Орчуулсан: С.Алтантуяа
Эрхлэн гаргасан: Сод ном хэвлэлийн газар

ISBN: 978-99962-54-16-1

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Морьтой хүн

Нэг бүлэг морьтон тариан талбайгаар явсаар гүвээн дээр гарч ямар сонин юм харсан гэж санана. Тариачин эр газар хагалж байв. Харин анжсаа морины оронд эхнэр, эмэг эх, жаал хүү гуравгаа хөллөсөн байж гэнээ.

Хөөрхий тэд модон анжсаа хэдэн алхам чирээд л зогсоно. Хэдэн алхам чирээд л зогсоно.

Морьтон газар хагалж байгаа тариачин дээр ирж тэдний толгойлогч нь:

—Хүнийг малын оронд хөллөдөг яасан хүйтэн сэтгэлтэй амьтан бэ? гэж ширүүхэн дуугарчээ.

Тариачин харвал өмнө нь эрээн цамцан дээр гоё дээл өмсөж илгэн савхиар хийсэн ногоон гуталтай, улаан оройтой малгайтай асар том хүн зогсож байжээ.

«Нутгийн ноён, магадгүй мужийн жанжин морилж яваа байх» гэж мань эр боджээ.

Тэр нөгөөх язгуурт эрийн хөлийн өмнө шан дээр сунаан унаж:

— Бид чинь гар хөлөө мухарлуулчихсан улс. Морь байхгүй. Морий минь эзэнтэн өрөндөө авчихсан гэлээ.

Морьтой хүний царай нь хувисхийн мориноосоо бууж тариачин уруу эргэхэд айсан эр ухарсаар босон зугтав.

— Савдаг минь зогс! Зогсож бай! Хаачих нь вэ, чи?! гэх дооглонгуй дуу сонсдоно.

Тариачин зүрхэлж зугтаж чадсангүй эргэж иржээ.

— Май, энэ морийг ав! гээд нөгөөх хүн тариачинд цулбуураа өгчээ. Тариачин мэгдэж, эхнэр, эмгэн эх хоёр нь мэлэрч, бяцхан хүү амаа ангайн энэ гайхамшигт явдлыг итгэхгүй ширтэн зогсож гэнээ.

Морийг нь харвал тайж язгууртан хөлөглөмөөр, толботой хөх зүсмийн дүүхгэр сайхан морь байлаа.

«Ноёнтон тоглож байна» гэж мань эр бодон хөдөлсөн ч үгүй зогсож байжээ.

— Ав л даа, ав. Авахгүй бол өгөхөө байчих нь шүү гэж нөгөө хүн сүрдүүлээд, морио өгөөд тариан талбай дундуур явахад морьтон хойноос нь дагалаа. Харин нэг залуу эгшин зуур саатан санамсаргүй хавтагтай тамхиа унагаажээ.

«Бурхан тэнгэр, бурхан тэнгэр явуулжээ» хэмээн мунгинуу тариачин шивнэж морь луугаа эргэж хараад арай энэ бүхэн чинь увдистай юм биш байгаадаа гэж бодон айдас хүрчээ. Тэгээд мориныхоо цулбуураас татвал морь давхийн цоройход тариачин эр туурай хүрсэн газраа гараараа даран:

— Ёстой морь байна! хэмээн аз жаргалдаа бялхсан тариачин дуу алдаад, Та нар хэн бэ? Хаанаас явж байна вэ? гэж залуу хүүг шалгаахад:

— Хаврын салхи шиг хаа сайгүй явдаг чөлөөт шонхрууд гэж залуу учиртайхан нүдээ ирмэхэд:

— Тэгээд бид хэний төлөө залбирах билээ? Тэр өндөр малгайт чинь тэгээд хэн юм бэ? гэхэд,

— Разин. Степан Тимофеевич Разин! гэж өнөөх залуу давхилтан дундаа хашгирч гэнээ.



Буучдын завь

— Разин, Разин айсуй!

— Степан Тимофеевич!

1670 онд Орос гүрэн ер бишийн түгшүүртэй ажээ. Хааны зарц бараа бологчид, ноёд асар их түгшиж байлаа. Өөрийн эрх мэдэлгүй дарлагдсан олон босжээ. Молдав, татар, башкир, казак ба тариачид гээд олон зуун мянган их хүч босжээ.

Тариачин цэргийг Донын казакийн зоригт атаман Степан Разин удирдаж байв.

— Разины яруу алдар бадартугай!

Босогчид Царицын хотод ойртон ирж хотоос арай дээхэн Ижил мөрний эгц өндөр эрэг дээр буудаллаж байрлажээ.

— Царицын хотыг даруйхан авах юмсан гэж казакууд ярилцдаг байлаа. Хотын иргэд үдшийн харанхуйгаар Разин дээр ирж:

— Ах минь очиж эзэмш. Царицыныхан таныг хүлээж байна.

Буучид цөөхөн, тэгээд тэд юу ч болохгүй. Бид танд хотын хаалгыг нээгээд өгчихнө гэхэд:

— Атаман минь Царицын хотыг эзэлж ав, ав гэж зөвлөгчид нь ятгана. Гэвч Разин яарсангүй. Модон завьтай олон тооны бууч цэрэг Ижил мөрнөөр Царицын хот уруу ирж явааг Разин мэдэж байлаа. Тэдгээр буучид

үхэр буу, бялтат буу, их буу, ихээхэн дарьтай ажээ. Буучид цэргийн эрдэмд сайтар сурснаас гадна нэрт дарга Лопатин тэднийг толгойлж байлаа. «Бага хүчээр ийм цэргийг яаж цохьё доо. Хотод нуугдах газар байхгүй. Тэгээд удаан барьж чадна гэж үү дээ. Яг үндсээр нь авах юмсан. Ёстой л казакийн далайц хэрэгтэй» гэж Разин бодож суужээ.

Лопатин Царицын хот уруу улам ойртож байжээ.

— Атаман, бэхлэлтийг ав! гэж казакууд хашгиралдана.

Атаман тэвдэж сандарсан юмгүй ажээ.

Лопатин өдөр бүр туршуул түрүүлүүлэн явуулахад казакууд хэрхэн яаж байгааг даргадаа ирж:

— Эгц эрэг дээр байрлаж, хотыг огтхон ч хөндөхгүй байна гэж илтгэдэг байлаа.

Тэнэгүүд, сайн даргагүй байх гэж тэргүүн Лопатин даажигнана.

— Эзэнтэн минь, эцэг минь, Царицын хотыг ав гэж босогчид атаманаасаа гуйна.

Разин дайчдынхаа уриаг сонсоогүй мэт үг дуугүй ажээ. Тэгсээр байтал Лопатин даргын цуваа казакуудын байрласан эгц эрэгтэй зэрэгцэн ирж гал нээжээ.

«Буудаж л бай, буудаж л бай! хэн ялалтын буудлага хийх нь л чухал» гэж

Лопатин хошигнож байжээ.

Тэрээр аюултай эргээс дөлж явлаа. Алсад Царицын хот ч харагдлаа, бүр хажууд нь хүрээд ирлээ. Хотын хэрэм дээрээс их буугаар баярын буудлага ч хийлээ. Лопатин сэтгэл хангалуун гараа үрнээ.

Тэгтэл...юу болох нь тэр вэ? Царицын хотын хананы тэндээс үрлэн сум хэдэн арваараа шаагиж гарчээ. Тэр сум хааныхны завь дээр тусаж цаасаар хийсэн хөлөг онгоцыг живүүлэх адил ажээ.

Хотын өндөр хэрмэн дээр атаман хувцастай өргөн ханхар цээжтэй казак байхыг хэн нэг нь ажиглаж:

— Разин, Разин Царицын хотод байна!

— Дээрэмчид хотод байна!

— Зогсоорой, эргээрэй! гэцгээх дуу гарчээ.

Гэвч энэ үеэр Ижил мөрний баруун зүүн эргээс яг командаар гарсан мэт казакуудын завь гарч ирэн зөгий балан дээр суух адил буучдын завь цуваа уруу дайрч гэнээ.

— Цохь! Хэмх цохь!

— Толгойгий нь толгойг тас цохь! гэлцэнэ. Тийнхүү буучдын завь бууж өгчээ.

— Манай атаман мөн зальтай шүү. Харахгүй юу тэр даргы нь залилсныг хараач. Царицын хотыг эцсийн хурам хүртэл эзлээгүй байсан шүү дээ гэж босогчид ялалтынхаа дараа шагширцгааж байжээ.

— Тэдний тэргүүн нэг толгойтой бол манай Разин хоёр толгойтой гэж

Разиныхан тоглоом тохуу болцгоодог байжээ.

Зэмлэхгүй

Нутгийн ноён Труба, —Нащекин хамжлагатаа тамлан цээрлүүлж байлаа. Хөөрхий амьтны гар хөлий нь мушгиж цулбуураар вандантай холбон хүлж, гөрмөл суран ташуураар тариачны нүцгэн нуруун дээгүүр ороолгон зодож:

— Чамайг ингэж байвал л таарна. Тариачин удмын шаар. Зарц чи үүнийг хүрт. Эзнийхээ өмнө малгайгаа авахгүй бол яадгийг үзүүлээд өгье гэж байлаа. Труба,

—Нащекин ташуураар занчиж байгаад арьсы нь урж цус гаргахын тулд суран бүс авчруулж түр амсхийгээд шархан дээр нь давстай ус асгаж дахин ташуурддаг байлаа.

— Ливонтий Минаич, эцэг минь намайг өрөвдөөч дээ. Ямар ч муу санаа байгаагүй шүү дээ, өршөөгөөч. Тааралдахдаа л харсангүй гэж гуйна.

Хошуу ноён тэр гуйлт, зовиурт дууг сонсох ч үгүй аймшигт үйлсээ үргэлжлүүлнэ.

Тариачин байдаг хүчээ барж, арай чамай сэхээ авч.

— Гайгүй ноёнтон минь. Разин ирнэ дээ. Тэгтэл...

— Разин, Разин айсуй гэсэн дуу хошуу ноёны гэрт цуурайтлаа.

Труба, —Нащекины царай айсандаа зэвхийрч, ташуураа шидэж, тариачдыг орхиод дээлийнхээ хормойг шүүрэн аваад хаалга уруу зугтахаар гүйжээ.

Хошуу ноёны нутаг дээр Разины казакууд нэвтрэн орж ноёны зарц нарыг цуглуулсан бөгөөд эзэн өөрөө хаа нэг газар нуугдсан байжээ.

— Разин тариачдыг задгай газар цуглуулж

— Та нар эрх чөлөөтэй болсон гэж зарлан тариачдын ахлагчийг сонго гэхэд:

— Хялар Гурьяныг сонгоё! Гуркийг! Гуркийг сонго, тэр бидний дотор хамгийн ухаантай, хамгийн шударга нь гэж хурагсад хашгирцгаажээ.

— Гуркийг сонговол сонгоё л доо. Хаа байна, наашаа гараад ир гэж

Разин хэллээ.

— Гурка гэртээ байгаа даа. Нутгийн ноён салмартал занччихсан байгаа гэжээ.

Разин цугларсан олныг орхиж хялар Гурьяныд очиж гэрт нь орвол вандан дээр нүдүүлж зовсон хүн хэвтэж байжээ. Тэр хүн хөдлөх ч үгүй хэвтэх бөгөөд нуруу нь ил харагдах авч нуруу биш, цус нөж л байжээ.

— Гурьян! гэж агаман тариачныг дуудахад нөгөө хүн арай ядан хөдлөх янз болсноо нүдээ нээж:

— Ирээ юу. Хүлээжээ хэмээн хөөрхий амьтан шивэгнээд, царайд нь инээмсэглэл тодорсноо тэр дороо алга болж Гурьян амьсгаа хураажээ.

Разин хүрээлэн зогссон казак тариачид дээр ирж:

— Ноёнтон хаана байна? гэж чарлав.

— Агаман минь, олсонгүй гэхэд,

— Ноёнтон хаана байна? гэж хариуг сонсоогүй мэт Степан Тимофеевич дахин асуужээ.

Казакууд дахиад л эрэлд гарч төдөлгүй пийшингийн уурт орон дээр шигдэн нуугдсан Труба—Нащекиныг татаж гаргаад Разин дээр авчирчээ.

— Дүүжил, дүүжил! гэх дуу гарахад,

—Тэр хусан дээр аваад оч! гэж Разин командлахад,

— Өрөвдөөч, өршөөгөөч гэж Труба—Нащекин гуйж, Өрөвдөөч гээд чавганцын чихарсан нарийхан дуугаар хашгиран уйлжээ.

Разин хорсолтойгоор инээвхийлэв.

— Агаман, цааш харуул, дуусга. Битгий зууралд гэж тариачид шуугилдав. Тэгтэл нэг бяцхан охин хүрч ирээд Разин уруу ширтэж:

— Ах минь өршөөгөөч үүнийг гэхэд тариачид таг жиг болж охиныг ширтэн хаанаас гараад ирэв ээ ? гэж боджээ.

— Сүжиггүй хэрэг хийчихсэн юм бол уу гэж гэнэт нэг нь хэлэхэд, Ухаан ороогүй бяцхан хүүхэд үймлэж байх чинь сайн юм болно гэжүү дээ гэлээ.

Цөм агаманыг ширтэн хүлээлээ.

Разин охиныг, тариачин эрсийг, дараа нь алсыг, тэгээд тэнгэр огторгуй өөд харсанаа:

— Өсөж том болоод учрыг ойлгож зэмлэхгүй. Дүүжил гэж казакууд уруугаа хашгирлаа.



Авар-аа-чээ

Разин Ижил мөрний эрэг дээр харанхуй шөнө сэлмээ түшин бодлогошрон сууж байжээ.

«Аян дайнаа хааш нь хийх билээ? Эх болсон Ижил мөрнөөр уруудан Астрахан уруу, Каспийн тэнгис уруу өмнө зүг явах уу, эсвэл Саратов, Самар, Казань, тэр Москва уруу умрыг чиглэх үү. Москва хот, бүгдийн хот болсон Москва. Тийшээ л очих юмсан. Ноёдууды нь хөөж тараах юмсан. Арай эрт байна. Одоохондоо хүч хүрэхгүй байх аа. Их буу, үхэр буу, дарь, сум багавтар байна. Тариачин эрс дайнд дасаагүй, олонх нь уранхай муу хувцастай байна. Тэгэхээр өмнө зүг хоол хүнс, хувцас хунартай болж... цэргээ ч янзалъя гэж Степан Тимофеевич тунгаан боджээ. Харин тэгээд... гээд Разины амьсгал давчдаж, харин тэгээд баяд ноёдыг багалзуурдаж авна даа» гэж бодож байлаа.

Ингээд атаман Ижил мөрний эрэг дээр суусаар, бодсоор байжээ. Тэгтэл мөрөн дээгүүр хашгирах чимээ гарчээ. Эхлээд аяархан дуу гарахад Разин худлаа байх гэж бодтол:

— Авар—аа—чээ! гэх дуу улам чанга чанга сонсогджээ.

Эргэн тойрон таг харанхуй, юу ч харагдахгүй ажээ. Гэвч хэн нэгэн хүн усны эргүүлэгт орж живж байгаа нь тодорхой ажээ.

Разин гол уруу, өмссөн хувцастайгаа гүйн очиж ус уруу орон дуу гарсан чиг үрүү сэллээ. Самраад дахин самарч:

— Хэн бэ? Тэсэж.үз! гэвэл хэн ч хариу өчсөнгүй. «Хожиджээ, хожимдож ямар ч гэмгүй хүн өнгөрч дээ» гэж

Разин гашуудан цаашаа хэдэн алхам сэлээд буцах гэтэл яг энэ үеэр сагсгар сахал харагдаж хэн нэг хүний гар хүрчээ.

— Авар—аа—чээ! гэж сахалт хоржигноод, дахиад л ус уруугаа орлоо.

— Одоо ч миний гараас гарахгүй гэж атаман баярлаад, усанд шумбаж нөгөө хүнийг татаж эргэн дээр гаргаад элсэн дээр тавьж цээж уруу нь өвдгөөрөө дарахад ус ам хамраар нь садарна. «Уучихжээ» гээд Степан Тимофеевич жуумалзав. Төдөлгүй аврагдсан хүн нүдээ нээж атаманыг хараад;

— Гялайлаа, казак минь гэв.

Разин тэр үл таних хүнийг харвал өлбөгөр хатингар биетэй, хажуугаараа ханзарсан цамцтай, уранхай олсон даавуу өмдтэй эр байлаа.

— Чи хэн бэ?

— Би дүрвэж яваа хүн. Разин дээр л очих гэсэн юм. Сонсоо биз дээ? Тариачин эр ёолсноо таг боллоо. Энэ үеэр эрэг дээр чимээ гарч:

— Эцэг! Атаман! Степан—а—н Тимофеевич! гэж хашгирлаа. Шадар хүмүүс нь Разиныг хайж яваа ажээ. Разин харанхуйн дунд умбалаа.

Казакууд тариачин эртэй зэрэгцэн ирж бөхийж чагнаад:

— Амьсгалж байна! Аврагдсан хүнийг хоёр нь байр луугаа аваад явж, бусад нь Ижил мөрний эргээр цааш явна.

— Эцэг! Атаман! гэж хашгирсаар явлаа.

Өглөө нь Разинд шөнө казакуудын хэн нэг нь дүрвэж явсан хүний амийг аварчээ. Гагцхүү хэн аварсан нь тодорхойгүй байна. Казакуудын зуутан дотроос аварсан хүн гарахгүй байна гэж илтгэлээ.

— Цөмөөс нь асуугаагүй юу? гээд

Степан Тимофеевич жуумалзав.

Яикийн чулуун хот

Яик мөрөн 1, Яицкийн цамхаг өндөр, хана хүн амьтангүй эл хуль, хаалга нь царс, ерөөсөө хот биш бэхлэлт л гэсэн үг.

«Тэнд очвол казакууд маань амарна. Харин хотыг эзлэх хэрэгтэй болно. Байлдаж эзэлнэ гэхлээр цэргийн тэн хагасыг хядуулна гэсэн үг» гэж Разин санааширна.

Тэгтэл нэг өдөр талд явсан хэдэн хүнийг барилаа гэж Разинд илтгэлээ. Яицкийн цайз уруу мөргөл хийхээр гуч орчим гэлэн мөргөлч нар явж байсан юмсанжээ.

«Ариун, энгийн номхон улс тавьчих, явж л байг» гэж Разин хэлснээ гэнэт:

— Хүүш байзаарай. Нааш нь аваад ир гэжээ. Гэлэнгүүд ирцгээжээ.

— Хувцсаа тайлцгаа! гээд казакуудаа дуудаж:

— Энэ хувцсыг өмсөцгөө! гэжээ.

Ингээд тэд хувцсаа сольж өмсөцгөөжээ. Яицкийн цайзынхан тайван биш байлаа

Буучид ч тэр, дарга нь ч тэр хажуухан талд Разин байгааг мэдэж байжээ. Тэгээд нэг мэдэхэд л хаалган дээр ирчихсэн байх вий гэж сэрэмжилнэ.

Дарга цайзын хамгаалалтыг нэмж, хэнийг ч зөвшөөрөлгүй оруулж гаргаж болохгүй гэж хатуу тушаажээ. Шөнийн цагаар дааман нь цаг үргэлж түгжээтэй байдаг байжээ.

Нар жаргахаар тонгойход харуулд гарсан цэргүүд гарч тал уруу анхааралтай ширтэв.

Тэгтэл хот уруу хэсэг бүлэг хүмүүс ирж явжээ. Дахин сайн харвал гэлэн нар ажээ.

1. Каспийн тэнгис. Яицкийн чулуун хот.

Мөргөлчид хаалган дээр ирээд:

— Хаалгаа нээгээч гэвэл хамгаалагчид тэвдэж:

— Та нар хаачих нь вэ? гэхэд,

— Яицкий хотын сүмд очиж ариун бурханд мөргөх гэсэн юм.

— Хээр хоно доо. Хэрмэл улсыг оруулдаггүй юм даа.

— Та нар яасан бурхан сүсэггүй улс вэ. Бурхан үүнийг чинь мартаггүй дээ гэж гэлэнгүүд дургүйцэн хэлжээ.

Харуулын цэргүүд зөвлөлдөж даргадаа илтгэхээр явжээ.

— Цаадуул чинь хэдүүлээ юм бэ?

— Гучин хүн.

— Оруулчих. Харин илүү хүн оруулчихуузай.

Ийнхүү мунгинасаар байтал бүр харанхуй болжээ. Явуулсан харуулууд эргэж ирээд түгжээг онгойлгожээ. Сахалтай буучин мөргөлчдийг нэг нэгээр нь оруулан тоолжээ.

— Нэг, хоёр,... хорь... гуч. Зогсоорой! гэвэл

— Сахалт минь тоолж чаддаггүй юм уу. Хорин хүн ч ороогүй байна шүү дээ гэж хэн нэгний дуу гарлаа.

«Юу гэнээ» гээд бууч мэгдлээ. Бүр дөчин хүн. Бүр тавин хүн оржээ. Тэгээд бас тариачид орж иржээ. Тэгтэл морины хошуу цухуйж дараа дараагаар морьтой хүмүүс орж ирлээ.

— Зогсоорой! Зогсоорой! гэж харуулын цэрэг хашгирна. Өнөөх чинь хаачив аа! Тэгтэл харуул уруу мундаг том эр гүйн ирж очиж амыг нь зориуд бэлтгэсэн зүйлээр таглажээ.

Цайзанд юу болж байгаагийн учрыг олж шуугиан дэгдээх гэсээр байтал бүр хожимдсон ажээ.

Ийнхүү Разин гуай Яицкий хотыг ямар ч байлдаангүй авчээ.

Үнэндээ гудамжинд буудалцсан авч тулалдаан гэж үзэхээр юм болсонгүй.

Ингэж Яицкий нутгийн ноёдын хот байснаа Разины хот болжээ.

Хоёр гар

Хэсэг дүрэвсэн тариачин Ижил мөрөн рүү, Разин дээр очихоор явжээ. Шөнө явж, өдөр ойн гүн шигүүд орж нуугдана. Олны замаас аль болохоор холуур гацаа тосгоныг тойрон бүтэн сар явжээ. Тариачин эрчүүдийн ахмад нь болох цоохор Митяй:

—Тэр, атаман Степан Тимофеевич чинь сургуульгүй хүнд маш дургүй, ширүүн хүн. Сэлэм эргүүлж чадах уу гэвэл чадна. Жадалж чадах уу гэвэл чадна гэж хэлээрэй гэж үг зааж өгдөг байжээ. Тэгээд тариачид Разин дээр очиж:

— Атаман эцэг минь казак цэрэгтээ биднийг аваач гэхэд:

— Сэлэм эргүүлж чаддаг уу?

— Чадна.

— Жадаар сүлбэж чадах уу?

— Сүлбэж чаднаа.

— Өө тийм үү гэж Разин гайхаад, морь авчир гэж тушаагаад За сахалт морд гэж Митяй өвөөд хэлээд, Май, сэлэм ав гэжээ.

Митяй ингэж шалгана гэж бодоогүй байжээ. Дүүрчээ, дүүрч, атаман худлаа хэллээ гэж цаазаар авна даа! Тэгээд Митяй булзаарч гарахын тулд:

— Бид чинь явган л эргүүлдэг юм гэвэл:

Казак цэрэг явган эргүүлэхийг хаа үзэв, чи? Аль вэ морд!

— Эцэг минь би замдаа ядарчихсан гэвэл,

— Цэргийн хүн ядарч болохгүй гэжээ.

Митяй мухардахад казакууд гараас нь барьж аваад моринд мордуулав. Тариачин эр ч сэлмээ авчээ.

Казакууд гуугалахад морьд тал уруу авч давхижээ. Митяй өвөөд эмээл маш эвгүй байснаас гадна анх удаа гартаа сэлэм барьж байгаа болохоор даллаад л сэлмээ алдчихжээ.

— Яасан зөрүүд сэлэм бэ? Бууж өгөхгүй байна шүү гээд казакууд тачигнатал инээлдэнэ.

— Тариачинд сэлэмний хэрэг юу байна. Хүрзээрээ л дайснаа намнаг гээд Степан Тимофеевич бусдаас илүү хөхөрнөө. Тариачинд маш ичгэвтэр санагдлаа. Тэгээд зориг гаргаж Разин дээр очоод:

— Агаман минь дэмий л хөхөрч байна даа. Та анжис баривал бид ч бахаа ханаж болох юм гэхэд Разин инээдэндээ болоод хөөрч:

— Аваад ир, барина гэлээ.

Анжис авчирч гүүнд хөллөв. Разин болон бусад казакууд хүн болсоор газар хагалж үзээгүй билээ. Гэвч амархан ажил гэж бодсон чинь эхлээд л болсонгүй.

— Хаачих нь вэ, хаачих нь вэ, тэр шал мурий болчихлоо гэж Митяй өвөө хашгирнаа.

— Өнгөн хөрсий нь аваад байна. Бүр гүнзгий хагал гэж тариачид ам амандаа дуугарна.

Агаман хүчтэй атгатал анжисны хошуу нь хугарчээ.

— Яасан зөрүүд анжис вэ, бууж өгөхгүй байна шүү гээд тариачид инээлдлээ.

Казакууд анжсаар яах юм бэ, тэд сэлмээрээ газар хагална гэж Митяй өвөө хөхөрлөө.

Разин тариачин эрс уруу харснаа бас л хөхөрлөө.

— Сайхан байна, сахалтаа гээд Митяйгийн мөрөн дээр Разин алгадсанаа, Эрдэм сургасанд баярлалаа. Хүүш тариачин ардыг битгий гомдоогоорой. Тэдэнд казакуудын адил морь зэмсэг олго гэснээ бодлогоширч тариачинцэрэг хоёр нэг хүний хоёр гар гэсэн үг хэмээн нэмж хэлсэн гэдэг.



Гуравны нэг аршин

Разин, хотыг эзэлж авахдаа худалдаачдын хэн нэгий нь ч гомдоож болохгүй гэж хатуу тушаажээ. Худалдаачингүйгээр давс ч, шүдэнз ч, хадаас ч олохгүй гэдгийг Разин ойлгож байлаа.

— Тэд л биднийг гомдоохгүй бол бид тэднийг яах ч үгүй агаман минь гэж босогчид хариулж байжээ.

—Та нарыг гомдооноо гээд Степан Тимофеевич инээмсэглэснээ, дутуу хэмжиж, жигнэж гомдоовол агаман миний нэрийн өмнөөс шийтгэ гэжээ. Разиныхан Астрахань хотод оржээ. Худалдаачид мухлагаа онгойлгож бараагаа өржээ. Разин өөрөө мухлаг дотуур явж Параша охиндоо бэлэг болгож бяцхан улаан гутал ч худалдаж авч гэнэ.

Степан Тимофеевич агаманыхаа асарт буцаж ирээд сэтгэл хангалуун байжээ. Тийнхүү худалдаа хөл ихтэй, гүйлгээ сайтай байжээ. Худалдаачин Окаемовын мухлагийн дэргэд олон хүн бужигнана. Худалдаачин торго дурдмын наймаа хийнэ. Казакууд гоёлын цамцандаа улаан, шар, ногоон янз янзын юм авна. Худалдаачин хэмжиж өгч байхдаа «ийм аятайхан үед дутуу хэмжихгүй бол би худалдаачин ч биш, худалдааны хүн ч биш болно» гэж бодож байлаа. Тэгээд хэмжихдээ хүн бүрээс гуравны нэг аршин дутуу хэмжиж байлаа.

Хагас өдөр өнгөрсний дараа казакуудын нэг нь уг мэх залиг ажжээ. Тэгээд казакууд авсан торгоо хэмжтэл хэдэн арван хүний торгоноос гуравны нэг зүсэм торго дутуу байжээ.

— Мөсгүй золигийг бариад ав!

— Хорон санаагий нь хариулна даа!

— Худалдан авагчид худалдагчийг барьж аваад мухлагаас нь гаргаж тэр дор нь шүүжээ. Цагийн дараа жижүүрийн цэрэг:

— Олон түмэн ард зэвүүрхэж худалдагчийг номхотгожээ гэж илтгэжээ.

— Яаж номхотгоо вэ? гээд Разин хөмсөг зангидав.

— Гурвны нэг аршин

— Гуравны нэг аршин гэж яаж?

— Толгойгоор нь.

— Тьфу! гэж Разин уурлаад,

Алив тэр гомдоосон этгээдээ дууд гэлээ. Казакууд агаман дээрээ ирлээ.

— Гуравны нэг аршины төлөө худалдаачныг алж байдаг.

Алгын чинээ алчуурын төлөө цус урсгаж байдаг гэж ирээд л Разин аймшигтайяа уурсан хашгирна.

— Атаман минь битгий хилэгнэ, битгий хилэгнэ. Сайн бод гэж казакууд хэлээд,

— Уг хэрэг аршинд байгаа бишээ. Луйварчны толгойг авснаар ард түмэнд л тустай. Бид ч үр ач, гуч нар минь ч уул хэргийг дурсан санаг. Атаман минь битгий хилэгнэ гэжээ.

Разины уур гарчээ.

— За явцгаа. «Ард түмэнд худалдаачин хэрэгтэй, чухал хэрэгтэй. Худалдаачин хүмүүсгүй байж болохгүй. Окаемовтон эзэгнэж байгаа болохоор багагүй гай тарих нь лав. Хүмүүс маань шударгаар шийдсэн ч байж болох юм» гэж Степан Тимофеевич дотроо боджээ.



Андгайлсан нь

Гусь, Присевка гэдэг хоёр залуу казак хэн нь ард түмнийхээ үйл хэрэгт илүү үнэнч вэ гэж маргажээ.

— Би үнэнч гэж Гусь хашгирахад

— Үгүй би үнэнч гэж Присевка мэтгэнэ.

— Би амь насаа хайрлахгүй гэж Гусь цээж уруугаа дэлсэнэ.

— Би ямар ч эрүү шүүлгийг гон гэхгүй даана гэж Присевка андгайлна.

— Тэгвэл би хуруугаа тас татах уу.

— Хуруу ч юу ч биш. Би гараа булга татах уу гээд л хоёр казак хэн хэндээ бууж өгөхгүй шуугиан дэгдээжээ. Разин энэ үеэр байраар явж байгаад казакийн маргааныг сонсож зогсоод инээмсэглэв.

Маргагсад атаманаа хараад чимээгүй болжээ. Степан Тимофеевич залуусыг хараад:

— Амь нас, эрүү шүүлт, хуруу, гар гэж хашгиралдана. Бас өөрийгөө

шалгахыг хүсэж байна уу?

— Айлдаарай, агаман! Казак ёсоор андгайлъя.

— Бичиг үсэг сурсан уу?

— Сураагүй, Степан Тимофеевич!

— За тэгвэл: хэн цэцэн мэргэнээ түрүүлж харуулна, тэр жинхэнэ итгэлтэй хүн байна гэжээ.

Казакууд мэгджээ. Ийм юм хэлнэ гэж огт бодоогүй байжээ. Гэтэл агаман эцэг ёстой л даалгавар өгчээ. Гэлээ ч гэсэн казак ёсоор ам алдаж андгайлсан болохоор яах билээ дээ?

Разин бичиг үсгийн тухай дэмий яриагүй ажээ. Түүнд бичиж, уншдаг хүн хэрэгтэй байжээ. Тийм бичигтэн цөөн байжээ. Тариачин цэрэг ч хэцүү байжээ.

Казакууд сүмд очиж дуганчийг хайж олоод:

— Урт үстээ номд сурга гэжээ.

Тэгээд мань хоёр казак үсэг шагайж шуухатнан хичээнгүйлжээ. Эрдэм сурна гэдэг амаргүй ажээ. Хэдэн долоо хоног өнгөрчээ.

— Хүчээ барж гүйцлээ, дахиад хүч хүрэхгүй нь гэж Гусь хүүхэд шиг уйлна.

— Буучийн суманд өртөж үхсэн нь дээр байна гэж Присевка енгинэнэ. Дахиад л долоо хоног өнгөрчээ.

— Толгой минь хагарах нь, үүнээс болж үхэх нь гэж Гусь санаагаар унана.

— Тамын зовлон гэж ийм байдаг байх гэж Присевка орь тавина.

Казакууд хувь зохиолоо харааж гиншинэ. Гинших авч казак ёсоор андгайлсан болохоор хичээсээр л байлаа. Бүтэн хоёр сар өнгөрч гэнээ.

— За явцгаа гэж дуганч хэлж дээ.

Казакууд салхинд хөөгдсөн мэт Разин уруугаа давхижээ. Эцэг атаман минь эрдэм ном сурлаа! гэхэд,

— Тэглээ гэж үү! гээд

Степан Тимофеевич итгэсэнгүй.

— Шалгаад үз л дээ.!

Разин Гусьд бичигтэй хуудас өгч:

— Уншаатах гэжээ.

Гусь уншлаа. Гэхдээ тийм ч шулуухан уншиж чадсангүй. Гэхдээ л цөмийг үнэн гаргаж байжээ.

— Сайн байна. казак! гэж Разин хөхүүлэв. Разин ам цагаан цаас авч Присевкад өгөөд,

— Бичээтэх гэжээ.

Присевка бичлээ. Гэхдээ тийм ч хурдан бичсэнгүй. Гэвч цөмийг зөв, үг үсэг хутгасангүй. Үнэн зөв бичив.

— Сайн байна. казак! гэж Разин шагшрав.

Степан Тимофеевич тэднийг дэргэдээ авч чухал мэдээ, бичиг баримт ялгах нягтлах ажилд тавив. Тэд ч сайн түшиг болохоо харуулав.

— Сайн эрс, казакуудын нэр төрийг шившиглэсэнгүй гээд Разин магтаж бардаггүй байв. Энэ ч яахав. Түмний үйлсээ яах билээ гэж Гусь, Прилевка хоёр сэтгэл дундуур байна.



Х:
Г:
а:
х:
х:
Д:
х:
У:
а:
С:

Разинка нэртэй алим

Симбирийн дэргэдэх тулалдаанд Разин толгойдоо хүнд шархадсан ажээ. Атаманд үнэнч казакууд түүнийг төрөлх Дон нутагт гэрт нь аваачив. Замдаа Ижил, Дон мөрний хоорондох жижигхэн гацаанд хоноглосон юмсанжээ. Тэгээд өвчтөнөө энхрийлэн нэг байшинд оруулжээ. Төдөлгүй

Разин дээр жаахан жаал ирж алим өгөөд:

— Разинка алим зоогло, Степан Тимофеевич... гэжээ.

— Юу гэнээ? гэвэл,

— Разинка гэдэг юм гэж хүү тайлбарлажээ.

Гайхахдаа Разин хөмсгөө зангидан сэргэж бодлогошров.

Уул явдал Разин казакуудтайгаа Ижил мөрөн уруу аялсан анхны жил

1667 онд болсон юмсанжээ. Тэгэхэд Разин яг тэр гацаанд хоноглосон билээ.

Гэрийн эзэн өвгөн өглөө байшингийнхаа хажууд алимын мод суулгаж байхыг Степан Тимофеевич хараад:

— Алив тусалъя гэхэд,

— Үйлс чинь бүт гэж өвгөн хариулжээ.

Разин нүх ухаж навчгүй бяцхан турыгүй нарийхан алимын мод суулгажээ.

— Степан минь, гурван жилийн дараа ирээрэй. Тэгээд разинка алимаа

ямар болсныг хараарай гэж өвгөн, атаманыг урьсан юмсанжээ.

Ингээд гурван жил ч биш бүтэн дөрвөн жил өнгөрчээ. «Хувь тавилангаар л боллоо доо. Сайн үйлс санасан ёсоор гэдэг» гэж Разин бодлоо.

— Танай өвөө хаана байна? гэж Разин хүүгээс асуувал:

— Өвөө маань бүр хавар цэцэрлэг ид цэцэглэх үед нас барчихсан. Амьсгаа хураахдаа Степан Тимофеевич таныг дуудаж, алимын модныхоо талаар яриад л байсан. Одоо байгаагий нь ч, хожим өсөж торнихы нь ч хайрлаж хамгаалж байгаарай гэж гэрээслэсэн гэжээ.

Разин өглөө алимын модыг харвал хүчит мөчир нь тал тал тийшээ салаалсан залуу саглагар сайхан мод болсон байлаа. Тэгээд мөчир бүрээс нь зангидсан гар шиг том, сэнгэнэсэн алим унжиж байлаа.

«Разинка» гэж аман дотроо Степан Тимофеевич хэлээд өвөөгийнхөө шарил дээр аваачихыг хүүгээс гуйж. Очоод тэргүүнээ ихэд бөхийлгөн хүндэтгэж цааш явахыг тушаажээ.

Разин зам зуураа цэцэрлэгийн тухай л ярьж явжээ.


— Гоё мод болжээ! Дон, Ижил мөрөн даяар, гэрэлт хорвоо даяар ийм сайхан мод тарина даа. Ноёдыг унагаад, цэцэрлэг тарих ажилд орно доо. Тэгвэл хавар болоход эргэн тойрон цагаан гал дүрэлзэж, намар мөчир нь газар шүргэн жимсээ даахгүй болсон цэцэрлэг тарьж амьдралаа өөрчилнө. Анжисны хошуугаар газрын хөрс эргүүлж хогийн муу ургамлыг арилгаж, алтан түрүү найгуулж ард олондоо аз жаргал, баяр цэнгэлийг авчирна даа гэж ярьж байжээ.

Атаманы удирдан боссон олон түмэн, хаад ноёдыг авч хаяж чадаагүй бөгөөд атаман өөрөө аз жаргалтай тэр үеэ хүртэл амьдарч чадсангүй. Разинг Дон нутагтаа ирэхэд нь баян казакууд баривчилж гавлаж дөнгөлөн Москвад аваачиж одоогийн улаан талбай дээр цаазалсан юмаа.

Алуурчийн сүх толгой дээр нь гялсхийж, тэргүүн нь дээш хөөрөн өнхөрчээ...

Ийнхүү Степан Тимофеевич Разин нас барсан боловч мөнхийн алдар, үүрдийн дурсгал нь үлдсэн юмаа.

Хаан Петр ба түүний үеийн тухай өгүүллэг



Их бууны сумангийн ахмад

Оросын арми Нарв уруу явж байлаа. «Тра—та—та, тра—та—та!» гээд л сумангийн аяны бөмбөр жигдхэн дэлдэнэ.

Цэргүүд эртний оросын Новгород, Псковыг дайран бөмбөрийнхөө эгшгэнд дуу дуулан явна. Уг нь хур бороогүй намар байснаа гэнэт усан бороо шавшиж моддын навч унаж зам харгуй зууралдаж хүйт эхэлжээ. Цэргүүд бороонд дэвтсэн замаар өвдгөө хүртэл шавар шавхайд шигдэн явна. Аян дайнд цэргүүд маш хэцүү байлаа. Жижигхэн гол дээр тавьсан гүүрэн дээгүүр гарч явтал гүүрний ялзарсан банзыг их бууны дугуй цоо дарж голдоо хүртэл шигджээ.

Цэргүүд хашгиралдан морьдоо ташуурдана. Урт замд турсан морьд арьс яс болжээ. Гэвч зодуулсан морьд байдаг хүчээрээ зүтгэх авч их бууг огтхон ч хөдөлгөж эс чадна.

Цэрэг эрс гүүрэн дээр овооролдож их бугаа гараараа татаж гаргахыг хичээцгээнээ.

— Урагшаа! гэж нэг нь хашгирахад

— Хойшоо! гэж нөгөө нь командална.

Тэд шуугин маргах авч уул хэрэг бүтээмж муутай байлаа. Ахлагч их буугаа тойрон гүйж яахаа үл мэднэ. Тэгтэл замаар эрээн цоохор сүйх тэрэг айсуй байгааг цэргүүд харжээ. Тарган цаггалан морьд дорхноо давхиж ирээд гүүрний дэргэд зогсоход тэрэгнээс цэргийн дарга гарч ирэхийг харвал их бууны сумангийн ахмад ажээ. Ахмад хоёр метр хиртэй асар өндөр бөгөөд дугуй царайтай, том нүдтэй, уруул дээрээ наамал юм шиг тас хар сахалтай ажээ. Цэргүүд айн мэгдэж номхон зогсоод таг болжээ.

— Ах дүү нар минь, муу л байна даа! гэж ахмадыг хэлэхэд

— Тийм ээ, их бууны ахмад аа! гэж цэргүүд нэг зэрэг хашгирчээ.

Заа даа ахмад одоо ч уурлаж гарна даа гэж бодож байжээ. Нээрээ л тэгж гэнэ. Ахмад их буу уруу очиж үзсэнээ.

— Хэн даргалж яваа вэ? гэж асуухад

— Би байна, ноён их бууны ахмад аа гэж түрүүч хариултал

— Ингэж цэргийн эд хогшлыг хайрладаг юм уу! Замаа хардаггүй, морио хайрладаггүй яасан улс вэ гээд ахмад түрүүч уруу бууж гарчээ.

— За би... за бид... гээд түрүүч ярьж эхэлжээ.

Гэвч ахмад түүний яриаг сонссонгүй, хүзүүн дундуур нь дэлсээд дахиад л их буун дээр ирж эргэмэл захтай гоё улаан дээлээ тайлж бууны доогуур ороод аварга том мөрөөрөө мөрлөж өргөхөд их буу данхагнаж дугуй нь нүхнээсээ тэгш газар гарахад цэргүүд гайхахдаа дуу алджээ.

Ахмад мөрөө—зассанаа «ах дүү нар минь, талархан соёрхоё!» гэж цэргүүд уруу хашгираад түрүүчийн мөрөн дээр алгадаад тэргэндээ суугаад цааш давхиж гэнээ. Цэргүүд гайхан амаа ангайж, ахмадын хойноос ширтсээр хоцорчээ.

— Үгүй мөн, мундаг аа! гэж түрүүч дуу алджээ.

Дарга нараас хоцорсон генерал цэргүүдийг гүйцэн иржээ.

— Хүүе цэргүүдээ эзэн хааны тэрэг явж өнгөрөв үү? гэж генерал хашгирахад

— Өнгөрөөгүй эрхэмсэг генерал минь гэж цэргүүд хариулаад,

— Харин их бууны ахмад л явж өнгөрсөн гэхэд

— Их бууны ахмад аа? гэж генерал лавшруулан асуувал

— Яг тийм! гэж цэргүүд хариулжээ.

— Тэнэг минь юуны чинь ахмад вэ? Тэр чинь эзэн хаан Петр Алексеевич өөрөө байхгүй юу! гэж генерал хэлжээ.

Нарв хотыг эзлэхгүйгээр тэнгис харахгүй

Цатгалан морьд омголон давхиж шаварт суусан хааны сүйх тэргийг тойрон гарч олон бээр үргэлжилсэн хороог гүйцэв.

Петр хааны хажууд нуруугаар адил авч өргөн мөртэй нэгэн хүн сууж яваа нь Меншиков ажээ. Петр, Меншиковыг бүр хүүхэд ахуйгаас нь мэднэ. Меншиков тэр үед бялуучныд ажиллаж Москвагийн зах зээл, талбайгаар явж бялуу зардаг байжээ.

— Хайрсан бялуу, хайрсан бялуу! гэж Меншиковын дуу тасалдан хашгирч байдаг байжээ.

Нэгэн удаа Алексашка Яуз гол дээр Преображенскийн гацааны эсрэг загас барьж байгаад хартал жаалхүү ирж явжээ. Хувцсыг нь харвал хаан хүү бололтой байлаа.

— Чи илбэ үзэх үү? гэж Алексашка Петрээс асуувал:

— Үзье гэжээ.

Меншиков учигтай зүү авч маш овжин хацраа хатгахад цус гарсангүй. Санамсаргүй байсан Петр дуу алдсан ажээ.

Тэр үеэс хойш арав гаруй жил өнгөрчээ. Меншиков танигдашгүй болжээ. Тэр одоо хааны хамгийн дотно нөхөр, зөвлөгч болжээ. Урьдын Алексашка хүүг одоо Александр Данилович гэж хүндэтгэн өргөмжилнө.

— Чүү, чүү! гэж өмнөх суудал дээр сууж яваа цэрэг хашгирагхад морьд хар хурдаараа давхиж хаан сүйх бартаат замд энхэл тонхол хийж бөөн шороо хуйлруулан цацна.

Петр үг дуугуй өмнөх цэргийнхээ өргөн мөрийг ширтэн сууж хүүхэд ахуй цаг, тоглоом, наргиант цэрэг тэргүүтнээ санан дурсана.

Тэр үед Петр Москвагийн ойролцоо Преображенск гацаанд суудаг байв.

Цэргийн тоглоомд илүү их дуртай тул их буу, зэвсэг авчирч хүүхдүүд цуглуулдаг байжээ. Харин жинхэнэ сум байсангүй, шинэхэн хураасан сармагаар сум хийж бууддаг байжээ. Петр цэргээ цуглуулж адилхан хоёр хуваагаад дайтаж гарна. Дараа нь гарз хохирлоо тоолоход нэг нь гараа хугалж, нөгөө нь хавиргаа бэртээж, бас нэг нь толгойгоо хагалсан болдог байжээ.

Ноёд Москвагаас ирж Петрийг наргиантай тоглоомоор тоглолоо гэж хараахад Петр их буугаараа буудаж шинэхэн сармаг бүдүүн гэдэс, сахалт нүүрэнд нь тусахад ноёд хувцасныхаа ширмэл хормойг шүүрч аваад тал тал тийшээ зугтана. Петр сэлмээ авч:

— Ялалт! Ялалт! Дайсан цаашаа харлаа! гэж хашгирдаг байжээ.

Одоо тэр наргиант цэргүүд нь өсөн бойжиж Преображенск, Семеновын хоёр хороо болжээ. Хаан тэднийг торгон цэргээ гэдэг байлаа. Одоо бүх хороодынхоо хамт Нарв уруу явж тэдэнтэйгээ хамт туулшгүй шавар шавхайг туулж яваа ажээ. «Хуучин анд нөхөд минь яадаг бол оо? Энэ ч ноёдтой дайтахтай адил бишээ» гэж Петр бодож явжээ.

— Эзэнтээн! Эзэнтээн, Нарв харагдаж байна гэж Меншиков хааны бодлыг тасаллаа.

Петр харвал голын зүүн талын эгц эрэг дээр Нарвын цайз хэрэм. Эргэн тойрон чулуун хэрэм харагдана. Яг голын дэргэд хэрмэн дотор Нарвын шилтгээн харагдана. Гонжгор Герман хэмээх Шилтгээний гол цамхаг тэнгэр баганадан сүндэрлэнэ.

Нарв голын баруун эрэг дээр Нарв хотын эсрэг талд Иван —хот хэмээх өөр цайз хэрэм харагдана. Иван хот ч нэвтэрч болшгүй хэрмээр хүрээлэгджээ.

— Эзэнтээн ийм цайзыг байлдан дагуулах амаргүй гэж Меншиков хэлэхэд:

— Амаргүй нь амаргүй. Авах л хэрэгтэй. Бид Нарвыг эзлэхгүй бол болохгүй. Нарв хотгүйгээр тэнгис харахгүй шүү гэж Петр хаан хариулна.



"Үг айлдахыг соёрхоно уу, хаатан"

Оросууд Нарвын дэргэд бут цохигджээ. Орос орон дайнд муу бэлтгэсэн ажээ. Буу зэвсэг, хувцас хунар хангалтгүй байснаас гадна цэргүүд сургууль муутай байжээ.

Өвлийн хүйтэн салхи салхилна. Морьдын туурай цагаан цасыг базан шидэх лугаа адил хол цацаж энхэл донхол бартаат замыг ардаа хийсээр гоёмсог тэрэг цастай замаар давхина. Петр хаан Тула хотын зэр зэвсгийн завод уруу Никит Демидов дээр очихоор давхиж яваа нь энэ ажээ.

Петр Никитийг жирийн дархан байх тэр үеэс эхлэн мэддэг байжээ. Тэгээд ажил хэргээр Тула хотод ирэхдээ Демидов дээр очиж:

—Демидыч, намайг төмрийн дарханд сургаач гэж байсан удаатай билээ. Никит хормогчоо зүүж хөөргөөс бахиараа улайссан төмөр хавчиж гаргаад лантуугаар төмрөө балбахдаа хаана нь яаж цохихыг Петрт зааж өгдөг байлаа. Заримдаа Петр лантууг авч далайн заасан газарт нь буулгахад тал бүр оч үсэрнэ.

— Ингэж цохь, ингэ! гэж Демидов заана. Хаан жаахан л эвгүй хийвэл:

— Мурий гартай юм уу! гэж Никит хашгирснаа:

— Та, Эзэнтэн минь битгий уурла. Энэ ажил чинь хашгируулж байх дуртай ажил. Хашгирахгүй бол гаргуйтэй л адил гэсэн үг гэхэд.

— Заа, заа гэж хаан хариулдаг байжээ.

Тэгсэн чинь хаан дахиад Тула хотод иржээ. «Зүгээр ч морилоогүй дээ, зүгээр ч морилоогүй» гэж Демидов бодож сууна. Тиймээ, үнэхээр зүгээр ирээгүй байжээ.

— Никита Демидович Нарвын тухай сонссон уу? гэж Петр асууна. Демидов юу гэж хэлэхээ мэдэхгүй ажээ. Хэлэхгүй юм хэлээд хааныг

уурлуулчихна. Шведүүд манайхныг нугалчихаж гэнэ гэж эргэн тойрон цөм ярилцаж байхад Нарвын тухай сонсолгүй яах вэ дээ.

Демидов үг дүүгүй, юу гэж хариулахаа бодно.

— За та битгий залилаад бай гэж Петр ярина.

— Сонссон гэж Демидов хариулна.

— За тэгээд л их буу л хэрэгтэй боллоо Демидыч минь. Их буу мэднэ биз дээ гэвэл,

— Мэдэлгүй яах вэ, хаан минь гэхэд,

— Олон л их буу хэрэгтэй гэж Петр хэлбэл,

— Мэдлээ, Петр Алексеевич. Харин манай Тула завод ч муу, бас тэгээд төмөр, мод байхгүй байна. Гай нь завод биш гэлээ.

Петр Демидов хоёр үг дуугүй сууна. Петр гоёмсог вандан дээр суугаад заводын хашаа уруу ширтэнэ. Тэнд уранхай хувцастай, маажгий шаахайтай эрс улиасан дүнз зөөж байлаа.

— Манай Тула ийм л байдаг юмдаа. Дүнзээр л галлана. Дүнзээр л галладаг, ядуу чадуу даа гэснээ Петр хаан уруу бөхийж аяархан шивнэж:

— Үг айлдахыг соёрхоно уу, хаантан минь гэж Демидов хэлэв. Петр дуугүй, Демидов уруу харснаа:

— Хэл, хэл гэлээ.

— Манайхан Урал уруу явсан юм гэж Демидов яриагаа эхлээд,

— Би ч бас явсан, хаантан минь. Төмөр байдаг л газар даа! Ойн хувьд бол зах хязгаар нь ч харагдахгүй далай тэнгис гэсэн үг. Ёстой л завод барьдаг газар даа, хаантан минь. Тэгвэл их буу, зэр зэвсэг, бөмбөг юу л хэрэгтэйгээ хийж болно доо гэжээ.

— Урал гэж ярив уу? хэмээн Петр лавшруулан асуухад

— Тиймээ, яг тийм гэж Демидов хариулав.

— Уралын тухай ч сонссон, Демидыч минь хол нутаг даа, хязгаар газарт байдаг юм. Завод барина гэсээр байтал хамаг цаг өнгөрчихнө!

— Гайгүй, хаан минь, гайгүй гэж Демидов итгүүлэнгүй хэлээд, зам тавииа. Гол мөрөн байна. Хүсэл байвал юу нь холдох вэ. Юу нь удаан байх вэ. Бид ямар нэг өдөр амьдрах биш дээ. Харж л байгаарай хоёрхон жилийн дараа л Уралын ширэм, Уралын их буу, цөм бэлэн болно гэжээ.

Петр Демидовыг ширтэж Уралын тухай Никитийн бодлыг ойлгож байлаа. Демидовын хараа ч Петрээс салахгүй хааны үгийг хүлээж байв.

— За, Никита Демидович, таныхаар болог, зарлиг гаргая. Урал уруу яв. Сангаас мөнгө ав, хүмүүс ав, аа тэгээд таныг бурхан өршөөг. Сайхан мэдээрэй. Улсад үүнээс илүү чухал хэрэг байхгүй шүү. Хэрэг бүтээхгүй бол хайрлахгүй гэдгийг санаж яваарай гэжээ.

Сарын дараа шилдэг хүдэрчид зэвсгийн дархчуулыг авч Демидов Урал уруу явжээ.

Петр хаан энэ хооронд Брянск, Липецк болон бусад хотууд уруу хүмүүс явуулж Оросын олон нутагт төмөр ухаж завод байгуулах шийдвэр гарсан ажээ.



Хонх

— Данилыч аа, сүмийн хонхнуудыг хурааж авья гэж Петр хаан нэг удаа

Меншиковт хэлэхэд гайхахдаа нүд нь орой дээрээ гарчээ.

— Юугаа ширтсэн юм бэ? гэж Петр хашгираад, зэс, ширэм хэрэгтэй байна. Хонхоор их буу цутгана. Их буунд хэрэглэнэ. Ойлгов уу? гэжээ.

— Зүйтэй, хаан минь, зүйтэй гэж Меншиков амыг нь дагуулаад өөрөө хааны ярьж байгаа, тоглож байгаагийн алин болохыг үнэхээр мэдсэнгүй.

Петр хаан тоглоогүй байжээ. Төдөлгүй янз бүрийн нутагт цэрэг явж хааны зарлигийг биелүүлжээ.

Цэргүүд томоохон тосгон болох Лопасный Успенскийн сүмээр иржээ. Тэгэхдээ яг оройн харангын үеэр харанхуй бүрийд ирсэн юмсанжээ. Хонх өвлийн агаарт янз бүрээр жингэнэлдэн эгшиг хослуулан байжээ. Түрүүч хонхыг хуруу даран тоолж найм хүргэжээ.

Холын замд сульдсан морьдоо цэргүүд тэрэгнээс нь салгаж байх хоорондуур түрүүч сүмийн ширээт ламынд очиж учир явдлаа хэлэхэд их лам хөмсөг зангидан духаа атируулжээ. Гэвч түрүүчийг маш эелдэг угтаж:

— Албаны хүү минь ор, ор, цэргүүдээ дууд, замдаа даарч хөрсөн байлгүй гэжээ.

Цэргүүд эсгий гутлынхаа цасыг удаан арилгаж залбиран даа ламын гэрт маш болгоомжтой орцгоолоо.

Ширээт лам цэргийг хооллож ундлаад, дарс авчирч:

— За идэж ууцгаа хүүхдүүд минь гэжээ.

Цэргүүд улаан зээрд болтлоо уугаад унтжээ. Түрүүч өглөө босоод гадаа гарч хонх уруу харвал цорын ганцхан хонх санжигнаж байлаа.

Түрүүч ширээт лам дээр гүйн орж:

— Хонх хааччихаа вэ? Хонх хааш нь хийсэн бэ? гэж хашгирахад ширээг гараа алдалж:

— Манай сүм маш ядуу, тэгээд цорын ганцхан хонхтой гэхэд

— Яагаад нэг байдаг билээ! гэж түрүүч унтууцаад,

— Өчигдөр яг найм байхыг нүдээрээ харсан, бас тэгээд жингэнэлдэж байхыг сонссон гэвэл,

— Яалаа гэж дээ, албаны хүү минь, яалаа гэж! гэснээ ширээт лам гараа далласнаа,

— Чи дэмий юм боджээ! Согтуу нүдээр хараад л тийм харагдсан байлгүй гэжээ.

Тэднийг дарсаар зүгээр дайлаагүйг түрүүч ойлголоо. Түрүүч цэргээ цуглуулж бүх сүм, хонгилыг нь нэгжин үзвэл хонх газар доогуур орсон юм шиг алга болсон байлаа.

Түрүүч Москвад мэдэгдэнэ гэж заналхийлэхэд:

— Мэдэгд, мэдэгд, гэж ширээг лам хариулжээ.

Гэвч түрүүч бичсэнгүй. Чухам ямар хариу ирэхийг ойлгож байсан тул

Лопаснь тосгонд үлдэж эрэл хайгуул хийхээр шийджээ.

Цэргүүд тэнд хоёр гурван долоо хоног байж гудамж талбай, айл өрхөөр тэнэх авч “Хонх байсан л юм, хаачсаныг нь мэдэхгүй” гэхээс өөр хонхны талаар юу ч мэдсэнгүй.

Энэ үеэр Федька нэртэй жаал, түрүүчийг дагаж буу зэвсгийг нь оролдож дайны тухай элдвийн юм шалгааж салахаа байжээ. Түрүүчийн хонгиог авах гэж ноцолддог сүрхий сэргэлэн жаал байжээ.

— Битгий эрхлээд бай! Лам хонхоо хаана нуусныг олбол хонгио чинийх болно гэж түрүүч хэлжээ.

— Өгөх юм биз дээ?

— Өгнө.

Федька хоёр өдөр үзэгдэлгүй байгаад гурав дахь өдөр түрүүч дээр гүйн ирж:

— Оллоо гэж шивэгнэжээ.

— Нээрээ юу! гээд түрүүч итгэсэнгүй.

— Нээрээдээ, олсон! Алив хонгиогоо

— Үгүй, бид эхлээд явж үзнэ гэж түрүүч хэлжээ.

Федька түрүүчийг дагуулан тосгоноос гарч голын эргээр өөрөө хийсэн цанаар гулгахад түрүүч арай ядан гүйцнэ. Федька цанатай болохоор амархан явж байлаа. Харин түрүүч бүсэлхийгээ хүртэл цасанд шигдэж хөлөрнө.

— Яв, яв ахаа, одоо удахгүй! гэж Федька зориг оруулна.

Тэд тосгоноос гурван бээр гүйж, эгц эрэгнээс мөс уруу буулаа.

— За, энд гэж Федька хэлбэл түрүүч цооног байхыг харлаа. Тэгээд зэрэгцээ хэдэн цооног байхыг тоолбол долоон цооног байлаа. Цооног бүрээс мөсөн дээр хөлдсөн олсны үзүүр

гарсан байлаа. Даа лам хонхоо мөсөн дор усанд нуусныг түрүүч ойлголоо. Тэгээд түрүүч баярлаж Федькад хонгиогоо өгөөд тосгон уруу буцаад л харайлгажээ.

Түрүүч, цэргүүдээ морьдоо хөллө гэж тушаагаад, өөрөө ширээт лам дээр очиж:

— Ламтан минь уучлаарай. Би тэгэхэд согтуу нүдээр л харсан нь зайлшгүй. Бид өнөөдөр Лопаснь тосгоноос явлаа. Та битгий уурлаарай. Бидний төлөө бурханд залбираарай! гэхэд,

— Замдаа сайн яваарай гээд ширээт лам инээмсэглэснээ, албаны хүүхэд минь сайн яваарай, залбиралгүй яах вэ? заавал залбирна гэлээ.

Маргааш нь ширээт лам тосгоныхоо иргэдийг цуглуулж:

— За нэг ангижирлаа. Гай ч зайллаа гэжээ..

Тосгоныхон хонхоо авахаар гол дээр очиж цооног уруугаа өнгийвөл хоосон байжээ.

— Бурхан шажнаа мартсан тамын эзэд!. Аваад явчихаж! Хонх алга байна гэж ламтан чарлажээ.

Голын дээгүүрх хүйтэн салхи ламын занчийг нэвт исгэрч тариачин эрсийн сахлыг илж цаашлах тусмаа эгц өндөр эргийг мөргөн тулна.

Өвс, сүрэл

Оросууд сургууль муутай цэргээр шведийн эсрэг дайтаж чадахгүйг Нарвын дараа ойлгожээ. Тэгээд Петр хаан байнгын армитай болохоор шийджээ. Дайнгүй байгаа дээр цэргүүд зэр зэвсэг эзэмшин сурч дэг горим, сахилга батанд дасаг гэж боджээ.

Нэг өдөр Петр хаан цэргийн байрны хажуугаар явж байжээ. Цэргүүд жагсчихсан эгнээгээр явган сургууль хийж байжээ. Хажууд нь залуухан дарга командална. Петр командыг чагнавал ер бишийн сонин команд дуулдана.

— Өвс, сүрэл! Өвс, сүрэл! гэж дарга хашгирна.

«Юу болж байгаа нь энэ вэ?» гэж Петр бодож мориныхоо амыг татаад харвал цэргийн хөлөнд ямар нэг юм багласан байхыг лавшруулбал: зүүн хөлд өвс, баруун хөлд сүрэл багласан ажээ. Дарга Петрийг харж:

— Номхон! гэж хашгирчээ.

Цэргүүд нам жим болоход дэслэгч хаан уруу гүйн очиж:

— Ноён их бууны ахмад аа! сумангийн дарга Вяземский явган сургууль хийлгэж байна! гэж илтгэжээ .

— Болноо! гэж Петр командлав.

Хаан Вяземскийг таашаажээ. Петр өвс, сүрлийн нь төлөө уурлах гэснээ больж:

— Цэргүүдийнхээ хөлд ямар новшоо багласан юм бэ? гэж Вяземскийгээс асуухад:

— Новш бишээ, нөхөр их бууны ахмад аа! гэж дарга хариулжээ.

— Яагаад новш биш байдаг билээ! Цэргээ шившиглэж, дүрмээ мэддэггүй юм уу гэж Петр няцаахад:

— Шившиглэсэн юм биш. Цэргүүдийн сурахад амар байгаа юм. Нөхөр их бууны ахмадаа, харанхуйд баруун зүүн хөлөө юу ч ялгахгүй байна. За тэгээд хөдөөнийхөн өвс сүрлээ хэзээ ч андуурдаггүй юм гэжээ.

Хаан даргын бодлын мэргэнийг гайхаж, инээмсэглэжээ. Петр энэ өдрөөс хойш удалгүй жагсаал хүлээн авчээ. Хамгийн сүүлчийн суман бусдаас илүү сайн байжээ.

— Дарга нь хэн бэ? гэж Петр генералаасаа асуувал:

— Дэслэгч Вяземский гэж генерал хариулжээ.

Ноёдын сахлыг хуссан нь

Москвад Буйносоз, Курносов гэдэг хоёр ноён байдаг байжээ. Тэд эрт дээр үеийн удам угсаатай, гэр байшиндаа эд агуурс нь багтаж ядсан бөгөөд тус бүр хэдэн мянган хамжлагат тариачидтай юмсанжээ. Гэвч тэдгээр ноёд юм бүхнээс илүү сахлаараа бахархдаг байжээ. Сахал нь их сэгсгэр ажээ. Буйносовын сахал хүрз шиг өргөн бол Курносовынх адууны сүүл шиг урт ажээ.

Тэгтэл сахлаа хус гэсэн хааны зарлиг гарчээ. Петр хааны үед сахлаа хусах, харь нутгийн хийцтэй хувцас өмсөж, кофе цай уух, тамхи татах зэрэг олон янзын шинэ журам орос оронд тогтсон билээ.

Хааны шинэ зарлигийг дуулсан Буйносоз, Курносов хоёр санаа алдан ёхолжээ. Тэгээд хоёулаа сахлаа авахгүйгээр тохиролцож хааны нүдэнд өртөхгүйн тулд өвдсөн болж баашлахаар шийджээ.

Төдөлгүй хаан өөрөө тэднийг санаж дуудуулжээ. Ноёд хэн нь түрүүлж очих талаар маргалдаж:

— Чи оч гэж Буйносоз хэлэхэд,

— Үгүй, чи оч гэж Курносов хариулжээ. Чингээд шавга хаятал Буйносоз явах болжээ. Ноён хааныд очиж хөлд нь сөхөрч:

— Эзэн хаан минь намайг битгий баллаач, насан дээр болсон хойно минь битгий шившиглээч гэж гуйсаар шалан дээгүүр мөлхөж хааны гарыг авч үнсэхийг хичээжээ.

— Бос! гэж хаан хашгираад,

— Ноёд сахалтайдаа биш тархиндаа ухаантай байх ёстой гэжээ. Буйносоз сөхөрсөн хэвээр: «Битгий шившиглээч гэгээнтэн минь». гэж гуйсаар байлаа. Тэгтэл Петр хаан уурсан зарц бараа бологчдоо дуудан ноёны сахлыг хүчээр авахыг тушаажээ.

Буйносоз, Курносов дээр нүцгэн эрүүгээ атгасаар нус нулимс болон ирж олигтой ч юм ярьж чадсангүй гэнээ.

Курносов хаан дээр очих аймшигтай санагдсан тул Меншиков дээр очиж зөвлөлгөө ивээл гуйжээ:

— Александр Данилыч минь хаантай ярьж туслаач гэж Курносов гуйжээ. Меншиков Петр хаантай яаж яриа эхэлье дээ гэж удаан бодсоны эцсэд ингэж ярьжээ:

— Эзэн хаантан минь хэрвээ ноёдын сахлын оронд төлөөс авбал яасан юм бэ? Бага ч гэсэн сан аривжиг гэжээ.

Үнэндээ сангийн мөнгө маш бага байсан учир Петр хаан хэсэг зуур бодсоноо зөвшөөрчээ.

Курносов ихэд баярлан гүйж мөнгийг төлөөд «мөнгө төлсөн» гэсэн үсэгтэй зэс товруу авч түүнийгээ загалмай тэмдэг шигээ л хүзүүндээ зүүж явдаг болжээ. Тэгээд сахлаа яагаад хусаагүй вэ гэж хэн хүн зогсоож асуувал сахлаа сөхөж нөгөөх товруугаа үзүүлдэг байжээ.

Одоо Курносов бүр ч их ихэмсэг болсон нь шал дэмий байжээ. Жил өнгөрөхөд шинэ төлөөсийг авахаар татвар хураагчид Курносовынд иржээ.

— Юу гэсэн үг вэ! гэж Курносов унтууцахад,

— Өө энэ товрууны чинь хугацаа дуусчихсан. Шинэ татвараа төл гэж татвар хураагчид хэлжээ. Курносов дахин төлөх хэрэгтэй болжээ. Жилийн дараа дахиад л төлжээ. Ингэхэд Курносов ухаарч хэрвээ энэ чигээрээ байвал хамаг хөрөнгөө өгөөд юу ч үлдэхгүй ганцхан сахалтайгаа үлдэх нь гэдгийг сэхээрчээ.

Тэгээд татвар хураагчид гурав дахь удаагаа ирэхэд Курносов сахлаа хусчихсан, хачин ууртай харцаар мөнгө хураагчдыг ширтэн сууж байжээ.

Меншиков маргааш нь Курносовын сахлын талаар хаанд ярихад Петр зөндөө хөхөрч:

— Тэнэгүүд тэгэх л хэрэгтэй байсан юм, яахав шинэ дэглэмд дасаж л байг. Харин мөнгөний тухайд гэвэл Данилыч та мөн ухаалаг бодсон байна лээ шүү. Ганцхан Курносовын сахлаас бүхэл бүтэн дивизийг хувцаслах хөрөнгө олсон шүү гэжээ.



Залуу ноёд гадаадад юу сурав аа

Буйносов, Курносов хоёр хааны түрүүчийн гоморхлоо мартаагүй байтал шинэ зарлиг гарчээ. Петр хаан хамгийн нэр цуутай ноёдын тавин хөвгүүдийг гадаадад сургахаар цутлуулжээ. Буйносов. Курносов хоёр хөвгүүдээ явуулах хэрэгтэй болжээ.

Ноёдын гэрт бөөн уйлаан хашгираан болжээ Ахайтан нар гүйлдэж хүмүүс үймэлдэн бужигнаж үдэлт биш яг л уй гашуу дайрсан мэт байжээ.

Буйносовын эхнэр зөрж:

— Ганц хүүгээ хааш нь явуулж байгааг бурхан л мэдэж байгаа байх, харь нутагт чөтгөрийн шүдэнд, немецийн аманд өгөх гэж үү! Явуулахгүй! хүүгээ өгөхгүй! гэж хашгирна.

— Хош! гэж Буйносов эхнэрээ зандраад тэнэг минь, эзэн хааны зарлиг! Сибирыг цөлөгдөх гээ юу? эсвэл дүүжлүүлэх гээ юу? гэнэ.

Курносовын гэрт ч үүнээс багагүй хашгиралдаан болж байлаа. Курносов ч эхнэрээ зандран:

— Тэнэг минь! ташуураар гутал улаж болдоггүйн адил хааны үгийг зөрөөд хол явахгүй! Тэвч, хөгшин минь гэжээ.

Жилийн дараа залуу ноёд нутаг орондоо эргэж ирэхэд хаан тэднийг төрийн албанд тохоон томилохоор дууджээ.

— За Буйносов ноёны хүү хилийн цаана хэрхэн яаж амьдарч байснаа ярь гэж Петр шаардахад,

— Сайн л сууж байлаа, хаан минь гэж Буйносов хариулаад,

— Тэд бие биенийхээ сахлаас зууралдахаас буцдаггүй, манай тариачдыг бодвол эелдэг, нөхөрсөг улс юм гэхэд

— За тэгээд юу сурав даа?

— Хаантаан их юм сурсан. «Аав» гэхийн оронд «фаттер», «ээж» гэхийн оронд «муттер» гэж ярьж сурлаа.

— За тэгээд өөр юу сурав? гэж Петр лавшруулбал,

— Хаантан, хоёр гурвантаа мэхийн ёслохыг сурсан, бүжиг, тэнгисийн тэртээх тоглоом тоглож сурлаа гэхэд

— За чамайг их юманд сургажээ. За тэгээд гадаад улс ямар шүү санагдав даа? гэж Петр асуувал

— Хаантан! ихэд таашагдлаа, элчингийн чингорилоном, харь нутагт суухад бахтай байна гэжээ.

— За чи юу яримаар байна? гэж Петр залуу Курносовоос асуухад

— Хаантан юугаа ярьдаг билээ... Асуу л даа

— Тэгье л дээ. Курносов ноёны хүү, бэхлэлт гэж юу юм бэ, хэлээтэх

— Хаантан, бэхлэлт гэж дайснаас цэргээ нуух зорилготой цэргийн шинжлэх ухаан гэж Курносов хариулжээ.

— Зүйтэй байна. Далай тэнгисийн тэмдэглэл гэж юу байдаг юм бэ? гэвэл

— Хаантан, далай тэнгисийн тэмдэглэл гэж гол тэнгисийн хайрдлага, гүн, салхины чиглэл урсгал зэрэг хөлөг онгоцны замд саад болох бүхнийг тэмдэглэсэн тэмдэглэлийг хэлдэг. Тэнгисийн аяллын хүн хамгийн түрүүнд далай тэнгисийн тэмдэглэлийг мэдсэн байх ёстой гэжээ.

— Маш хичээлтэй байна гэж Петр дахин хэлснээ,

— Өөр юу сурсан бэ? гэж асуувал

— Өө янз бүрийн л юм харлаа, хаантан минь гэж Курносов хариулаад, хөлөг онгоц яаж барьдаг, уул уурхайн ажил ямар байдаг, өвчнийг яаж эмчилдэг зэргийг харлаа. Герман, голландуудад баярлах л байна. Юм мэддэг сайн ард түмэн юм. Хаантан, харин бид өөрийнхөө, оросынхоо юмыг муулах юм алга гэж бодож байна. Манай орон ч тэднээс муугүй, орос хүмүүс ч муугүй, эд агуурс ч бага биш шүү дээ гэжээ.

— Сайн байна гэж Петр хэлээд, залуу Курносовыг барьж үнсэж элдвээр магтав. Тэгээд Буйносов уруу хандаж,

— За чи тэнэг амьтан байсан бололтой, тэр чигээрээ хоцорчээ. Бас тэгээд гадаад улсад явах санаатай! Чамд орос орон эрхэм биш байх шив дээ. Миний нүдэнд харагдахгүй зайл! гэжээ.

Ийнхүү залуу Буйносов сураггүй алга болж, Курносов төдөлгүй төрийн том хүн болсон гэдэг.

Ном сургасан нь

Тэр үед орос оронд бичигтэй хүн цөөн байжээ. Хүүхдийг аль нэг сүмд юм уу, заримдаа баян чинээлэг айл гэрийн багш урьж сургадаг байжээ.

Петр хааны үед сургууль нээгдэж эхэлжээ. Тэдгээрийг тоолж сурах сургууль гэдэг байлаа. Сургуульд хэл бичиг, тоо, газарзүй заадаг байжээ.

Москва, Тула хот хоёрын тэг дунд байдаг Серпухов хотод ч сургууль нээж багш очжээ.

Багш сургууль дээрээ очиж шавь нараа хүлээнэ. Нэг өдөр, хоёр, гурван өдөр хүлээсэн боловч хэн ч ирсэнгүй.

Тэгэхээр багш айл гэрээр явж учир явдлыг тайлбарлахаар шийдэж нутгийн худалдаачин нэг айлд орж эзнийг дуудан:

— Яагаад хүү чинь сургуульд явахгүй байгаа юм бэ? гэж асуужээ.

— Хүү тэнд очоод юу хийх юм бэ! гэж худалдаачин хариулаад, бид бичиггүй болоод л байсан, энэ ч бичиггүй болно. Сургуульд сурвал албин шүглэнэ гэжээ. Багш хоёр дахь айл гуталчныд орвол:

— Сургууль гэдэг чинь бидний ухаан хүрэх ажил биш! гэж гуталчин хариулаад, —Бидний ажил бол гутал тахлах ажил. Элдвийн донгосох юм сонсож цагаа дэмий үрээд яах вэ! гэжээ.

Тэгэхээр нь багш Серпухов мужийн ноёныд очиж уул явдлыг яривал мужийн ноён дэмий л гараа тэлж:

— Эцэг нь явуулахгүй гэж байгаа бол би яах юм бэ? Нэг нь бичиг сурдаг байхад нөгөөд нь бичиг хэрэггүй байж болно шүү дээ гэжээ. Багш ноён уруу ширтэж ямар ч туслалцаа үзүүлэхгүй нь гэдгийг ойлгон уурлаж:

— Тийм юм бол эзэн хаанд би бичлээ шүү гэв.

Мужийн ноён багшийг харвал маш шийдэмгий байгааг бодвол багш хэлснээ биелүүлэх нь гэж ойлгов.

— За битгий яар, сургууль дээрээ оч гэж мужийн ноён хэлжээ.

Багш сургууль дээрээ очоод хүлээж байтал удалгүй гадаа хөлийн чимээ гарахад харвал буутай цэрэг хүүхэд туугаад ирж явжээ.

Хүүхдийг долоо хоног цэрэг дагажээ. Тэгээд эцгүүд эвлэрч дассан бололтой чимээгүй болов. Хүүхдүүд ч өөрсдөө сургууль уруугаа гүйдэг болжээ.

Багш тэднийг хэл бичигт сургах ажлаас эхэлж

— А гэж багш хэлэхэд

— А гэж хүүхэд нэгэн зэрэг давтана.

— Б гэж багш хэлэхэд

— Б гэж хүүхэд давтана. Дараа нь тоо заажээ.

— Нэг дээр нэмэх нь нэг хоёр болно гэж Багш хэлэхэд

— Нэг дээр нэгийг нэмбэл хоёр болно гэж шавь нар нь давтав. Төдөлгүй хүүхэд үсэг бичиж тоо нэмж сурчээ. Бас Каспийн далай. Хар тэнгис, Балтийн тэнгис хаана байдгийг мэдэж өөр олон зүйл сурчээ.

Нэгэн удаа Петр хаан Серпуховоор дамжин Тула уруу явжээ. Тэгээд Серпуховт хоноглож, өглөө нь сургуулиар орохоор шийджээ. Эцгүүд хүүхдээ сургуульд дургүй өгдгийг Петр сонссоор байжээ. Тэгээд үнэн худлыг шалгахаар шийдэж танхимд орвол пиг дүүрэн хүүхэд байжээ. Петр хаан гайхаж яаж ийм олон шавь цуглуулсан тухай багшаас асуувал, багш болсон бүх явдлыг ярьж гэнээ

— Зүйтэй! Мужийн ноён сайн байна. Бид ингэх л ёстой байсан юм. Бусад нутгийн сургуулийг хүүхдээ ингэж хүчээр аваач гэж хэлье байз. Манай хүмүүсийн ухаан ч мөн хомс байна даа, өөрийнхөө ашгийг ойлгохгүй, төрийн хэргийн төлөө санаа зовохгүй юм. Бичигтэн хүн бидэнд үгүй мөн хэрэгтэй байна даа! Хүмүүс маань юм мэдэхгүй бол Орос орон сүйрнэ гэсэн үг гэж хэлээд инээжээ.



Бага юманд баярлавал их үйлс бүтнэ

Бид өөрийнхөө сонинтой болох юмсан гэж Петр хаан шадар хүмүүстээ нэг биш удаа ярьж, — Сонинтой болбол худалдаачид ч, ноёдод ч иргэдэд ч цөмд нь тустай гэдэг байжээ.

Тэгээд Петр харшнаасаа алга болчихоод бүр орой болтол ирсэнгүй. Ордныхон хаанд ямар нэг муу юм болоогүй байгаа гэж санааширчээ.

Петр хэвлэлийн мастер Федор Поликарповтой хамт оросын анхны сонинд орох зүйлийг шилж сонгож явсан юмсанжээ.

Хамрынхаа үзүүр дээр нүднийхээ шилийг тогтоож ядсан өндөр, туранхай

Поликарпов хааны өмнө цэрэг шиг номхон зогсож:

— Хаантан, Урал, Верхотурскийн дархчуул цөөн биш их буу цутгалаа гэж тэндээс мэдээлсэн байна.

— Бич бич, Нарвын дэргэдэх хохирол юу ч биш, хүсвэл юу ч хийж болдгийг цөмөөрөө мэдэг гэж Петр ярина.

— Хаантан, Москвад хонхны ширмээр дөрвөн зуун их буу цутгалаа гэж мэдээлжээ хэмээн Поликарпов үргэлжлүүлэн ярихад:

— Үүнийгээ ч бич. Петр хаан сүмийн хонхыг дэмий хураагаагүй байна гэдгийг мэдэг.

— Заводын эрчүүд үймээн дэгдээж, одоо ноёд худалдаачид амар заяа үзэхгүй байгаа тухай Невьянскаас Никита Демидов бичиж гэвэл:

— Үүнийг битгий бич. Тэр эрчүүдийг залхаахаар цэрэг явуулсан нь дээр гэж Петр тушаан хэлжээ.

— Хаантан, багагүй их нефть, зэсний хүдэр оллоо гэж Казаниас бичсэн байна хэмээн Поликарпов яриагаа үргэлжлүүлэхэд:

— Тэрнийгээ ч бич, Орос орон тоолж баршгүй, ширгэшгүй их баялагтай юм байна гэдгийг мэдэж аваг гэж ярилцана.

Петр хаан чагнан сууж байснаа цаас авч хэвлэх зүйл дээр улаанаар ольдос тавьж хэрэггүй зүйлийг хойш болгоно.

Поликарпов шинэ шинэ мэдээ илтгэсээр байлаа. Үүнд: Энэтхэгийн хаан Москвагийн хаанд заан явуулсан тухай, Москвад сарын дотор гурван зуун наян зургаан эрэгтэй эмэгтэй хүүхэд төрсөн тухай зэрэг бас бус олон зүйл байлаа.

— Федор, бас сургуулийн тухай бич, сургуулийн ашиг тусыг цөмөөрөө мэдвэл бас сайнсан

гэж Петр ярилаа.

Хэдэн өдрийн дараа сониноо хэвлэн гаргаж «Ведомость» гэж нэрлэжээ. Сонин боровтор цаасан дээр маш жижиг үсгээр бараг захгүй шахам жижигхэн болсон ажээ. Харахад сонин л байв. Петр хаан анхныхаа сонинд маш сэтгэл хангалуун ажээ. «Ведомость» сониноо шүүрч аваад харшин дотуураа гүйж тааралдсан болгондоо үзүүлэн:

— Хараач оросын, өөрийн анхны сонин! гэдэг байв.

Петр Головин вантай уулзжээ. Головин ван гадаадад явсан, харь хэл мэддэг, өөрийгөө мэдлэгтэй хүн гэдэг байжээ. Тэгээд Головин сонинг хараад хямсаганаж:

— Хаантан, сонин ч гэж дээ! Харин би германы Гамбург хотод ёстой л сонин харсандаа! гэхэд Петр хааны нүүрэнд байсан баяр баясгалан арчсан мэт алга болж барайн хөмсөг зангидаж:

— Иш, чи мөн ярив аа! Боддог газраараа бодсонгүй бас тэгээд

Головин (голова—толгой гэсэн үгнээс үүсэлтэй нэр) нэртэй! Ван хэргэмтэй!

«Германы Гамбург хотод гэнэ шүү!» Мөн гайхуулах юмаа олжээ. Харийн юм болгон л сайн байгаа биз дээ. Харийн юм сайн гэдгийг өөрөө мэдэж байна. Тэднийхийг ч аваад үзье, тэр бүр тийм сайн байгаагүй шүү. Хугацаа л өг. Бага ч гэсэн баярлаж байвал их үйлс бүтнэ гэсэн гэдэг.

Данилын тухай

Данилыг тойрог даяараа ухаантай хүн гэдэг байлаа. Аливаа нэг хэргийн талаар өөрийн ойлголттой хүн байжээ.

Нарвг ялагдсаны дараа тэдний тосгонд хаан Карл, Петр хаан цэрэг байлдааны ажиллагааны тухай янз бүрийн яриа гарчээ.

— Швед маш хүчтэй байна, бидэнтэй дүйцэх юм алга. Бидэнд тэнгис ямар хэрэгтэй юм бэ. Тэнгисгүй амьдраад байсан, амьдрах л болно гэж тариачид ярьдаг байлаа.

— Худлаа л ярьж байна даа. Швед хүчтэйдээ биш, бид сул байна. Тэнгисийн талаар ч бас буруу байна. Орос орон тэнгисгүй байж болохгүй. Загас барих, худалдаа арилжаа хийх зэрэг олон зүйлд тэнгис хэрэгтэй гэж Данил ярьдаг байжээ.

Тэгээд сүмийн хонхыг авахад тосгонд дахиад хэдэн өдөр шуугиан дэгджээ.

— Хорвоо өнгөрлөө гэж гэлэн орилж үсээ зулгаана. Авгайчуул уйлан залбирч, эрэгтэйчүүд уруу царайлан явна. Цөмөөрөө л гай түүтгэр болно гэлцэнэ. Харин Данил тийм биш, өөрийнхөөрөө ажээ.

— Ингэх л хэрэгтэй. Хонхноос улсын ашиг эрхэм шүү дээ. Бурхан тэнгэр ийм хэргийг зэмлэхгүй гэдэг байлаа.

Ноёд дээдэс Данилыг:

— Бурхан номоо мартсан амьтан! гэж нэрлээд, тэр цагаас хойш ихэд

хорсон хилэгнэдэг болжээ.

Төдөлгүй Петр шинэ татвар гаргажээ. Тариачид гаслан сангийн хөрөнгөнд эцсийнхээ зоосыг өгч бүсээ улам чангалдаг болжээ.

— За хааны шинэ журам чамд ямар санагдаж байна даа? Дахиад л зөв үү? гэж тариачид Данилаас асуухад:

— Үгүй, ер нь хаантай би юм болгонд биш ерөнхийдөө тохирч байдаг гэвэл:

— Хараач! Хаантай тохирдог гэнэ шүү! Мөн нөхрөө олж нөхөрлөжээ.

Хаан чамайг харах ч үгүй өнгөрнө дөө гэж тариачид хорыг нь мааждаг байв.

— Харахгүй бол харахгүй байг. Өөрийнхөө ухаанаар бодохыг хориглоогүй шүү дээ гэж Данил хариулаад, улсынхаа алдрыг мандуулж байгаад нь Петр хаанд баярлах л байна. Харин тариачин олны арьсыг хэдэнтээ хуулж байгаагаа хариуцах цаг ирнэ дээ гэдэг байлаа.

Тариачид Данилын үгийг зөвшөөрч толгой дохино. Хэн нэг нь:

— Харин чи хаанд өөрт нь үүнийгээ хэл! гэж хашгирахад,

— Яадаг юм бэ хэлнэ хэмээн Данил хариулжээ.

Тэгээд ч хэлсэн юмсанжээ. Гагцхүү уул явдал шууд болсонгүй ийнхүү болжээ.

Даниловын хэлсэн үгийн талаар лам ч юм уу, өөр хэн нэг нь засагт ховложээ. Тосгонд цэргүүд ирж Данилыг хүлж ван Ромодановский дарга дээр Москвад аваачжээ.

Данилын гарыг хүлээд эрүүдэж гарчээ.

— Эзэн хааны тухай юу гэж ярьсан бэ, хэн цэцэрхсэн бэ? гэж ван

Ромодановский байцаана.

— Хэлсэн үгийг минь салхи аваад явчихсан гэж Данил хариулбал:

— Юу гэнээ? хэмээн Ромодановский хашгираад:

— Энэ үгний чинь төлөө самуун дэгдээгч чамайг гадсан дээр суулгана даа гэхэд:

— Суулга гэж Данил хариулаад, —Тариачид хаа ч байсан ялгаагүй биш үү. Харин ноёдын ажилд зоогоо авснаас гадсан дээр суусан ч шулуухан байж магадгүй гэжээ.

Ромодановский ван хорсон хилэгнэж улайссан халуун саваа—гаар Данилын нүцгэн бие дээгүүр хайрахад Данил тэнхээ алдаж далдуу мэт унжийлаа.

Энэ үеэр пинд Петр хаан орж ирээд:

— Ямар хүнийг ингэж цоройлгоо вэ? гэхэд:

— Самуун дэгдээгч гэж Ромодановский ван хариулаад, —Засаг төрийн эсрэг, муу ам гаргасан байна гэлээ.

Петр Данил дээр очиход арай ядан нүдээ нээн харвал өмнө нь хаан өөрөө зогсож байжээ. Тэгэхээр нь Данил байдаг хүчээ гаргаж:

— Ээ, хаантан та агуу их хэрэг үүсгэжээ. Гэвч жирийн олон түмэн амьдарч чадахаа байлаа. Ард түмний бүх шим шүлтийг их замын дээрэмчин шиг л цөлөмжээ. Хаантан минь ард түмэн ийм хэргийг хэзээ ч мартахгүй, сайн үгээр дурсан ярихгүй л байх гэж хэлжээ.

Тэгээд Данил дахин нүдээ аньж тэргүүнээ үслэг цээж уруугаа унжуулав. Харин Петр хааны дотроос юм хайрах шиг болж толгойгоо баруун зүүн тийш нь хаялан ууртай харцаа Данил дээр тусгаж:

— Дүүжил! гэж хатгуулсан мэт орилоод пингээс гарчээ.

Тэнгисийн дэргэдэх хот

Төдөлгүй Петр хаан Шведтэй шинэ дайн эхэлжээ. Оросын цэрэг анхныхаа ялалтыг хийж Нева мөрөн цутгадаг финийн булан уруу иржээ.

Нева мөрний эрэг хов хоосон бөгөөд ой мод, нэвтэршгүй намгаас өөр юмгүй ажээ. Явахад ч хэцүү, амьдарч суух газар ч байхгүй боловч тэнгистэй залгаа учир чухал газар байлаа.

Петр Меншиковыг авч хэдэн өдрийн дараа завинд сууж тэнгис уруу явжээ. Нева мөрний тэнгист цутгадаг тэр газар арал байдаг байжээ. Петр завинаасаа бууж арал дундуур алхална. Уул арал гонзгой урт бөгөөд алга шиг тэгш ажээ. Тургир бут ёрдойн хөлийн дор хөвд чийг хөвсөлзөнө.

— Хаантан, үгүй мөн нутгаа! гэж Меншиков хэлэхэд:

— Ямар нутгаа, нутаг шиг л нутаг байна. Тэнгис бол чухал газар хэмээн

Петр хариулжээ.

Тэгээд цааш явцгаатал Меншиков гэнэт өвдгөө тултал намагт шигджээ. Хөлөө угзраад дөрвөн хөллөж хуурай газар мөлхөн гарчээ. Нил шавартай зууралдаад босоод харвал өрөөсөн гутал нь алга байжээ.

— Ээ Алексашка минь, ээ ямар болчихоо вэ! гээд хаан хөхрөв.

— За мөн муухай газар юм даа! гэж Меншиков гоморхонгуй хэлээд, — Хаантан буцаад явья, энэ намгийг хэмжээд юу хийх вэ.

— Яагаад буцдаг билээ урагшаа явна, Данилыч. Хай бид эзэмшихээр ирсэн болохоос биш зочид биш шүү дээ гээд Петр цааш тэнгис уруу алхжээ.

Меншиков дуртай дургүй хойноос нь гэлдэрчээ.

— За харлаа гэж Петр Меншиковт хэлээд, — Ямар ч амьдрал алга гэсэн бил үү, энэ чинь амьдрал биш үү? гэлээ.

Петр сондуул дээр очиж буты нь болгоомжтой ярвал шувууны үүр байхыг

Меншиков харлаа. Үүрэнд суугаа шувуу тэр хоёр хүнийг гайхан харж ниссэнгүй.

— Хүүш чи яасан зоригтой юм бэ! гэж Меншиков хэллээ. Тэгтэл шувуу гэнэт далавчаа дэлгэж нисээд бутыг тойрон эргэлдэв.

Тийнхүү Петр, Меншиков хоёр явсаар тэнгист хүрчээ. Уйтгарт хар тэнгис тэмээний бөх шиг махир гүдгэр долгиогоо эрэг уруу цацаж, эргийн хайргыг дэлдэнэ.

Петр хаан мөрөө хаялан зогсож цээж дүүрэн амьсгална. Тэнгисийн салхи дээлийн хормойг дэрвүүлж нэг улаанаар нь, нэг ногооноор нь эргүүлнэ. Петр алсыг ширтэнэ. Тэнд хэдэн зуун бээрийн тэртээ умартад өөр эрэг, өөр орон байлаа.

Меншиков чулуу сандайлан сууж хувцсаа солино.

— Данилыч! гэж Петр дуудлаа.

Петр тийм аяархан хэлсэн юм уу, эсвэл Меншиков дуулаагүй дүр үзүүлсэн юм уу, хариу дуугарсангүй.

— Данилыч! гэж Петр дахиад л хэллээ. Меншиков болгоомжиллоо.

— Энд тэнгисийн дэргэд гээд гараараа тойруулан зааснаа:

— Энд тэнгисийн дэргэд хот барина гэж давган хэллээ. Үүнийг дуулаад

Меншиков гартаа байсан гутлыг алдаж:

— Хот гэнээ? Энд энэ намаг дотор хот барих хэрэг үү? гэлээ.

— Тиймээ, гэж Петр хэлээд эрэг даган алхлаа.

Харин Меншиков холдож яваа Петрийн барааг ганхан бишрэн ширтэж гутлаа барьсаар зогсоно.

Шинэ хотыг бариулахын тулд Нева мөрөн дээр Орос орны өнцөг булан бүрээс шилдэг уран дархчуул, мужаан, өрлөгчин, нарийн мужаан болон жирийн тариачдыг цуглуулжээ.

Бяцхан хүү Никита эцэг Силанггий Дымовын хамт шинэ хотыг барилцахаар ирсэн юмсанжээ. Дымов бусад ажилчдын адил чийгтэй газар гэрт суух болжээ. Никита хүү эцэгтэйгээ хамт нэг ханзан дээр байрлажээ.

Өглөөний дөрвөн цагт их буу тавих нь ажилчдыг босгох дохио бөгөөд ажилчидтай хамт Никитагийн эцэг босно. Ажилчид өдөржингөө намаг дотор шавартай зууралдан ухна. Тэд суваг ухаж, ой мод хяргаж хүнд хүнд дүнг зөөнө. Тэгээд харанхуй бүрий болсон хойно гэртээ буцаж ирдэг байлаа.

Тэд ядарчихсан ирэх бөгөөд зуухны дэргэд хөлийн нойтон ороолтоо өлгөж уранхай цооронхой гутал бээлийгээ өрж, хоосон ногооны шөл оочоод ханзан дээрээ хэвтэж өглөө болтол үхсэн юм шиг унтана.

Тэгээд үүр тэмтрэхтэй зэрэг дахиад л их буу нижигнэнээ. Никитка

өдөржингөө ганцаараа байх бөгөөд эргэн тойрны олон улс, харанхуй бүдүүлэг цэргүүд, хажууд байгаа тэнгис цөм түүнд сонин байдаг байлаа. Никита хэзээ ч ийм их ус үзээгүй билээ. Тэр усыг харахад ч аймшигтай ажээ. Никита усан зогсоол уруу гүйн очиж хөлөг

онгоцыг шагширна. Хот дундуур тэнэж ой модыг хэрхэн чавчиж хөрөөдөж чөлөө гаргаад түүний дагуу байшин барьж байгааг харна.

Никита хүүд ажилчид дасчээ. Ажилчид түүнийг хараад гэр бүлээ дурсана. Цөмөөрөө Никитад хайртай болж «Никитка ус аваад ир» гэж гуйна Никитка гүйнэ. «Никитка цэргийн тамхийг яаж авснаа яриач» гэхэд Никита ярина.

Никита хүү намар болтол ийнхүү хөгжөөнтэй байлаа. Тэгтэл намар болж бороо цутгаж эхэллээ. Никита өдөржингөө газар гэртээ уйтгарлан суудаг байв. Газар гэрт өвдгөөр ус татна. Никитад маш уйтгартай ажээ.

Тэгэхээр нь Силантий хүүдээ модоор буутай цэргэн тоглоом хийж өгөхөд

Никитка хөгжөөнтэй болжээ.

— Босоод! гэж команд өгөхөд цэрэг нүдээ ч чавчихгүй зогсоно.

— Хэвтээд! гэж Никита хашгираад, өөрөө цэргээ гараараа сэмхэн түлхэнэ.

Никитаг ийнхүү тоглох хооронд усны төвшин ихэснэ. Тэгэхээр усыг гудамж уруу зөөж, зөөж амрах хооронд дахиад л их болно. Уйлсан ч тус болохгүй ажээ!

Төдөлгүй хотод өлсгөлөн болжээ. Намрынхаа хүнсийг бэлтгээгүйгээс гадна зам харгуй дэвтэн шавхайрчээ. Өвчин гарч хүмүүс ялаа шиг үхэж байлаа.

Никиткагийн ээлж болж өвчин тусчээ. Эцэг нь нэг өдөр ажлаасаа иртэл хүү нь халуурсан, банзан дээрээ хөрвөж уух юм гуйна.

Силантий шөнөжингөө хүүгээсээ холдсонгүй. Өглөө ч ажилдаа явсангүй. Тэгтэл өдөр газар гэрт нь цэрэг дагуулсан дарга ирж:

— Ёс горим мэддэггүй юм уу? гэж Силантийг дарга загнахад

— Хүү минь энд өвчтэй... үхэх гэж байна... гэжээ.

Гэвч дарга өвгөний үгийг сонссонгүй тушаал өгч Силантийгийн гарыг мушгиж ажилд нь хөөн аваачжээ. Тэгээд ажлаасаа ирэхэд нь Никиткагийн бие хөрчихсөн байжээ.

— Никитка минь! гэж Силантай хүүгээ сэгсэрнэ.

Никита хөдөлгөөнгүй хэвтэх бөгөөд хажууд нь буутай цэргэн тоглоом хэвтэнэ. Никита хүү өнгөрчээ.

Никитад авс хийсэнгүй нийтийн нүхэнд оршуулжээ.

Үүнээс хойш Силантий ч удсангүй. Хүйг тачигнах үеэр Силантийг оршуулжээ. Тэр үед маш олон хүн нас барж олон сайхан тариачин эрс намагт ясаа тавьжээ.

Никитагийн эцгийн барилцаж байсан хот нь Петрбург хот байсан юмсанжээ. Тэр хот хэдэн жилийн дараа Орос гүрний нийслэл болсон ажээ.



Орос орны яруу алдрын төлөө

1704 онд оросын цэрэг Нарвг хоёр дахь удаагаа тулж очжээ. Ширүүн тулалдаан оросуудын бүрэн ялалтаар төгсчээ.

Петр Меншиков хоёр цайзнаас морьтой гарахад оросын хэсэг генералууд нилээд зайтай дагана. Петр эмээл дээрээ мөрөө бөгцийн лаглайн сууж мориныхоо зээрд сэрвээг уйтгартай ширтэнэ. Меншиков дөрөөн дээрээ өндөлзөн ийш тийшээ харан замд тааралдсан цэрэг дарга нарт талархан бүрх малгайгаараа даллана.

Тэд үг дуу үгүй явж байлаа. Тэгтэл Меншиков:

— Хаантан, Петр Алексеевич, хараач гээд гараараа Нарвын эрэг уруу заалаа.

Петр харвал голын эрэг дээр голоо дээш ёрдойлгосон их буу байх бөгөөд түүний дэргэд тал талд нь цэрэг бужигналдана. Гартаа шанага барьсан түрүүч их бууны суурь дээр авиран гараад их бууны гол уруу шанагаа шургуулж ямар нэг юм утган цэргүүдэд тараан өгч байлаа.

— Хаантан, хараач гэж Меншиков хэлээд, ууж байгаагаас зайлахгүй шүү.

Үгүй мөн боджээ! Хараач, хаан, их бууны голонд дарс хийчихэж! Ээ их буучин шонхор баатрууд! гэлээ.

Петр инээмсэглэснээ мориныхоо амыг гатаж зогсоход цэргүүдийн яриа сонсогдоно.

— Юуны төлөө уух вэ? гээд түрүүч цэргүүд уруугаа харна.

— Хаан Петрийнхээ төлөө ууя! гэх хариу дуулдана.

— Нарвыг авсны төлөө юү!

— Алдарт хот Санкт—Питербургийн төлөө! ууя гэлцэнэ. Петр Меншиков хоёр цааш явбал хойноос нь:

— Их бууныхаа төлөө ууя!

— Ясаа тавьсан нөхдийнхөө төлөө ууя! гэх сонсдоно.

— Данилыч, тэнгис уруу очъё гэж Петр хэллээ.

Цагийн дараа Петр тэнгисийн дэргэд зогсоно. Тэнгисийн долгио Петрийн том савхин гутлын улыг шүргэнэ: Хаан гараа зөрүүлж, алсыг ширтэнэ. Меншиков нилээд цаахан зогсоно.

— Данилыч гэж Петр Меншиковыг дуудаад, —Новгородод бидний ярьж байсныг санаж байна уу? гэвэл:

— Санаж байна.

— Нарвын тухай санаж байна уу?

— Санаж байна.

— За тэр дээ, Энд бид дэмий алхаж, оросын хөлс цусыг дэмий урсгаалүй байж таарах нээ гэвэл,

— Тийм ээ хаантан, дэмий биш байна.

— Хонх ч дэмий аваагүй байна. Завод байгуулсан ч тэр, сургууль ч тэр дэмий биш байхнээ...

— Цөм үнэн байна гэж Меншиков давтана.

— Данылыч, тэгэхээр архи уух нүгэлтэй гэж үү? Нүгэлгүй биз дээ, Данылыч аа? гэвэл

— Уух нь зүйтэй, хаантан.


— За тэгвэл юуны төлөө уух вэ?

— Хаан Петр Алексеевичийнхаа төлөө! гэж Меншиков хэлэхэд:

— Тэнэгээ! гэж Петр хэлээд. Тэнгисийн төлөө, Орос орны яруу алдрын төлөө уувал зохино гэжээ.



Суворов жанжин болон оросын цэргийн тухай өгүүллэгүүд



Дугтуйтай бичиг

Суворов эзэн хааны үгийг дагаагүйн учир армиас халагдсан байжээ. Тэгээд фельдмаршал маань Кончанск гацаанд сууж хүүхдүүдтэй шагай тоглон, сүмийн хонхчид хонхоо дэлдэхэд нь тусалдаг байжээ. Ариун номын баярын өдөр сүмийн тайзнаа дуулдаг байлаа.

Энэ хооронд оросын арми шинэ аян дайнд хөдөлжээ. Орос оронд өөр Суворов байхгүй болохоор Кончанск тосгоныг дурсан санах хэрэгтэй болжээ.

Гуравласан морин тэрэгтэй залуухан дарга фельдмаршал Суворов жанжинд эзэн хаан Павел I—ээс чандлан нууцалсан бичиг авчирчээ.

Суворов дугтуйг харвал:

«Гүн Александр Суворовын гарт нь» гэж хаягласан байжээ. Фельдмаршал дугтуйтай бичгийг эргүүлж тойруулж харснаа авчирсан даргад буцаан өгчээ.

— Надад бишээ. Над биш гэж давган хэлээд, Битгий садаа—руул, би хүүхдүүдтэй ойд явж жимс мөөг түүнэ гээд яваад өгчээ. Дарга дугтуйг харвал «гүн» гэсэн хэргэм, «Александр Суворовт» гэсэн овог нэр бүх ёсоороо байжээ.

— Александр Васильевич! Эрхэмсэг гүнтэн! гэж дарга хашгирвал:

— За юу гээ вэ? гээд Суворов зогсоход

— Дугтуйтай...

— Над бишээ гэж хэлсэн шүү дээ. Над л биш, өөр Суворов бололтой гэлээ. Ийнхүү ирсэн элч яаж ч чадалгүй буцжээ. Хэдэн өдөр өнгөрсний дараа дахиад л Кончанскад гурвалсан морьдтой залуу дарга иржээ. Бас л эзэн хаанаас таван лацтай дугтуйтай бичиг авчирчээ.

Суворов дугтуйг харвал;

— «Оросын фельдмаршал Александр Суворовт» гэж хаяглажээ.

— Энэ бол над ирсэн захиа гэж Суворов хэлээд дугтуйг задалсан гэдэг.

Тоолох гэж ирээгүй цохих гэж ирсэн

Суворов анх бүр залуухан дарга байхдаа дайнд оржээ. Орос орон энэ үед Прусстай байлдаж байжээ. Орос Пруссийн аль алины нь ч цэрэг маш өргөн фронтоор тэлсэн байжээ. Армиуд ширүүн тулалдаанд бэлтгэж бие биенийгээ сорин жижиг үймээн гаргадаг байлаа.

Суворовт казакийн зуут өгч, дайсныг ажиглах үүрэг ноогдуулжээ. Суворовын алба хааж байсан ангиас дөчин бээрийн зайтай Пруссийн хот Ландсберг байдаг байлаа. Тэр хот жижиг авч чухал ажээ. Тэр хот их зам дээр байдаг бөгөөд пруссийн сайн зэвсэглэсэн морин цэргүүд хамгаалдаг байжээ.

Суворов зуутынхаа хамт хайгуулд хэд хэдэн удаа явж бүх тойргийг хөндлөн гулд хэрсэн боловч нэг ч амьд прусс хүн олж хараагүй ажээ.

Дайснаа олж харахгүй бол ямар дайн байх билээ? Тэгээд мань залуу дарга азаа туршиж Ландсбергийг авч ёстой их үйлс бүтээхээр шийджээ. Тэгэхэд Суворов залуу ч, галтай цогтой ч байжээ.

Чингээд шөнө дунд зуугаа босгож морьдоо эмээллэхийг тушаажээ.

— Хаачих юм бэ? гэж казак зуут нь санаа түгшихэд:

— Урагшаа! гэж Суворов товчхон хариулжээ.

Суворовын зуут үүр тэмдгэрэхээс өмнө дөчин бээр явж гүн уст голын эрэг дээр Пруссийн хотын яг эсрэг талд иржээ.

Суворов сайтар харвал гүүр байхгүй ажээ. Пруссууд аюул заналаас болгоомжлон гүүрийг шатааж гэнэтийн дайралтаас сэрэмжилсэн байжээ.

Суворов голын эрэг дээр зогсон бодолхийлж байснаа гэнэт:

— Миний хойноос усанд! гэж командлан өөрөө хамгийн түрүүнд гол уруу оржээ.

Казакууд дайсны хотын хананы хажуу руу голын эсрэг эрэг дээр гарчээ. Хот манайх боллоо. Урагшаа гэж Суворов командалжээ.

— Хотод пруссийн морин цэрэг байгаа шүү дээ гэж казак зуутан

Суворовыг болиулахыг оролдоход:

— Бурхан өршөө, тийм тусмаа л сайн! Яг л бидний эрж байгаа юм чинь тэд шүү дээ гэж Суворов хариулав.

Суворовыг зогсоож чадахгүйгээ зуут мэджээ.

— Александр Васильевич, тэднийг хир олуулаа байгааг мэдэхийг зөвшөөрнө үү гэхэд:

— Мэдэх хэрэг юу байгаа юм бэ? Бид тоолох гэж ирээгүй, цохих гэж ирсэн шүү дээ хэмээн Суворов хэлжээ.

Казакууд хот уруу орж дайснаа бут цохисон гэдэг.

Хатан зориг

Турктэй дайтаж байх үес Суворов, генерал болчихсон байжээ. Фокшанын дэргэдэх тулалдаанд туркууд их буугаа ар талаасаа нэвтэршгүй намагтай газар байрлуулсан байжээ.

Их бууны энэ байрлалаас өөр сайн байр байхгүй байлаа. Ар талаас дайсан ирэхгүй, хажуу талаар тойрч чадахгүй, сандраах юмгүй амар тайван ажээ. Гэвч Суворов намгаас айсангүй. Суворовын баатрууд намаг дундуур гарч туркийн их бууны араас нартай өдрийн цахилгаан шиг гэнэт гарч ирэн дайрч туркийн их бууг эзлэн авчээ.

Туркууд ч, авструуд ч, оросууд ч өөрсдөө Суворовын энэ аргыг хэтэрхий зоримог аюултай арга гэж үзсэн юмаа.

Цэргүүд намаг дундуур гарсан нь сайн болж, хэрэв гараагүй бол яах байсан бэ?!

— Хатан зориг бол зориг гээд Суворов инээмсэглэсэнээ.

— Хатан зоригтой байх явдал цэргийн хүнд муу бишээ гэжээ.

Харин Суворов намаг дундуур цэргээ явуулахын өмнө хашир цэргээсээ явуулж, намгийг хөндлөн гулд хэсүүлж найдвартай зам сонгож авсныг мэдэх хүн цөөн байжээ. Суворов цэргээ хайрлан энхрийлж яв цав ажилладаг байлаа.

Сарын дараа туркуудтэй хийсэн шинэ тулалдаанд хурандаа Илловайский

Суворовын энэ зоримог аргыг дахин хэрэглэхээр шийджээ.

Туркийн их буу мөн намгаар хамгаалуулсан байдал адил төстэй байжээ.

— Суворов болсон юм. Над юу нь дутах вэ? Мөн л болох ёстой гэж

Илловайский хэлжээ.

Харин Илловайский хурандаа замаа урьдчилан судлаагүй замаар цэргээ явуулснаас бүтэмжгүй болжээ. Цэргүүд намагт шигдэж живэн шуугилдан хашгиралджээ.

Туркууд уг учрыг мэдэж их буугаа эргүүлж оросын цэргийг бууджээ.

Олон цэрэг амь сүйдсэн боловч Илловайский амьд гарчээ.

Суворов жигтэйхэн их уурлаж хоолойгоо сөөтөл хашгирчээ.

— Би тан шиг зоригтой байх гэсэн юм гэж Илловайский биеэ өмөөрнө.

— Зориг! гэж Суворов хашгираад, зориг ч байна. Зоригоо гаргасан чинь хаана байна аа?! гэжээ.

Суворов цэргүүдийг хий дэмий аллаа гэж хурандааг жагсаалын цэрэг болгон ачааны хэсэг уруу явуулж:

— Тийм хүнд, хүнийг итгэн даатгаж болохгүй. Адуутай ажиллавал аюулгүй гэж Суворов хэлсэн гэдэг.

Измаил

Өргөн Дунайн эрэг дээр орших Туркийн цайз Измаил нэвтэршгүй гэж үздэг байлаа. Тэр цайзанд хоёр зуун их буу, дөчин мянган цэрэг байдаг байлаа. Түүнээс гадна хэрмийн гадуур Измаил цайзыг тойруулан гүн суваг ухаж, өндөр далан босгожээ. Измаилийн эргэн тойрны цайз хана зургаан бээр үргэлжилнэ.

Оросын генералууд туркийн энэ цайзыг эзлэн авч чадахгүй байжээ. Тэгтэл Измаил уруу Суворов ирлээ гэсэн чимээ таржээ. Үнэхээр ч удалгүй

Суворов ирэв. Тэгээд зөвлөлөө цуглуулж:

— Яавал таарах вэ? гэж асуужээ. Намар орой болсон байсан юмсанж.

— Өвлийнхөө байр луу гэр өөдөө ухарвал зохино гэж генералууд ятгажээ.

— «Өвлийнхөө байр луу гэнээ!» гэж Суворов даажигнаад. «Гэр өөдөө!» харихгүй гээд, Оросын цэргийн гэртээ харих зам Измаилаар дайрч гарах л зам бий. Оросын цэрэгт өөр зам байхгүй! гэжээ.

Тэгээд Измаилийн ойролцоох ер бишийн амьдрал эхэлжээ. Суворовын тушаалаар цайзыг тойруулсан далан шиг далан босгож цэргүүд сургууль хийж эхэлжээ. Цэргүүд өдрийн цагаар жадат дайралтанд сурч, шөнө болохтой зэрэг туркуудэд харагдахгүй далан өөдөө авчирч сургуулилахыг Суворов шаарддаг байлаа. Цэргүүд далан уруу гүйхэд:

— Орхиё! Сүрэг хонь шиг ингэж гүйж яаж болдог юм бэ хэмээн Суворов хашгирна.

Ийнхүү цэргүүд далан уруу нааш цааш гүйж нуруулдсан шороонд хүрч сурахад далан дээр хэрхэн яаж гарахыг Суворов зааж:

— Адилхан хэмжээнд цөм зэрэг авирч, зэрэг далан дээр гарах хэрэгтэй гэдэг байлаа.

Суворов цэргээ ингэж хэдэн өдөр сургасны дараа туркийн генерал уруу элч илгээж бууж өгөхийг шаарджээ. Гэвч генерал ихэмсгээр:

— Оросууд Измаилыг авахаас өмнө Дунай мөрөнд тэнгэр унана гэж хариулжээ.

Чингээд Суворов цайзыг дайран эзлэх тушаал өгчээ. Цэргүүд Суворовын сургасан тэр бүгдийг давгаж, суваг уруу ирж цайзны далан дээр гарч нүүдлийн шатаар ханан дээр гарчээ.

Туркууд зоригтой тулалдсан боловч оросын цэргийн довтолгооныг тогтоож чадсангүй. Суворовын дайчид Измаилд цөмрөн орж туркийл армийг бүхлээр олзлон авчээ.

Харин нэг турк хүн сэмхэн дайзнаас гарчээ. Тэр хүн айн чичирч туркийн нийслэл уруу гүйн очиж Оросын цэргийн шинэ гавьяа, Суворов генералын шинэ ялалтын тухай айлтгажээ.

Медаль

Дарийн үнэр аваагүй залуу цэрэг Кузьма Шапкин Рымник голын дэргэд болсон тулалдаанд ороод айж өдөржингөө бутан дотор суужээ.

Шапкин, Суворов өөрий нь ажсаныг мэдсэнгүй.

Суворовын арми туркийг ялсныг тохиолдуулан одон медаль илгээсэн байжээ. Дарга нар хороо, сумангаа жагсаахад Суворов цэргүүд дээр ирж шагналы нь гардуулжээ.

Шапкин нөхдийнхөө хамт жагсаалд зогсож энэ бүх ёслол түргэн дуусаасай гэж бодож байжээ. Түүний сэтгэл зовно.

Тэгтэл...

— Тусгай сумангийн Шапкин над дээр! гэж Суворов хашгирвал Шапкин цочиж буруу дуулав уу гэж боджээ.

Мань цэрэг хөлий нь газартай бариад хадчихсан юм шиг л хөдлөлгүй зогсож байжээ.

— Тусгай сумангийн Шапкин над дээр! гэж Суворов дахин дууджээ.

— Очооч, очооч гэж хажуугийн нь цэрэг Кузьмаг нударчээ. Шапкин харцаа буулгаж, царайгаа улайлгасаар жагсаалаас гарчээ. Харин Суворов жанжин цамцан дээр нь медаль зүүж өгчээ. Орой нь цэргүүдэд нэг нэг гүц дарс өгчээ. Цэргүүд майхныхаа хажууд сууцгаан тулалдааны тухай нарийвчлан дурсаж хэнд юун тухай ямар шагнал олгосныг ярьцгаалаа. Нэг нь туркийн окопийг булаан авах аргыг хэрхэн олсны тулд, нөгөө нь Туркийн тугийг авсны төлөө, гурав дахь нь ганцаараа арван туркийн эсрэг шархдаж туйлдсан боловч олзлогдон бууж өгөлгүй тулсны төлөө шагнал авсан ажээ.

— За чамд яагаад медаль өгөв өө? гэж цэргүүд Шапкиныг шална. Шапкин ч хариулах үг байсангүй.

Шапкин медалиа зүүх боловч тайван байх цаг ер үгүй сэтгэлээр унаж нөхдөөсөө жожгорч өдөржингөө дуу шуугүй явна.

— Медаль аваад хэлээ тас хазчихаа юу! гэж цэргүүд тоглоно. Долоон хоног өнгөрчээ. Цэргийн сэтгэл бүр хямарч гүйцжээ.

Тэгээд Шапкин тэсэж чадсангүй Суворов дээр очиж асарт нь ороод медалиа эргүүлэн өгвөл:

— Бурхан өршөө!шагналаа аваад яв! гэж Суворов хэлжээ. Шапкин тэргүүнээ шаланд хүртэл бөхийж бүх үнэнээ Суворовын өмнө хүлээжээ.

«За ингээд ч миний толгой байхгүй» гэж боджээ. Суворов хөхөрч цэргийг тэврээд:

— Сайн байна! Дүү минь чамгүйгээр цөмий нь мэднэ. Шалгах гэсэн юм. Сайн цэрэг байна. Маш сайн цэрэг байна. Баатраараа төрдөггүй, баатар болдог гэдгийг санаж яваарай. За яв. Яах вэ, медаль чинь одоохондоо надад байж байг. Харин медаль чинийх болно гэж болзов. Чи гавьяа байгуулбал зүүх л ёстой гэжээ.

Суворов жанжин эндүүрсэнгүй.

Шапкин дараагийн нь тулалдаанд хамгийн түрүүнд туркийн цайзанд цөмрөн орж медалиа авч агуу их алдраа мандуулжээ.

Гүүр

Оросууд Италид тулалдаж байлаа. Суворовын эсрэг францын генералууд байлдаж байлаа. Францчууд Суворовыг лавтай бут цохиход боломжтой тийм газрыг сонгон авчээ. Францчууд Адде гол уруу ухарч нөгөө талд нь гараад гүүрий нь шатаажээ. «За ингээд Суворовынхныг гол гатлах үед нь бид устгана» гэж шийджээ.

Тэгээд францын генералууд Суворовг өөрийнхөө төлөвлөгөөг мэдэгдэхгүйн тулд цаашаа гүн тийш явсан дүр үзүүлжээ. Чингээд өдөржингөө голоос цааш ухарснаа эргэж ирээд цэргүүдээ гуу жалга бутанд нуужээ.

Суворов гол дээр ирээд буудаллаж гүүрээ янзлах тушаал өгчээ. Цэргүүд ханцуй шамлан сүх авч ажилд орцгоожээ. Бие биенээсээ холгүй зайтай гүүр барьж цэргүүд хоорондоо уралдана. Гүүр болгоноо түрүүн дуусгахыг хичээнэ.

Голыг ажиглаж байсан францийн харуулууд оросуудын ажил хэрхэн явж байгаа тухай генералууддаа цаг тутам илтгэнэ. Бүх ажил яг төлөвлөснөөр нь явж байгаад францын генералууд сэтгэл хангалуун байжээ. За Суворов ч бидний гарт орлоо гэж баярлахдаа гараа үрж байжээ!

Францууд зальтай ажээ. Гэвч Суворов тэднээс зальтай байлаа.

Гүүр бараг бэлэн болох гэж байхад Суворов гэнэт шөнө дунд армия хөдөлгөж Адде голын эргийг даган урууджээ.

— Эрхэмсэг генералаа, гүүрээ яах вэ? гэж барилга ангийн дарга нар сэтгэл түгшингүй хэлэхэд,

— Чимээгүй гээд Суворов аман дээрээ хуруугаа тавьж хэлээд, гүүрээ барина. Сүхээрээ шаламгай балба гэжээ.

Голын дээр сүхний чимээ хангинаж байх хооронд фельдмаршал армия гол зэтгүүлэн гаргаж ямар ч гүүргүйгээр дайсны эрэг дээр гарчээ.

Гүүр бэлэн биш гэдгийг мэдэж байсан францийн генералууд тайван байжээ. Гол дээр хангинах сүхний чимээ ч францчуудыг тайвшруулжээ. Тийм ч учир генералууд сэтгэл төвдсөнгүй.

Тэгтэл... ар талаас нь Суворов гарч ирэн жадлан дайрчээ.

— Ура! Гайхамшигт баатруудаа миний хойноос!.. Генералууд учрыг мэдсэн авч нэгэнт хожигджээ. Оросуудыг ингэнэ гэж францчууд бодсонгүй чичрэн дагжиж зугтжээ. Суворовынхны гарт зөвхөн хоёр зуу гаруй дарга нар олзлогдсон байлаа. Гүүрээ бүрэн барьж дуусгажээ. Арми зөвхөн цэргийн гайхамшгаар болдог зүйл бишээ, бас ачаа бараа, их буу байдаг болохоор гүүргүй байж яахин болох билээ.

Аймхай эр ард нуугдавч алагддаг

Суворов, Турин уруу дайралт хийхийнхээ урд шөнө хошууч Пронин, ахмад Забелин хоёрыг дагуулан эргүүлд гарч явжээ. Фельдмаршал өөрөө хот уруу орох газрыг үзэж дарга нарыг цаас авч газрын зураглал хийхийг тушаажээ.

Тэргэл саран гийгүүлж, од мичид гялалзаж чимээ аниргүй саруул сайхан шөнө байжээ. Жижигхэн ой мод, өндөр улиангартай гоё сайхан газар байлаа. Суворов сонирхон явна. Тэд бараг хотын хажууд очиж довцог дээр зогсжээ.

Дарга нар мориноосоо буулаа. Зоригт хошууч Пронин цаасаа авч хотод бүүр ойртон очив. Харин ахмад Забелин Суворовын ард нуугдах шахна.

Хориод минут өнгөрсний дараа гэнэт маш аймшигтайгаар гал нээлээ. Францчууд оросуудыг ажигласан юм уу, эсвэл зүгээр л замыг буудсан юм уу дайсны сум нөгөөх довцгийн дэргэд, Суворовын хажууд фельдмаршалыг тойрон шороо оволзуулна.

Суворов морин дээрээ хөдөлгөөнгүй сууна. Хошууч Пронинг харвал айсан юмгүй тэр их сумны дор газрын зургийг зурна. Харин Забелин алга болжээ. Хаашаа ч юм алга болжээ.

Оросын цэргүүд тэр аймшигт галлалтыг дуулаад Суворов жанжиндаа санаа түгшиж казакийн эргүүл Турин уруу давхиж иржээ.

— Эрхэмсэг фельдмаршалаа, яваарай, яваарай! Аюултай газар байна! гэж казакийн зуут хашгирна.

— Үгүй, явахгүй, зуут минь. Энэ чинь сайхан газар байна гэж Суворов хариулаад, хараач, илүү сайхан газаргүй гээд өндөр улиангар зааж маргааш эндээс довтолгооноо эхэлнэ гэжээ:

Галлалт зогсоход Суворов буцаж явах гээд Пронин, Забелин хоёрыг дууджээ.

Пронин хаана гуу жалга, хаанаа дов довцог байгааг бүх ёсоор нь ам дөрвөлжин цаасан дээр зурчихсан иржээ. Харин Забелин алга байлаа. Ахмадыг эрж хайвал Суворовоос цаана хоёр зуун метр хиртэй газар үхчихсэн байжээ. Забелины толгойг дайсны сум тас хяргаж, хажууд нь юу ч бичээгүй цагаан цаас хэвтэнэ.

Суворов Забелины хүүр уруу харснаа, Пронин тийш харж:

— Зоригтон үргэлж түрүүнд нь, зориггүй аймхай эр ард нуугдавч алагддаг гэжээ.



Цэргийн хоол амттай

Суворовын арми шуурхай довтолгож явсаар шөнө голын хажуугийн налуу дээр буудаллаж ой дотор хоноглох болжээ.

Цэргүүд хээрийн гал өрдөж шөл, агшаасан будаа чанаж эхэлжээ. Хоол нь болж цэргүүд идэж эхэлжээ. Харин генералууд асрынхаа орчим хөлхөлдөж Лушкаг хүлээж ядна. Лушка бол генералуудын тогооч ажээ. Тэгээд Лушка хаана ч юм бэ замд хоцорчихсон тул генералууд тарчилж хоолгүй сууж байгаа ажээ.

— Ноёд генералуудаа цэргийн гал дээр очёе. Өөр яах билээ? гэж

Суворов хэлжээ.

— Үгүй дээ. Хүлээе, Мөдхөн Лушка ирнэ гэж генералууд хариулжээ. Генерал хүнд цэргийн хоол таалагдахгүй гэдгийг Суворов мэдэж байсан тул мартасангүй.

— За дураараа болцгоо гээд Суворов ойрхон байгаа гал уруу очжээ. Цэргүүд шахцалдан Суворовг хамгийнхаа сайн суудлыг тавьж таваг, халбага өгчээ.

Суворов сууж хооллож гарлаа. Фельдмаршал цэргийн хоолонд дассан юмсанжээ. Тэгээд шөл, агшаасан будаанаас нэрлэхэлгүй цадталаа иджээ.

— Сайхан шөл, амттай шөл байна! гээд Суворов халбагадана. Цэргүүд инээлдэнэ. Фельдмаршал муу шөл идэж байгаагүй болохоор үнэхээр сайхан шөл чанасан бололтой ажээ.

Суворов шөлнөөс идчихээд, агшаасан будаа уруу орж;

— Сайхан агшааж, сайхан будаа байна! гэжээ.

Суворов цадталаа идээд цэргүүдэд талархаж генералууд дээрээ иржээ. Тэгээд фельдмаршал хэвтэж баатар эрийн унтлагаар унтжээ. Харин генералуудын нойр хүрэхгүй эргэж хөрвөнө. Тэд өлсөн зовж, Лушкаг хүлээсээр ажээ.

Өглөө болоход Лушка алга байжээ. Суворов цэргээ босгож, арми цааш явжээ. Генералуудын гэдэс хоржигнон идэх юм нэхэж толгойгоо ганзагалан явна. Тэгээд хөөрхийс дараагийн

үдлэлт хүртэл тамаа эдэлжээ. Харин цэргүүд буудаллахад Суворовын хойноос цэргийн гал уруу очицгоожээ. Яая гэх вэ, өлсөж үхэлтэй бишдээ. Тэгээд сууцгаан чанаж буй цэргийн хоол болохыг байж ядан хүлээжээ.

Суворов инээмсэглэж тэдэнд өөрөө шөл, агшаасан будаа түгээж өгөхдөө хүн бүрд:

— Ид ид, сайн ид. Дахиад цэргээсээ битгий цамаарх. Битгий сэжиглэ. Цэрэг чинь хүн шүү. Цэрэг бол над өөрөөс минь эрхэм нандин байдаг гэжээ.



Хөтөч прошка

Прошка Суворовын хөтөч болохдоо «Эрт босохгүй, сумангийн ямар ч хичээл хийхгүй, ямар ч ёс дэглэмд захирагдахгүй ёстой боллоо! Ийм их буян хишиг байх! гэж» хэмээн мань цэрэг багагүй баярлажээ.

Гэвч эхний өдөр Прошкийн урам ихэд хугарчээ. Өглөөний дөрвөн цагт нэг хүн хөлнөөс нь угзарчээ.

Прошка нүдээ нээж харвал Суворов:

— Бос бос сайн хүү минь, их унтах нь оросын баатарт хань болохгүй гэжээ.

Суворов арми дотроо хамгийн түрүүнд босдог байсан юмсанжээ.

Прошка бостол бас нэг аягүй явдалтай тулгарчээ. Фельдмаршал хувин хүйтэн ус авчрахыг тушааж, бие уруугаа асгуулж хүзүү цээж, нуруу гараа арчина. Прошка ямар гайхамшигтай юм бэ? гэж бодон нүдээ бүлтийлгэнэ.

— За чи юугаа хийгээд зогсоод байгаа юм бэ? гэж Суворов хашгираад

Прошкад бас бие уруугаа ус асга гэж тушаажээ.

Бие уруугаа ус асгаж сураагүй цэрэг чичирч хүйтэнд дуу алдав. Харин

Суворов хөхөрнө.

— Эрүүл биенд саруул ухаан гээд Суворов дахиад л хөхөрлөө. Суворов бие рүүгээ ус асгасны дараа Прошкаг дагуулан нуга уруу очиж гүйж гарлаа. Тэгээд:

— За намайг хөөж гүйц! гэж фельдмаршал цэрэгт хэлжээ. Прошка хагас цаг гаруй Суворовын хойноос гүйж амьсгаа, давхцан, бөөрөөр нь хатгана. Харин Суворов хэдүйгээр насан дээр гарсан боловч огтхон ч хөдлөөгүй юм шиг амьсгадахгүй зогсоод дахиад л хөхрөв.

Ингээд Прошкад амьдрал биш харин шаналал эхэлжээ. Суворов хамгаалах цэгийг эргэхэд Прошка бүтэн хоногоор морин дээр сэгсрэгдэнэ. Эсвэл шөнийн харуулыг шалгах гэж Прошкаг унтуулахгүй тарчилгана. Тэгтэл

Суворов турк хэл сурч эхлэн, Прошкаг ч сур гэж шаарджээ.

— Над харийн хэл ямар хэрэгтэй юм бэ? гэж цэрэг эсэргүүцэхэд

— Яагаад ямар хэрэгтэй юм бэ? гэхэд Туркууд дайнд бэлтгэж байна. Турктэй дайтна гэж Суворов уурсчээ.

Прошка эвлэрэх хэрэгтэй болж Турк хэлний үсэглэл барин хөлсөө асгаруулан, үзээгүй

муугаа үзжээ.

Прошка ганц амардаг газар ирлээ гэсэн нь бүтсэнгүй. Буцаад сумандаа очихыг хүсчээ. Гэвч хожим дасаж фельдмаршалтай наалдан насан туйл болтлоо Суворовт үнэнч шударгаар итгэн алба хаажээ.



Ёстой л цэрэг

Суворов нэг удаа цэрэг дээр очиж:

— Дэлхийгээс сар хүртэл хичнээн хол бэ? гэж тулган асуужээ.

— Суворовын хоёр давааныг зайтай гэж цэрэг ажиг ч үгүй хэлжээ.

— Хариулт ч хариулт! цэрэг ч цэргээ! гэж фельдмаршал санаандгүй дуу алдсан билээ.

Цэрэг хүн огтхон ч түгдрэлгүй овжин хариулахад Суворов маш дуртай ажээ. Суворов залууг ажиглажээ. Фельдмаршалд цэргийн хариулт таалагдсан авч өөртөө гомджээ. «За, би Суворов, цэргийг мухардалд оруулж чадахгүй байж болохгүй» гэж дотроо боджээ.

Хэдэн өдрийн дараа Суворов нөгөөх овжин цэрэгтэй тааралдаж:

— Тэнгэрийн од хэд вэ? гэж тулган асуужээ.

— Эрхэмсэг фельдмаршалаа, одоохон тоолоодохье гээд цэрэг тэнгэр ширтэн зогсчээ.

Суворов хүлээгээд л байж, хүлээгээд л байж, тэгээд салхинд жихүүдэс хүрчээ. Харин мань цэрэг яарсан юмгүй одоо тоолсоор байжээ.

Суворов харамсалтайгаар нулимаад яваад өгчээ. «Цэрэг ч цэргээ!» гэж дахин бодоод, за гурав дахиа чамд чадагдахгүй гэж фельдмаршал шийдээд, би чамайг мухардалд оруулж чадна даа гэж боджээ.

Суворов цэрэгтэй гурав дахиа уулзаж:

— Алив залуу минь миний элэнц хуланцын эмээг нэрлээтэх гэж дахин асуужээ.

Суворов жирийн цэрэг фельдмаршалын элэнц, хуланцын эмээг хаанаас мэдэх вэ гэж ихэд сэтгэл хангалуун байлаа. Тэгээд гараа үрж «за дүү минь над чадагдав уу!» гэж хэлэх гэтэл цэрэг номхон зогсож

— Эрхэм генерал аа, Викторияг гэж гэнэт хариулжээ.

— За Виктория ч биш ээ! гэж

Суворов баярлан хэлэхэд

— Виктория, Виктория гэж цэрэг давгаад, манай фельдмаршалын элэнц хуланцын эмээ Викториягаас өөрөөр байж болохгүй гэжээ.

Суворов цочив! Үгүй мөн хариулав аа! Яасан зальтай цэрэг вэ? гэж боджээ.

— За чи ийм зальтай болсон хойно танай сумангийн дарга бид хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ, хэлээтэх гэж Суворов хэлжээ.

Цэрэг огтхон ч бодсонгүй.

— Сумангийн дарга намайг түрүүч болгохыг хүссэн ч болгож чадахгүй, харин та эрхэмсэг фельдмаршал бол юу л болгоё гэвэл, би... гэжээ.

Суворов яах байсан бэ? гэвэл цэргийг түрүүч болгохоос өөр аргагүй байжээ. Суворов асартаа эргэж ирээд:

— Бурхан өршөө, мөн чадуулав аа! Ийм л байх ёстой! Ёстой л цэрэг байна! Бурхан өршөө. Ёстой л цэрэг Оросын цэрэг! гэж бахархан шагширсан гэдэг.

Зам тавь

Суворов мориор давхих маш дуртай ажээ. Тэгэхдээ эсвэл морь унаж, эсвэл тэргэнд хөллөж нүүрээ салхи ороолготол тийм хурдан давхих дуртай байлаа.

Уул хэрэг Суворовыг умартад байхад болжээ. Нэгэн удаа Суворов Прошкатайгаа хамт чаргаар цайзнуудаа эргэж явжээ. Яг энэ үеэр нь Петербургээс Суворовт чухал бичиг хүргэхээр элч довтолгожээ. Залуу дарга штабын гадаа хөөрсөн морьдынхоо ам татан:

— Фельдмаршал Суворовт яаралтай хүргэх бичиг авчирлаа гэв.

— Суворов яваад өгсөн гэж элчид хариулжээ.

— Хаашаа яваа болоо?

— Нуурын цайз уруу явсан гэхэд дарга тийшээ давхижээ.

— Энд Суворов ирэв үү?

— Ирээд явчихсан.

— Хаашаа яваа юм бол оо?

— Ликолийн цайз уруу явсан Ликолийн цайз уруу давхиж очоод:

— Суворов гуай энд байна уу? гэхэд

— Яваад өгсөн.

— Хаашаа яваа бол оо?

— Кюмень—град уруу явсан гэжээ. Дарга Кюменьград уруу довтолгож очоод

— Суворов гуай байна уу? гэтэл

— Яваад өгсөн ... гэжээ.

Суворов явах нь явжээ. Гэвч замдаа саатжээ. Морьдын нэг доголж буцах хэрэгтэй болжээ. Морьд гэлдрэн алхалж ядан явах бөгөөд Прошка суудал дээрээ үүрэглэж, Суворов нуруу уруу ёворч морьдоо давхиулахыг шаардана.

— Болохгүй, болохгүй эрхэмсэг фельдмаршалаа, морь доголон байна гэж Прошка нэг л үгээ давтана.

Суворов зөөлөрч жаал байсхийгээд дахиад л Прошкагийн нурууг нударна. Тэрээр эцсэн морин тэргэн дээр сажлах залхуутай тул байс байсхийн өндөлзөнө.

Хоёр бээр газар явтал гуравласан морин тэрэг айсуу байхыг Суворов харжээ. Морьд тал дундуур шувуу нисэх лугаа адил хурдалж ган туурайгаараа бөөн бөөн цас шидэлж, хамраас нь яндангаар утаа гарах лугаа адил уур савсана.

Суворов баясан ширтэж байлаа. Жолоочийн суудал дээр залуухан дарга сууж гартаа жолоо цулбуураа атгажээ. Тэр даргын ташаанд сэлэм савлаж, папак малгайтай авч моголцог үс нь сахал адил салхинаа хийсэх ажээ.

— Эрэмгий зоригтон! Ээ, эрэмгий зоригтон! гэж Суворов тэсэж чадалгүй шагширчээ.

— Эрхэмсэг фельдмаршалаа, буухиа элч байна. Эндхийнх биш, Питерээс яваа бололтой гэж Прошка хэлжээ.

Суворов харж сонирхоно. Өвлийн зам нарийхан, ганцхан зурвас тул зөрөхөд хэцүү байлаа. Тэгтэл морьд улам бүр ойртож, бүр зэрэгцэн ирж чарганы чахралдах чихнээ сонсдоно.

— Зам тавь! гэж дарга хашгирна. Прошка зам тавьж сураагүй тул саатна.

— Зам тавь! гэж дарга давтгал хоёр чарга мөргөлджээ. Суворов Прошка хоёр цас уруу бүсэлхийдээ хүртэл унажээ.

Улаач хажуугаар нь өнгөрөхдөө эсгэрч, салхи шиг хурдлан цааш явжээ. Прошка босож буухиа элчийн хойноос ууртай харж цасаа сэгсрэн элдвийн муухайгаар зүхнэ.

— Чимээгүй! гэж Суворов хашгираад дахиад л: — Эрэмгий зоригтон. Бурхан өршөө, яасан эрэмгий зоригтон бэ! гэж шохоорхоно.

Залуу дарга оросын умард хилээр гурван өдөр давхисны эцсэд Суворовыг эрж олжээ.

— Эрхэмсэг фельдмаршалаа танд Питерээс бичиг авчирлаа гэжээ. Суворов бичгийг авснаа буухиа элч уруу харж бөгжөө аваад даргад өгчээ.

— Эрхэмсэг фельдмаршалаа, яалаа гэж! хэмээн элч гайхахад,

— Таны эрэмгий чадлын төлөө! гэхэд дарга ойлгож эс чадан зогсоно. Суворов дахиад л:

— Ав, ав! Таны эрэмгий чадлын төлөө өгч байгаа юм. Таны оросын сэтгэл, эрэмгий зоригийн төлөө өгч байгаа юм ав! гэжээ.

Жад

Суворов нэг удаа Новгород мужид найзындаа зочилжээ. Анд нөхөд оройд нь гэртээ сууж хуучин нөхөд, аян, дайн тулааныхаа тухай дурсан ярилцаж, өдөр нь Суворов ой дотор тэнэж орчин тойрныг сонирхоно. Тэгээд ой дотор хөгшин дуб модны дэргэд Санька Выдрин гэдэг жаалтай тааралджээ.

— Өвөө та цэрэг үү? гэж Санька Суворовоос асуужээ.

— Тийм ээ цэрэг гэж фельдмаршал хариулжээ.

— Хаанаас яваа вэ?

— Дайнаас буцаж явна.

— Суворовын тухай ярьж өгөөч.

Фельдмаршал нүдээ анивчиж, жаал уруу зальтайгаар харж:

— Ямар Суворовын тухай байдаг билээ? гэвэл

— Мэдэхгүй юү? Яагаав, туркуудтэй байлдаж байсан Суворов. Измалыг байлдаж авсан фельдмаршалын тухай яриач гэхэд нь:

— Үгүй мэдэхгүй гэж Суворов хэлжээ.

Суворовыг мэддэггүй бол ямар цэрэг байх вэ! гэж Санька жуумалзаад, Ура! Миний хойноос гайхамшигт баатруудаа, урагшаа! гээд жаал хүү мөчир авч Суворов шиг хашгирчээ. Санька! фельдмаршалыг тойрон гүйж Суворовын гэдэс уруу мөчрөөрөө жадлах гэнэ.

«Энэ жаалыг!» гэж Суворов шагширна. Харин өөрийн нь үйлсийг хүүхэд мэдэж байгаа явдал таатай санагджээ.

Тэгээд Санька томоотой болж мөчрөө бүсэндээ хавчуулаад:

— Өвөө жадаа бэлэглэчих гэж гуйжээ.

— Чи жадаар яах нь вэ?

— Байлдаж тоглоно. Дайснаа дарна гэхэд нь

— Бурхан өршөө! Над жад байхгүй гэж Суворовыг дуу алдахад

— Худлаа хэл, худлаа хэл. Жадгүй цэрэг байдаггүй ном гэж Санька хэлжээ.

— Байхгүй дээ, бурхан л мэдэх байх гэж Суворов итгүүлээд гараа тавихад

— Та аваад ир л дээ гэж Санька бууж өгсөнгүй шалжээ. Тэгээд Суворов аргагүй л өгнө гэж амлахад хүрчээ. Санька хүү маргааш нь ой уруу хөгшин царс модон дээр гүйн ирж орой болтол хүлээсэн боловч цэрэг дахиад ирсэнгүй гэнээ.

«Худалч! Олхиогүй цэрэг бололтой» гэж Санька уурлажээ.

Тэгтэл хэдэн өдрийн дараа Санькагийн байшин уруу морьтой хүн давхин ирж хүүг дуудан боодолтой юм өгчээ.

— Фельдмаршал Суворов явууллаа гэжээ.

Санька санамсаргүй болсон явдалд гайхширч амаа ангайн хоцорчээ. Жаал хүү боодолтой юмаа ширтэж нүдэндээ ч, чихэндээ ч итгэхгүй зогсоно. Фельдмаршал өөрөө Санькад Элч илгээж, элч явууллаа гэж үү!

Выдрины байшин уруу тариачид, чавганц, хүүхэд шуухад гүйлдэн ирэхэд өрөөл дутуу Качкин хүртэл өрөөсөн хөлөөрөө догонцон иржээ.

— Задал! Задал!, гэж тариачид хашгиралджээ.

Санька чичирсэн гараараа боодлыг задалбал жад байлаа.

— Суворовын дийлдэшгүй жад байна! гэж Качкин хашгирлаа.

— Бурхан минь үнэхээр жад байна! гэлцэн чавганц нар залбирна.

— Алив үзүүлээч, үзүүлээч! гэж жаалууд гараа сарвайна. Яг энэ үед Санька сэхээ авч амаа ангайхаа больж, гар нь чичрэхээ байжээ. Санька учрыг тааварлаж ой дотор уулзсан хүний тухайгаа эцэг зх, хүүхэд багачууд, Качкин болон тариачид, чавганц цөмд нь ярьжээ.

Тэгээд Санька хүү Суворовтой уулзсан тухай яриа хэдэн жил яригджээ.

Жадаа яасан болоо?

Санька хүүгийн хорвоо дээрх хамгийн их нандигнан хадгалдаг юм нь Суворовын жад болжээ. Жадандаа уут оёулж цэвэрлэж хийгээд унтахдаа жаднаасаа салдаггүй, үргэлж үнэт эрдэнэ мэт биедээ авч явдаг байжээ. Тэгээд Санька өсөж цэрэг болохдоо жадаа авч дайнд яван Суворовын ёсоор дайснаа цохисон гэдэг.

Оо-Дарь биш

Эзэн хаан Павел I армидаа шинэ дэглэм тогтоож эхэлжээ. Эзэн хаанд оросын бүх юм таашаагдсангүй, харин гадаадын, тэр дотроо германы юманд илүү их дурладаг байжээ.

Тэгээд Павел, прусс өөрөөр хэлбэл герман маягаар оросын армийг өөрчлөхөөр шийджээ.

Чингээд цэргээ урт гэзэг тавьж шанаан дээрээ долгиолсон үс нааж, үсээ гурилаар оодохыг шаарддаг болжээ. Тийм цэрэг уруу харахад оросын цэрэг биш естой л чихмэл гэсэн үг.

Цэргүүдийг буудах, жадлахад сургахгүй, харин жагсаалд хөлөө тавьж алхах, өлмий дээрээ овжин эргэж чаддаг болгоход сургаж эхэлжээ.

Суворов шинэ дэглэмийг үзэн ядаж, заримдаа муу хэлдэг ч байжээ.

«Пруссууд орост дандаа ялагдаж явсан юм тэгэхлээр тэднээс юугий нь сурах юм бэ?» гэж фельдмаршал ярьдаг байжээ.

Нэгэн удаа Павел I Суворовыг жагсаал дээр урьжээ.

Жагсаалд оросын алдар цуут хороод явжээ. Гэтэл Суворов гайхамшигт баатруудаа хараад таньсангүй гэнээ.

Тэдэнд эрэмгий зориг, баатарлагийн аль аль нь ч алга байжээ.

Цэргүүд явах нь хиймэл юм шиг ажээ. Харин хөлийн өсгийгөөрөө замыг таг таг цохилж гэзгээрээ нуруугаа ороолгохоос өөр зүйл алга байжээ.

Гэтэл ззэн хаан сэтгэл хангалуун зогсож:

— Хараач, хараач дахиад жаахан сургуулилчихвал Германыхаас огтхон ч дутах юмгүй болно гэж Суворовт ярина.

Энэ үгийг сонсоод Суворов ярвайн үрчилзэв.

—Эрхэмсэг ззэн хаан минь, энд баярлаад байх юм алга. Оросууд пруссуудийг үргэлж цохиж байсан шүүдээ. Тэгэхээр юунд нь баярлах вэ дээ гэж хариулжээ.

Эзэн хаан үг дуугараагүй боловч ууртай харцаа фельдмаршал дээр тусган дуугүй зогссоноо дахиад л:

— За чи хараач гэзгий нь, сайхан гэзэг шүү! Бас тэр шанааны нь хуузыг хараач! Ямар сайхан хууз гээч! хэмээн Суворовт хэлжээ.

— Хууз ч гэж хэмээн фельдмаршал бөвтөнөжээ.

Эзэн хаан тэсэж чадсангүй Суворов уруу эргэж, өөрчилж солиогүй байгаа оросын фельдмаршалын дүрэмт хувцас уруу нь чичилж:

— Соль! нэн даруй соль! Тушааж байна! гэж хашгирчээ. Тэгтэл Суворов:

— Оо—дарь биш! Шанааны үс

— Их буу биш, гэзэг

— Балт илд биш, харин эрхэмсэг эзэн хаан, би герман биш, төрөлхийн орос хүн! гэсэн суут үгээ хэлээд жагсаал тийш яваад өгсөн ажээ.

Павел уурсан хилэгнэж хөгшнийг зориуд Кончанск гацаа уруу цөлөхөөр явуулсан байна.



Гахайн өөх

Альпийн өндөр уулс, эгц өндөр ганга, ёроолгүй гүн ан цав, гарч болшгүй элгэн хад, шуугин хүрхрэх хүрхрээгээр дүүрэн ажээ. Уулын орой мөнх цастай бөгөөд ширүүн хүйтэн салхи цаг ямагт салхилна.

Суворов жанжин гайхамшигт цэргийнхээ эцсийн аянг Альпийн уулсыг давуулан хязгааргүй ан цав, харгиа, ганга дундуур явуулсан ажээ.

Нүд нүүргүй шуурч, цас нурж, тэнгэр муухайрч үзэж хараагүй алсын замаар цэргүүд явж гулсан, ёроолгүй ганга уруу ниснэ. Хүнд их буу чирч, хөлдөж доголсон нөхдөө зөөнөө.

Гэтэл эргэн тойрон дайсан, хэдхэн бээр яваад л байлдаан болно. Дахиад хэдэн бээр яваад л тулалдана.

Оросын цэрэг уулыг давж, дайснаа дарсаар Альпийн аян дайнаа явуулна. Аян дайнд цэргүүд өлсөнө. Авч явсан хатсан талх нь норж ялзарчээ. Швейцарийн гацаа ховор бөгөөд ядуу ажээ. Иймээс цэргүүд адуугаа идэж хөндий газраас янз бүрийн үндэс түүж иднэ. Тэгээд үндэс, адууныхаа махыг дуусмагц арьсыг нь иджээ.

Өлсөж доройтсон цэргүүд суран бүсээ эцсийн нүхэнд нь хүртэл чангалж, сайхан үнэртэй шөл, будааны амтыг дурсан ярьж санаа алдана.

— Дугуй талх, хэрчим өөхтэй ч болоосой! гэж цэргүүд хүүрнэлдэнэ. Тэгсэн чинь цэргүүд уулын нэг байшингаас хэрчим гахайн олжээ. Алгын чинээ жаахан өөх байлаа. Цэргүүд тэр өөхийг тойрч нүд нь гялалзан, хамар нь сортолзоно.

Өөхөө хуваах гэтэл нэг хүн идээд цадахгүй юмыг яаж хуваах билээ гэж асуудал болгон шуугилдан:

— Алив мөрийцье гэж нэг нь санал гаргахад

— Хэн олсон бэ тэр хүн идэг гэж нөгөөх нь хэллээ.

— Үгүй, хүн бүрд ноогдохоор хуваах хэрэгтэй! гэж гурав дахь нь хашгирна.

Ийнхүү цэргүүд маргалдаж байтал хэн нэг нь:

— Ах дүү нар аа, өөхөө Суворов жанжиндаа өгье гэж би бодож байна гэжээ.

— Зүйтэй! Суворовтоо! Жанжиндаа өгье! гэгцгээжээ. Цэргүүд Суворовын хөтөч Прошкаг дуудаж өөхөө өгөөд фельдмаршалд өг гэж тушаажээ.

Цэргүүд сэтгэл хангалуун ажээ. Прошка ч сэтгэл хангалуун байв. Тэгээд удаан хэрэглэж болох бол уу гэж түгшин хэрэв өдөрт хуруу шиг зузааныг хэрчвэл долоо хоног хэрэглэж болно гэж үзжээ.

Прошка Суворов дээр очиход:

— Гахайн өөх өө? Хаанаас олоо вэ? гэж Суворов гайхжээ. Прошка цэргүүдийн тухай ярьж, тэдний бэлэг гэж хэлжээ.

— Баатрууд минь! хүүхэд минь! гээд Суворов уйлснаа Прошка уруу эргэж, —чи яагаад авч байгаа юм бэ! Чи яасан зүрхтэй хүн бэ! Цэргүүд адууны шир идэж байхад, би гахайн өөх...гээд л гэнэт бууж гарчээ.

— Цэрэг тийм байдаг ёстойгоос хойш! гээд Прошка өөрийгөө өмөөрөх гэхэд,

— Цэргүүд чинь юу юм бэ? Цэрэг, над өөрөөс минь эрхэм зүйл. Одоохон явж өөхий нь буцааж өг. Харин баярлалаа гэж цэргүүдэд хэлээд өлмийд нь сөхрөөрэй гэж Суворов намжирджээ.

— Тэр цэргүүд чинь өөрснөө явуулсан юм шүү дээ гэж Прошка зөрөөд,

— За тэгээд алгын чинээ гахайн өөх тэдэнд гарзтай юм биш! Тэд долоосон ч гэсэн цөмд нь хүрэхгүй шүү дээ. Тэд хичнээн олон билээ дээ, тэгэхэд гахайн өөх маань нэг л хүнд болох зүйл байна гэхэд Суворов гахайн өөх уруу харвал үнэхээр жаахан ажээ.

— За тийм байна гэж Суворов зөвшөөрөөд,

— Эмнэлгийн асар уруу очиж шархдагсдад өг гэхэд Прошка дахиад л зөрж:

— Шархдагсдад аа? Тэдэнд өөхөөр яах юм? Өөхтэй өөхгүй үхнэ гэвэл,

— Нинжин сэтгэлгүй ичгүүргүй амьтан! гэж Суворов хашгираад ташуур уруугаа ухасхийжээ.

Уул хэрэг муугаар эргэх нь гэдгийг Прошка мэдэж гахайн өөхөө аваад эмнэлгийн асар уруу харайлгажээ.

Маргааш нь цэргүүд Прошкатай уулзаж:

—За гахайн өөхөө яав даа? фельдмаршал идсэн үү? Юу гэж байна? гэж асуужээ.

Прошка хариулах гээд амаа нээтэл хажууд нь Суворов ирчихсэн:

— Хүүхдүүд ээ! Баатруудаа! Сайхан өөх байна лээ. Ийм сайхан өөх өдий болтлоо идэж үзээгүй юм байна, Өвгөн ах нь их гялайлаа! гээд цэргүүдийн өмнө бөхийн хүндэтгэжээ.

Прошка гайхахдаа нүд нь бүлтрэх шахжээ. Харин цэргүүд инээлдэж фельдмаршалд ёслоод суман уруугаа явжаа.

— Таалагджээ. Үгүй тэр талархаж байгаагий нь. Гахайн өөх чинь фельдмаршалд ч таалагддаг тийм зүйл байгаа юм гэж цэргүүд замдаа шивэгнэлджээ.



"Харж байна!"

Бөгсний сэргийлэх анги дайсантай тулалдаж дуусахад ахмад Луковын суман шархдагсдаа аваад өөрийнхнийгөө гүйцэж очжээ. Цэргүүд нарийхан жимээр гүн хавцлын ирмэг дээгүүр бараг бээр газар цувралдан явна.

— Битгий хоцроорой, шархтнаа түрүүнд нь оруул! Битгий хоцроорой! гэж Луков хашгирна. Шархтнаа дамжлан явна.

Ийнхүү суман хоёр бээр газар явахад үдшийн бүрий болж, салхи үлээж, цас орж эхэллээ. Ингээд цас лавшиж, цасан шуурга боллоо.

Цэргүүд нэг, хоёр, гурван цаг явна. Аяны гал харагдаж байгаа эсэхийг мэдэхийн тулд ахмад Луков урагшаа ширтэнэ. Эргэн тойрон таг харанхуй ажээ. Цасан шуурга нүд анилзуулж салхинд цэргүүдийн цув, нөмрөг хийсэж цасан ширхэг зах ханцуйгаар орж гар, нүүр хүйтэнд янгинана. Цэргүүд харанхуйд бүдэрч, хальтарсаар явна. Цэргийн хөшсөн хөл нь арай ядан урагш хөдөлж алхаа| нь аажим аажмаар суларсаар байлаа.

— Битгий хоцор! битгий хоцор! гэж Луков хашгирна.

Дахиад нэг цаг өнгөрөхөд цэргүүд хүч тамираа барж гүйцжээ. Цэргүүд зогсож чулуун дээр суун алсан ч цааш явахгүй мэт ажээ.

— Урагшаа! Урагшаа! хэмээн Луковын дуу тасалдана. Үнэнийг хэлэхэд цэргүүдийг цааш аян замд нь хөл дээр нь босгох тийм хүч байсангүй. Луков ч өөрөө туйлдаж гүйцжээ, харанхуй уруу дахин харвал гал харагдахгүй болохоор чулуун дээр лаг хийн суужээ. Тэгтэл:

— Харагдаж байна! харагдаж байна! гэх дуу сонсдоно. Ахмад ч, цэргүүд ч сэргэж харвал дамнуурга дээрээс шархадсан цэрэг Иван Кожин өндийчихсэн гараараа урагш нь зааж байлаа.

— Гал харагдаж гэнэ! харагдаж гэнэ! хэмээн цуваа даяар цууриатжээ.

Чухам хаанаас хүч авсныг бүү мэд, цэргүүд чулуун дээрээсээ осон харайж буугаа аван дахиад л замдаа гарлаа. Манай Кожин мөн хурц нүдтэй шүү! гэж цэргүүд хөгжилдөнө.

Бээр гаруй газар явгал нөгөөх гал нь харагдаагүй тул Кожинд ойр явсан цэргүүд шуугилдаж:

— Чиний өнөөх гал чинь хаана байна? Худлаа хэлээ юу! гэхэд

— Харагдаж байна! харагдаж байна! гэж Кожин түрүүчийнх шигээ хашгирч, хуруугаараа урагш нь заана.

Цэргүүд харсан чинь юу ч харагдахгүй ажээ. Хараагүй ч гэсэн явсаар л байлаа. Үнэндээ Кожин тийм хурц нүдтэй байхыг хэн мэдэх билээ.

Дахиад л бээр орчим явсан авч нөгөөх гал нь харагдахгүй хэвээр бөлгөө. Цэргүүд дахин шуугилдаж:

— Цаашаа явахгүй!

Цаадахдаа битгий итгэ! гэлцэхэд,

— Ах дүү нараа! харагдаж байна. Ээ бурхан минь, харагдаж байна! гэж Кожин хашгираад, —
Одоо тийм холгүй байна. Бүр ойрхон байна. Тэр дүрэлзэж байгаагий нь ээ гээд дахиад л хуруугааграа заалаа.

Цэргүүд харааж гоморхсон авч явсаар л байлаа.

Жим мурийж ямар нэг хадан хошуу тойртол гэнэт доохоно бүр хажууд цасан шуурган дунд гал уласхийх харагджээ. Цэргүүд зогсож нүдэндээ итгэсэнгүй.

— Харж байна уу? гэж бие биенээсээ асууна.

— Харж байна!

— Харж байна!

— Харж байна!

— Кожин, Кожин хурц хараатай сайн залуу шүү! Хамгийн түрүүнд харсан шүү. Кожин ура!
гэж цэргүүд хашгирна.

Цэргүүд байрнаасаа ухасхийж дулаан илчит гал уруу, дайчин нөхөд уруугаа хурдаллаа.

Иван Кожинг дамнаж явсан дамнуургыг ч авчирлаа.

— Галд ойр, галд ойр бид бүхнийг аварч гавьяа байгуулсан хүн! гэцгээнээ. Иваны нүүрийг галын дөл гэрэлтүүлэхэд цэргүүд хараад сэтгэл түгшлээ.

Нүүр нь түлэгдэж зовхи нь хуйхлагдсан бөгөөд нүдний нь оронд...ажээ.

— Ах дүү нараа, энэ чинь сохор юм байна! гэж хэн наг нь шивнэв. Цэргүүд харвал Кожины нүд хоосон ажээ. Өчигдрийн тэргүүн шугамын байлдаанд францын гранат цэргийн нүдийг бүлт цохисон юм байжээ.

Генералын генерал

Альпийн аян дайныг амжилттай хийсэн учир Суворовг оросын цэргийн генералиссимус цол олгожээ.

Фельдмаршал хэсэг цэрэгтэй эх орондоо буцаж яваад хилийн нэг дэн буудалд амрахаар буудаллажээ. Тэгээд гуанзанд орж тугалын хүйтэн мах, таваг сагадайн зутан, жүнз дарс

захиалжээ.

— За мөн сайхан зутан аа! гэж магтаад, —Ийм хоол идээгүй удаж шүү. Дарс ч мөн сайхан дарс аа. Оросын цэргийн төлөө ийм дарс уухад нүгэл болохгүй гэж Суворов хэлжээ.

Байшингийн хажууд цэргүүд сууцгаан зутан зооглож, дарс ууна.

— Сайхан дарс, хатуу дарс гэж цэргүүд магтаж, —фельдмаршалынхаа төлөө ийм дарс уух нь нүгэл болохгүй гэлцэж байлаа.

Харин ганцхан Прошка л агтныхаа дэргэд эргэлдэхэд нутгийн тариачид хүрээлж:

— Танай эзний чинь цол хэргэм ямар хачин үл ойлгогдох цол хэргэм бэ? гэж Суворовын хөтчөөс шалгаана.

— Юу нь ойлгогдохгүй байгаа юм бэ? гэж Прошка хариулаад,

— Тодорхой байна шүү дээ. Генералиссимус гэж бүх генералын генерал гэж ойлговол зохино. Одоо бол хамгийн том хүн нь байгаа юм гэхэд:

— Мөн догио! гэж хөлөө ороосон залуу дуу алдахад:

— Нээрээ тийм үү! гэж уранхай өмдтэй туранхай тариачин хачирлахад:

— Гавьяа байгуулжээ гэж сахалтай тариачин зөвшөөрөв. Харин Суворов энэ үед байшингийн довжоон дээр зогсоод тэр бүгдийг сонсож байжээ. Тэгээд:

— Би биш! Би биш! гэж босгон дээрээс хашгираад, —Би гавьяа байгуулаагүй юм гээд тариачид уруу очиж, —Энэ Прошка хамгийн гол хүн. Бас тэр гээд өндөр цоохор цэрэг уруу хуруугаараа зааж, —бас энэ гээд намхан буурал бага даргыг зааж, —эд цөмөөрөө гээд бусад цэргүүдийг гараараа тойруулан зааж билээ.

Суворов ингэж хэлээд казак тэргэндээ сууж, явахыг тушаалаа.

Цэргүүд ч босож замдаа гарлаа. Замын тоос суунаглан босож цэргийн дуу цууриатлаа.

Тариачид зам дээр хоцорч учрыг үл ойлгон хойноос нь харна.

— Ноёнтон тоглоом хийлээ гэж хөлөө ороосон залууг ам нээхэд:

— Гайхамшигтай үг хэллээ гэж туранхай эр өгүүлэхэд:

— Та минь ээ! фельдмаршал үнэн ярьсан байна. Цэрэггүй бол тэд яах ч үгүй шүү дээ. Оросын хүч ард түмэндээ л байгаа юм. Тэгэхээр тэр чинь ёстой генерал байхнээ гэж сахалтай эр хэллээ.



Яруу алдар

Генерал Сарохвостов Суворовын алдарт агаархжээ. Тэгээд нэгэн өдөр цэргээсээ:

— Суворовт армийнхан яагаад хайртай байдаг юм бэ? дүү минь хэлээтэх гэжээ.

— Эрхэмсэг генерал аа яагаад гэвэл Суворов цэргийн хоол иддэг гэж цэрэг хариулжээ.

Барохвостов Суворов шиг л ногоотой шөл, цэргийн будаа иддэг болжээ. Мань генерал Суворов шиг алдаршихыг хуссэн тул ярвайсаар иддэг байжээ.

Нилээд хэдэн хоног өнгөрсөн боловч Барохвостовт алдар цуу нэмэгдсэнгүй гэнээ. Тэгэхээр нь бас л цэргээс:

— Яагаад миний алдар өсөхгүй байна вэ? гэж асуухад

— Эрхэмсэг генерал аа, яагаад гэвэл Суворов ногоотой шөл, будаа идээд зогсдоггүй цэргийн адил унтдаг гэж цэрэг хариулжээ.

Барохвостов жирийн майханд хатуу өвсөн дээр цэргийн адил унтдаг болжээ. Генерал булбарай зөөлөн биеэ нухуулан нухуулан даарч дагжих авч тэвчиж байлаа. Суворов шиг алдарших хүсэл нь тийм их байж.

Бас л хэдэн хоног өнгөрсөн авч генералд алдар цуу нэмсэнгүй. Дахиад л нөгөө цэргийг дуудаж:

— Суворовт өөр ямар нууц байдаг вэ хэл? гэхэд,

— Фельдмаршал цэргүүдээ хүндэлдэг гэж нөгөөх цэрэг хариулжээ.

Ван Барохвостов өөрийнхөө доорх хүмүүсийг хүндэтгэж цэргүүдэд эелдэг зөөлөн үг хэлдэг болжээ.

Чингээд ч генералын алдар цуу нэмэгдсэнгүй гэнээ. Цэргүүд генералыг харж жуумалзахаас өөр зүйл нэмэгдсэнгүй.

Мань генерал уурлаж дахин нөгөө зөвлөгч цэргээ дуудаж:

— Ногоотой шөл, будаа идлээ, сүрэл дээр унтлаа, цэргүүдэд эелдэг зөөлөн үг хэллээ, тэгээд яагаад над алдар цуу ирэхгүй байна вэ?! гэж Ван Барохвостов зэвүүцэн асуухад,

— Эрхэмсэг генерал аа, энэ ч юуч бишээ хэмээн цэрэг хариулахад

— Өөр бас юу байдаг билээ? Суворовт бас ямар нууц байдаг юм бэ! гэхэд нь:

— Суворовт дайснаа дарж чаддаг бас нэг нууц байдаг юм гэж цэрэг хариулжээ.

Харин Барохвостов үүнийг л хийж чаддаггүй байжээ. Чухам иймээс түүнд алдар цуу ирсэнгүй, мань генерал ор сураггүй талийжээ. Харин Суворовын яруу алдар үеийн үед үлдэж түүнийг хүн болгон мэддэг болжээ.

Баатрын хүч



Цэргүүд гүүрэн дээгүүр алхана

1812 оны зун. Неман голын гүүр. Оросын хил. Цэргүүд гүүрэн дэдгүүр хороо, хороогоороо, цуваа, цуваагаараа алхална. Франц, австр, прусс, саксон, Итали, швейцар янз бүрийн үл ойлгогдох хэл яриа сонсогдоно. Гамбург, Бремен нутгийн хүмүүс, голланд, бельги, испани цэргүүд гүүрэн дээгүүр алхална.

— Эзэн хаан мандтугай!

— Франц гүрэн мандтугай!

— Яруу алдар нь бадраг, яруу алдар нь бадраг! хэмээх дуу тал талаас цууриатна.

Наполеон араб үүлдрийн дүүхгэр морь унаж гармыг ширтэнэ. Францын эзэн хаан дүрэмт хувцасныхаа товчийг ярайтал товчилж, гурвалжин оройтой малгайгаа дух уруугаа хэлтгий тавьсан байх багөөд магнай нь үрчийн бодлогоширчээ.

Бараа бологчид архан талд нь хагас дугуйрч хүндэтгэлтэйгээр үг дуугүй ажээ. Харин өглөөний агаарт үхэр хэдгэнийн дүнгэнэх л тодхон сонсдоно.

Наполеон өөрийнхөө ойр дотнын хүмүүсийн нэг генерал Коленкур уруу гэнэт эргэж:

— Та чинь франц хүн биш байх аа! гэж эзэн хаан хашгирлаа.

Колнкор хариу өгсөнгүй.

— Та чинь франц хүн биш байх аа! гэж Наполеон бүр ч ууртай хашгирлаа.

Өчигдөр цэргийн зөвлөл дээр Коленкур ширүүн үг хэлсэн юмсанжээ. Бүх маршал, генералуудын дотроос тэр ганцаараа Оросыг эсрэг дайн хийхийг эсэргүүцэж:

— Энэ бол тамын зам юм гэсэн ажээ.

— Манайд оросын талыг баримтлагч байна! гэж Наполеон хашгираад

Коленкурыг зааж байжээ.

Тэгээд өнөөдөр ч уур нь гараагүй тул генерал уруу тайван харж чадахгүй байжээ.

— Оросын сахал ургуулж, орос нөмрөг, шаахай өмс гэж Наполеон доромжилжээ.

Холгүй байгаа ойн цаанаас наран мандаж, бяцхан улаан цацраг хөх огторгуйг шарж, дараа нь орос пийшингийн амыг нээсэн мэт гал улаан цагираг хөөрч, нүд гялбам төөнөн халуун нар огторгуй дээгүүр жирийнэ.

Наполеон дөрөөн дээрээ өндийж:

— Аустерлицийн 1 нар энэ дээ! гэлээ.

— Эзэн хааны яруу алдар бадартугай!

— Францын яруу алдар бадартугай!

— Мандтугай, мандтугай, мандтугай! гэж тал талаас хашгирна.

Эргэн тойрон улаан, шар, хөх дүрэмт хувцас эрээлжилнэ. Энэ бол огторгуйн цэнхэр өнгө, үнсэн саарал өнгө, ойн өвс ногооны өнгө ажээ. Галзуурсан мэт бөмбөр дэлдэж армийн бүрээ, бишгүүр хангинаж цэргийн хөлийн чимээ сонсдоно.

Цэргүүд гүүрэн дээгүүр алхална. Нэг, хоёр гурван цаг, хоёр гурван өдөр цэргүүд гүүрэн дээгүүр алхална. Тэд үхэл уруугаа явж байгаа нь энэ ажээ.

Наполеон Австрийн хот Аусгерлицад нилээд том ялалт хийсэн юм.

Хөгшин бага даргын үлгэр

Оросын цэрэг бээр бээрээр ухран холдсоор байлаа. Тэд талаар, ой тайгаар, гол мөрнөөр, ус намгаар, уул хадаар, гуу жалгаар явна. Оросын цэрэг ухарч явна. Оросуудад зохих хэмжээний хүч байсангүй.

Цэргүүд дургүйцэн хүнгэнэлдэж:

— Бид чинь аймхай туулай юм уу!

— Бид чинь мэлхийн цустай улс уу!

— Оросууд дайсан уруугаа шилээ харуулан зугтаж байхыг хаана харсан юм бэ! гэлцэх сонсдоно. Цэргүүд тулалдахыг хүснэ.

Оросууд хоёр армитай байжээ. Генерал Барклай де Толлийн командалсан нэг арми нь Вильн Дрисс, Полоцк уруу ухарч байхад хоёрдугаар арми нь Гродно хотоос Слуцк, Бобруйск уруу генерал Багратионоор толгойлуулан ухарч байлаа.

Наполеоны цэрэг Барклай, Багратион хоёрын армийг нийлүүлснээс гурав дахин их цэрэгтэй ажээ. Францчууд оросын армийг нэгтгэх боломж өгөхгүй саланга саланга цохихыг хүсчээ.

Заналт дайсантай үзэлцэх хүч оросуудад одоохондоо алга гэж оросын генералууд мэдэж байлаа. Тэгээд цэргээ хайрлаж хороодоо ухруулж байлаа.

— Ээ дээ юу л болж байна даа?!

— Цэргийн алдар нэр өнгөрчээ! хэмээн цэргүүд санаа алдана. Хөгшин бага дарга нөхдийгөө ширтэж, нөхдийнхөө хамт алхана.

— Би та нарт нэг үлгэр ярих уу?

— Ярь л даа ярь.

Цэргүүд дугуйран сууж чимээгүй боллоо.

— Эртээ урьд гэвэл зрт урьд биш, энэ нэгэн цагт ой дотор зэвхий саарал чоно ходолтой тааралдаж аймшигт шүдээ ярзайлгаж: «ходол, ходол би чамайг иднэ» гэжээ.

«Зэвхий саарал минь хүлээж үз. Би дөнгөж хорвоотой золгоод байна. Би өсөж том больё» гэж ходол хэлжээ.

Ойн дээрэмчин зөвшөөрч яахав, ходол өсөж мах шөл нь арвин болог гэж боджээ.

Цаг хугацаа удаан түргэн өнгөрснийг бүү мэд, саарал чоно нөгөө ходолтой тааралджээ. Харвал ходол тэр хугацаанд том болсон байжээ. Ходол эвэр ургаж, туурай нь бэхэжсэн

байжээ. Нэг үгээр хэлбэл чононы өмнө тугал биш том хандгай байжээ. Хөнөөлт чоно шүдээ ярзайж «Хандгай, хандгай би чамайг иднэ» гэжээ. «Тэг, тэг саарал чоно минь ид, харин төрсөн нутагтайгаа салахыг зөвшөөрнө үү?» гэж хандгай хэлжээ.

«Тэг, тэг» гэж чоно хэлжээ.

Залуу хандгай төрөлх, хязгаар нутгаараа царсан ой шугуй, тал хээрээр явж төрөлх нутгийнхаа шимийг хүртэж хүчтэй болсоор байжээ. Чоно тэгээд дагаад л гүйгээд байжээ. Тэгж явсаар чоно ядарч эцэж туйлдан үс нь зулмарч хавирга нь хэрзийж, хэл нь өөрийн эрхгүй санжигнана.

Зогсооч, зогсооч гэж гайхал чоно дуугармагчаа болжээ.

Цаг хугацаа удаан, түргэн өнгөрснийг бүү мэд, нэг удаа хандгай чононы өмнөөс эргэн харж зогсжээ. Чоно харвал өмнө нь жирийн нэг хандгай биш нас бие гүйцсэн том хандгай зогсож байлаа. Саарал боохой шүдээ ярзайж:

«Хандгай, хандгай би чамайг иднэ» гэжээ.

Ойн үзэсгэлэн гуа болсон хандгай инээмсэглэж:

— Алив наашаа хүрээд ир гэжээ.

Чоно ч урагшаа дайрчээ. Гэтэл түүнд хуучин хүч нь байсангүй, харин хандгай ч нөгөө ходол биш болжээ. Баатар хандгай хойд хөл дээрээ зогсож цоройгоод чоныг хүнд туурайгаараа чавчиж эврээрээ дээр өргөн газар чулууджээ! Ийнхүү саарал дээрэмчин цааш харжээ гээд бага дарга дуугүй болжээ.

Цэргүүд ч үлгэрийн утгыг бодон санааширчээ.

— Ухаантай тугал байсан бололтой.

— Бие гүйцсэн хандгай болтлоо өсөж шүү!

— Хүүш та минь ээ, энэ үлгэрт чинь нэг санаа байна.

— Ухраад! ухраад! гэх команд өглөө.

Цэргүүд босон харайж эгнэн жагсаад тэргүүнээ өргөж тал хээр, ой тайга, царсан шугуй, хотгор гүдгэрээр алхална. Тэгэхдээ харь нутгаар биш төрсөн газар шороон дээрээ алхалж яваа билээ.

"Тэр баатрууд чинь хаана байна вэ?"

Оросын армиуд Смоленскийн ойролцоо нэгдэж тулалдаанд орсон билээ. Францчууд хотыг хоёр өдөр дайрчээ.

Дайралт. Дахиад л дайрна. Дайралт. Дахиад л дайрна.

Цэргийн хөлийн чимээ, их бууны зэрлэг нүжигнээ, алагдсан хүмүүсийн овоо хачин жигтэй ажээ.

Цэргүүд команд ч хүлээлгүй францчуудын өөдөөс дайрч жадална. Баатрууд улайрчээ. Галт сум нь галт сум л юм. Гар бөмбөг байвал байг, цэрэг юунаас ч айхгүй ажээ. Нэг цэрэг, суман францын өөдөөс, хоёр цэрэг бүхэл бүтэн хорооны өөдөөс дайрна.

Симбирск, Волын, Уфимийн хороо мөр зэрэгцэн тулалдана.

Бусад суман хороод ч тулалдаж баатарлагаараа бие биенээсээ дутахгүй ажээ.

Симбир нутгийн цэрэг Егор Пинаев эгэм уруугаа жадлуулж, бие нь улаан нил болсон авч өвчнөө мэдэхгүй:

— Дайраад, дайраад! гэж хашгирна.

Волын нутгийн Петр Заноз гар бөмбөгөнд чихээ тас авахуулсан авч цусаа арччихаад нөхдөө хөгжөөж:

— Ялаа шувуу биш, хонь өлөгчин чоно биш, чих толгой биш гэж хошигнож байжээ.

Уфим нутгийн Рассад галт суманд хөлөө хугалж газар унасан чигээрээ онилж дайснаа буудаад:

— Ах дүү нараа урагшаа! гэж байжээ. Баатрууд тулалдаж, цусан далай урсана.

Хоёр дахь өдрийн орой дайсны их бууны аймшигт галлалтаас! Смоленек хот шатжээ.

Галын дөл огторгуй өөд цойлж, мянга, мянган оч тал тал тийшээ үсчин, гудамжаар дүүрэн утаа баагиж, Днепр мөрний дээгүүр манан бүрхжээ. Байшин барилга шажигнан нурж дөлнөөс хорогдох газаргүй, амьсгалахад ч хэцүү ажээ. Гал эргэлдэн хуйлран ноцож Смоленскийн толгод өөд мацна.

Симбир, Волын, Уфим нутгийнхан тулалдаж байлаа. Бусад суман, хороод ч тулалдаж байлаа. Баатрууд айхыг үл мэднэ.

Францчуудад шинэ шинэ анги туслахаар ирнэ. Барклай де Толли францчуудаас хүч давамгайлж чадахгүйгээ мэдэж шөнө болмогц ухрах тушаал цэрэгтээ өгчээ.

Хороодоо шугамнаас нь авч чимээ аниргүй Днепр мөрнийг гаталжээ. Дахиад л бээр бээрээр газар ахина.

Пинаяв эгнээндээ алхална. Заноз жагсаалдаа алхална. Харин Рассадыг тэргэн дээр ачиж явна.

Симбир, Волын, Уфимчууд алхална. Бусад суман, хороод ч алхална. Цэргийнхээ хажуугаар генерал Барклай де Толли явж өнгөрөхдөө:

— Баатруудын алдар мандтугай! гэхэд цэргүүд бие биенээ харж,

— Барклай де Толли хэнд баяр хүргэж байна? гэлцэнэ.

— Волынчуудад баяр хүргэж байгаа байх гэж Симбирчууд бодно.

— Уфимчуудад баяр хүргэж байгаа байх гэж Волынчууд бодно.

— Симбирчүүдэд баяр хүргэж байгаа байх гэж Уфимчүүд бодно. Цэргүүд тал тал тийшээ харж:

— Тэр баатрууд чинь хаана байна? гэлцэнэ.



Байлдааны уран мэх

Кутузовын амьдрал хэцүү бэрх боловч яруу алдартай байж билээ.

1812 онд Михаил Илларионович Кутузов жаран долоон настай байлаа. Тэр олон зүйл ардаа хийжээ.

Аян дайн тулааныг тоолохын аргагүй ажээ. Крым, Дунай, Австрийн тал, Измаилийн ширүүн өдрүүд, Алуштын ойролцоох тулалдаан, Очаковын бүслэлт, Кагулийн дэргэдэх шаргуу тулалдаан зэрэг олон аян дайн хийжээ.

Кутузов гурван удаа шархдахдаа толгойдоо хоёр удаа, хацартаа нэг удаа шархаджээ.

Кутузов нэг тулалдаанд баруун нүдээ бүлтлүүлжээ. Уг нь халагдаж өвгөдийн адил ясаа амрах цаг аль хэдүйн болсон авч тийм бишээ. Ард түмэн Кутузовыг үгүйлжээ. Тэгээд одоо ч агт морьдоо бэлтгэж цугларчээ.

Шинэ ерөнхий жанжин Кутузов дайчид уруугаа ирж явна.

Цэргүүд эгнэн жагсчээ. «Кутузов францчуудыг цохихоор ирж явна» гэж эгнээнээс эгнээ дамжин цэргүүд ярилцана. Хатирч морь нь замаар халигуулж, нар эгц дээрээс төөнөж, царцаахай амгалан донгодож бүлээн салхи өвс ногоог элэн таална.

Кутузов явах замдаа: «Манай үйлс ч муухан байна даа. Арми ухарна гэдэг чинь базаахгүй хэрэг. Оросын цэрэгт ийм явдал байгаагүй л юмсан. Зоригт бүргэдүүд ээ!

Тийм ээ манай хүч одоохондоо сул дорой байна шүү. Армиа хамгаалах хэрэгтэй. Армигүй бол Орос улс сөнөнө. Гэхдээ цэргээ таньж мэдэх хэрэгтэй. Орос хүний сэтгэлийг ойлгох хэрэгтэй» гэж дотроо бодож явлаа.

Кутузов дайчид дээрээ ирлээ.

— Ура! Эцэг минь биднийгээ тулалдаанд жолоод, бид чинь тулалдахыг туйлгүй хүсэж, цангаж гүйцлээ гэж цэргүүд ерөнхий жанжиндаа хэлж байжээ.

— Та нарын зөв, үнэн байна. Дайснаа дарах цаг болсон гэж Кутузов хариулжээ. Цэргүүд сэтгэл хангалуун, бие бие уруугаа нүд ирмэж ёстой л дайчин генерал шүү гэлцэнэ.

— Бид чинь орос хүн биш үү? Бидэнд бурхан тэнгэр хүч өгөхөөс таггалзаа юү? Бидний зориг дутаж байна гэж үү? Бид хичнээн ухрах юм бэ! гэж Кутузов үргэлжлүүлэн ярина.

— Ийм л үг байх ёстой юм.

— Генерал Кутузов мандтугай! гэж цэргүүд хашгирна. Цэргүүд сэтгэл хангалуун ажээ.

За, ах дүү нараа, алхам ч ухрахгүй шүү. Маргааш шийдвэрлэх тулалдаан болно гэлцэнэ.

Цэрэг эрс тайван нойрсчээ. Маргааш өглөө нь сэрэхэд Кутузовын анхны тушаал гарчээ. Тэр тушаал дээр ухралтыг үргэлжлүүл гэж цагаан цаасан дээр хараар бичсэн байлаа.

Цэргүүд шуугилдаж:

— Тулалдах яалаа!

— Нэг л ойлгогдохгүй байна гэлцэн гараараа дургүйцлээ илэрхийлнэ.

— Хуучин үеийн тушаал хэвээрээ үлдсэн юм болов уу? гэлцэнэ. Тэгээд Кутузовыг хараад:

— Хүчирхэг жанжин минь, дахиад л ухрах хэрэг үү? гэхэд Кутузов цэрэг уруу харж өрөөсөн нүдээ зальтайгаар онийлгон:

— Ухарна гэж хэн хэлсэн юм бэ? Энэ чинь байлдааны уран мэх байхгүй юу! гэжээ.

Шинэ албан тушаал

«Эрхэм өршөөлт ноён Михаил Илларионович аа!...» гэсэн захиаг

Кутузов уншиж байлаа.

Уул захиа генералын хуучин танил, чөлөөнд байгаа нөхрөөс нь ирсэн юмсанжээ. Генерал Кутузовтой олон жил хамт алба хааж байсан болон аян дайнд явж байсан тухайгаа дурсаж, ерөнхий командлагчийн шинэ тушаалд дэвшсэн явдалд баяр хүргэж шинэ их амжилт хүссэн байв. Гэвч чухам юуны тулд захиа бичсэн нь эцэстээ гарчээ. Генерал өөрийн хүү залуу дарга Гришенькийн тухай өгүүлсэн ажээ. Генерал, Кутузовыг хуучин нөхрийн хувьд хүүгий минь асрамжилж штабтаа, бүр туслахаараа авбал сайн байна гэсэн байжээ.

— За бид ийм юмнаас эхлэх ёсгүй л юмсан. Одоогийн залуучууд нэг л бишээ. Дулаан тайван амьдрал, байр дагнан хайж байх юм. Цөмөөрөө л штаб, штаб гэлцэн тулалдааны талбай уруу явах] хүн байхгүй болжээ гээд Кутузов санаа алдав.

Гэвч нөхөрлөл бол нөхөрлөл. Тэр генерал дайчин гавьяатай генерал байсан учир Кутузов хүндэтгэж гуйлтыг биелүүлэхээр шийджээ.

Хэдэн хоногийн дараа Гришеньк хүрэлцэн иржээ.

Кутузов харвал өмнө нь дарга битгий хэл бүр нусгай жаал зогсож байжээ. Саваа шиг нарийхан туранхай, уруулынхаа сахалд тонгорог хүргэж огт үзээгүй хүүхэд байлаа.

Кутузов хараад инээд хүрчээ. Нээрээ залуучууд ч залуучууд биш болжээ, дарга ч дарга биш болжээ. Бие сэтгэл нь сул дорой болжээ.

Кутузов Гришенькаас эцэг эхийн нь тухай асуув.

— За. яв. Би Петр Никодимычийн гуйсныг биелүүлсэн юм, явж хиа хувцас оёул гэжээ.

Гэвч тэр дарга явсангүй.

— Эрхэм гэгээнтэн!... гэхэд нь Кутузов залуу дарга талархаж эхлэх нь дээ гэж бодоод хөмсөг зангидан:

— Яв! яв! гэвэл

— Эрхэм гэгээнтэн!.. гэж Гришеньк дахиад л эхлэхэд Кутузов «Яасан салдаггүй амьтан бэ?» гэж бодон:

— За юу гэх гэв? гэвэл

— Михаил Илларионович, хороо уруу явуулж өгөөч... Би ван Петр

Багратионы армид очих гэсэн юм хэмээн Гришеньк шулганажээ.

Кутузов энэ үгийг дуулаад баярлан хөгжиж бяцхан дарга уруу харвал дээд уруулд нь сахлын оронд шар үс сэрвийнэ. Хүүхэд, шал хүүхдээрээ юм гэж бодлоо. Кутузовг залуу хөөрхийлөлтэй санагдана. Ийм шувуухайг чинь яаж сумны өөдөөс явуулах вэ дээ...

— Үгүй явуулахгүй, би чиний эцэгт чамайг энд байлгана гэж амласан юм гэхэд тэр даргын уруул татваганаж хариугүй уйлмаар боллоо.

— Үгүй, чадахгүй нь гэж Кутузов давтан хэлээд.—чамайг яаж хороо уруу явуулах юм бэ? Чамайг цэрэг чинь тулалдаанд анзаарахгүй шүү дээ гэвэл дарга гоморхож:

— Суворов ч өндөр хүн байгаагүй шүү дээ.

Кутузов түүнийг гайхан ширтэж, Гришеньк бол эцгийнхээ буянгаар амьдрахыг хүсдэг тэр хүүхдийн адил хүүхэд биш гэдгийг ойлгож, фельдмаршал дарга дээр очиж үнсэж:

— За, за чиний эцэг ч цагтаа... гээд яриагаа дуусгаж чадалгүй хөгшчүүлийн амархан гардаг нулимс нүдий нь бүрхжээ.

Тэд нилээд дуугүй зогссоны эцэст Кутузов гараа дохиж:

— Яв, яв. Өөрийнхөө замаар дуртай зүгтээ нис гэжээ, Гришеньк ёсолж өсгий дээрээ овжин эргээд гарчээ. Кутузов жанжин хойноос нь удаан бодлогошрон харснаа, ам дөрвөлжин цаас авч хөгшин генералд ийнхүү захиа бичжээ.

«Өршөөлт ноён, Петр Никодимович аа! Бурхан тэнгэр надруу агуу их баяр баясгалан заяажээ. Чиний Гришеньк чинь хүрэлцэн ирлээ. Хүү чинь ерийн нэг шинэ найлзуур биш, ёстой хүү байна гэж над бодогдлоо. Ийм сайн хүү төрүүлсэнд чинь баярлалаа. Түүнийг баатар болно гэж найдаж байна...» гэснээ бодолхийлж:

Таны хүсэлтийг биелүүллээ. Одоо Гришеньк миний хамгийн нандин газар сэтгэл санааны минь хиа болсон...» гэж дахин бичжээ.

Хөгшин генерал Кутузовын захиаг хүлээж аваад:

«Сэтгэл санааны хиа гэдгийг чинь яаж ойлговол зохих вэ? ээ дээ! би ч цэргийн талаар хоцорч дээ. Ерөнхий Командлагчийн дэргэд шинэ албан тушаал бий болсон юм байлгүй» гэж толгойгоо эргүүлжээ.

Татар цэрэг

Гжатска хотын дэргэд цэргүүд амь үрэгдсэн нөхдөө оршуулж байжээ. Тэд том нүх ужжээ. Гурван хусны дэргэдэх толгод дээр аятайхан газар сонгон авчээ.

Зүүн тийшээ харвал голын ус угалзлан урсаж, баруун тийшээ харахад зам зурайж урагшаа харвал оросын хязгааргүй уудам тал цэлийж харагдана.

Баатрууд тайван нойрсоно.

Цэргүүд амь үрэгдэгсдээ толгод дээр авчирч нүхний амсар дээр тавихад армийн лам хойтохыг нь уншихаар иржээ.

Алагдагсад жагссан мэт харагдана. Гагцхүү нүд нь аниастай ажээ. Бүгдийн нь гарыг цээжин дээр нь тавьжээ.

Хөгшин залуу, тарган туранхай, сахалтай сахалгүй, өтгөн шингэн хөмсөгтэй, янз бүрийн царайтай ажээ. Харин тэдний дунд бараг хөмсөггүй авч өргөн шанаатай залуу байлаа.

— Хүүе энэ чинь татар хүн байна шүү дээ. Татар хүн хрестьян шүтлэггүй, өөр шүтлэгтэй одоо яах билээ. Хойтохы нь яаж хөтөлдөг юм болдоо? Бурхан тэнгэр ийм юманд битгий л хилэгнээсэй гэж бодон цэргүүд бөөгнөрөлдөн өөр хоорондоо шивнэлдэнэ.

— Тэгж яаж болох вэ. Бидэнтэй хамт Орос улсын төлөө тулалдаж яваад үхсэн шүү дээ. Хрестьян шүтлэггүй байг л дээ, тэгэхдээ цэрэг эрийн цус шүү дээ. Үгүй, хрестьян шүтлэггүй гээд түүнийг өөр тийш нь гаргаж хэрхэвч болохгүй, бүгдтэйгээ л хамт байг гэлцэнэ.

Лам ирж бойпороо гаргаад сахлаа илж уншлагадаа бэлдлээ. Тэгээд уншлагаа эхлэх гэтэл татар цэргийг харж хөмсөг зангидан:

— Үүнийг ав! гэлээ. Цэргүүд огтхон ч хөдөлсөнгүй.

— Үүнийг ав! гэж санваартан дахин хэллээ.

— Эрхэмсэг гэгээн минь, яахав хамт үлдэг л дээ. Энэ чинь цэрэг хүн. Бурхан тэнгэр зэмлэхгүй шүү дээ гэж цэргүүд гуйжээ.

Энэ үгийг дуулаад ариун санваартны царай зэвхийрч сахалтай шанаа нь шалчийж, ам нь тэвхэдсэн мэт ангайж:

— Бурхан номоо муучилсан, Хрест багшаа худалдсан хогууд! гэж ламтан хашгираад,

—Ариун хутагтад залбир, залбир!... гэлээ.

Цэргүүдийг харвал үг дуу ч үгүй, чимээ анир ч үгүй ажээ. Тэд сэмээрхэн ухраад л явмаар байжээ. Гэвч цэрэг ёсоор ахан дүү болсон явдал л тэднийг тогтоож байлаа.

Яг энэ үеэр гурван хусны толгой дээгүүр Кутузов жанжин явж байжээ. Тэгээд булш, үхсэн цэрэг, санваартан тэргүүтнийг хараад Кутузов малгайгаа авч мориноосоо буун наманчлаад:

— Эрхэмсэг гэгээнтэн, юу болоо вэ? гэхэд санваартан уг явдлыг тайлбарлан ярихад Кутузов алагдсан цэрэг, татар цэрэг, амьд цэрэг бүгдийг харснаа санваартанд хандаж!

— Цэрэг хүнийг хүндэтгэж болохгүй юү? гэж асуухад:

— Эрхэмсэг жанжин минь бурхнаас эмээ!...гэхэд

— За, заа гэж ерөнхий командлагч хөмсөг зангидсанаа,. цэрэг, санваартан уруу дахин харж бойпорыг заагаад,

—Алив наадахыгаа өгөөтөх гэжээ.

Ламтан мэгдэж бойпороо өгвөл Кутузов авч бойпороор даллан ариутгах ёслолыг гүйцэтгэжээ.



Нам жимийг эвдсэн нь

Бородино гацааны төвд байгаа сүмийн хонхны тагт дээр гарч тал тал тийшээ анхааралтай хараарай.

Асар их гуу жалга огточсон энэ тал дээр 1812 оны есдүгээр сард үхэшгүй мөнхийн тулалдаан болсон юм.

Орос орны агуу их алдар тэр тулалдааны талбай дээр бэхжиж, бидний алс тэр цагийн өвгөдийн минь гэрээс үлдсэн билээ.

Тийм ч учраас бид тэр асар уудам талбай, тэр агуу их баатарлагийн өмнө бөхийн хүндэтгэдэг бөлгөө

Дурсан сана! “ Мэдэж ав!

Бүү март!

Кутузов жанжин үүрийн гэгээнээс өмнөхөн хэнд ч огтхон ч хэлэлгүй морио унаж харанхуйгаар яваад, Бородиногоос бүтэн хагас бээрийн зайтай очиж Горка гэдэг бяцхан тосгоны дэргэдэх толгод дээр зогсжээ. Тэрээр өчигдрөөс хойш л тэр газрыг сонирхсон юмсанжээ.

Тулалдааны үеэр тэнд ерөнхий жанжин Кутузов байх болно.

Баруун талд нь Колоча гол Москва голтой зэрэгцэн махиралдан урсана. Эндээс оросын цэргийн байрлалын баруун жигүүр эхэлж байгаа ажээ.

Дараа нь оросын хороодын шугам шинэ Смоленскийн замыг хөндлөн гарч алс зүүн тийшээ бүтэн долоон бээрээс багагүй газар Семеновын горхи, Семенов гацаа хуучин Смоленскийн зам,, Утиц тосгон хүртэл зурайна.

Хэд хэдэн өндөрлөг дээр оросын цэргийн батарей байрлажээ. Толгодын батарей гэж нэрлэгддэг эдний нэг нь Бородиногийн тулалдааны гол газар болох ёстой байлаа.

Энэ бол Раевын суут батарей юмаа. Түүнээс зүүнтээ Семенов гацааны

цаагуур дайсан уруу өнцгий нь харуулсан газар нуувчууд байх нь цуут

Багратионы нуувчууд ажээ.

Оросын армийн баруун жигүүрийг Баркляя де Толлийн арми эзэлж байлаа. Зүүн армийг Багратион командалж байлаа.

Үндсэн хүчнээсээ нилээд бээрийн зайтай бут сөөгтэй хотгор дотор морин цэрэг, казак зуут, бэлтгэл хорооднуугдаж байжээ. Тас харанхуй ажээ. Кутузов морин дээрээ чимээгүй сууна.

Шатан дүрэлзэх хуарангийн галын гэрлээр дайсны цэргийн байрлалыг тааж болох ажээ.

Дайсны байрлал дахь хөдөлгөөнийг хашир дайчин хурц сэргэлэн зөнгөөрөө мэдэрч байлаа.

Кутузов мориноосоо яаралгүй буулаа. Нүсэр том биетэй, настай хүн хөндлөнгийн туслалцаагүй бол хэцүү байлаа. Залуу нас эргэж ирэхгүй шүү дээ.

Ерөнхий командлагч янцаглаж амьсгаадсаар сөхөрч суун бөхийгөөд чихээ газар наалдуулан өөрийнхөө тааврыг шалгана.

Шөнийн нам жимд газар битүү нүргэлнэ. Кутузов хөгжимчний адил бяцхан дуу чимээг эндэгдэлгүй тодорхойлно.

Тэгснээ босож мориндоо мордоод шөнийн алсыг дахин дахин ширтэнэ.

Дорнодод үүрийн цагаан гэгээ тэмдгэрч турлиах мөчир дээр гарч сууна. Кутузовын унасан морь өвс чавчилж аяархан янцгаана.

Кутузовын бараа бологч генералууд, штабын дарга нар, хианууд санаа зовнин давхилдан ирж Кутузовыг хүрээллээ.

Дорно дахин улам улам гэгээрсээр ажээ. Толгойн орчим газар яг чиний алган дээр байгаа мэт ажээ. Цөм чимээ аниргүй нам жим ажээ.

Цэрэг ч хөдөлгөөнгүй, тал ч нам жим, гагцхүү үүлс ойн дээгүүр муур хэтэх лугаа адил зугуухан хөвнө.

Тэгтэл их бууны чимээ ниргэж тэр их нам жимийг эвдсэн Ийнхүү Бородиногийн тулалдаан эхэлсэн ажээ.

Багратионыг хаанаас хайх вэ?

Кутузов тулалдааны өмнө зүүн жигүүрт цэргээ байрлуулж Багратионы армийг тавьжээ. Энэ бол орох зам задгай, хамгийн аюултай газар билээ. Францчууд яг эндээс дайрна гэдгийг Кутузов мэдэж байв.

— Петр вангийн цэрэг цөөтөхгүй биз? гэж штабын генералуудын нэг нь сэтгэл түгшихэд:

— Энд чинь Багратион байгаа шүү дээ. Тэгэхээр хүчийг хоёр дахин ихэсгэнэ гэж Кутузов хариулжээ.

Нээрээ Кутузовын бодсончлон Наполеон зүүн жигүүрээр дайрчээ. Эзэн хаан Багратионын газар нуувчийг авах, дараа нь цэргээ төв уруу хаях төлөвлөгөөтэй байжээ. Францын нэг зуун гучин их буу гал нээж морин цэргийн гурван корпус газар нуувч уруу дайрч, хэдэн арван явган хороод тэр жаахан газар хутгалджээ. Францын шилдэг маршал Ней, Даву, Мюцарт нар дайралтыг биеэрээ удирдана.

— Нэг генералын эсрэг ийм олон маршал тавих гэж хэмээн оросын цэргүүд тоглоом хийнэ.

— Багратион ван уруу таван маршал ч явуулбал явуулаг!

— Хүүхдүүд ээ, битгий зүрх алд, барьж бай! гэлцэнэ. Францчууд дараа дараагаар дайрч айхыг үл мэднэ. Газар нуувч уруу дайрна, үхэгсдийн оронд шинэ баатруудын эгнээ тодорно

— Зүйтэй, зүйтэй! гэж Багратион хашгирна. Магтуулсан баатрууд тэсэхгүй байж болохгүй! гэнэ.

Гэвч оросууд шаантаг шиг ажээ. Багагүй чин зоригтой байлаа. Хоёр лут хэрэм мөргөлдлөө. Баатар, баатартайгаа тулалдаж, зоригтон зоригтонтойгоо үзэлцэж, үнэндээ л алх дөш гэсэн үгээ. Оросууд ч алхам ухрахгүй, францчууд ч алхам давшихгүй ажээ. Гагцхүү үхсэн цэргийн дов ихэссээр л байлаа.

Газар нуувчны дэргэдэх дайн тулаан намдаагүй байна. Наран бүр дээр хөөрчээ. Гэвч газар нуувч бууж өгөхгүй л байлаа.

Эзэн хааны төлөвлөгөө биелэгдэхгүй байгаа учир Наполеоны уур хүрч хоёр, гурав, дөрвөн зуун их буу явуулна. Эзэн хааны зарлиг маш ширүүн ажээ.

— Бүх хүчээ зүүн жигүүр лүү чиглүүл! гэжээ. Тулалдаанд шинэ хүчнүүд орсоор байлаа.

— За Багратион яаж ухарч байна? гэхэд

— Ухраагүй байна, эрхэмсэг эзэн хаан минь гэлээ.

Кутузов Багратион уруу элч довтолгоно. Элч янз бүрийн зарлиг, тушаал, сургамж зөөнө. Байлдааны үед генералыг хайж олоход хэцүү ажээ. Багратион нэг газраа удаан байдаггүй

байв.

— Би генерал биш, анхны цэрэг гэж тэр тоглоом болгох дуртай билээ. Элчүүд Петр ванг хайна.

— Энд л байгаа байх гэтэл

— Генерал тийшээ явсан гэж элчийг өөр тийш нь явуулна. Элч тийшээ давхиж очвол:

— Тиймээ байсан, яваад өгсөн гэх хариу сонсдоно.

Элч тийшээ давхиж очвол бас л байхгүй байна. Хөөрхий элч үнэт цагаа алдаж, морины нь хөлс асарна.

Харин ганцхан дарга Воейков л Кутузов жанжнаас тушаал хүлээж авмагц л тэр дороо Багратионыг олно.

Бусад элч атаархаж «энэ Воейков яасан үйлстэй амьтан бэ гэлцэнэ. Тэгээд түүнийг алдаа эндэгдэлгүй яаж олдгийг шууд давхин давхин мэдэхийг оролдоно.

— Маш амархан гэж Воейков хариулаад, Петр Иванович Багратион ван өөрөө над тусалдаг юм гэдэг байв.

Бусад дарга нар гоморхож, Воейков тоглоом хийж байна хэмээн ойлгож:

— Чи бидний толгойг битгий эргүүлээд бай. Бид тийм тэнэг амьтад биш ээ. Чи нууцаа л хэл гэхэд Воейков хөхөрч:

Нууц гэнээ? Тэр нууц чинь л энэ байна гээд Багратионы арми байгаа газар луу гараараа заана.

Элч нар тийшээ хараад ер бишийн юм огтхон ч эс харна. Арми бол арми. Тулаан бол тулаан. Буудлага, угаа униар, жадат дайралт, ёолон гаслах дуунд газар дэлхий доргино.

— Сайн хар, сайн хар! гэж Воейков хашгираад,—хамгийн ширүүн газар нь хаана байна вэ? гэлээ.

Дарга нар тэр газрыг олж.

— Тэнд байна гэлцэн яаруу сандруу хуруугаараа чичилнэ.

— Тэгвэл тийшээ давхиад оч, тэнд л миний нууц байгаа юм. Багратионыг гал дотор л хайгаарай, тэгвэл үйлс чинь үргэлж бүтнэ гэж Воейков хариулжээ.

Баатар хүч

Дэслэгч Жабрины батарей байраа яаралтай өөрчилж байлаа. Цэргүүд морьдоо хөллөж шинэ байрлуугаа яарна. Генерал Милорадович давшиж буй тул түргэн амжиж туслах хэрэгтэй байлаа.

— Түргэл, түргэл! гэж Жабрин командалж,—Сүнсий чинь гаргаад өгье... Түргэл! гэж хэнд хэлж байна хэмээн хашгирна.

Зам саяхны тулалдаан болсон газраар гардаг байжээ. Морьд хотгорт ороход бүх талбай хүүрээр дүүрчээ. Орос франц цэргүүд ундуй сундуй хөндлөн гулд, бие биеэ дэрлэн хэвтэх нь ер нь хүн биш ямар нэг хог новш хаясан мэт ажээ. Цэргүүд зогсоцгоолоо.

— Ээ бурхан минь ээ!

Жабрин хаашаа ч харсан сул газар байсангүй. Тэр их хүүрийг тойрон явах цаг ч байсангүй тул дэслэгч загалмайлан залбирч:

— Чигээрээ, урагшаа! Үхсэн нь амьдыгаа барьдаггүй юм... гэжээ.

Цэрэг Епифанов бусдаасаа жаахан хоцроход айдас хүрч нүдээ таглажээ. Энэ тамын газраар түргэн л явж гарах юмсан. Их буу нь энхэл тонхолд донсолно. Цэргийн нуруун дээгүүр хүйт оргино. Тэгтэл аяархан ёолох сонсодлоо. Епифанов нүдээ нээвэл яг их бууны нь өмнө дугуйны дэргэд

буурал үстэй бага дарга хөдөлж байжээ. Цэргийн хөлс асгарч:

— Тпру! гэж Епифанов морьд уруугаа хашгираад үсрэн буув. Бага дарга дэмийрэн ёолж хэвтэх бөгөөд хажуу тал нь цусанд хутгалджээ. Хажууханд нь унгар маягийн цэргийн малгай хэвтэнэ. Харин сугандаа буутай байгаа харагдлаа.

Епифанов бага дарга дээр гүйн очиж дугуй дороос татаж гаргахыг оролдоно. Бага дарга нүсэр хүнд биетэйгээс гадна бусад хүмүүстээ дарагджээ. Шаналсан бага дарга гэрэл гэгээ, цэрэг, их буу уруу харж:

— Хаанаас ирэв ээ! гэж шивнэв.

— Бид их буучид зүүн жигүүрээс баруун жигүүр лүү явж байна. Туслахаар довтолгож явна даа. Өвөө эргэн тойрон их буугаар буудаж байгааг сонсож

байна уу ...Генерал Милорадович давшиж байна гэхэд

— Манай, манай генерал! гэж бага дарга хашгираад, —за алив толгойг минь өргөөтөх! гэлээ.

Бага дарга дов өөд харахад үй олон цэрэг явж хашир дайчин эрд дасал болсон дуу сонсдоно. Нөхдийнхөө уриаг сонсох мэт ажээ. Бага даргын нүүрэн дээгүүр инээмсэглэл тодорч: За алив

түшээтэх гэхэд Епифанов бага даргыг газраас өндийхөд нь тусаллаа.

— Алив тэр малгай өмсүүл гэхэд нь Епифанов буурал толгойд нь өндөр малгай өмсүүлэв. Бага дарга жагсаалд байгаа мэт цэх болж, дайралтанд орох гэж байгаа мэт буугаа бэлтгэж нэг, хоёр, нэг хоёр гэсээр гүйнэ.

Бага даргын цус гоожиж байгааг цэрэг Епифанов сандран хэлжээ.

— Ура—а! гэх ялгуусан дуу толгодын зүгээс цууриатна.

— Ур—а! гэж бага дарга хариу хашгарна.

Ийнхүү бага дарга арав арван метр гүйснээ модчин хүний эцсийн хүчит чавчилтыг авсан асар том царс мод шиг далжийн газар унажээ.

Епифанов баатар луу гүйн очлоо. Дайчин бага дарга ёолох ч үгүй амьсгаа ч ,үгүй болж цэрэг эрийн дайчин замаа дуусгаж байлаа.

Епифанов өөрийхнийгөө гүйцэж очиход Жабрин уурлаж:

— Хаашаа алга болчихоо вэ?

Чи чинь болжмор шиг амьтан юмаа!... гэжээ.

Цэрэг саатсан тухайгаа тайлбарлаж хөгшин бага даргын тухай түгдчин ярина.

Дэслэгч номхорч, цэргүүд үг дуугүй зогсоно.

— Хэн гэдэг нэртэй юм бэ? тэгээд баатрын нэр алдар хэн юм бэ? Епифанов дэмий л гараа тэлж:

— Бага дарга, Сахалтай хөгшин хүн. Тэр хүнд ямар ч хүч байгаагүй гэхээс өөр зүйл мэдэхгүй байлаа.—

Цэргүүд малгайгаа авцгаалаа.

— Хүч байхүй байсан гэнээ? Тэнэг минь тэр чинь баатар хүчтэй байжээ гэлцсэн гэдэг.

Цэрэг эрийн сэтгэл

Хашир догь цэрэг Матвей Бородулин, залуухан цэрэг Клим Дуга хоёр аян дайны үед анд нөхөд болшгоосон юмсанжээ.

Тэд Неманаас хамт ухарч, Витебскийн дэргэд хамт үзэлцэж, Смоленскийн хананы дэргэд золтой л үхэлгүй, Бородиногийн талбайд хамт ирсэн ажээ.

Матвей Бородулан, Клим Дугагийн дэргэд өвөө л гэсэн үгээ. Цэргийн янз бүрийн эрдмийн талаар сургамжилж дариа яаж хуурай байлгах, жадаа яаж хурцлах, аян дайнд явахад хөлөө яавал эцээхгүй байх талаар зөвлөдөг байжээ. Тэр ч байтугай үдлэг болоход Бородулин багадаа суудлаа тавьж галд ойр суулгана. Дуга зөрж:

— Би ямар хүүхэд юм уу? гэхэд

— Хэвт, хэвт! гэж цэрэг хэлээд,

— Би дассан юмаа. Над хүйтэнд бүр ч дээр байдаг юм гэдэг байв.

Хоол аягалж байхад Бородулин бас нэгийг бодно. Аяганаасаа нөгөө аяганд аль сайны нь авч хийнэ.

— Матвей өвөө, би хоолондоо цаддаггүй ховдог юм уу? гэж

Клим няцаана.

— Идээ ид, иддэг нас. Хоол сайн идвэл ашигтай гэж Матвей хэлнэ. Хижээл насны Бородулин, асар том Клим хоёр Бородиногийн тулалдааны үед мөр зэрэгцэн тулалдаж Дуга хөпшин найзаа халхалж байжээ. Гэнэ алдсанаас найз нь шархаджээ. Матвей Бородулин гэссэн газар алдлан уналаа.

— Матвей өвөө! гэж хашгирсаар Клим сөхрөн сууж Бородулиныг сэгсэрч чихээ цээжин дээр нь тавиад, — Матвей өвөө! Миний өвөө! гэж хашгирлаа.

Бородулин нүдээ нээж найзаа харснаа:

— Ус гэж хэлээд дахиад таг болжээ.

Цэргүүд дашмагаа үзвэл хоосон байжээ. Буудалцаад арван цаг болох гэж байлаа. Дашмаг дотор балга ч ус үлдээгүй ажээ.

Ус алгаа. Ойр горхи ч байдаггүй. Ойр байгаа горхи францчуудын гарт байлаа.

Ус! Ус! Ус! гэсэн үг цэргийн эгнээ даяар амнаас ам дамжина. Говь цөл шиг л хаана ч ус байсангүй.

Дуга босож мэгдсэн харцаар ширтсэнээ гэнэт цахилгаанд цохиулсан мэт болж хоосон дашмаг шүүрэн авч гараа дээш өргөж цаад талд нь жад буу агссан францчуудын өөдөөс алхлаа.

Түүний эгнээнд хамт байсан нөхөд нь сүнс нь зайлж:

— Бурхан минь гарцаагүй үхнэ... Савдаг минь!

Дуга францчуудаас юм хүртэнэ гэлцэж байлаа. Цэргүүд түүний хойноос сэтгэл түгшин ширтэнэ. Гүйж яваа орос цэргийг ч францчууд ширтэнэ.

— Камрады1 гэж Дуга хашгираад,

— Матвей минь нас барж байна! Өвөө ус уух гэсэн юм! гээд хоосон дашмагаараа дохио өгөх мэт даллана.

— У—с! гэсэн үг тал даяар цууриатна

Францчууд хэдийгээр дайсан боловч хүн шүү дээ. Тэд орос үгийг ойлгохгүй байлаа. Гэлээ ч гэсэн хүний сэтгэл болсон хойно цэрэг зүгээр гүйгээгүй гэдгийг ойлгож байлаа.

Францчууд горхи уруу очих зам гаргаж өглөө. Тэр хэсэг дээр гал намдаж аль ч тал нь буудсангүй бүгд нам жим болж гагцхүү:

— Матвей өвөө үхэж байна! гэсэн цангинасан дуу агаарыг зүснэ. Дуга ганга хүртэл гүйж дашмагаа хүйтэн ус уруу дүрж ус дүүргээд франц цэргүүдийн хонгил гаргасан нарийхан зурвасаар эргээд гүйлээ.

Цэрэг Матвей өвөө дээр ирж, өвдөг дээрээ толгойгий нь тавьж дашмагтай усаа ам уруу нь цутгаж, духын нь норголоо.

Бородулин нүдээ нээж ухаан ормогц залуу найзаа сайшааж:

— Дүү минь чи хаанаас ус олов оо? гэж асуулаа. Хаанаас олов оо гэнээ? Цэрэг эрийн сэтгэлээс олсон юмаа.

Камрады—францаар нөхөд гэсэн уг. (Орч.)

Алдар бол шувуухай

Цэрэг Изюмов Бородиногийн тулалдаан хүртэл алдар гавьяа байгуулья гэж боддог боловч нэг ч удаа тодроогүй ажээ. Тэгээд яаж алдар гавьяа байгуулья даа гэж цаг үргэлж боддог байжээ.

Бүр дайны эхэнд Изюмов нэг цэрэгтэй ингэж ярьсан юмсанжээ.

— Алдар гавьяа гэдэг чинь юу юм бэ? гэж Изюмов асуухад

— Алдар гавьяа бол шувуухай байгаа юм. Тулалдааны үед дандаа эргэлдэж байдаг юм. Түүнийг барьсан хүн л алдар гавьяатай болдог гэж цэрэг хариулжээ. Цэрэг чухам тоглож хэлсэн, эсвэл өөрөө ингэж ойлгож итгэж байсныг бүү мэд. Харин Изюмов тэр цагаас хойш амар тайван суухаа больж өнөөх илбэт гайхамшигт шувууны тухай бодол болж түүнийг хэрхэн барихыг боддог болжээ.

Витебскийн дэргэд ч байхдаа энэ тухай бодож байжээ. Бусад цэрэг нь дайралтанд орж дайснаа зоригтой жадалж байхад Изюмов тэнгэр хараад л суугаад байжээ. Ээ дээ тэр гайжамшигтай шувууг л өнгөрөөчихгүй юмсан! гэж бодож байлаа. Тэгээд ямар ч л байсан харалгүй өнгөрчээ. Бусад нөхөд нь алдар гавьяа байгуулжээ.

Смоленскийн дэргэд болсон тулалдааны үед ч мөн л ингэжээ. Энд ч мань цэрэг алдар гавьяагүй хоцорчээ. Тэгээд аймшигт уй гашуутай Изюмов золгүй явдлаа нөхөддөө ярьж гоморхжээ.

Цэргүүд инээлдэж:

— Алдар гавьяаг барьдаггүй юм. Алдар гавьяа өөрөө хамгийн зоригтой хүн дээр нисэж ирдэг юм. Алдар гавьяа бол нэг ёсонд шувуухай гэсэн үг. Харин түүний тухай бодоогүй нь дээр. бүрмөсөн үргээчихэж болно шүү гэжээ.

За тэгээд Бородиногийн тулалдаанд мань цэрэг үнэндээ алдар гавьяаг мартжээ. Уул явдал санаатайгаар биш ч гэсэн санамсаргүй болсон юмсанжээ. Тулалдаан эцэс уруугаа дөхөж байжээ. Францчууд ялалт

байгуулахыг хичээнэ. Тэгээд оросын явган цэргийн өөдөөс кирасирийн болон улааны морьт хороодыг илгээжээ. Морин цэргүүд ямар ч хүнийг замаасаа зайлахаар довтолгон дайрна.

Изюмов хараад таг чит болохдоо алдар гавьяаны тухай ч мартжээ. Ганцхан л морин цэргийн эсрэг яах вэ гэдгээ бодно. Морьд улам улам ойртсоор ажээ. Энэ морьд цэргийг талхлаад өнгөрнө дөө. Илд, хурц сэлэм орос цэргүүдийн толгой дээр бууна даа гэж бодохоос Изюмовын бие арзасхийв. Изюмов хамгийн түрүүний эгнээнд зогсож байлаа.

— Буугаа бэлтгэ! Онил. Гал нээх газар дөхүүл! гэх команд сонсоглоо. Изюмов буугаа шагайж буудлаа. Чухам тэгээд цаашаа юу болсныг яг өгүүлэхгүй, уг байдлаас тодорхой болох бизээ.

Изюмов хурам хиртэй бул чулуу шиг зогссоноо буугаа жадлан дайрах маягаар шагайж

Францын морин цэргийн өөдөөс дайрчээ. Түүний хойноос бусад цэргүүд орж, нэг ёсондоо явган цэрэг морин цэргийн эсрэг дайралт хийжээ.

— Изюмов, —Ура хашгирахад

— Ура!—г бусад цэрэг түрж дуу тасарсангүй.

Францын кирасир, уланууд сандран тэвдлээ. Дайнд ийм явдал гарч байгаагүй билээ. Хэдүйгээр тэд дайралтаа зогсоогоогүй боловч морьтон цэргийн сэтгэл можжээ. Тулалдаанд хамгийн гол нь л энэ байлаа. Сүр сүлд нь ч буураад явчихлаа. Цэргүүд францынхан уруу дайран орж жадална гэж сэрээдсэн л юм шиг болжээ. Явган цэрэг морьтонг няцааж гайхамгийн ид шидийг харуулжээ. Цэрэг эрийн идрийн цог гялалзана.

Ах дүү нараа, морины гэдсийг хүүл! Бууныхаа бөгсөөр францчуудын жадыг унатал цохь!» гэх Изюмовын үг бүгдэд дуулдана. Францчууд бүр мэгдэж, сэлэмнийх нь далайлт улам улам цөөрсөөр байв. Гар цохилт нь улам бүр намжлаа. Францчууд чичрэх цаг боллоо. Үнэхээр ч тэд чичирч мориныхоо амыг эргүүллээ. Бүгд ялалт хийчихсэн юм шиг байсан боловч тийм биш байлаа.

— Ах дүү нараа, хойноос нь хөөе! гэж Изюмов хашгирлаа.

Цэргууд францчуудын хойноос хөөлөө. Явган цэрэг морин цэргийн хойноос тал дундуур хөөж байгааг хараад нүдэндээ итгэх аргагүй ажээ.

Морьд явган хүнээс хурдан нь лав боловч цөөнгүй олон францын нуруу уруу оросын жад шигдэж амжжээ. Тэр ч байтугай цэргүүд гүйцэхгүй болмогцоо жадтай буугаа францчуудын хойноос шидэж онох нь онож байлаа.

Францчууд дахиад холдоход цэргүүд буу зэвсгээ авч өөрийнхөн дээрээ иржээ. Цэргүүдийг ирэхэд өөдөөс нь:

— Баатруудын алдар бадартугай!

— Изюмовын алдар бадартугай!

— Зоригтныхоо алдрыг хүндэтгэе гэцгээж байлаа.

Цэргүүд тулалдаандаа хөөрч, юу ч сонсохгүй, юу ч харахгүй явна. Цэргууд юу ч харахгүй ажээ. Гэвч бид тэдний дээгүүр алдар гавьяаны шувуухай эргэлдэн нисэж байгааг сайн харж байна.

Фили тосгон

Мооквагийн даргэд фили хэмээх жижигхэн тосгон бий. Буландаа бурхны хөрөгтэй, голдоо тосон дэнтэй, царсан вандан ширээтэй тариачны байшин байна. Тэр байшинд оросын генералууд цугларчээ. Цэргийн зөвлөлийн хуралдаан болж байгаа нь энэ ажээ. Москваг дайн тулаангүй орхих уу, эсвэл дахиад Москвагийн хананд шинэ тулалдаан хийх үү? гэдэг асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байлаа.

Москваг орхиё гэж хэлэхэд амархан. Харин ийм үг орос хүний зүрхэн дундуур хутгалсантай адил ажээ. Генералууд тулалдах саналтай байлаа.

Кутузовын амьдралын хамгийн хэцүү үе байлаа. Тэр дөнгөж саяхан хэргэм нэмэгдсэн билээ. Бородиногийн тулалдаанд амжилт гаргасан учир фельдмаршал цол хүртлээ. Тэр хамгийн ахмадын хувьд, ерөнхий жанжны хувьд, фельдмаршалын хувьд тулалдана, эсвэл тулалдахгүй гэх гол саналыг хэлэх хэрэгтэй байлаа.

Бородиногийн дэргэд францчууд оросуудыг хүч давамгайлаагүй авч оросууд ч хүч давамгайлаагүй юмаа. Нэг үгээр хэлбэл яг тэнцүү тулаан болсон ажээ. Тулаан тэнцүү байсан ч уул хэргийг юу гэж үзэх вэ? Наполеон анх удаа дайсныхаа армийг цохиж чадаагүй билээ. Оросууд дэлхий дээр анх удаа Наполеоны өмнө бууж өгөөгүй билээ. Чухам ийм учраас л оросууд ялалт байгуулж, францчууд болон Наполеон ялалт байгуулаагүй юмаа.

Генералууд шинэ тулалдаан уруу тэмүүлнэ. Цэргүүд ч гэсэн ялгаагүй ажээ. Тэгэхээр Кутузов яаж шийдэх хэрэгтэй вэ?

Кутузов цэргийн эрдэмд гарамгай буурал өвгөн. Витебск, Смоленскийн тэндээс Наполеонд туслахаар цэрэг яаран ирж явааг Кутузов мэдэж байлаа. Францчууд шархадсан боловч үхээгүй ажээ.

Шинэ тулалдаан бол эцсийн тулалдаан юмаа. Ээ, дайны аюул яасан их вэ!

Энд долоо хэмжиж нэг огтол гэдэг л болж байгаа ажээ. Армийн хамгийн үнэ цэнэтэй зүйл бол цэргээ хайрлах явдал мөн. Арми бүхэл бүтэн бол дайсныг бут цохиж болно. Бүгдээрээ Кутузовын юу гэхийг хүлээж ядна.

Фельдмаршал царсан сандлаасаа босож генералуудыг харлаа. Генералууд хүлээсээр байлаа.

Кутузов бурхны дүр, дэн, цонхоор харагдаж байгаа саарал тэнгэрийн хэргийг хараад газар шагайлаа.

Генералууд хүлээсээр, Орос орон хүлээсээр ажээ.

— Москваг алдсанаараа гэж Кутузов аяархан эхэлснээ, —Орос орныг хараахан алдахгүй... Гэвч арми устгагдах юм бол Орос орон ч, Москва ч сөнөнө гэж хэлжээ.

Кутузов яриагаа зогсоолоо. Цонхны давцан дээр ялаа дүнгэнэнэ.

Нүсэр том биетэй фельдмаршалын доорх шал чухарна. Хэн нэг хүн гүнээр санаа алдах сонсдоно. Кутузов буурал тэргүүнээ өргөн харвал зайсан Платовын царай харагдлаа. Хашир дайчны хацар дээгүүр урвамтгай нулимс бөмбөрнө.

Үг хэлэх нь чухал биш тушаах нь чухал байгааг фельдмаршал ойлгож:

— Эзэн хаан, эх орноос минь над өгсөн эрхээр бол ухар гэж би тушаах байна. Тушаах байна... хэмээн түргэн бөгөөд итгэлтэй давтан хэллээ.

...Тэгээд оросын цэрэг Москвагаа орхиж Яуз голын гүүрээр гунигтай алхална. Кутузов гүйцэж ирээд цэргээ ширтлээ. Цэргүүд түүнийг харсан боловч хараагүй дүр үзүүлэн анх удаа түүнд ура хашгираагүй ажээ.



Галан тэнгис дүрэлзэнэ

Оросын арми Москвагаас өмнүүр Тарутино гацааны дэргэд байрлажээ. Кутузов аж ахуйн ажилдаа эн түрүүнд оржээ. Арми даяараа ноорсон учир хувцаслах хэрэгтэй байлаа. Нөгөө талаар намар болсон тул дулаан хувцасны талаар ч бодох цаг болсон ажээ. Хүнс тэжээл муу байснаас тариа будаагаа базаах хэрэгтэй байлаа.

Кутузов жанжинд янз бүрийн үй олон ажил байлаа.

Москваг авсан Наполеонд ч багагүй ажил байлаа. Францчуудын итгэл талаар болжээ. Хүмүүс дүрвэхдээ бүх зүйлээ аваад явсан ажээ. Москвад талх, тариа ч, мах ч байсангүй. Агтаа тэжээх юм ч алга байлаа. Харин ходоод л байдаг юм бол зооринд дарс л элбэг байжээ. Цэргүүд нь архидаж дээрэмдлэг хийнэ. Дээрэм болсон газар бүрт л түймэр гарна. Бороо хургүй намар гал асан авалцахад амар ажээ. Хятадын хотхон, зочдын хашаа, Загалмайтны эгнээ, анчдын эгнээ цөм дүрэлзэнэ. Москва голын чанадад Балчуг шатна. Шөнө өдөр шиг гэгээтэй ажээ. Наполеон Москвагийн Кремельд сууж хаашаа л харвал гал, дандаа гал дүрэлзэнэ. Ёстой л галан тэнгис дүрэлзэнэ.

— Эрхэмсэг эзэн хаан, аюултай байна! Гал Кремельд ойртож байна гэж францын генерал маршалууд сэтгэл түгшинэ.

Наполеон Кремелээс зайлахыг хүссэнгүй. Тэндээс явах нь гутамшигтай ажээ. Москвагийн Кремелийг эзэлж авмагц л ухаан сүнсгүй тонилох тун эвгүй ажээ. Наполеон аль болохоор сатааруулна.

— Эрхэмсэг эзэн хаан, амиа авар! Түргэн гол уруу... гэж генералууд эзэн хаанаасаа гуйна. Наполеон яарсангүй

— Эрхэмсэг эзэн хаан!.. гэж дахин хэлэхэд л эзэн хаан дуртай дургүй дээлээ эгэлдрэглэлээ.

Улаан дөл газар авч хуйлран мушгирна. Наполеон харшийн өргөн шатаар гүйж явахдаа «Энэ чинь тамын зам» гэсэн Коленкурын үгийг санаж уурсахдаа уруулаа хазлаа.

Түймэр дөрвөн өдөр хуйларлаа. Тав дахь өдөр нь Москва хот үнсэн товрог боллоо.

Францчуудын гарт хот биш бөөн балгас байлаа.

Тарутино тосгоны тэнд байгаа оросын цэргийн байдал маш сайн байжээ. Хүнс тэжээлтэй болж, цэргээ хувцаслаж, агт нь тэвээрэг авч, цэргүүд тайван амарч байлаа.

Москвад байгаа францчуудын үйлс муу ажээ.

«Би ялагч уу, үгүй юу?» гэж

Наполеон бодоход хүрлээ.

— Оросууд яагаад найрамдах гэж гуйхгүй байна вэ?! Ийнхүү зовуурьтай гурван долоо хоног өнгөрчээ. Наполеон зэвүүцэн:

— Оросуудтай нэн даруй найрамдъя! гэлээ.

Ингэж эзэн хаан оросын элчийг хүлээсэнгүй өөрийнхөө хиа генерал тайж Лористоныг дуудаж:

— Тарутино уруу тэр хөгшин үнэгэн дээр оч! гэсэн гэдэг.

Тарутино

Лористоныг ирсний дараа францчуудын үйлс муу байгааг Кутузов мэдлээ. Тэгээд Тарутиногийн дэргэд тулалджээ.

Дахиад л их буу нүргэлж, жад сэлэм зөрөлдөж, хоёр хүч тулгарлаа. Тулалдаанд францчууд ялагдаж, оросууд гучин зургаан их буу олзолж авлаа.

Тэр тулалдаанаас хойш дөрвөн өдрийн дараа түрүүч Языков казак отрядтай туршуулд явж байгаад казакууд увайгүй зан гаргаж Москва уруу явж очжээ.

Тэд шатаж түлэгдсэн хотыг харж зогсоно.

— Манай зовсон хот чинь энэ байна даа...

Хэдүйгээр салхигүй дулаан боловч намрын шиврээ бороо уйлагнаж хаа нэг газар нохой хуцах сонсоно.

— Хүүш хараач францчууд бүх нохойг идчихлээ гэсэч шүү дээ! гэтэл

— Энэ зальтай гөлөг зугтсан бололтой.

— За, сайхан Москва минь ингээд баларч дээ.

— Тэнэгээ, үхэгсдийхээ төлөө уйл! Москва сөнөөгүй байна дахиад л барьчихана гэх зэргээр өөр хоорондоо шивнэлдэнэ. Тэгтэл гэнэт хотод аймшигтай дэлбэрэх чимээ гарчээ. Донын казакууд дарга уруугаа нүднийхээ сэжүүрээр харж, сониуч сэтгэл нь дийлж Москва уруу давхицгаав.

Ай даа юу ч болбол болог! Бурхан сахиус харах биз. Юуны төлөө тагнуул билээ!

Казакууд хотын хоосон гудамжаар давхихад францчууд ч, оршин суугчид ч байхгүй тэр их анир чимээгүйн дунд эвдэрхий балгас сүрлийнэ. Гагцхүү нам жимийн дунд морьдын туурайн чимээ аянга мэт чанга ажээ. Морьтон хотын төв уруу давхиж, Ордынка бараг Кремель уруу очжээ. Хаана ч францчууд алга байлаа.

Замд нь нэг өвгөн дайралдлаа.

Хүүш сахалтаа, буруу номтнууд хаана байна вэ?

— Францчууд Москвагаас тонилсон, тонилсон. Хонгорууд минь тэд аль өглөө тонилсон гэлээ.

Наполеон сар гаруй Москвад байжээ. Эзэн хаан оросын элчийг найрамдая гэж ирэх байх хэмээн хүлээж байлаа. Тэгтэл элч ирсэнгүй. Өөрөө Лористоныг явууллаа. Лористон найрамдахыг хүсээгүй мэдээ авчирчээ. Тэгтэл Тарутиногийн дэргэд тулалдаан болжээ. Бас

тэгээд удахгүй өвөл болно. Арми өлсөж эхлэв. Тэгэхээр торонд орсон хулгана шиг Москвад суугаад байх хэрэг үү. Үгүй, жаахан хүч байгаа дээрээ түргэхэн гэр өөдөө явъя. Францчууд ямар ч алдар гавьяагүй, сүр сүлдгүй Москвагаас тонилжээ.

Казакууд огт сонсоогүй сонин дуулж, дэлбэрсэн дуу чимээг ч мартаж мориныхоо амыг эргүүлж удаан хүлээсэн мэдээг Кутузовт хүргэхээр хар хурдаараа давхижээ.

Хожим дэллбэрэлтийн тухай мэджээ. Наполеон хонзорхог тул амжилтгүй явдалдаа хорсож Москвагаас зайлахдаа Кремлийг дэлбэлэх зарлиг буулгасан юмсанжээ. Аз болоход амь үрэгдсэн хүн цөөн, бас тэгээд бороо орж байсан тул амархан унтарчээ.

Кутузов Языковын илтгэлийг сонсоод загалмайж:

— Болох нь тэр дээ. Заавал тэгэх байсан юм... Одоо орос орон аврагдлаа гэснээ, Тарутино тосгон уруу эргэж:

— Тарутино чамдаа баярлалаа гэсэн гэдэг.

Тишка минька хоёр

Наполеон Москваг орхиод Калуга хот руу явжээ. Калуга дайнд хэлмэгдэж хоосорч сүйдээгүй хот учир францууд тэнд хүч сэлбэж дараа нь Смоленск уруу эргэж Вилна хотоор дайрч Оросоос гарья гэж бодож байжээ.

Кутузов дайснийхаа бодлыг мэдэж байсан учир армиа авч амджээ. Тэгээд бага Ярослав хотын дэргэд шинэ тулалдаан болжээ. Бородиногийн тулалдааны дэргэд шиг өглөөнөөс орой болтол тулаан үргэлжилжээ. Франц, Оросууд аль аль нь шургуу тулалджээ.

Францчууд оросуудыг бага Ярославаас хөөж гаргахад Оросуудын дайралт эхэлнэ. Оросууд францчуудыг бага Ярославаас хөөж гаргахад францчуудын дайралт эхэлнэ. Ийнкүү хот найман удаа тулалдагч хоёрын гараас гарт шилжиж байжээ. Бага Ярослав хотын ах дүү жаал Тишка, Минька хоёр францчуудын анхны дайралтын үед зооринд нуугджээ. Зоорь гадагшаа харсан жаахан цонхтой учир хоёр жаал цонхон дээрээ шавааралдаж харвал хэдүйгээр аймшигтай боловч сонин ажээ.

Францчуудыг хот орж ирэхийн өмнө хотын бараг бүх оршин суугчид дүрэвсэн юмсанжээ. Тяшиса, Минька хоёрын эцэг эх ч явжээ. Тэд явахдаа хүүхдээ аваад явсан авч ах дүү хоёр зугтаж амжжээ. Тэр хоёр олны үймээн дотор орсноо дахин хотод ирж жинхэнэ дайныг харахад сонин байжээ.

Ингээд мань хоёр жаал бяцхан цонхон дээр зогсоно. Анх удаа байлдаан үзэж байгаа болохоор маш сонин ажээ. Цэргүүд дайралтанд хэрхэн орж байгаа, дарга нь юу гэж командалж байгаа, бууны утаа гудамжаар хэрхэн хөшиглөж байгааг харахад ер бишийн сонин ажээ.

Эхлээд францчуудыг дайрч байхад тулаан нилээд алс байсан учир хүүхдүүдэд зөвхөн хүмүүсийн аймшигт хашгиралдаан сонсдож байжээ. Дараа нь оросууд хотод орж ирсний

дараах нэг тулалдаан яг Тишка, Минька хоёрын байгаа гудамжинд болжээ. Оросын цэргийн отрядыг гоё, дэгжин залуу дарга удирдаж байжээ.

Хоёр хүү тэр даргыг ширтэж:

— Генерал гэж Минька шивэгнэв.

— Генерал гэхэд залуу байна, дэслэгч бололтой гэж Тишка дүүдээ засаж хэллээ. Яг тэдний цонхны дэргэд жадны ширүүн тулалдаан болжээ.

— Хүүхдүүдээ! Жадаа ажиллуулахгүй бол зэвэрдэг юм. Ялалт хийхгүй цэрэг бол цэрэг биш. Урагшаа! гэж дарга хашгираад өөрөө хамгийн түрүүнд дайралтанд орно. Эгшин зуур жад улаан цусанд умбаж шархдагсдын хувцас улаанаар эргэлдэж, тулалдааны талбарт цусан далай тогтоно. Тэнд орос франц цэргийн цус холилдоно. Хүүхдүүд цонхноос холдлоо.

— Аймаар байна уу? гэж Тишка дүүгээсээ асуулаа.

— Үгүй гэж Минька хариулна.

«Үгүй» гэж хэлж байгаа авч гар нь чичирнэ. Тишкагийн гар ч бас чичирч байлаа. Гар нь өөрийн эрхгүй чичирч байжээ. Тэр хоёр цонхон дээр дахиад очиход тэр газар тулаангүй нам жим болж амь үрэгдэгсэд хөндлөн гулд хэвтэнэ. Хамгаас ойр залуу дарга хэвтэж байгаа харагдлаа. Тэр дарга дайралтанд орохдоо жаданд шархадсан байлаа. Тэрбээр уянгалуулан гиншиж хөдөлгөөнгүй хэвтэнэ. Жаалууд бие биеэ харлаа.

— Үүнийг зoorь луугаа авах юмсан гэж Тишка болгоомжтой хэллээ.

— Тэгье гэж Минька зөвшөөрөв.

Гэвч тэд гадагшаа гарахаасаа айж байлаа. Хоёр жаал жаахан зогссоноо зориг гарган гэтсээр гудамжинд гарлаа. Тэгээд даргыг гараас нь авч чирлээ.

— Яасан хүнд юм бэ гэж Минька шивнэхэд

— Даргын хоол иддэг хүн тэгэлгүй яах вэ гэж Тишка зөвшөөрнө.

Тэд даргыг зoorиндоо оруултал гудамжинд дахиад тулалдаан эхэлжээ. Гэвч хүүхдүүд цонхон дээрээ очсонгүй. Нөгөөх даргынхаа хажууд л эргэлдэж байлаа. Толгой дээр нь ус асгалаа. Тишка цамцныхаа хормойны цэвэр байгаа хэсгийг урж аваад даргын хажуу талын онгойж байгаа шархан дээр тавилаа.

Дарга халуурч солиорон ямар нэг юм хашгирна. Тэгээд жаал гайгүй болсноо дахиад л солиорно. Ийнхүү оройжин, шөнөжин байлаа. Хоёр жаал бүр зовж гүйцжээ. Тэгтэл хажуугийн нь байшин шатлаа. Муухай гашуун утаа зoorиор нэг болжээ. Харин Тишка, Минька хоёрын байшин чулуун байшин болохоор галд аюулгүй ажээ.

Дараа нь хамгийн аймшигтай юм боллоо. Бага Ярослав хот францчуудын гарт үлджээ.

Ямар нэг цэргүүд тэдний байшинд байрлажээ. Ингээд л тэд зоорь луу ороод ирнэ дээ гэж хүүхдүүд айцгаана.

— Эрхэмсэг даргаа чимээгүй, чимээгүй... гэж тэд даргыг ятгана.

Дарга тэдний үгийг ойлгосон маш чимээгүй болсноо, дахиад л халуун нь шатаж хашгирч гарна. Аз болоход бүх юм тайван аятайхан өнгөрлөө.

Шөнө дундын хирд хүүхдүүд бөх нойрондоо орж, нар дээр хөөрсөн хойно сэржээ. Эргэн тойрон нам жим ажээ. Цонх уруу гүйж очвол эргэн тойрон хүнгүй, хаана ч францчууд үзэгдэхгүй байжээ.

Хэдүйгээр бага Ярослав хот францчуудыг гарт үлдсэн боловч Калуга уруу Наполеон сэтлэн гарч чадахгүйг ойлгож байсан учир эзэн хаан амьдралдаа анх удаа шинэ тулалдаан хийхийг төвдсөнгүй цэргээ ухрах тушаал өгсөн юмсанжээ.

Хүүхдүүд зоориноос гадагш гарч, хотод орос цэргүүд, нутгийн улс ирж байжээ. Тишка, Минька хоёрын аав ч ирж явжээ. Эцэг хүүхдээ үзээд,

— Ээ муусайн шааруудыг! Ээ муусайн гөлөгүүдийг! гэлээ. Тишка, Минька хоёр хөдөлж чадсангүй. Эцэг нь шууд л суран бүсээ тайлж гудамжинд хүүхдүүдээ ороолгож гарчээ. Ах дүү хоёр тэвчлээ. Эцэг нь хатуу болохоор өөр зүйл ч хүлээж байгаагүй билээ. Тэгтэл эцгийн гар цуцаж амьсгаа авчээ.

— Аваа тэнд шархадсан хүн бий гэж Тишка гараараа газраас цухуйж буй цонх уруу заахад,

— Дарга гэж Минька гонгинов.

Эцэг зоорь луу орлоо. Хүүхдүүд худлаа хэлээгүй үнэн ажээ. Залуухан хурандаа хэвтэж байлаа.

— Ээ хөөрхий!

Эцэг зохих хүмүүст очиж илтгэхэд сувилагч нар ирж хурандааг аваачжээ. Аав нь дахиад л суран бүсээ авч зодож гарчээ. Харин тэгэхдээ тийм их өвдөхөөр зодсонгүй, тэгж их харааж загнасангүй, харин аман дотроо:

— Ээжийгээ хайрлахаа яана... Гайтай түйтэй золигууд!... гэж гөвтнөж байлаа. Хэдэн өдөр өнгөрсний дараа эцгий нь хотын захиргаан дээр дуудаж медаль гардуулжээ. Зарлигт бага Ярослав хотын иргэн Кудинов Иван Михайлович, өөрөөр хэлбэл Тишка Минька хоёрын эцгийг оросын цэргийн даргын амийг аварсны төлөө медалиар шагнаж байна гэсэн байжээ. Мань эцэг би ямар ч хамаагүй, тэр даргы чинь би авраагүй Тишка Минька хоёр л аварсан юм гэж тайлбарлажээ. Гэвч захиргааныхан түүний үгийг дуулсангүй,

— Хэн аварсныхаа учрыг өөрсдөө олцгоо медалиа авсан бол саад битгий болоод бай, яв гэжээ. Эцэг гэртээ ирээд медалиа яахаа мэдэхгүй байлаа. Медалийг нь адилхан хоёр хуваадаг ч юм бил үү гэж боджээ.

— Та хоёрын дунд нэг медаль өглөө гэж эцэг хэлжээ. Тишка, Минька хоёр медалиа харж нүд нь дүрэлзэнэ. Тэр ч байтугай гар нь медаль уруу өөрийн эрхгүй сарвайна. Ийм медаль энгэр дээрээ зүүх юмсан гэж бодогдоно,

Гэвч хатуу чанга эцэг нь медалийг аваад авдрандаа хийж:

— Ийм юмаар эрсэлдэггүй юмаа гэж ширүүн хэлжээ. Медаль авдранд хэвтээд л байжээ. Харин жилд хоёр удаа христосын мэндэлсэн өдөр, улаан өндөгний баяраар Кудиновынхан сүм уруу явахад эцэг нь медалиа гаргаж өгдөг байжээ. Сүм уруу явахдаа Тишка медалийг зүүж, буцахдаа Минька зүүдэг байжээ.



Их хөнөөл

Бородиногийн тулалдаан болохоос бүр өмнө оросын армийг ухарч байх тэр үед Петр Багратион ван дээр Ахрырский морин хорооны дэд хурандаа Денис Давыдов гэнэт хүргч иржээ.

Багратион Давыдовыг аль эртний мэдэх билээ, тэр ч байтугай Давыдов тэр нэг үед Багратионы туслагч байсан болохоор тэр дор нь маш элэгсэг хүлээн авчээ.

— За ярь, ярь дарга нар чинь гомдоогоо юу? гэхэд

— Үгүй гэж Давыдов хариулжээ.

— Шагнал өгсөнгүй юү? Чөлөө гуйж явна уу? гэвэл

— Үгүй гэж Давыдов хариулжээ.

Багратион гайхаж, дэд хурандааг юу гэж хэлдэг бол хэмээн хүлээнэ.

— Би нэг ийм юм бодсон юм... гэж Давыдов яриагаа эхэлжээ. Тэгээд францын армийн тухай ярьж хэдэн зуун бээр урт газар үргэлжилж байна. Бүр Неман голоос оросын нутаг даяар ачаа тэрэг, сэлбэг хүч, дарь сумаа зөөж байна гэж ярьжээ.

— Үнэн гэж Петр ван хэлэхэд,

— Цаг үргэлж нааш цаашаа элчүүд бичиг зөөж байна. Францчуудад энэ бол маш урт замаа гэхэд

— Тийм, тийм гээд чагнаж байснаа, шинэ юм юу байгаа юм бэ? гэж

Багратион хэллээ.

— Эрхэмсэг генералаа, шинэ юм гэвэл Бонапартынхны ар талд манай морин отрядыг үлдээ гэж бодох юм. Яахав тэд ачаа тэрэг, бусад жижиг сажиг зүйлийг чимхлэг л дээ. Дайсанд багагүй хохирол учруулах болно. Тэгээд казакууд, морин цэрэг гуйх гэсэн юм, бололцоотой бүхнийг хийж баталж харуулья гэж Давыдов гэнэт хэлжээ.

Давыдовыг энэ бүгдийг ярьж байх хооронд Багратионы царай туяарч байгаад бүр инээмсэглэл тодорлоо.

— Сайн байна! Алив үнсье гээд үнсэж —намайг хүлээж бай гэв.

Тэгээд Багратион тэр дороо Кутузов жанжин дээр очиж Давыдовын ярьснаас яриагаа эхэлжээ. Францын арми олон зуун бээр газар үргэлжилж байна... гэж эхлээд Денис Давыдовын хүсэлтийг үг үгээр дамжуулжээ.

Кутузов Багратионы яриаг сонсоод

— Янз бүрийн хоосон санаархал... гэжээ.

Кутузов дөнгөж саяхан армия хүлээж аваад байлдаанд бэлтгэж байсан болохоор хэсэг бусаг цэрэг бүрээ хайрлаж байлаа.

— Эрхэм жанжаан гэж маш цочмог ууртай Багратион гоморхоод,— Бид заримдаа хувийнхаа ашгийг ухаарахгүй байгаад л хоосон санаархал байгаа юм даа гэснээ бүр нам дуугаар: —Уг нь бүрэн учир утгатай л юм. Их ирээдүйтэй юм даа гэхэд.

— За, за хонгор минь. Би зүгээр л тэгсэн юм. Чиний тэр дэд хурандаа чинь итгэлтэй хүн байгаа юм биз дээ? Морин цэргээс гэнээ? Тэд ч даргынхаа нүдэнд шороо цацах улсдаа.

— Эрхэм даргаа, итгэлтэй хүн. Таван жил миний туслагч байсан юм. Кутузов бодлогоширсноо:

— За яахав. Үнэндээ чухал хэрэг ч байж болох юм гэж хэллээ. Тэгээд

Давыдовт 50 морин цэрэг, 80 казак цэрэг гаргаж өгөх тушаал өгчээ.

Ингэж анхны партизаны отряд бий болсон юмсанжээ. Оросын арми цаашаа явахад Денис Давыдов ой уруу явжээ. Партизанууд францчуудад багагүй хөнөөл учруулжээ. Фельдмаршал,

Давыдовын гаргасан ухаалаг цэцэн саналыг төдөлгүй үнэлж, дайсныхаа ар тал уруу цэргийн отрядууд томилон явуулах болжээ.

Цэргүүд дээр тариачид улам улам нэгдсээр байлаа. Тад өөрсдийн отрядоо байгуулж байлаа. Зуу, мянган тариачны отрядууд одоо дайсныг цохиж эхэллээ.

Тариачдын уур хилэн бадарч ардын дайнд голын үер шиг орчноо хамна. Хоёр сарын дараа оросын армийг давшилтанд ороход Кутузов ерөнхий жанжны байрандаа Давыдовыг дуудуулжээ.

Тэгээд морин цэргээ удаан ширтсэнээ.

— Петр ванг амьд ахуй цагт чиний санаачилсан аргыг хоосон санаархал гэж нэрлэж байж билээ. Хөгшин буурал намайг өршөө. Харин намайг хэлсэн үгнээсээ ухарлаа гэж бодуузай. Та нарын хийж байгаа үйлс чинь жинхэнэ санаархал байна гэжээ.

Тэгээд Багратион ван тэгэхэд тэвэрч үнссэн шиг Денис Давыдов уруу очиж үнсжээ.



Дураараа дургисны гай

Денис Давыдовын партизаны яруу алдарт үйлсийн тухай чимээ оросын армийн дотор далайн давалгаа мэт цууриатжээ.

Амаас ам дамжин ярилцана. Дарьтай тэрэг дайрч эзэлсэн л гэнэ, явж байсан их бууны ангийг тарааж хөөсөн л гэнэ. чухал бичиг авч явсан элчийг барьж авч л гэнэ.

Давыдов өөрөө байлдаанд онцгойрч дөрвөн францын толгойг хяргаж гэнэ гэх зэргээр ярилцана.

— Залуу дарга Васильчиков партизан луу яаж очъё доо гэж боддог

болжээ. Тэгээд морьт сумангийнхаа даргаас;

— Давыдов уруу явуулаач гэж гуйжээ. Хорооныхоо дарга дээр очиж.

— Давыдов уруу явуулж өгөөч! гэжээ

Гэвч дарга нар нь явуулсангүй. Тэгэхээр мань дарга бодож, бодож зөвшөөрөлгүй яваад өгчээ. Гэхдээ зурвас үлдээжээ. «Намайг цэргийн албанаас зугтаасан гэж битгий үзээрэй, би тэсэж чадсангүй партизан уруу явлаа» гэжээ.

Васильчиков Давыдовын отряд байсан Гжатский хошуу уруу очжээ. Явах замдаа Давыдовын тухай бодож явж дээ.

Партизаны даргыг морин цэргийн сүржин гоё хувцас отгот малгайтай байх биз гэж бодож явжээ.

Мань дарга Гжатск хүртэл сайн явжээ. Партизаны отрядыг хайж олжээ.

Үнэндээ түүнийг партизанууд Гжатскийн дэргэдээс барьж аваад Давыдовын байранд аваачжээ.

Мань дарга Денис Давыдовыг хараад морин цэргийн дээл, малгай, гутал нь хаа байнаа?! гэж боджээ.

Өмнө нь тариачны хувцастай, сахалтай, ёстой тариачин зогсож байжээ. Васильчиков мэгдэж өөрийгөө ч танилцуулахаа мартжээ.

— Нэр алдар дэд хурандаа Давыдов. Таны ярихыг сонсьё, бага даргаа гээд Давыдов хөхөрчээ.

— Васильчиков гэж Васильчиков гонгинов.

Тэр замдаа ядарсан байсан тул унтуулахаар явуулжээ.

Васильчиковыг нарс модны дор шинель дээр нь хэвтүүлж ямар нэг юмаар хучсан болжээ.

Ингээд л партизаны амьдрал нь эхэлжээ. Маргааш өглөө нь Давыдов түүнийг сургаж:

— Партизанд хамгийн чухал юм юу вэ? гэхэд бага дарга дэмий л гараа тэлнэ.

— Гэнэтийн дайралт гэж Давыдов хариулаад,— Ямар байрлал хамгийн сайн бэ? гээд дахиад л, тасралтгүй хөдөлгөөнтэй байх явдал мөн. Партизаны гол хүч юунд байдаг вэ? Цохих тоогоороо биш, цохиж чаддагтаа байх ёстой гэлээ.

За тэгээд л аян дайн, аян дайн нэг газраас нөгөө уруу шилжиж ой дотор хононо.

Эсвэл бороонд шалба норж, эсвэл хүйтэнд чичирч, эсвэл нойтон газар унтана.

Төлөвлөгөөгүй, ямар ч горим дэглэмгүй дайн тулаан болно, эсвэл өглөө эрт, үгүй бол үдэш орой санаандгүй тулаан, эсвэл дөнгөж унтмагц түргэн авна.

Бага дарга ийм зүйлд дасаагүй ажээ. Тэр ангиасаа явсандаа харамсана. Тэгээд долоо хоног тэсэж ядан байгаад партизаны отрядыг хаяад явжээ. Тэр ч байтугай зурвас ч үлдээсэнгүй.

Васильчиков армидаа эргэж иржээ.

Түүнийг алга болсон тэр өдрүүдэд арми дотор нь бөөн хэрэг гарчээ. Дарга нарын дунд дураараа дургих явдал бол ноцтой хэрэг байлаа. Тэгээд бага даргын алга болсон тухай Кутузов жанжинд илтгэжээ.

Одоо ч бас түүний ирсэн тухай илтгэжээ. Кутузов үүнийг соноод:

— Дураараа дургиж явсанд нь шийтгэ гэснээ бодлогоширч, — Бас буцаж ирсэнд нь давхар шийтгэ гэж хатуу тушаажээ.

Цэрэг ноён

Морин сумангийн цэрэг Ермолай Четвертаковын унаж явсан морь байлдаанд шархаджээ. Четвертаков олзлогджээ. Түүнийг Гжатскад авчирчээ.

Гжатскаас мань цэрэг оргожээ.

Тэр дайсны эзэлсэн нутагт байжээ. Морин цэрэг Басман тайгад иржээ. Тэндэхийн тариачид их дайчин учир францчуудыг тахал хэмээн харааж

бөөн хорслоор дүүрэн ажээ.

Тэгээд Четвертаков тариачдыг францчуудтай тэмцэх тэмцэлд босгож, партизаны отряд байгуулья гэдэг санаа төржээ. Тэр санаагаа ярьжээ.

Тэгтэл тариачид булзааруулж чамайг хаанаас ирснийг мэдэхгүй байна. Тэгээд бас юу болохыг хэн мэдэх вэ! гэж шалтаглажээ.

Харин ганцхан цоохор залуу морин цэргийг дагажээ.

Тэд Задково тосгон уруу тариачдыг босгохоор явжээ. Замд нь хоёр франц дайралдахад алжээ. Дахиад хоёр дайралдахад бас л цааш харуулжээ.

— Хараач таминь! Хоёулхнаа дөрвийг няхчихлаа гэж Басманы тариачид гайхжээ.

— Хэрэв дөрвүүлээ бол наймыг ална!

— Хэрэв наймуулаа бол арван зургаа болно!

Задково тосгоны тариачид түрүүлээд отряд байгуулчихвал яах вэ? Басман тосгоныхон сэтгэл зовиноно.

— Алив морин цэргээ буцаарай!

— Бид өөрснөө отряд байгуулахыг хүсэж байна!

Морин цэрэг Басман тосгонд буцан ирэхэд тосгоныхон уучлал гуйжээ.

— Битгий гомдоорой. Чамайг шалгах гэсэн юм гэж тариачид заль зохиогоод

— Хэрэгтэй л цэрэг юм гэжээ.

Тэгээд түүний отрядад хоёр зуу гаруй тариачид шууд элсэн орохоор зөвшөөрчээ. Энэ бол зөвхөн эхлэлт байлаа. Төдөлгүй бүх тойргоос дөрвөн мянга гаруй тариачин Четвертаковын командан дор цугларчээ.

Ингээд Четвертаков нэртэй дарга болжээ. Цэргийнхээ дотор цэргийн дэг журам тогтоож харуул манаа, жижүүр томилж сургууль хийдэг болжээ. Тариачид толгой дээгүүр харж гэдсээрээ бөхийхгүй байх журам хатуу баримталжээ.

— Чи чинь ингэхэд хурандаа юу гэж тариачид инээлдэх авч ийм хатуу даргатай болсондоо сэтгэл хангалуун ажээ.

— Юу хурандаа гэж, өөрөө генерал байхгүй юу! эрхэмсэг ноён! гэлцэнэ. Тариачид урьдын адил тосгон тосгондоо сууна. Тэгээд хэрэгцээ гарсан үед л түргэн жагсаал авна...

Францын отряд оросын замаар ирж явжээ. Маш их лут хамгаалалттай ажээ. Армидаа дарь хүргэж яваа нь энэ билээ. Түүрүүнд нь моринд их буу ачсан байлаа. Энэ бол тариачдыг айлгаж сүрдүүлэх, бас өөрсдийгөө зоригжуулж явсан нь лавтай ажээ. Сүмийн тагтны хонх жингэнэн дүнгэнэж нэгэн янзын ая хөг гарна. Францчууд тэр чимээг таатай сонсох бөлгөө. Энд хонх жингэнэлдэнэ. Тэгээд дов дээгүүр гартал бас л тосгон сүм.

Бас л баруун зүүн талд түрж байгаа юм шиг тосгоноос тосгонд хонх жингэнэлдэнэ. Ээ яасан сайхан дуу вэ...

Францчууд цаашаа явсаар л ажээ. Тэд хонхны сайхан дуунд уярна. Энэ бол жирийн нэг эгшиг биш харин тэдний хувьд оршуулгын хагацалтын дуу байсныг тэд мэдэхгүй байж билээ.

Четвертаков сүмийн хонхны дууг отряддаа дохио болгон ашигладаг байжээ. Тэр бол жирийн нэг түгшүүрийн дохио биш, дууны хослол бүр команд байсан юмсанжээ. Тэр дууг анхааралтай сонсвол хаашаа явах, хаана цугларахыг мэдэж болно.

Францчууд явсаар л байлаа. Харин янз бүрийн тосгоноос отрядууд гарчээ. Тэднийг өнөөдөр горхины дэргэд Егорьевскийн жалгын тэнд цугларах тушаал өгсөн юмсанжээ.

Францынхан гол дээр ирэхэд тариачид тал талаас нь шахна. Тэд тоо томшгүй олон ажээ. Тэд хувцаснаасаа болоод хав хар харагдана. Тариачдын дунд морьтой хүн харагдах нь дарга нь бололтой.

Морьтой хүн командлахад дайчин тариачид францын цэрэг уруу дайрлаа. Цэргүүд мэдээж их буугаараа хааш нь аль тал уруу буудах учраа ч олсонгүй! Эргэн тойрон тариачид байжээ. Дэмий л ахлагч нь бололтой морьтой хүн уруу бууджээ. Аз болоход оносонгүй.

Буудалт анхных, сүүлчийх байжээ. Францчууд буугаа шинээр цэнэглэж амжаагүй ажээ. Тариачдын хөл хурдан, гар урт, маш чанга бөлгөө. Их буу, ачаа тэрэг, цэргүүд хэдхэн минутын дараа тариачдын гарт оржээ.

Партизаныуд зоригт үйлсээсээ гэр өөдөө буцаж явна. Четвертаков морьтойгоо явна. Ермолай... эцгийн чинь алдар хэнсэн билээ? Эцгийн нэр усгүйгээр болно биз дээ. Ермолай Четвертаков тариачны генерал, цэрэг ноён л гэвэл боллоо! гэжээ.

Бугуйл

Локотка тосгоны тариачид францчуудыг бугуйлдаж барьдаг болжээ. Тэд ой доторх замын бутанд нуугдаж байгаад ямар нэг отряд явахыг хүлээнэ. Тэгээд морьтой буюу явган отряд явахыг хүлээж хоцорсон хүний хүзүүнд бугуйл шидэж татаж авчран дуугарахаас нь урьд аманд нь юм чихнэ. Тэнд дэгээнд орсон хэлтгий загас шиг ланжгар мусье ч тааралдана.

Нэг удаа тариачид аятайхан байр эзлэн отжээ. Эхлээд хэн ч явахгүй бүтэлгүй байжээ. Тэгтэл морьт отряд хатирч гарч иржээ. Ердийнхөө заншлаар нэг нь хоцорсхийж явна. Энэ удаад өндөр нуруутай тав гээгтэй франц таарчээ. Тариачдын нуугдаж байгаа бут уруу франц ойртон иржээ. Бугуйл дугуйран нисэж нөгөө хүн мориноосоо хийсэхэд тэр даруй амы нь таглажээ.

Тариачид францыг Локотка тосгондоо аваачихаар явжээ. Тэр франц мөчөөгөө тавьдаггүй эр байсан тул тариачдыг хөлөөрөө өшиглөжээ.

Олзолсон хүнээ тариачид ямар нэг пинд хийж ус авчран толгой уруу нь асгаж. амны нь таглааг авч Сычева хошуу уруу аваачихаар шийджээ. Тэнд олзлогдсон хүнийг хүлээн авчээ.

Тэгтэл франц өндийж:

— Будлиу хар сахлууд! Усан тэнэгүүд! Улаан хоолойгий чинь шахна даа!

гэж оросоор хашгирчээ.

Тариачид энэ үгийг соясоод гайхан амаа ангайжээ. Зарим нь ээрч түгдэрнэ. Хэн нэг нь бут уруу давхижээ.

Тэгсэн чинь нөгөө барьсан хүн нь франц биш, харин Денис Давыдовын отрядын донын казак байсан юмсанжээ. Казакууд зориуд францын хувцас өмссөн байжээ. Тэд эсвэл хайгуулаар, үгүй бол өөр ямар нэг хэргээр явж байжээ.

Тариачид сая нэг ухаарч:

— За бид яаж мэдэх вэ дээ.

Ямар духан дээрээ бичсэн биш.

— Амьд үлдсэндээ л гялайлаа гэж хэл гэцгээлээ.

— Унтаа нүдтэй ургаа чулуунууд минь гэж казак яриагаа үргэлжлүүлэн, Энэ юу юм бэ?! гээд таваа заан чичилнэ. Францчууд тавгүй байсан нь лавдай билээ. За тэгээд ямар цаг үе байгааг хардаа.

— За, за хундага дарс байна уу? гэж казак гуйжээ.

— Дарс ч байлгүй яах вэ?

Казак дарс ууснаа мөрөө сэгсэрч:

— За тариачид аа, сайн сууцгааж бай! Зочилсонд чинь талархья гэжээ. Тариачид хэдэн өдөр зам тосохоор явж зүрхэлсэнгүй.

— Дахиад л нөгөөгийг чинь бариад авчихана гэж боджээ. Тэгснээ төдөлгүй ажилдаа гарсан авч урьдахыг бодвол болгоомжтой хандаж францыг барьж авбал юуны өмнө казах гээг байна уу, үгүй юу гэж толгойгий нь үздэг болжээ.

Малгайгаа авч шидсэн нь

Кутузов тариачдын янз бүрийн ажиллагааны тухай мэдээ сонсоод тэр амьд баатруудыг харахаар шийджээ. Юхнов хотын ойролцоо Кутузов дээр партизанууд цугларчээ. Тэд хөгшин залуу, том жижиг дайны шарх сорвитой, тэр ч байтугай Кутузов шиг баруун нүдгүй янз бүрийн хүмүүс байлаа.

Тариачид байшин дүүрэн инээлдэнэ. Кутузов жанжин тэднийг цайгаар дайлахад тариачид ёотонгоор амтлан яаралгүй ууна.

Цай уух зуур дайн байлдаан, францчуудыг тухай яриа гарсан нь лав билээ.

— Францчууд баатарлаг улс юм гэж тариачид хэлээд, харин сэтгэл сул улс юмдаа. Бонапарт Орос орныг айлгаж эзэлнэ! гэсэн нь эндэгдэл болж гэв.

— Илд барьж ирсэн хүн илдэндээ үхдэг гэж Невский хэлж байсан! хэмээн өрөөсөн нүдэт дурсан ярихад

— Үиэн, үнэн! гэж тариачид шуугилдав. Дараа нь Москвагийн тухай ярилцлаа.

— Тун харамсалтай байна. Ямар бага хот бишдээ. Ард түмэндээ үеийн үед алдарших хот. Москва ямар орос орон биш дээ! Хотыг байгуулчихана биз. Гүрэн л бүрэн бүтэн байвал боллоо.

Кутузов тариачдыг францчуудтай зоригтой тулалдлаа гэж магтана.

— Бид юу юм бэ... Бид ч «улаан нүдэнг» урхилна даа гэхдээ арми л түрүүнд нь байлгүй яахав гэлцэнэ.

Ухаалаг улсуудтай ярилцаж байгаадаа Кутузов таашаалтай байв.

— Денис Давыдовын тухай сонссон уу?

— Сонсолгүй яах вэ! Манай хошуунд түүний отряд бий. Зоригтой дарга, агуу их үйлсийг үүсгэгч хүн.

— Смоленскт нэртэй авгай бий юм уу, тэгж ярилцах юм.

— Тэр чинь Кожина байхгүй юу гэж тариачид хариулаад, Ахлагчийн эхнэр Василиса. Торгон цэргээс дутахгүй эм! Эр хүн л гэсэн үг гэв.

Цэрэг Чегвертаковыг санаж:

— Төрөлхийн дарга хүн. Дарга л байвал таарна гэлцэв.

Дараа нь яагаад ч юм бэ Кутузов анзаараагүй байтал яриа өөр зүйлд шилжсэн байлаа.

Тариачид өвөлжих, зусах тарианы тухай ярилцав. Тэгээд Смоленск нутагт ган гачиг болсон тухай, зуушны газрын тухай ярьж байснаа гэнэт:

— Михайл Илларионович, эрхэмсэг фельдмаршалаа, эрх чөлөөний талаар та юу гэж үзэж байна? Ялалтын дараа тариачдыг чөлөөлөх бол уу?

— Газар ер нь яах бол оо? гэж хэн нэг нь хошуу дүрлээ. Кутузов ийм асуудал гарна гэж бодоогүй байжээ. Эрх чөлөөний талаар тариачдад тэр юугаа хэлдэг билээ? Орос орон ч зэрлэг бүдүүлэг л байна даа. Кутузов бол ч эрх чөлөө өгчихмөөр байлаа. Тэгтэл ганцхан цэргийн л дарга шүү дээ. Энэ ч түүний шийддэг асуудал бишээ.

Фельдмаршал юу гэж хариулахаа мэдэхгүй байлаа. Тэр анх удаа л ингэж балмагдав.

Хүнд асуудал тавьсан нь тариачдад тодорхой байлаа. Кутузов ичихийг хүсээгүй тул дахин дайны тухай ярьсан авч нэг л авцалдахгүй байлаа. Кутузов тариачдыг явуулав.

Тариачид тосгоны гудамжаар явж:

— Эрх чөлөө ч олгохгүй бололтой.

— Газар ч гэсэн хуучин хэвээрээ ноёдод хоцрохнээ. Тэгтэл нэг залуу алхаагаа удаашруулж малгайгаа авч газар чулуудан:

Шал дэмий францчуудтай тулалдаж байна! Амьдралаараа л наадаж байна гэлээ.

— Дуугаа тат, амны нь сүү хатаагүй хүү минь гэж нөгөөх өрөөсөн нүдэт хашгираад:

Энэ чинь адилхан зүйл биш, хюёр өөр зүйлээ. Эзэд гэдэг эзэд! орос орон бол орос орон! гэжээ.

Жааз

Жорж Мишле гэдэг цэрэг Орос орон уруу явахдаа маш дуртай байжээ. Яагаад гэвэл «Орос орон баян орон, Гэртээ багагүй их хөрөнгө авчирна» гэж боджээ. Ганцхан Мишле ч биш бусад бүх цэргүүд ингэж итгэж байжээ. Эзэн хаан ч өөрөө ингэж амласан ажээ.

Мишле багагүй баялаг хуримтлуулжээ. Смоленскоос үенгийн арьсаар хийсэн дээл, Вязьмаас үнэтэй лааны тавиур, Гжатскаас памир нутгийн ноосоор хийсэн хивс, Москвагаас нэг том сүмээс бурхны мөнгөн жааз тус тус авчээ.

Мишле илүү авмаар байсан авч маш хүнд учир авсангүй сэтгэл хангалуун байлаа.

«За одоо оросууд найрамдвал найрамдаг, гэртээ харихад ч бэлэн л байна» гэж Мишле бодож байжээ.

Тэгтэл оросууд найрамдахыг хүссэнгүй. Харин францчуудад өдөр ирэх тутам улам бүр муу болсоор л байлаа. Москва тэдэнд хамгийн хэцүү байжээ.

Чингээд францчууд Орос орноос тонилохоор замдаа оржээ.



Мишле санд мэнд юмаа цуглуулж боож баглажээ. Памир нутгийн ноосон хивсээ тампуунд, лааныхаа тавиурыг цэргийн үүргэвчиндээ хийж үен дээлээ хувцастайгаа давхар өмсжээ. Жаазаа хаанаа хийдэг билээ? тэгээд жаазаа хүзүүндээ углажээ. Тэр жаазнаас тонуулч цэргийн нүүр ариун гэгээний дүр мэт цухуйна.

Оросынхон францчуудыг хөөж армий нь цохиж партизанууд ойд замы нь отно.

Францчууд түргэн маршаар явна. Мишле хөлөрч зовно.

Тийм их баялгийг аваачихад багагүй хүч хэрэгтэй ажээ. Үүргэвч мөрий яь холгож, хагас пүүгийн мөнгөн хүнд жааз толгойгий нь дарж урт дээлийн хормой газар шүүрч явахад тээртэй ажээ.

Францчууд ухарна. Казакууд тэднийг тасралтгүй түгшүүлж, Кутузов тулалдаанд цохисоор байлаа Францчуудаас хоцрогсод улам улам их болсоор байлаа. Мишле сүүдэр шиг л сажилна. Өөрснийхөөсөө хоцорч хүч тамир нь барагдсаар байлаа.

Аргагүйн эрхэнд авсан баялгаасаа хагацах хэрэгтэй болжээ. Гжатска хүртэл яваад давшилтын үед хивс авснаа Мишле санаж тэр сайхан үеэ бодож уйлаад памир хивсээ хаяжээ.

Вязьм хүртэл явжээ. Тэндээс лааны үнэтэй тавиур авсан юмсанжээ. Тэгээд тавиураа хараад нулимсаа арчиж лааны тавиураа шиджээ.

Смоленск хүртэл яваад үен дээлнээсээ салжээ.

Мишле эд уурсаа хаясаар, гашуудан уйлсаар явжээ. Буугаа сэмхэн хаяжээ.

Үүргэвчээ авч чулуудлаа. Харин нөгөө жаазнаасаа салахгүй авч явна.

— За чи энэ гайтай жаазаа хая! гэж нөхөр нь зөрүүд эрд хэлнэ. Хаячихвал ч баярлах авч хаяж чадахгүй ажээ. Мишле жаазнаасаа хагацан

салж чадахгүй байлаа. Түүнд эд баялаг амласан шүү дээ. Тэр магадгүй Орос оронд зориуд энэ жаазыг авах гэж ирсэн ч байж болох юм.

Цэрэг хүч тамираа улам барж доройтсоор ажээ. Мишле Смоленскоос цаахна хоцорчээ. Тэгээд хоцорсон чигээрээ хаягдаж хөлдөж үхжээ.

Замын хажуугийн суваг дотор жааз цухуйж түүнээс тонуулч цэргийн нүүр ариун гэгээний дүр аятай цухуйна.



Хурим

Сморгонийн ойролцоох ямар нэг тосгонд Кутузов тариачны хурим дээр тааралджээ. Урьсан урилгы нь урамтай зөвшөөрчээ.

Таван ханатай байшинд ширээ сандал уртаар эгнүүлэн тавьж, бүжиг бүжих зай гаргажээ. Согтсон хүнд өгөх хувинтай давсалсан ус зэхжээ. Зочид цөм тод өнгийн хувцастай ажээ. Хүргэн хүү хөх цамцтай, бэр ягаан өнгийн гоёлтой ажээ.

Залуус Кутузовын хажууд зэрэгцэн сууна. Хурим фельдмаршал битгий хэл генералын оролцоотой болж байхыг оросын тосгон хэзээ ч үзээгүй билээ! Эргэн тойрон тосгоныхон цөм цугларчээ. Хурим найр хөгжөөнтэй, бэрийн төлөө хундага өргөнө.

— Гэрлэгсдийн эрүүл энхийн төлөө хундага тулгана!

— Гашуун, гашуун! гэж тариачид хашгиралдана. Залуус үнсэлдэнэ.

— Өнөр баян өрх болохын төлөө!

— Бэрийн эцгийг эрүүл мэндийн төлөө!

— Хүргэн хүүгийн төрөл төрөгсдийн төлөө!

— Эхчүүдийн аз жаргалын төлөө! хундага хундага бялхам архи сөгнөнө Тэгтэл:

— Эрхэмсэг фельдмаршал Кутузов вангийн төлөө! хундага өргөхөд

Кутузов хүндэт байрнаасаа босож:

— Байзнаарай нөхөд өө байзнаарай! Би ямар хүргэн хүү биш гээд хундгаа өргөж, эх болсон Орос эх орныхоо төлөө. Оросын баатарлаг ард түмний төлөө! ууя гэхэд

— Орос орны төлөө! гэж тариачид хашгирлаа.

Кутузовыг хурим найрнаас штабтаа ирэхэд генералууд тойрч

— Эрхэмсэг та тариачны хуриманд очиж биеэ хайрлахгүй яаж болох билээ гээд тариачдыг зэмлэн:

— Дайн дажин болж байхад бас хурим найр хийж байдаг чинь зохимжтой хэрэг үү гэхэд нь

— Зохимжтой, зохимжтой гэж Кутузов хариулаад, Ард түмэн энх амгалан амьдрал уруу тэмүүлж байгаа нь тэр. Дайны эцэс болж байна. Орос хүн төрөлхөөсөө дайныг биш энхийг, үхлийг биш амьдралыг хүсдэг юм гэсэн гэдэг.

Шинэ аян дайн

1812 оны арван хоёрдугаар сар. Оросын хил, Неман гол хагас жилийн өмнө цэрэг гарч байсан нөгөөх гүүр.

Цэргүүд гүүрээр алхална. Харин тэгэхдээ оросын зүг биш нөгөө тал уруу алхах ажээ. Одоо цэргийн хөлийн жигд алхаа ч сонсдохгүй, бөмбөр ч дэлдэхгүй, цуур ч жингэнэхгүй, туг ч намирахгүй ажээ. Эд бол яаж амьд гарсан нь гайхалтай, ядарч туйлдсан хэсэг бусаг францчууд оросын эргийг орхин одож байгаа нь энэ билээ. Агуу эх хүчний хөөрхийлөлтэй өчүүхэн үлдэгдэл ажээ. Энэ бол эсрэг тал хүчтэй байгаагийн нотолгоо юм.

Оросууд Неман голын гүүрэн дээр ирээд зогслоо. Энэ бол аян дайны эцэс бөлгөө.

— Орос орон амь мэнд гарлаа! гэхэд

— Амь мэнд, гэж буурал үстэй бага дарга хэллээ. Цэргүүд харвал танил бага дарга ажээ.

— Өө, ингэхэд та бидэнд үлгэр ярьж байл уу?

— Тийм ээ би гэж бага дарга хариулахад

— Тэгвэл нөгөө ходол чинь өсөж нас бие гүйцсэн хандгай болчихоод хортон дайснаа цавчилж алаа юу! гээд цэргүүд инээлдэнэ.

— Тэгсэн л болж таарч байна.

Цэрэг эрийнхээ үүргийг биелүүлсэн цэргийн сэтгэл амарчээ.

Цэргүүд голын захын ганга жалганаа зогсож Витебск Смоленскийн дэргэд болсон тулалдаан, Бородино орчмын аймшигт өдрүүд Москвагийн гал... зэрэг өнгөрсөн явдлыг дурсана. Ялалтын зам амаргүй байжээ. Хойч үе маань эиэ үйлсийг дурсан санах бол уу... Орос хүний цус багагүй асгарч билээ. Олон сайхан нөхөд нь үрэгдсэн билээ.

Тэд гуньж гутах авч, нөхдөө дурсан санана. Тэр өдөр баяртай ч уйтгартай ч ажээ.

Яг энэ үеэр Кутузов Жанжин бараа бологчдынхоо хамт гол дээр ирэхэд:

— Ура—а! гэж цэргүүд хашгиралдахад

— Эх орноо аврагчдын яруу алдар бадартугай!

— Фельдмаршалын яруу алдар бадартугай!

— У—у—ра! гэж сонсогдоход Кутузов цэргийн өмнө бөхийж:

— Эх орны баатруудын яруу алдар бадартугай! Оросын цэргийн яруу алдар бадартугай! гэж

хэлснээ цэргүүдэд ойртон очиж:

— Ядарцгаав уу? гэж асуухад

— Ядарсан гэж цэргүүд үнэнээ хүлээгээд, аян дайны төгсгөлд шүү дээ гэхэд нь

— Үгүй, бас та нарын өмнө шинэ аян байна гэж Кутузовь хэлэхэд

Фельдмаршал хаашаа яах гээд байна? гэж цэргүүд мэгдсэн боловч:

— Хичээнгүйлэн зүтгэхэд баяртай байна! гэж цэргийн дүрэм ёсоор хэлжээ.

Кутузов хамгийн өндөр газар гарч цэргээ тойруулан хараад өвгөн хүний хахир дуугаар биш, жингэнэсэн дуугаар:

— Витбск, Смоленскийн баатрууд аа, Тарутино, Ярославийн шонхрууд аа, Бородиногийн талын бүргэдүүд ээ Орос орны хэзээ ч үл мартагдах хүүхдүүд ээ! гээд эмээл дээрээ өндийснөө үлдэгсэд үрэгдэгсэд жагсацгаа!

Үеийн үед дурсагдах шинэ аяны баатрууд болцгоо! гэсэн гэдэг.

Хөдөлмөрийн улаан туг

Емельяновка тосгоны ойд

Емельяновка тосгон Петербург орох их замаас гурван бээрийн зайтай оршдог билээ. Тосгоноос цаахна ой, түүнээс цааш залгаад финийн булан байдаг билээ.

Емельяновка тосгон онцгой зүйлгүй цөөн хэдэн байшинтай, оршин суугчид нь амар жимэр ажээ. Тэнд ямар ч түүх, ямар ч үйл явдал болоогүй билээ.

Онцлох юмгүй жирийн нэг л ой, хус нарс, бөөрөлзгөнийн өргөст бут, шид модны ширэнгэ ургана. Зорчигчид тийшээ очих нь ховор билээ.

За тэгтэл...

Нэгэн өдөр нутгийн жаал Санька Лапин ойн орчим эргэлдэж байгаад хоёр үл таних хүн харжээ. Тэд ийш тийшээ харан тал дундуур явж ширэнгэн дунд далд оржээ.

«Хэн байдагсан билээ? Эрүүл саруул залуус байх юм, тэгтэл дээрэмчид шиг нуугдаж байдаг» гэж Санька боджээ.

Жаал хүү ширэнгэ уруу сэмхэн гэтэж очмоор байсан авч зүрхэлсэнгүй. Холуур тойрч булан дээр гүйж очвол эрэг дээр хэд хэдэн завь байхыг харжээ. Тэдгээр завинаас хүмүүс бууж бас л ийш тийшээ харсаар ой уруу оржээ.

Санька тосгон уруугаа найз Пашка Дударов дээрээ гүйн ирж:

— Паш, Паш хоёр зуу орчим хүн! гэж шивэгнэжээ.

— Битгий худлаа хэлээд бай!

— Очиж үзье л дээ

Найзууд булан уруу гүйж очвол үнэхээр завь байхыг Пашка харжээ. Тэд ой уруу гүйж ороод болгоомжтой гэтэж бутнаас бут дамжсаар ойн цоорхой уруу тэнд байгаа улс дээр очжээ!

Тэд хагас дугуйрч зогсоод голд нь өргөн цээжтэй ажилчин зогсож улаан туг дэлгээд ярьж гарчээ. Жаалууд мэл гайхаж, модны цаана нуугдан амьсгаа даржээ.

— Өнөөдөр Петрградын ажилчид бид энд цугларсан юм... Бид өнөөдөр маш цөөн байна, гэвч ард түмний сэргэх цаг ойр болжээ... гэх илтгэгчийн үг Санька, Пашка хоёрын чихэнд сонсдоно. Илтгэгч удаан ярьсны эцсэд:

— Манай пролетарийн баяр мандтугай! гэсэн үгээр төгсгөлөө. Санька

Папкаг нударч:

— Энэ юуны тухай яриад байна вэ? Пашка мөрөө хавчина. Анхны ажилчин илтгэсний дараа хэд хэдэн ажилчин үг хэлжээ.

Тэд бүгд хөдөлмөрчин хүний хувь тавилан хүнд бэрх байгаа тухай, сайн амьдралын төлөө тэмцэх хэрэгтэйн тухай, бас л нөгөөх баярынхаа тухай ярьцгаалаа.

Хүүхдүүд бутан дотор хоёр цаг гаруй хэвтжээ. Цуглаан дуусаж, ажилчид хэсэг бүлгээрээ тарж эхэллээ.

Тэдний явахыг хүлээж байгаад босож явахдаа ой дотор юу болоо юм бол оо, ямар баярын тухай ажилчид яриад байв аа? гэж тааж явлаа.

Тэд Емельяновка тосгондоо ирээд ахмад хүмсээс учрыг мэдэхээр шийджээ.

Санька эцэг өөдөө асаж цуглааны тухай, улаан тугны тухай ярихад

— Чи худлаа юм зохиогоогүй биз гэж эцэг нь эргэлзэхэд

— «Зохиох оо!» Бид бутны дор хэвтэж байгаад нүдээрээ харсан гэвэл

Санькагийн эцэг дэмий л мөрөө хавчиж юу ч тайлбарлаж чадсангүй.

Хүүхдүүд ээжээсээ асууж, Марья эмээ дээрээ очиж, Егоров өвөө уруу ч гүйжээ. Гэвч ажилчны баярын тухай хэн ч юу ч мэдэхгүй байжээ.

Тэгээд хүүхдүүд Онучкин өвгөн дээр харайж очжээ. Тэр ч хамгийн ахмад нь учраас мэдэж байх ёстой гэж боджээ. Онучкин бурхны мэндэлсний баяр, улаан өндөгний баяр, хааны төрсөн өдрийн баяр, хатан хааны төрсний баяр... гээд л янз янзын баярын тухай тайлбарлаж гарахад

— Биш ээ биш! гэж хүүхдүүд яриаг нь таслахад

— Зул сарын баяр, загалмайсны баяр гэж бас байдаг.

— Ажилчны баярын тухай! гэж хүүхдүүд хашгирахад

— Ажилчны ий? гээд өвгөн бодлогоширсноо шилээ маажиж тийм баярын тухай сонсоогүй гээд гараараа зангалаа.

Ийнхүү хоёр найз юу ч олж мэдсэнгүй.

Емельяновка тсгоны ой дотор оросын ажилчид анх удаа майн нэгнийг тэмдэглэсэн юмд байжээ. Энэ нь 1891 онд болсон юмсанжээ.

Харин Майн нэгэн гэж ямар баяр, яагаад түүнийг тэмдэглэх болсон тухай Санька, Пашка хоёр тэр даруйдаа мэдээгүй олон жил өнгөрсөн хойно өсөж том болоод ажилчин болсон хойноо мэджээ.



Хойтохы нь уншсан нь

Майн нэгний баяр тэмдэглэхийг ажилчдад хориглосон байжээ. Тэр өдөр хэсэг бүлгээрээ цугларч жагсаал, цуглаан хийж болдоггүй байлаа.

Тэгээд ажилчид янз бүрийн арга заль хэрэглэдэг болжээ. Москвагийн нэг захын ажилчид оршуулгын газар цугларахаар шийджээ.

Авс хийж, лам хөлслөн авч, зургаан хүн авсаа гар дээрээ өргөж бусад нь араас нь жагсжээ. Тэгээд оршуулгын газар луу явахад өмнө нь ламтан явж бойпироо сүржин даллана.

Одоо ажилчдыг хэн ч хөөн тараахаасаа өнгөрчээ. Тэр ч байтугай хотын цагдаа нар хүндэтгэлтэйеэ зам тавьж байлаа.

Оршуулгын газрын сүмд талийгаачийн хойтохыг лам уншиж бойпороороо даллан:

— Бурхны боолын хойд насны буяны төлөө... гэж уянгалуулснаа, Хэнсэн билээ? гэж ажилчдаас асуулаа.

— Николай гэдэг юм.

— Бурхны боол Николайн хойд насны буяны төлөө гээд уянгалуулав. Ламтан буян үйлдээд хэлэлцээ ёсоор таван рублиэ авч далд оржээ. Харин ажилчид оршуулгын газрын зэлүүд буланд очиж цуглаан хийжээ.

Тэд аман дотроо хувьсгалын дууг аяархан дуулж майн нэгний тухай ухуулах хуудас уншицгаажээ.

Орой нь оршуулгын газрын манаач Тятык булшнуудаа эргэж яваад булаагүй австай тааралдаж ихэд гайхан тагийг авч харвал бодохоос аймшигтай юм байжээ.

Манаач хэсгийн харгалзагч дээр харайн очиход:

— За юу болоо вэ? гэхэд нь

— Эрхэм харгалзагчаа, авс гэвэл

— Тэгээд яагаа вэ?

— Тэнд авсанд гээд... Тяткин ээрч эхлэхэд

— За тэгээд авсанд юу байгаа юм бэ дээ? гэхэд нь

— Эрхэм дээд эзэн хаан Николай хоёрдугаар гэж Тяткин хэлэхэд

— Чи чинь тэнэглэж гүйцээ юү?!



— Үгүй гэж оршуулгын газрын манаач залбираад, эзэн хаан яг дүрээрээ байгааг танд илтгэх гэсэн юм гэжээ.

Харгалзагч оршуулгын газар очиж авсыг харвал үнэхээр юм байсан боловч

Николай хоёрдугаар биеэрээ биш харин хөргий нь яг өндрөөр нь, цэрэг хувцастай нь одон сэлтгэй нь зурсан байжээ.

Ингээд мөрдлөг эхэлжээ.

Тятыкин шинэ юм юу ч мэдэгдэж чадсангүй. Нөгөө ламыг барьж:

— Хойтохыг уншсан уу? гэж харгалзагч асуувал

— Уншсан.

— Хэний хойтохыг уншаа вэ?

— Бурхны боол Николайн хойтохыг уншсан.

— Мангуу хог! гэж харгалзагч хашгирлаа.

Ламтан яагаад ингэж хэлж байгаа юм бол, ямар гэм хийлээ гэж санваартан хүнийг цагдаагийн хэсэг дээр авчирч байдаг билээ гэж учрыг ойлгохгүй удаан мунгинажээ.

Тэгээд учрыг мэдмэгц намрын навч мэт чичирч загалмайлан нүд нь бөлтийж цавчлан бие нь чичирнэ.

— Цуглаан дээр хэн байсан бэ? гэж харгалзагч шална. Ламтан хэн байсныг санахыг хичээх авч санасангүй.

— Янз бүрийн л улс байсан. Дөч гаруй хүн өндөр нам, залуу хөгшин янз бүрийн л улс байсан, хэн нэг нь бурхны магтаал их сайхан дуулж байсан гэлээ.

— Бурхнаа ч мөн магтав аа! гэж харгалзагч шоолоод, хэн чамайг хөлсөлж авсан бэ? Хэн чамд мөнгө төлсөн бэ? гэж байцаахад

— Их ханхгар цээжтэй гэж лам хэлээд сэргэснээ, сахалтай, бас гар нь эвэртсэй хүн байсан гэлээ.

Тэгээд хайж гарлаа. Ажилчдын дунд ханхар цээжтэй, сахалтай хүн аль олныг тэр гэх вэ.

Ажилчин бүр гартаа эвэртэй шүүдээ. Тэгээд ч олж чадсангүй. Харгалзагч, Тятыкин лам хоёрыг хараан зүхэж уул хэрэг зүйл дуусчээ. Ажилчид сэтгэл хангалуун байлаа. Майн нэгнээ тэмдэглэж, эзэн хаандаа хойтохыг үйлдсэн буян хийсэн нь тоглоом гэж үү дээ.



Гриша лозняк

Гриша Лозняк ганц хүний өрөөнд хоригдож байжээ. Тэрбээр намхан биетэй, туранхай, шувтан мөртэй ажээ. Харахад онцгой юмгүй бөлгөө. Бас тэгээд даруу зантай учир шоронгийн харгалзагчидтай хэрүүл маргаан үл үүсгэнэ. Шоронгийн горимыг зөрчдөггүй байлаа. Тэр ч байтугай нарлах үед ярьж хөөрдөггүй байв. Түүнийг харгалзагчид хараад: «тэнэг амьтан хилс орсноос зайлахгүй» гэж боддог байжээ.

Долоо хоногт нэг удаа эргэлт оруулахдаа дүү нь ирж нэг дугуй талх, шил сүү, зуун грамм хиртэй хамгийн хямд чихэр цаасанд боож авчирч өгдөг байлаа.

Дүүгийн нэрийг Лиза гэдэг бөгөөд ахыгаа бодвол бүр туранхай, жижиг охин шиг ажээ. Лиза өөрийнхөө ээлж дугаарыг тэвчээртэй хүлээж хулчигнан сагстай юмаа өгөөд холддог байлаа.

— Аймхай амьтан бололтой гэж манааныхан ярилцдаг байлаа. Харин үнэн хэрэг дээрээ тийм биш ажээ.

Гриша ч шоронд санамсаргүй орсон биш байжээ. Тэр большевик намын гишүүн, хэвлэгч ажилтай байгаад нууц хэвлэлийн үйлдвэрийг бут ниргэх үед баригдсан юмсанжээ.

Лиза ч ерөөсөө түүний дүү биш байжээ. Тэр хүүхэн большевик намын гишүүн учир намынхаа даалгаврыг биелүүлж байжээ. Бас тэгээд талх, чихэр, сүү зүгээр ч авчирч өгдөггүй байжээ. Чихрийн цаасан дотор эрх чөлөөнд байгаа нөхдийн нь захиа байдаг байлаа. Гриша шоронд сууж байсан авч бүх мэдээ, байдлыг бүрэн мэддэг байлаа.

Гриша талхаар бэхний сав хийж сүүгээ хийгээд, сүүгээр нөхдөдөө хариу бичдэг байжээ. Тэгээд хэрвээ манаа өрөөнд нь дөхөж ирэх чимээгээр «бэхнийхээ савыг» бэхтэй нь залгичихдаг байлаа. Владимир Ильич Ленин шоронгоос ингэж захиа бичдэг байсныг та нар лав мэдэж байгаа байх аа.

Майн нэгний баяр ойртож байлаа.

Гриша майн нэгний жагсаалд нэг биш удаа оролцож байжээ. Тэр шорон дотроо ажилчдын баярыг тэмдэглэхээр шийджээ. Тэгээд хажуугийнхаа өрөөний хоригдлуудад энэ тухайгаа мэдэгджээ. Тэгэхдээ тусгай дохиогоор тогшиж мэдэгджээ. Эхлээд баруун талынхаа ханыг, дараа нь зүүн талыхыгаа тогшжээ. Нөхөд нь дохиог ойлгож дэмжин, нөгөөх зэрэгцээх өрөөндөө мэдэгдэж байлаа.

Төдөлгүй Гриша Лознякийн саналыг улс төрийн бүх хэрэгтнүүд мэджээ. Тэгээд маргааш нь номын шил дотор, бялууны шанзны оронд талхан дотор улаан даавууны өөдөс хийж шоронд оруулжээ.

Чингээд зугаалгын үед хоригдлууд Гришад даавууныхаа өөдсийг сэмхэн өгөхөд Гриша шөнөжин оёж улаан туг хийжээ. Май нэгэн ч болоход хоригдлуудыг ерийнхөө байдлаар наранд гаргажээ. Шоронгийн хашаа их биш тул тэд цувралдан явна. Гучин минутанд арван

удаа тойрно. Тэгээд ч зугаалга дуусна.

Хоригдлууд эхний тойргийг тойрч, хоёр дахиа явж байтал гэнэт хоригдлуудын дээр гал улаан туг агаарт намирч, тэнгэр нар өөд дэрвэжээ.

Хүч тэнцүүгүй тулалдаанд

Хөгжүүн зоригтой байгаарай нөхөдө! гэж Гриша

Лозняк дуулж эхлэхэд

Эх болсон эх орноо хамгаалж

Эрх чөлөө, нэр төрөө бодъё! гэж бусад нь түрлээ. Харуул манаа сэтгэл түгшин гүйлдэж:

— Чимээгүй! Чимээгүй! хэмээн хашгирна. Хоригдлууд сонссон ч юмгүй:

Шорон гяндандаа хорьж л байг Шөрөг галаар тамлаж л байг Уурхайн алсад цөлж л байг

Улаан цайм цаазалж л байг!...гэж дуулна. Шоронгийн дарга ирж хоригдлуудыг тал талаас нь хүрээлж бэрээдэн занчиж өмхий муухай чангаланд хөөж оруулжээ.

Жагсагчид хоёр долоо хоног чангаланд суужээ. Дараа нь тэднийг янз бүрийн хотын шорон уруу тараажээ. Гриша Лозняк ч бас явжээ.

Түүнийг шинэ шоронд аваачиж ганцаарангий нь нэг өрөөнд суулгажээ.

Долоо хоног өнгөрсний дараа Гришад бэх, бэхийн сав бий болж наранд байгаа нөхдөөс нь захиа ирдэг болжээ...

Гришаг харахад намхан биетэй, туранхай, даруу авч онцгой юм огтхон ч үгүй билээ...

Их буу

Майн нэгний өглөө цагдаагийн хурандаа Голова—Качановт захиа гардуулжээ. Дугтуйг задлан үзвэл: «Майн нэгэн мандтугай! Хаант засаг сөнөтүгэй!» гэсэн ухуулах хуудас байжээ.

Голова—Качанов хонхийн цайж ухуулах хуудсаа барьсаар цагдаагийн газраа ирж доорх хүмсээ цуглуулжээ. Тэгтэл мөн тийм захиаг: Ротмистр Галкин, дэслэгч Кутейкин, цагдаагийн түшмэл Тупиков, Носорогов болон бусад цагдаа нар хүлээн авсан нь тодорхой боллоо. Төдөлгүй Голова—Качановын газар луу хотын янз бүрийн язгууртай хүмүүс: фабрикийн зэвч Рублев, худалдаачин Собакин, чөлөөнд гарсан генерал Атакин зэрэг бусад хүмүүс утасдаж гарлаа. Тэдэнд бас ийм захиа ирсэн юмсанжээ.

Голова—Качанов толгойгоо базална. Тэгтэл цагдаагийн түшмэд

Носорогов бүгдийн дунд:

— Эрхэмсэг нөхөд өө ямар нэгэн үймээн гаргах гээгүй байгаа? гэхэд

— Байр байрандаа! гэж Голова—Качанов хашгираад, гудамжинд их буу, үхэр буу зоогоод! гэж командалжээ.

Цагдаа нар зарлигийг ёсчлон биелүүлж гудамжны бэлчир бүр дээр шүршүүр буу, цагдаагийн захиргааны орчим их буу зоожээ. Хот дотор цагдаагийн тагнуулууд тэнэнэ. Гэвч хотод ямар ч үймээнгүй амар тайван ажээ. Харин цагдаагийн захиргааны тэнд зоосон их бууны орчим жаалууд эргэлдэнэ. Тэр хүүхдүүдийн олонх нь их буу анх удаа үзэж байгаа болохоор бүр ойр очихыг бодно. Тэр ч байтугай хамгийн зоригтой нэг нь гол төмөр болон дугуйг нь оролдоно.

— Холд, холд! гэж цэргүүд хашгирахад жаалууд холдсоноо дахиад л ойртоно.

— Буудаач гэж цэргээс гуйна.

Үдийн хирд хурандаа Голова—Качанов тайвширч, хөгжөөнтэй болжээ. Тэгтэл цагдаагийн газар түшмэл Носорогов гүйн ирж хурандаад цаас үзүүллээ.

— Ээ—э... Ээ—э гэж ээрснээ, — ээ—эрхэм хурандаа хараач, их буун дээр наасныг нь хуулаад ирлээ гэжээ.

Хурандаа харвал: «Майн нэгэн мандтугай! Хаант засаг сөнөтү—гэй!» гэсэн ухуулах хуудас байжээ.

Голова—Качанов дахиад л цонхийж, дахиад л толгойгоо базаллаа. Харин Носорогов өөрийнхөө хэлдэг санааг ахиад л илчилж:

— Эрхэмсэг хурандаа, бослого биш байгаадаа гэлээ.

Тэгээд хот дотуур дахиад л тагнуулууд шиншилж, их буугаа бэлтгэжээ.

Харин Голова—Качанов их буугаараа цаг тутгаад хий буудаж байх тушаал өгчээ. Энэ нь засгийн хэрэгсэл бэлэн байгааг мэдэгдэж айлган сүрдүүлэх зорилготой байжээ.

Хурандаа дээр цагдаагийн түшмэд, дарга нар ирж газар сайгүй амгалан тайван байгааг илтгэнэ.

Түшмэд Тупиков ирж:

— Эрхэм хурандаа, бүх юм горимоороо байна гэхэд

— Сайн байна, яв гэжээ.

Дэслэгч Кутейкин ирж:

— Эрхэм хурандаа, бүх юм горимоороо байна, гэхэд

— Сайн байна, яв гэжээ.

Носорогов ирж:

— Эрхэмсэг хурандаа ямар нэгэн зөрчил гарсангүй, бүгд ёсоороо байна гэхэд

— Сайн байна, яв гэжээ.

Носорогов эргээд явтал нуруугий нь тэр аяар нь эзэлсэн «Майн нэгэн мандтугай! Хаант засаг сөнөтүгэй!» гэсэн ухуулах хуудас наасан байжээ.

— Мангуу хог! гэж Голова—Качанов хашгираад, баривчилж, цэргийн шоронд хий! гэжээ.

Дахиад л хот даяар цагдаа тагнуулууд гүйж, шүршүүр бууныхаа ард хүлээн хэвтэж, их буугаараа бууджээ.

Харин энэ хооронд нь ажилчид хотын захын ой дотор цугларч майн нэгнийхээ баярыг тайван тэмдэглэж баярласан байжээ.

Ажиллана, Ажиллахгүй

Дөрөвдүгээр сарын дундуур Полисадовын завод дээр хэсэг бельги ажилчид иржээ. Тэд заводад авчирсан суурь машиныг угсрахаар ирсэн юмсанжээ.

Майн нэгэн ойртож байлаа. Орос ажилчид тэр өдөр ажилдаа гарахгүй гэж тохиролцоод, Бельгүүд яадаг бол оо? гэж бодож байжээ.

Нэг хэсэг нь:

— Бельгүүд ажиллана гэхэд

— Үгүй, ажиллахгүй гэж нөгөө хэсэг нь няцаана.

Заводын хүүхдүүд ч бас маргалджээ. Колька Зудов Бельгүүд ажиллана гэхэд ажиллахгүй гэж Ленька Косичкин хэлжээ.

— Тэдэнд бидний цус байхгүй, бельгичүүд оросыг дэмжихгүй гэж Колька хэлэхэд

— Ямар ч байсан дэмжинэ гэж Ленька зөрнө.

— Маргаж, маргаж эцсэд нь хэн дийлдсэн нь арав няслуулахаар болжээ. Хэрвээ Колька зөв болж бельгүүд ажилдаа гарвал яах вэ? Колькагийн хуруу чанга хэцүү бууна даа.

Колька ч бас унтсангүй. Ленька л дийлэх байх! Колька няслуулахаас нэг их айгаагүй боловч хүүхдүүдийн өмнө эвгүй байдалд орно гэж боджээ. Колька цаг үргэлж дийлж байх дуртай билээ.

Маргааш нь өглөө эрт тэд завод дээр харайж иржээ. Тэнд Колька Ленька хоёроос гадна Ленькагийн эгч хонгор Катька бас бус арваад хүүхэд байжээ. Тэдний маргаан яаж дуусахыг харахад хүүхдүүдэд сонирхолтой ажээ.

Өглөөний долоон цагт заводын хаалган дээр бельгүүд иржээ. Эхлээд таван хүн, дараа нь дахиад таван хүн, дараа нь бусад бельгүүд иржээ.

Хүүхдүүд тоолбол тэнд хорин хүн байлаа...

— За би хэлээгүй бил үү? гэж Колька сүржин хэллээ.

— Хэлсэн.

— Алив духаа гэв.

Хүүхдүүд жалган дотор орж салхинаас хоргодоход Колька ханцуйгаа шамлав.

— Нэг хоёр, гурав, дөрөв... гээд Колька тоолно.

Колька чанга няслахад Ленька үрчийж, өвдөхдөө хэлээ хазаж шүдээ зууна.

— Тав, зургаа...

Ленька хичээхээр хичээх авч нулимс нь өөрийн эрхгүй асгарна.

— Долоо, найм, ес, арав.

Колька ч арав дахиа нясалтал Ленькагийн эгч хонгор Катька

— Бельгүүд яваад өглөө! Заводаас яваад өглөө! гэсээр гүйж ирэхэд

— Юу яваад өглөө гэж?! гэхэд

— Яах вэ, яваад л өглөө!

Хүүхдүүд жалганаас босож харвал үнэхээр бельгүүд яваад өгсөн байлаа. Урд нь таван хүн, хойноос нь бас таван хүн, бусад хүмүүс тэднийхээ хойноос явж байлаа. Тоолж үзвэл яг хорин нэгэн хүн байлаа.

Ленька Колька уруу нударга зангидаж

— Би хэлээгүй бил үү! хэлсэн шүү дээ! Алив духаа гэхэд

— Яагаад тэр билээ, тэд эргээд ирэх ч юм бил үү хэмээн Колька цааргалахад, хүүхдүүд Ленькаг өмөөрч:

— Эргэж ирэхгүй. Яасан ч эргэхгүй. Манайхныг байхгүй болохоор л яваад өгч байхгүй юу гэхэд

— Алив духаа! хэмээн Ленька дахин шаардахад Колька номхорч духаа бөхийв...

Жаалууд булцруу болсон духтай гэр өөдөө харьж яваад тосгонд эцэгтэйгээ тааралджээ.

— Хэн чамайг ингэчихээ вэ? хэмээн

Колькагийн эцэг хүүгээсээ асуухад:

— Пээ, пээ гэж Ленькагийн эцэг шагширна.

— Бельгүүдээс болоод ингэсэн юм гэж хонгор Катька ярианд оролцоход

— Яагаад бельгүүдээс болдог билээ? гэхэд охин болсон явдлыг цөмийг ярилаа.

Ажилчид элгээ хөштөл хөхрөлдөж:

— Бидний цус байхгүй гэлээ гэнээ. Энэ чинь л худлаа байна. Бидний цус пролетарийн цус шүү дээ. Манай үйл хэрэг нэг гэжээ.

Шинэ цамц

Эцэг нь майн баяраар хүү Николайдаа шинэ цамц худалдаж авна гэж амлажээ. Үдэш болоход эх, эцэг, Николайг эгч Клава нар цуглаж цамцны тухай яриа болжээ.

— Бүстэй цагаан цамц авбал дээр гэж Клава хэлэхэд

— Угаагдахгүй. Бараан өнгийн юм уу, хөх цамц авах хэрэгтэй гэж эх хэлнэ. Хөх цамцаар яах юм бэ, хүүдээ намуу цэцгийн өнгөтэй тод улаан цамц авч өгнө гэж эцэг цааргаллаа. Николай хүү зүрх даран чагнаж нүд нь дүрэлзэнэ.

— За чамд ямар цамц авах вэ? гэж эцэг асуужээ.

— Энгэртээ халаастай улаан цамц авч өгөөч гэжээ. Николай найз нөхдөдөө цамцныхаа тухай ярьж сайрхана. Хүүхдүүд түүнд ямар цамц авч өгөх талаар маргалдаж:

— Усан цэргийн цамц дээр гэж Зойка Носкова хэлжээ.

— Захан дээрээ хээ угалз хатгасан цамц ав гэж Пашка Солдатов зөвлөнө.

— Цээжин дээрээ товчтой, товчтой гэж Кузя Водичкин шивнэнэ. Николай заводын байшин дундуур гүйж дайралдсан болгондоо цамцныхаа тухай ярина.

Степан Широкий гэдэг ажилчинтай тааралдаж:

— Над шинэ цамц авч өгнө! гэхэд

— Өө тийм үү?!

— Нээрээ, нээрээ!

Слесарь Тихон Громовыг харж:

— Аав над майн баяраар цамц авч өгнө гэсэн!

— Хараач! Эцэг чинь их сайн хүн байна даа гэхэд

— Сайн гээд Николка инээжээ.

Токарьчин өвгөн Кашкинтай уулзаж:

— Аав над цамц авч өгнө гэсэн!

— Хэлж хайрлаач!

— Намуу цэцгийн өнгөтэй, цээжин дээрээ товчтой, халаастай, шинэ цамц гэж жаал хүү сайрхана. Хэдэн хоногийн дараа тосгон даяар тэр цамцны тухай мэдэхгүй хүнгүй болсон

ажээ. Николайн эцэг Иваново хот уруу ажлаар явжээ.

— За Николка, ээжийнхээ үгэнд сайн орж байгаарай. Чамд цамц авчирна гэж эцэг явахдаа хэлжээ. Эцэг нь яваад эргэж ирсэнгүй. Гай дайрч Николкийн эцгийг Иваново хотын харгис цагдаа баривчилсан юмсанжээ.

Николкийн гэрийн байдал өөрчлөгдөж эл хуль болжээ.

— Ээжээ, ээжээ яагаад аав ирэхгүй байгаа юм бэ? гэж Николка шална.

Эх хүүгээ тэвэрч биендээ наахаас өөр үг хэлдэггүй байжээ. Николай хүү уйлна.

— Чимээгүй, чимээгүй гэж Клава дүүгээ тайтгаруулаад, аав удахгүй ирнэ.

Аав биднийгээ мартахгүй гэнэ.

Ажилчид майн нэгний өмнөхөн цуглаан хийж баярын тухай, эв санааны нэгдэл, тусламж дэмжлэгийн тухай ярилцжээ. Тэнд өвгөн Кашкин, слесарь Тихон Громов, Степан Широков зэрэг бусад ажилчид байжээ. Нөхөд нь Николайн аавыг дурсан санаж хүүдээ майн баяраар цамц авч өгнө гэж амласны нь саналаа.

— Николай хүүд цамц худалдаж авахаар ажилчид шийджээ. Майн нэгний баяр ч боллоо. Николай сэрээд хажуу дахь сандал дээр цамц байхыг хараад нүдэндээ итгэсэнгүй. Тэр цамц цээжин дээрээ товчтой, намуу цэцгийн өнгөтэй, халаастай ажээ.

— Аав, аав хүрээд ирж! хэмээн Николка хашгирлаа. Эх нь ирээд юу гэж хэлэхээ мэдэхгүй зогссоноо:

— Үгүй, миний хүү, аав нь ирээгүй, хавьдаа ирэхгүй байх аа гэжээ.

Николка ээжийгээ ширтэж: тэгээд энэ цамц хаанаас гараад ирэв ээ? хэмээн бодно. Аа мэдлээ Аав явуулсан юм байна! гэж хашгирчээ. Эх хүүгээ харж хэлэх үү, байх уу? гэж бодно. Николка даанч жаахан байна даа. Ажилчин ангийн эв санааны нэгдэл гэж юу байдгийг ойлгох болоогүй тэнэгээрээ байна даа гэж бодоод хэлэхгүй байхаар шийджээ.

Николка шинэ цамцаа өмсөөд гудамжинд харайн гарч тааралдсан болгондоо сайрхана. Степан Широков гэдэг ажилчин залуутай тааралдаад:

— Аав над цамц явуулсан!

— Өө, тийм үү?! хэмээн залуу гайхахад

— Тийм, явуулсан юм. мартаагүй л байна! гээд Николка цаашаа харайжээ. Тэгээд слесарь Тихон Громовыг хараад:

— Аав над цамц явуулсан гэхэд!

— Хараач, их сайн аав юмаа гээд Громовыг инээмсэглэхэд

— Сайн аав! гэж Николка хөхрөөд, Сайн, сайн! гэсээр гүйж Токарьч Кашкиныг гүйцэж очоод:

— Аав над цамц явуулсан! гэхэд

— Хэлж хайрлаач, үнэхээр сайхан цамц байна! гэж Кашкин хэллээ.

— Цоо шинэ цамц, халаас, товч, намуу цэцгийн өнгийг ч мартаагүй байна шүү хэмээн шулганана.

Кашкин, Николкаг биедээ нааж толгойгий нь илэн, нүдий нь нулимс бүрхжээ. Николка толгойгоо сөлийж:

— Та яагаад уйлж байгаа юм бэ? гэхэд

— Зүгээрээ, би л гэж өвгөн сандарснаа, үгүй, явж тогло. Энэ жилийн Май... ажилчны баяр болно гэжээ.

Гацаантай цөн

Энэ жилийн хавар оройтлоо. Гол тэлсэн боловч цөн түрээгүй байлаа. Голын мөс майн нэгний баярын өмнөх шөнө л ханзарчээ.

Өглөөнөөс аваад голын эргийн дагуу хүмүүс цугларчээ.

Том том цөн голоор бие биенийхээ хойноос эргэлдэн хавиралдан харгилдаж цоройсноо мянган бутархай болж дахин усан дээрээ унаж хөвнө.

Хүмүүс зогсож шохоорхоно.

Тэнд яг голын эрэг дээр ахлагч Охапкин жижүүрлэж байжээ. Тэгээд олон хүн цугларсан байхыг хараад «Ээ майн нэгэн битгий л гай тарьсан байгаасай. Ажилчид ямар нэг юм зохиогоогүй байгаа даа» гэж боджээ. Зөвхөн ингэж бодтол голын эргүүлгийн цаа—наас асар том цөн хөвж иржээ. Охапкин хараад нүдэндээ итгэсэнгүй, цөн дээр улаан туг намирч явжээ.

Эрэг дээр улсууд шавааралдана.

— Ура! Майн нэгэн мандтугай! гэх дуу Охапкины ард цууриатлаа. . Ахлах цагдаа мэгдэж шүглээ авч хүмүүсийн зүг харан шүгэлдсэнээ, эргэж цөн уруу шүгэлдлээ.

Хурсан олон инээлдэн зогсож тарсангүй.

— Тарцгаа! тарцгаа! Битгий бөөгнөрөөд бай! хэмээн дуу нь тасалдан хашгирна.

Харин энэ үед цөн улам улам ойртон ирж, зориуд эрэг уруу ирж байгаа мэт байлаа. Салхинд улаан туг намирна.

Ахлагч цагдаа яахаа мэдэхгүй, ийш тийшээ самгардсанаа зогсож уртаар амьсгаа аваад дахиад л шүгэлдэж гарлаа.

Шүгэлдсээр байтал цөн бүр эрэгт ойртож, Охапкинтай зэрэгцэн хөвөхөө больж даажигнах мэт зогсоно.

Хэрвээ энэ цөн лүү үсэрч буугаад тугий нь авчихвал хамаг хэрэг дуусах юм биш байгаа? гэж ахлагч шарлахан боджээ.

— Харайгаач! гэж цугларсан олны дундаас хэн нэг нь хашгирлаа. Охапкин ч үсэрлээ. Цөн түүний үсрэхийг хүлээж байсан мэт эргээс холдон хөвжээ.

— Харуул! амь авраарай! гэж ахлагч чарлана.

Охапкин цөн дээр жирийн шүгэл тугны тухайгаа ч мартаж малгай нь шил уруугаа хийсэж гараараа даллаж тусламж эрнэ. Харгис цагдаагийн ахлагчийн төлөө хүйтэн усанд орох дуртай хэн байх билээ?

Каспийн тэнгист мэнд хүргээрэй! гэж даажигнана.

—Аян замдаа сайн яваарай!

— Майн мэндчилгээ хүргээрэй! гэх сонсдоно.

Хоёр цөн мөргөлдөхөд ахлагч тогтож чадсангүй ус уруу налбайлаа.

— Амь авраач! гэж Охапкин дахин хашгираад живлээ.

Хэсэг залуучууд цугларсан олноос онцгойрч хувцсаа тайлан усанд шумбаж, айж сүнс нь зайлсан Оханкиныг эрэг дээр гаргаж ирлээ.

Цагдаагийн ахлагч цайж хөхөрсөн царайтай нийтийн инээдэм тоглоомын дунд загалмайлан чичрэн зогсоно.

Энэ үед цөн голын дунд хэсэг уруу хөвөн очиж эргэлдэн хөвөрсөөр цааш урслаа. Хаврын агаарт улаан туг наадан намиран

— Майн нэгэн мандтугай! гэх дуун эрэг даяар цууриатна.

Хөдөлмөрийн улаан туг

Майн баярыг гурван завод зэрэг тэмдэглэжээ. Ажилчид Нагорный, Литейный, Маршева болон бусад гудамжнаас хотын төв уруу нягт цуваа болон хөдөлжээ. Гошкины эцэг өглөө эрт завод уруугаа явахад:

— Би тантай явна гэж Гошка хүү шалжээ.

— Чи бага байна. Гэртээ үлд гэхэд эцэг нь инээмсэглэхэд

— Би явах гэсэн юм. Миний хийсэн юмыг хараач гээд хүү улаан дарцаг үзүүлжээ.

— Сайхан дарцаг болж гэж эцэг хүүгээ магтсан авч дагуулж явсангүй. Гошка гэртээ үлдээд тасалгаан дотуураа жаал эргэлдээд дарцгаа өвөртөлж хаалга уруугаа явахад эх нь болгоомжилж:

— Чи хаачих нь вэ? гэхэд

— Ванька Серегин дээр очно гэжээ.

Тэгээд хашаан дотроо гүйж Ванька Серегиний уруу гүйж байгаа дүр үзүүлэн явснаа бийшингаа тойроод Нагорный гудамж уруу салхинд хөөгдсөн мэт харайжээ.

Нагорный гудамжинд байгаа улс уруу гүйж очжээ. Гудамжаар ажилчдын цуваа явна. Жагсаалын толгойд улаан туг намирна.

Гошка ажилчдыг явж өнгөрөхийг хүлээж байгаад өмнөөс нь өврөөсөө дарцгаа гаргах гэтэл:

— Гэртээ харь! Ээж дээрээ оч! гэж ямар нэг ажилчин хашгирчээ.

Үгүй би.та нартай явж майг тэмдэглэнэ гэвэл

— За түргэл. Одоохон яв! гэжээ. Гошка буцаж явах хэрэгтэй болжээ.

Тэгээд бодлогоширч жаахан зогссоноо Литейний гудамж уруу харайжээ. Литейнийн гудамжинд улсууд дээр гүйж иржээ! Гудамжаар ажилчдын цуваа явж байжээ. Жагсаалын толгойд улаан туг намирна.

Гошка ажилчдын хойноос очиж жагсаад дарцгаа гаргах гэтэл:

— За чи яагаад энд яваа билээ? гэхэд нь

— Тийм ээ, би... гэтэл

— Чихий чинь тас мушгина шүү. Гэртээ харь! гэжээ. Гошка хоцорч бодлогошрон зогссоноо, Маршевагийн гудамж уруу харайжээ.

Цугларсан олон дээр гүйж ирлээ! Гудамжаар ажилчдын цуваа явна. Жагсаалын толгойд улаан туг намирна. Гошка ажилчид дээр очоод заль гаргаж:

— Би аав дээрээ очих гэсэн юм. Ээж намайг явуулсан юм. Би тэр урд яваа аав дээрээ очих хэрэгтэй юмсан гэжээ.

Ажилчид зай гаргаж зам тавьж өгөхөд Гошка хүү эхний эгнээ хүртэл явжээ. Тэгээд сэхээ аван харвал хажууд нь үнэхээр эцэг нь улаан туг барьчихсан явж байлаа.

Гошка аавдаа мэдэгдэхгүй сэмхэн хойшоо ухрах гэтэл амжсангүй.

— Алив наашаа хүрээд ир гээд эцэг нь дохижээ. Гошка явж очвол:

— Чамд ээж аав чинь хэлээгүй гэж үү? гэхэд ,

— Би бүгдийн адил л жагсах гэсэн юм. Би ийм юм хийсэн шүү дээ гээд өврөөсөө улаан дарцгаа гаргажээ. Эцэг инээмсэглэж хүүгээ бахархана. Бусад ажилчид ч хөхрөлджээ.

—Туг байна, хараач!

— Ёстой туг байна!

— Улаан туг шүү! гэлцлээ.

Эцэг нь өөрийнхөө том улаан тугийг харснаа Гошкагийн дарцаг уруу харж инээмсэглэснээ хүүгийнхээ толгойг илж:

— За одоо ээж дээрээ оч гэхэд

— Өө би... гэлээ.

Гошкаг үгээ хэлж дуусаагүй байтал булангийн цаанаас винтов буутай цэргүүд жагсагчдын хажуугаас гарч иржээ.

— Зогс! Зогс! гэж нэг дарга ажилчид уруу хашгирна. Жагсагчид алхаагаа удаашруулж зогслоо.

— Тарцгаа!

Ажилчид шахцалдан Гошкагийн эцэг туг хоёрыг хүрээлжээ.

— Буугаа! гэж дарга командлав. Цэргүүд буугаа бэлтгэхэд:

— Хүү минь, миний хүү гүй! гэж эцэг нь Гошкад шивнэжээ. Гошка хөдөлсөнгүй.

— Гүй гэж би хэнд хэллээ? гээд хүүгээ хүчтэй түлхэхэд Гошка явган зам дээр гартлаа үсрэв. Бяцхан хүү нүдээ эргэлдүүлэн цэрэг ажилчин хоёрыг ээлжлэн харна. Даргыг гараа өргөхөд цэргүүд винтовоо мөрлөж хурмын дараа буудахад бэлэн боллоо.

Тэгтэл:

Нөхөд минь хөл дээрээ

Нөр тэмцэлд сэтгэлээрээ хатуужъя! Эрх чөлөөний хаанчлалын замыг

Энэ биеэрээ тавьцгаая! гэж Гошкийн эцэг дуулж улаан тугаараа даллахад ажилчид яг нэг хүн шиг цэргийн урдаас алхаж очлоо.

— Галлаад! гэж дарга сөөнгөтөн хашгирлаа.

— Аав аа! Аав аа! гэж Гошка хашгирсаар жагсагчид уруу гүйж очин аавынхаа гуянаас зүүгдэн
—— аав аа! Аав аа! гэлээ.

Эцэг бөхийж хүүгээ аваад мөрөн дээрээ суулгалаа.

Жаал хүү өндөр дээрээс харвал цэргүүд буугаа буулгаж ажилчдад зам тавин өгч замын хажуу уруу гарсан байлаа.


— Галлаад! Галлаад! гэж дарга сөөнгөтөнө.

Гэвч даргын тушаалыг сонсох нэг ч хүн байсангүй.

Гошка хүү инээмсэглэж улаан дарцгаараа цэргүүд уруу даллана. Ажилчид Маршевагийн гудамжаар өнгөрөн Нагорный, Литейний гудамжаар явж байсан хүмүүстэйгээ нийлж, хотын бусад гудамж, талбайгаар явж байсан хүмүүстэй нийлэн нийлж нэг их далай болжээ. Тэдний дээр нэг ч биш, хоёр ч биш хэдэн арван улаан туг хаврын тэнгэрт дүрэлзэн намирна. Хотын дээгүүр:

Хэдэн зуун жилийн дарлалыг Хүчит гараараа үүрд унагаж Хөдөлмөрийн улаан тугаа Хорвоо ертөнц дээр мандуулья! гэх дуу тасралтгүй цууриатна.

Хаанаа түлхэн унагаасан нь



Оросын бүгд найрамдах улсын иргэн

Данилка Питер хотын Литейнийн гудамжны өндөр байшингийн хонгилд суудаг байжээ. Данилка тэнд төрж өссөн болохоор бүх суугчдыг толгой дараалан таньдаг байлаа.

Байшингийн нэгдүгээр давхрыг Щербацкая гүнжтэн эзэлж, хоёрдугаар давхрыг тайж Пирогов —Пищевых, гуравдугаар давхарыг нууц зөвлөх Горохов эзлэн сууж, хамгийн дээд давхарт тавдугаар зэргийн зөвлөх Ардагов суудаг байлаа. Тэр байшинд оршин суугчид цөм нэр төртэй, чухал цол хэргэмтэй улс байлаа.

Хувьсгал гарсан цагаас хойших хугацаанд олон янзын юм болж Данилка гайхаж цөхөрчээ. Тэгтэл тэр нэг өдөр...

Данилкагийн эцэг сонин авчирч дэлгээд хүү уруугаа харж:

— За, чи одооноос эхлээд Оросын Бүгд Найрамдах Улсын иргэн болжээ. Владимир Ильич Ленин өөрөө хулинд гарын үсэг зуржээ гэж хэлсэн ажээ.

Данилка яагаад ч юм бэ итгэсэнгүй, бас тэгээд Оросын Бүгд Найрамдах

Улсын иргэн гэгч юу болох нь огт тодорхойгүй байлаа.

— Энэ чинь тавдугаар зэргийн зөвлөхөөс дээгүүр хэрэг үү? гэвэл

— Дээгүүр гээд эцгээ инээмсэглэхэд

— Нууц зөвлөхөөс дээгүүр үү гэвэл

— Нууц зөвлөхөөс ч дээгүүр гэхэд нь

— Тэгээд гүнгээс илүү юү?

— Илүү гэхэд нь

— Ноёноос дээр үү?

— Дээр, дээр гээд эцэг нь хөхөрчээ. Данилка гудамж уруу гүйн гарч найз нөхөд Уруугаа харайлгалаа.

Ванюшка Дозоровтой тааралдаж:

— Би тавдугаар зэргийн зөвлөх, нууц зөвлөх, гүн, ноёнтноос илүү өндөр хэргэмтэй болсон! Би Оросын Бүгд Найрамдах Улсын иргэн болсон! Энэ тухай сонинд бичсэн байна. Владимир Ульянов—Ленин өөрөө хуулинд гарын үсэг зурсан байна! гэжээ

Данилка цааш гүйтэл Люба Козулинатай тааралдаж:

— Би маш өндөр, дээгүүр хэргэм цолтой... гэжээ.

Тэр өдөр Данилка олон хүнтэй уулзаж цөмд нь тэр нэг зүйлээ давтсаар л байлаа. Тэгээд ядарч байшингийнхаа хажууд суугаад, тэр Ульянов—Ленин Данилка намайг хаанаас яаж мэдэв гэж бодлогоширлоо. Ленинд үүнийг хэн хэлсэн байдаг билээ? Ийнхүү бодлогошрон сууж байтал хонгор Кирюх өөр дээр нь харайн ирж явахыг харжээ. Кирюх хар хурдаараа гүйж ирээд амьсгаа авснаа:

— Намайг хэн болохыг чи мэдэх үү?! Би бол Оросын Бүгд Найрамдах

Улсын иргэн гэлээ.

Данилка санаандгүй юм дуулаад исгэрэв.

— Чи ямар иргэн юм уу гэж дооглонгуй хэлээд,

— харин би л иргэн. Миний тухай л сонинд бичсэн байгаа юм гэвэл

— Чиний тухай гээд Кирюх исгэрснээ, чиний төлөө цаас сүйтгэсэн хэрэг үү гэжээ.

Данилка гомдохдоо өөрийн эрхгүй нударга зангидаж Кирюхад ойртон очиж, аяыг олж хамрын тус газар нульж орхилоо! Ингээд зодоон эхэлжээ.

— Би л иргэн... гэж Данилка Кирюхад хашгиран хэлэхийг хичээнэ.

— Үгүй, би иргэн... гэж хонгор Кирюх гудамж дүүрэн орилно. Яг энэ үеэр гудамжаар ажилчин залуу явж байгаад хүүхдүүдийг салгажээ. Тэд хэргийн учрыг ярилгүй удаан дуугүй байснаа ярихад залуу инээмсэглэж халаас уруугаа гараа шургуулж сонин гаргаж иржээ. Хүүхдүүд үе үеэр нь уншиж үзвэл:

— «Язгуур угсаа, иргэдийн хэргэмийг устгах тухай хууль» гэсэн гарчиг байлаа.

Тэгээд цааш нь аливаа чухал цол хэргэм, язгуур угсааг өнөөдрөөс хойш үүрд устгалаа.

Цаашид тайж язгууртан, худалдаачин, нууц зөвлөх, дугаар зэрэг, ван гүн аль нь ч байхгүй болно. Оросын бүх хүн амын дунд ерөнхий нэг Оросын Бүгд Найрамдах улсын иргэн гэсэн нэр тогтоож байна гэж уул хуулинд заасан байлаа.

— Тэгээд дор нь:

— Ардын Комиссаруудын зөвлөлийн дарга

Вл. Ульянов (Ленин) гэж гарын үсэг зурсан байжээ.

Ингэхээр та хоёр хоёулаа зөв болж таарах нь шив дээ гэж залуу хэлээд, — чи ч би ч бид бүгдээрээ Оросын Бүгд Найрамдах улсын иргэн гээд Данилка, Кирюх хоёр луу гараараа зааснаа,

— Жирийн бүх хүмүүсийн тулд Владимир Ильич Ленин энэ хуулийг бичжээ гэв.

Уул хууль ганц өөрт нь биш бүх иргэдэд бичсэн явдал эхлээд Данилкад гомдолтой мэт байсан боловч төдөлгүй цөмийнх байх нь дээр гэдгийг ойлгожээ. Владимир Ульянов—Ленин Данилкагийн эцэг, эх, анд найз нөхөд цөмийг санаж хэнийг ч мартаагүй байсан юмсанжээ.

Тиймээс ч гүнжтэн Шербацкая, ноён Пирогова

— Пищаев, нууц зөвлөх Горохов, тавдугаар зэргийн зөвлөх Ардатов нарт Лениний уул хууль таалагдаагүй учир тэд гадаадад дүрвэн гарчээ. Энэ ч бүр сайн хэрэг.

Литейний гудамжин дахь өндөр байшинд Данилкагийн эцэг эх шиг жирийн ажилчин шинэ хүмүүс орсон ажээ. Тэд зөвхөн иргэд болоод зогсоогүй улс орныхоо эзэн нь болсон бөлгөө.



Учир мэддэг хүн

Еремка Выков унтаж чадахгүй эргэж хөрвөнө. Тэгээд ч пийшин дээр давчуу бөгчим ажээ.

Эцэг нь унтахгүй ажээ. Өглөө болмогц ноёдын газрыг хуваарилах гэж байгаа болохоор унтахын ч арга алгаа. Ийм явдал өдөр бүр тохиолддоггүй шүү дээ.

— Та унтаач гэж ханзан дээрээс ээж нь уцаарлалаа. Эцэг Еремка хоёр чимээгүй боллоо.

Гучин минут өнгөрөхөд, тэвчээд тэвчээд нойр хүрэхгүй болохоор эцэг нь пийшингийнхээ дээр суниаж:

Гарч чөлөөтэй жаахан , явья гэхэд

— Би тантай явья гэж Еремка гуйлаа.

— Тэг, тэг хувцасла гэв.

— Яасан уймраа сэтгэлтэй юм бэ дээ гэж эх нь дахиад л бувгнав.

Өөрөө яагаад ч юм бэ унтахгүй байгаа мөртлөө уцаарлаад байна. Бас л газрын тухай бодож байгаа бололтой.

Еремка эцэгтэйгээ гудамжинд гарч, тосгоны дагуу явж захад нь гараад жижигхэн гүүр дээгүүр өнгөрч толгой өөд өгслөө. Тэнд ноёдын тариан талбай байдаг байжээ.

Шөнийн сэрүү татаж, салхи сэнгэнэн үлээж наадна. Одод анивчина. Хавирган сар үүлийг сэмлэн дэгээдэж, хаа нэг газар талын оготоно дуугарч, тосгонд нохдын хуцах сонсдоно.

Еремкагийн эцэг тариан талбайг хараад нүдий нь нулимс бүрхлээ.

— Аав аа, та яагаад уйлж байгаа юм бэ? гээд Еремка эцгийнхээ гараас угзрахад

— Зүгээр, зүгээр гэж эцэг хэлээд алгаараа нүдээ арчиж,

— цөмөөрөө түүний тухай, тэр сайн хүний тухай бодож байна гэхэд нь

— Хуулинд гарын үсэг зурсан Ульянов—Лениний тухай юу? Сайн хүн бололтой гэвэл

— Еремка, чи үгээ олсонгүй. Тэр хүн учрыг мэддэг хүн шүү. Тариачид газаргүй бол амьдарч чадахгүй. Тариачин эрсийнхээ талархлыг Лениндээ дэвшүүлье гэлээ.

Тэд тариан талбайг харж цэвэр агаараар амьсгалан зогсоод гэр өөдөө буцлаа.

Еремка дахиад л пийшин дээрээ гарлаа. «Ээ дээ унтчихгүй л юмсан. Газар хуваахад унтаад хоцорчих бий дээ. Хамгийн сонирхолтойгоос нь л хоцорчихгүй юмсан» гэж бодно.

Тэр толгой тавимагц унтлаа.

Тэгээд Еремка гайхалтай зүүд зүүдэлжээ. Ленин өөрөө ноёдын газрыг хувааж өгөхөөр ирээд тариан талбай дундуур явж гартаа газар хэмжих хэмжүүр барьж алхаж яваад Еремкаг харж:

— Миний туслагч болох уу? Хэнээс эхлэх вэ, хэнийх хэдэн ам бүлтэй вэ, хэнийд хир зэрэг газар өгөх вэ? Хэлээч гэжээ.

— Хэнээс эхлэх вэ гэнээ? Еремкагаас л эхлэхгүй яах вэ.

— Надаас эхэл гэж Еремка хэлбэл

— Үгүй ээ, чи газар хувааж байгаа учир хамгийн сүүлд авна гэж Ленин хариулжээ.

Тэд ноёдын газрыг хуваахдаа хэнийг ч гомдоосонгүй. Тэгээд Еремкагийн ээлж болжээ.

Ингээд жаал хүү сэрж харвал нар дээр хөөрчихсөн эцэг эх хоёр нь гэртээ алга байжээ.

Аа би зүүдэлсэн байна шүү. Унтаж орхижээ. Талбай уруу л түргэн очъё. За байз зүүдэлсэн зүүдээ яах вэ, Еремка өөртөө хуваасан газраа яах билээ? Хамгийн чухал газраа хүрээд сэрчих юм гэж Еремка харамслаа.

Еремка дахиад л нүдээ анилаа. Ямар газар хуваасан болоо, сонин оо? Тэр голын хажуугийн толгой дээрх хуучин хусны дэргэдэх газар л байгаасай. Еремка буурцаг тарьж зун нөхдөө дайлна даа.

Тэгээд нүдээ аньтал хаалга чахран дуугарч эцэг эх хоёр нь орж ирлээ:

— Еремка, сэр, бос! гэлээ.

Еремка ноёдын газрыг хуваарилахад унтаж орхисон, бас зүүдээ дуустал зүүдлээгүйдээ гомдож байлаа. Дэмий л боссон боловч баяр баясгалангүй байлаа.

— Еремка чи юу болоо вэ?!

Жаал хүү юу ч хариулсангүй, хувцаслаад гудамжинд гарчээ. Хүүхдүүд түүнийг хүрээлж аваад дүрсгүйтэж инээлдэнэ.

— Унтаа, унтаа!...

— Унтчихжээ.

— Гол юмы нь харсангүй!

Еремкад бүр ч ичгүүртэй ажээ Тэгээд, хүүхдүүдийг харж байгаад гэнэт:

— Харин би Ленинийг, Ленинийг харсан. Манай, энд Лениний ирэхийг харсан гэлээ.

Хүүхдүүд мэл гайхлаа.

— Ирсэн, ирсэн гэж Еремка итгүүлээд, газрын хэмжүүр бариад надаар туслагчаа хийгээд явж байсан гэвэл

— Чи тэгж зүүдэлсэн байх.

— Үгүй, зүүдлээгүй, зүүдлээгүй, яг тэгсэн юм гэлээ.

Энэ үеэр хүүхдүүд дээр өвгөн Прозоров хүрч ирэхэд Еремка түүнд хандаж:

— Би Ленинийг харсан. Ленин газар хувааж өгч байсан гэлээ. Хүүхдүүд дахиад л инээлдэв. Өвөө Еремкагийн хичнээн дэмий донгосдог болохыг хараарай гэсэн байртай байлаа.

Тэгтэл өвгөн жаахан бодлогошрон зогсож байгаад, хашгиралдаж байсан хүүхдүүд уруу ширүүн харснаа гэнэт Еремкаг дэмжиж:

— Нээрээ, Ленин ирсэн байсан шүү дээ. Газар хуваахад байсан, Еремка эндүүрээгүй байна гэхэд хүүхдүүд гайхаж:

— Тэгээд бид яагаад үзээгүй байдаг билээ

— Муу л харж дээ. Ойлгосонгүй

— Тэгээд л хараагүй байхгүй юу гэж өвгөн хэлсэн ажээ.

Шкурин хапурин хоёр

Шкурин Хапурин гэдэг хоёр хүн тус бүр заводтай байсан юмсанжээ. Шкурин нь хадаасны, Хапурин нь савангийн заводтай ажээ.

Тэр хоёр анд найз, бас тэгээд хоёулаа баян, хоёулаа ховдог шунахай, хоёулаа бусдын хогшилд атаархдаг байжээ. За тэгээд Хапурингийн савангаас олсон орлого өөрийн нь хадаасны орлогоос илүү юм шиг Шкуринд бодогддог бол Хапуринд эсрэгээр бодогддог байжээ.

— Ээ дээ над Шкуриний хадаас байдаг ч болоосой гэж Хапурин санаа алддаг бол

— Ээ дээ над Хапуриний саван байдаг бол доо гэж Шкурин боддог байлаа.

Тэр хоёр уулзахдаа ийнхүү яриа үүсгэнэ.

— Сил Силыч чиний савангийн мөнгө ч ёстой л алтан бороо шиг урсаж байх шив дээ гэж Шкуринг хэлэхэд

— Битгий ингэж ярь даа гэж Хапурин хариулаад.

— Тит Титыч чиний л хадаасны орлого тулам дүүрч байна гэдэг байлаа. Тэдний атаархал бие биенийхээ хорыг малтаж заводаа солилцох яриа болдог авч үнэн хэрэг дээрээ айдаг байлаа.

— Тэгээд алдаж орхивол яах билээ.

Тэд ийнхүү шийдэж чадахгүй бодлогоширч байтал 1917 он болж газар, фабрик, завод, хөдөлмөрчин ардын гарт шилжиж эхэлжээ.

Шкурин, Хапурин хоёр сандран гүйлдэж жаал амьсгааджээ.

Чингээд удахгүй бидний ээлж болно гэдгийг мэдэрч байлаа. Гэвч чухам эхлээд ямар заводыг улсын болгохыг мэдэхгүй байлаа. Хапурин бодохдоо өрийнхөө савангийн заводыг эхлээд улсын болгоно гэдэг бол Шкурин хадаасныхаа заводыг түрүүнд улсын болно гэж боддог ажээ.

Тэд тааж зовж суух завсар дахиад л заводаа солих санаа төржээ. Бас л аймшигтай бөгөөд жигтэй ажээ.

— Ээ дээ Хапурин намайг залилчихана, залилчихана!

— Шкурин намайг мэхлээд хоосруулчихана! гэж бодоцгооно. Нилээд хугацаа өнгөрсний дараа хошууны Ажилчин Тариачны Депутатын Зөвлөлөөс

Шкуринд бичиг иржээ. Шкурин дугтуй задалж бичгийг уншаад нүд нь харанхуйллаа. Хадаасны заводыг улсын болгоно гэж яах ч аргагүй цагаан цаасан дээр хар бэхээр бичсэн байлаа.

— Эх болсон бурхан тэнгэр минь ариун сахиус минь! Яагаад тэр билээ? Ямар нүгэл хийлээ гэж миний заводыг улсын болгодог билээ. Яагаад Хапуриныхыг улсын болгодоггүй юм бэ? гэж Шкурин чарлалаа.

Тэр бурхны өмнө наманчлан залбирахдаа: «Хэрвээ Хапурин уруу одоохон гүйж очоод, юу ч мэдээгүй байхад нь заводаа сольчихъя гэж ятгавал яадаг болоо» гэж боджээ.

Харин Хапурин тэр өдөр яг тийм бйчиг авсан юмсанжээ. Бурхан тэнгэрийн өмнө залбиран наманчилж: «одоо түргэн Шкурин руу очвол яадаг бол....» гэж боджээ.

Тэд газар хүртэл нахилзан наманчилж байснаа больж бие бие уруугаа харайлгалаа. Тэгээд замын дунд уулзаж, сандарч явсандаа нэг нэгнийгээ золтой л дайрчихсангүй, хүндээр амьсгаадан зогсоцгоолоо.

— Эрхэм Сил Силыч минь би чам дээр очихоор явж байна гэж Шкурин арай ядан хэлэхэд

— Би ч гэсэн танайд очих гэж явна, хүндэт Тит Титыч! гэж Хапурин дуугарлаа.

— Алив заводаа сольчихъя.

— Тэгье.

Ийнхүү хоёр найз заводаа сольсондоо сэтгэл хангалуун байлаа.

Би ч түүнийг мөн дөнгөв өө, хи хи гэж Шкурин бодож байлаа. Хи хи, хонгор минь мөн чадагдав аа гэж Хапурин даажигнана.

Тэд хот дотуур маш ихэмсгээр толгойгоо дээгүүр хаялан явсаар заводынхаа байранд очвол тэнд хууль ёсны шинэ эзэд

— ажилчин анги байж байжээ.

— Сайн байна уу, Шкурин! Сайн байна уу, Хапурин! Өө хүрээд ирэв үү, буцдаа. Танай засаг дууссан! Гэлээ

Шинэ сургууль

Октябрийн аугаа их хувьсгалаас өмнө хотын сургуулийг Гимназ гэж нэрлэдэг байлаа. Хүүхдүүд гимназад явдаг байлаа. Кириллийн эцэг газрын эзэн, Павелынх хааны чухал түшмэл, Наталиягийнх генерал, Розалиягийнх фабрикийн эзэн, тэнэг Модестийн эцэг цагдаа байдаг байжээ.

Харин тэгвэл Сорокин Петягийн амьдрал нь хэцүү ажээ. Хүүгийн эх юм угаагч билээ. Сурах явдал өндөр үнэтэй учир Петя гимназад явдаггүй, гимназад явах мөнгө хаанаас олох билээ. Эх нь үүрийн гэгээнээс үдшийн бүрий хүртэл тэвшний дэргэд нуруу өндийхгүй гараа халцарч улайтал үрж юм угаана. Тэр эх Наталия, Розалия, Кирилл, Павел, Модест зэрэг бүх баядын юмыг нуруугаа бөгтөр болтол угаана. Хүү эхдээ тусалж ус авчирч, бохир усы нь асгаж, мод хагалж өгсөөр байгаад Петягийн гарт эвэр ургажээ. Тэгээд жаал хүү эздийн захиалан угаалгасан зүйлсийг хүргэн өгч фабрикийн эзний уруу, генералын уруу, чухал түшмэлийн уруу, харгис цагдаагийн уруу, газрын эзний уруу зөөж гүйнэ. Баядын хүүхдүүд Петяг нүд үзүүрлэнэ.

— Хи хи гэж Наталия, Петяг хармагц шоолон хөхрөхөд

— Хи хи гэж Наталияг дэмжин Розалия хөхөрнө.

— Хо хо хэмээн Кирилл, Павел хоёр хошуу дүрж шоолно

— Хараач, хараач, угаагч ирж явна! гэж тэнэг Модест бусдын анхаарлыг татна. Петя нэг өдөр тэсэж чадсангүй Модестийг балбаж орхисон нь өөрт нь л муу юм болж дуусчээ. Модест эцэгтээ хэлж цагдаагийнх Петягийн ээжид ажил өгөхөө байжээ. Петя хүү эрдэм сурахыг ихэд хүснэ. Гэвч юм угаагчийн хүү хаана сурах билээ дээ. Ийнхүү Петя бусад олон хүүхдийн адил бичиг мэдэхгүй хоцорчээ. Тэгтэл хувьсгал гарлаа. Заводын эзэд, газрын эздийг хөөж, баячуудын засаг үгүй боллоо. За тэгээд Наталия, Розалия, Кирилл, Павел бүр харагдахаа больж тэнэг Модест ч хаана байгаа нь хэнд ч мэдэгдэхгүй сураггүй алга болжээ. Бүх юм өөрчлөгдөж, дахиад гимназ ч байхгүй болж, гимназын оронд одоогийн сургууль байгуулагджээ. Шинэ хүүхдүүд хичээлдээ явна. Вася Лотановын аав ажилчин, Толягийнх зөвлөлтийн албаа хаагч, Олягийнх мужаан, Полягийн аав ачигч, Гришагийн аав уурын пийшингийн галч ажээ. Бидний танил Сорокин Петя бусад нөхдийнхөө хамт өнөөдөр сургууль уруу явж байна. Үнэ төлбөргүй сургадаг зөвлөлтийн шинэ сургууль уруу хүүхэд бүлэг бүлгээрээ явна.

Артель

Орос орны хамгийн алсын зах хязгаар бол Агнуурын тэнгисийн эрэг билээ. Тэр эргээс цааш Номхон далай буюу Их тэнгис бургилж байдаг билээ. Тэнгисийн эргээр загасчдын суурин ярайна. Тэндээс баруун зүүн тийш зуу зуун бээр давхихад дахиад тосгон тааралддаггүй нь энд хүн цөөнийг гэрчилнэ.

Тосгонд загасчны гучин гэр бүлийн гучин дүнзэн байшин бий. Зогсоолын дэргэд дөрвөн том завь байх бөгөөд загасчид тэнгист алс явж тороор загас барина.

Агнуурын тэнгис ч харамч биш болохоор том завь загасчлаад буцахдаа хүнд ачаандаа болоод арай л живчихдэггүй ирдэг ажээ.

Загасчид загасаа тэнгисийн эрэг дээр давсалж торхолно.

Өгүүлэх нь: тосгонд артель байдаг ажээ. Гэвч торх, том завь, бүх барьсан загас цөм эзний хөрөнгө байлаа. Эзэн загасчдад улаан мөнгө төлөөд өөрөө өдий төдий мөнгө шулдаг байжээ. Үйлдвэрийн эзэн худалдаачин Федор Проворов, нутгийн лам Мефодий хоёр л эзэн нь байлаа. Тэд бүх орлогоо хуваадаг ажээ. Нэг хэсэг нь загас барьдаг, нөгөө хэсэг нь орлогыг нь хуваадаг ийм л артель байжээ. Ийм ёс дэглэм бүх Орос орон даяар байлаа. Үнэндээ гэхэд Федор Проворов хоосон хоцордоггүй байлаа. Тэр хэдийгээр ажилчдын хөдөлмөрийн хөлсөнд улаан мөнгө төлдөг боловч тэр дороо эргүүлэн авдаг ажээ. Тосгонд дэлгүүр нээж өгсөн мөнгөө эрүүлэн авна.

Ариун санваартан эцэг багш Мефодий ч муугүй ажээ. Тэр бурхны нэр барьж их зүйл хийнэ. Загалмайллаа гэж авна, буян үйлдлээ гэж авна, сүм хийдийн засварт гэж авна, шинэ бурхан бүтээлгэнэ гэж авна.

Тосгоныхон ингэж л амьдарч байлаа. Проворов худалдаа наймаа хийж, Мефодий сангийн бойпороо даллаж, загасчид ширүүн догшин тэнгист амь өрсөн явж орлого нь баячуудад, ажилчид улаан зоос хүртдэг байлаа. Энэ маань мөн л артель билээ.

Гэвч алс тэртээх Агнуурын тэнгист Зөвлөлт засаг тогтлоо. Феодор Проворов нутгийн багш лам Мефодий нар торх, том завь, орлогоосоо хагацжээ. Тосгонд жинхэнэ артель зөвлөлтийн артель бий болж, агнуурын тэнгист загасчлагчид орлогоо хуваадаг болсон билээ.

Чийчаан

Колька «улсын болгох», «хөрөнгө хураах», «Оросын Бүгд Найрамдах Улсын өмч» гэх мэт шинэ үгс сонсжээ. Тэгээд найз нөхдөө цуглуулж шинэ амьдралын тухай ярилцаж гарлаа.

— Хөрөнгө хураана гэдэг бол газрын эзэд, буржуйлгүүдийн бүх баялгийг булаан авахыг хэлж байгаа юм. Улсын болгох гэдэг бол тэр баялгаа хөдөлмөрчин ардын гарт шилжүүлэн өгч байгаа хэрэг. Тэр баячууд чинь ёстой л нударганчууд байгаа юм. Тэднээс хүчээр авахгүй бол болохгүй гэж Колька тодруулан хэллээ.

Хүүхдүүд ч гэсэн нийтийн хэргээс хоцрохыг хүсээгүй ажээ. Тэгээд тэд ч улсын болгож, хөрөнгө хураах тухай боджээ. Тэдний нэг нь генералын хүү Ардалеон Кукуевийн хөл бөмбөгийг, нөгөө нь худалдаачин Бондалетовын мухлагийн чихэр, ёотонг, гурав дахь нь Чичерина гүнжтэний ярьдаг тотийг булаан авах санал гаргалаа.

Тоть оо! гэж Колька дооглонгуй асуугаад, хөдөлмөрчин ардад тоть ямар хэрэгтэй юм бэ. Фабрикийн эзэн Зайкиныг мэдэх үү? гэлээ. Мэднээ.

— «Роллс — ройс» чийчааны нь харсан уу?

— Харсан

Чийчааны нь хурааж авна даа. Санаандгүй байсан хүүхдүүд таг чиг боллоо.

— Жолоодож сураад бүгдий нь үнэгүй хотоор зугаалуулна гэж Колька үргэлжлүүлэн хэллээ. Колькагийн зөв. Үүнээс илүү сайхан юм яаж бодох билээ.

Маргааш нь хүүхдүүд Зайкины байшингийн орчим отож. эзэн нь «роллс—ройс»—оороо ирж орхин явахыг хүлээлээ. Тэгээд эзнийг явмагц тэд чийчаан дээр тал талаас нь шавж Колька кабинд орж тоормосны бариулыг тавилаа. Хүүхдүүд чийчаан дээр шавж машин ч өнхөрч гарлаа.

— Түргэл, түргэл! гэж Колька машиныхаа кабинаас хашгирна.

Хүүхдүүд «роллс—ройс»—ыг түлхэж өнхрүүлэн, цааш явах тусам улам хурдан боллоо. Машин ч хурдаа авлаа. Колька сэтгэл хангалуун ихэмсэг сууж машины жолоог гараараа зуурчээ. Налуу гудамж уруудтал, дугуй улам улам хурдан эргэж, хүүхдүүд арай чамай араас нь авирч гарлаа.

— Барьж бай, барьж бай! гэж Колька хашгирна. Гэвч тогтоож яахин чадах билээ. Машин хурдалж хүүхдүүд хоцорлоо. Колька тоормозны бариулыг татахыг хүссэн авч айж тэвдэхдээ бариулаа хаанаа байдгийг ухаарч чадсангүй. Уул машин гудамжны баруун талаас зүүн тийшээ хөндлөн гарч явган хүний зам дээгүүр очиж мод мөргөлөө! Колька кабинаас суга усэрч, чулуу мөргөн уналаа. Гудамжаар дүүрэн шуугиан гарахад хүүхдүүд уул хэрэг муугаар дуусаж болохыг ойлгож тал тал тийшээ тарж зугтлаа. Колька ч өндийж босон харайж нүд ирмэхийн зуур машинаас холдон зайллаа.

Цамц нь урагдаж нүднийхээ дор хөх няц болж нүүр нь хавдаж Колька гэртээ буцаж иржээ.

— Ээ бурхан минь! Дахиад л Гриша Марафетовтой зодолдсоноос зайлаагүй гэж эх нь гараараа зүхэн заналаа.

— Дахиад л дүрсгүйтээ юу? гэж эцэг нь уурлалаа. Колька дуугарсангүй.

— За би чамайг дуугарахгүй байхы чинь харуулаад өгье! Эцэг суран бүсээ авч дундуур нь нугалахад Колька хайрлахгүй нь гэдгийг ойлгож үнэнээ хүлээхээр шийдлээ.

— Чийчаан гэвэл

— Ямар чийчаан?

— Заикины чийчаан гэвэл

— Заикины ямар чийчаан? гэхэд нь Колька хөрөнгө хураалтын тухай ярилаа. Колькагийн эцэг суран бүсээ буулгаж инээмсэглэв.

— Энэ ер нь газар сайгүй юм болгонд хошуу дүрж байх хэрэгтэй юм уу гэж эх нь бувтнаад, Митрофан Афанасьевич, цаадахаа нэг ураад өгөөч гэхэд

— Урах нь ч урна. Би нэг үзүүлээд өгье гэж эцэг хэллээ. Гэвч эхийн ярьсан ярианы өнгө, эцгийн хариулсан хариултаас үзвэл өнөөдөр зодохгүй нь гэдгийг Колька мэдлээ.

Үнэндээ ч яалаа гэж зодох билээ? Колька өөрийнхөө төлөө биш нийт хөдөлмөрчин ардын төлөө хичээсэн байна шүү дээ.

Галт онгоц "Миссисипи"

Хүүхдүүд ижил мөрний эрэг дээр очиж «Миссисипи» хөлөг онгоцны сэлэхийг харах дуртай байлаа. Галт онгоцны хоёр дугуй, хос яндан, үхсэн хүнийг авснаас босгохоор яндандах чимээ нь сонирхолтой учир тийм хөлөг онгоцон дээр зугаалахыг хүсдэг байлаа.

Гэвч муусайн хүүхэд «Миссисипи» дээр суух хувь тавилангүй байлаа. Галт онгоцны давцан ноёд, янз бүрийн ихэмсэг нөхдөөр л дүүрэн байдаг байлаа. Хөлөг онгоцны эзэн урт сахалтай, ханхгар чээжтэй, бадриун худалдаачин Миридатов өөрөө зорчигчдыг угтан уулзана.

— Морилж хайрла, тусгай өрөө, зоогийн газар, халуун ус, зуушны газар энэ бүгд таны тавгай зорчиход үйлчилнэ гэж хүн болгонд тайлбарлана. Галт тэрэгний галчийн хүү Димка Пухов нэг удаа галт тэргэн дээр явснаа хожим ярьсан билээ.

— Ёстой л машин даа! гэж

Димка гараа өргөөд, нүүрсий чинь мөн ууна даа! гээд өлмий дээрээ өндийж, давцан нь тэгш сайхан, шат нь цул хивс болсон сайхан орд, «Миссисипи» гэдэг чинь Америк тивд байдаг гол гэж ярьсан билээ.

Галт онгоц арван долоо, найман оны өвөл зогсоол дээрээ зогсоож өнгөрүүлжээ. Харин хавар нь гол мөрний тээврийг улсын болгоход Миридатов

«Миссисипи» онгоцноосоо хагацсан ажээ.

Миридатов цэглэжээ гэж Димка найз нартаа тайлбарлаад, ингээд л тэр одоогийн эзэн нь гэртээ харьж, хөдөлмөрчин ард бүхний эзэн болж, Сайхнаа! гэлээ. Тэгээд хүүхдүүд галт тэрэгний галч эцгээ биднийг хөлөг онгоцоор зугаалуул гэж гуйгаач хэмээн Димкаг шалж гарлаа.

— Үгүй мөн хүсэв ээ гээд Димка мушилзсан боловч, өөрөө зугаалах санаа өөрийн эрхгүй төрлөө.

— Бүтлээ гэж тэр хэдэн өдрийн дараа хэлжээ.

Тэр жил усны түвшин их, Ижил мөрөн эргээ хальж ольтрогхоныг ус авч татуургыг холбож алс тэртээх нарсан ой уруу оджээ. Ийм үед ижил мөрөн эрх дураараа байдаг. Хэзээ галт онгоцоор явахыг хүүхдүүд хүлээж ядна.

— Удахгүй гэж Димка тайвшруулна. Маргааш нь:

— Бүр удахгүй гэнэ. Бас нэг өдөр өнгөрөхөд

— Маргааш зугаална! гэлээ.

Тэгтэл шөнө нь Ижил мөрөн дээр аймшигтай дэлбэрэлт боллоо. Хүүхдүүд үүр цайхтай зэрэг эгц эрэг дээр гүйлдэн очиж доош харвал «Миссисипи» алга болчихсон байжээ. Митридатов галт онгоцоо хөдөлмөрчин ардад өгөхгүй гэж “Миссисипиа” дэлбэлж живүүлсэн юмсанжээ.

— Ээ харла, ингэж зугаалга өнгөрдөг байжээ.

Галт онгоцыг голын ёроолоос гаргаж засаж будаж янзалсаар байтал зун өнгөрчээ. Намар нь хүүхдүүд дахиад л зугаалгын тухай яриа үүсгэжээ. Димка ахиад л эцэгтэйгээ ярьж:

— Бүтлээ гэжээ. Хүүхдүүд Димкагийн очиж:

— Удахгүй юу? гэхэд

— Удахгүй.

— Бүр удахгүй.

— Маргааш явна гэжээ.

Хүүхдүүд өглөө эрт Ижил мөрний эгц эрэг рүү гүйлдэн очиж доош харвал

«Миссисипи» байхгүй байжээ.

— Юу болоо вэ? Галт тэрэг хаана байна вэ?

Энэ үе бол цаг түгшүүртэй үе байлаа. Газар, Фабрик заводаа алдсан баячууд эвлэрэхгүй, цагаантны арми зохион байгуулж, залуу Зөвлөлт Бүтд Найрамдах Улсын эсрэг дайн дэгдээсэн байлаа.

Тэгээд «Миссисипи» дайнд явсан ажээ. Түүн дээр их буу, үхэр буу зоож улаан цэрэг сууж цагаантныг бут цохихоор явсан юмсанжээ.

Хүүхдүүд ижил мөрний эгц эрэг дээр бөөгнөрөлдөж:

— Зүйтэй. — Бид хүлээж л байя.

— Бид яарах юу байх вэ. Улаан цэрэг явж цагаантныг бут цохиж л байг.

— Манай «Миссисипи» эргэж ирнэ, ирнэ гэлцэж байлаа.

Муухай үг

— Чи эзэн хаанаа юунд нь дурссан юм бэ! гэж Марья авгай: Ипат өвөө рүү хашгирч, — Тэр хаан чинь чиний төрсөн эцэг юм уу? Чи яагаад түүнийг мартаж болдоггүй юм бэ? гэхэд

— Эцэг биш нь ч биш ээ, гэлээ ч гэсэн хаантай үед дээр байсан юм гэж

Ипат өвөө мэтгэлээ.

— Дээр байсан гэнэ шүү гэж Марья авгай дооглоод,

— Чамайг зоогийн газар сахлаас чинь чангааж байсан нь л дээр байсан байхдаа. Жинхэнэ эр хүн шиг дуулж байсан болдоо.. гэжээ.

Выселка гэдэг тосгоныг шатсанаас хойш Марья авгай Ленкагийнхаа хамт Москвад суудаг Ипат өвөөгийн ирээд сар гаруй болсон юмсанжээ. Тэд Москвагийн зах хязгаарын нэг Марьиный шугуй гэгчид бөхийж яажийсан хуучин байшингийн хонгилын чийг үнэртсэн бяцхан байшинд суудаг байжээ.

Тэр сар ёстой гайхалтай сайхан сар байлаа. Сахал нь тал тал тийшээ ишигний эвэр шиг сэрвийсэн сахалтай, ханхар том биетэй Ипат өвөө тэднийг хэрхэн угтсаныг Ленка санаж байлаа. Тэр эхлээд Марья авгайг үнсэж, дараа нь Ленка уруу харж:

— Ленка энэ үү. Аа ийм хүн байсан юм бий. Намхан л юм даа, гайгүй эр хүн өснө гэсэн билээ.

Ипат өвгөн Тверийн гудамжин дахь зоогийн газрын үүдний жижүүрээр ажиллаж байхдаа сав угаагчийн туслагчаар Ленкаг оруулья гэж бодож байтал Октябрийн хувьсгал гарч бүтээгүй ажээ. Зоогийн газар хаагдаж эзэн нь зугтаж яваад, Ипат өвөө өөрөө ажилгүй хоцорчээ.

— Одоогийн энэ дэг журмыг хардаа. Сайхан үе байжээ. Одоо л цаг үе өөрчлөгджээ гэдэг байлаа. Нэг өдөр Ипат өвгөн Ленкаг дагуулан халуун усанд орохоор явжээ. Москвагийн халуун уснаас савангийн үнэр ханхалж, хананд нь толь шил гялалзаж, нүцгэн хөлийн дор гоёмсог хээтэй гудсан хивс бамбалзана.

— Сайхан байгаа биз. Чи анх удаа л ийм юм үзэж байгаа байхдаа гэж

Ипат өвөө ярина.

Ленка ч сонирхон харна. Ипат өвгөн яаралгүй ихэмсгээр хувцсаа тайлна.

Цамцаа тайлж эвхээд сахлаа илснээ, дотуур өмдтэйгөө удаан сууж тэнд байгаа хүмсийг цөмий нь харлаа. Тэр өдөр халуун усанд хүн ч олон байлаа.

Ипат өвгөн ханатлаа савандаж усанд булхаж, урт сахлаа угааж хүзүүгээ ширүүн үрж угаалаа.

Дараа нь Ленъкаг уурын хэсэг уруу дагуулан орж халуун уураар утахад амьсгалахад хэцүү ажээ. Эргэн тойрон ханзан дээр хүмүүс байх ажээ.

— ЁХ, ёх! гэж бүдүүн ноёнтон амьсгаадна.

— Халуун уур, халуун уур! гэж залуу хархүү хашгирна. Нүдний хавчдаг шилтэй ямар нэг хүн туранхай ташаагаа эв хавгүй ороолгоно. Өвгөн Ипат дээд давхрын давцан дээр хэвтэж Ленъкад навчин шавшуур өгч нуруун дээгүүрээ ороолго гэлээ. Ленъка ороолгох авч эвийг олохгүй байлаа.

— Чи чинь гартаа хүчгүй юм уу? гэж Ипат өвгөн бувтнаад

— За ингээд цохь. Ээ мөн мөн, тэг тэг гэж сэтгэл хангалуун хавчигнана:

Өвгөн ууранд утаж байснаа:

— Хааны үед ямар ч байсан дээр байжээ гэж хэлж орхилоо. Тэгтэл Ипат өвөө уруу нөгөө залуу, тэгээд бусад нь ширтэж гарлаа.

— Зүйрлэшгүй дээр байж хэмээн Ипат өвөө дахин хэллээ

— Сахалтай нөхөр зүйтэй хэллээ гэж бүдүүн эр хүнгэнэв.

— Юу, зүйтэй гэж хэн хэлэв гэж нүдний хавчаар шилт хашгираад ханз өөд авирч гараад гараас нь чангааж: Иргэдээ бид эрх чөлөөт орос орны төлөө тэмцсэн юм шүү гэвэл

— Хэн тэмцсэн юм бэ? Чи тэмцсэн юм уу?

Хэн нэг хүн илтгэгчийг уруу нь татаж бас нэг хүний гар Ипат өвөөгийн сахлаас чангаалаа.

— Цохь түүнийгээ

— Сахлы нь хуу тат! гэцгээлээ.

Өвгөн чарлаж, уруугаа шалан дээр гулсан ойчлоо. Уурын өрөөнд хүмүүс гүйлдэж түмпэн сав тарчигнаж хүмүүсийн ярилцах жигд биш учир намбаагүй ажээ. Туранхай этгээд тавцан дээр дахин гарч

— Иргэдээ, бид эрх чөлөөт Орос орны төлөө тэмцсэн юм шүү... гэлээ. Шуугиан гарахад халуун усны эзэн гүйн ирж яах ч учраа олохгүй хаалганы дэргэд зогсон:

— Ноёдоо! гэснээ Иргэдээ гээд бүр гүйж: Нөхдөө! гэж хашгирлаа

Шуугиан намдсангүй. Хэн нэгэн хүн түмпэнтэй ус авч эзний нүүр өөд цацахад эзэн тургиж хараасаар гарч одлоо.

Нилээд болсны дараа зэвсэглэсэн эргүүл орж ирлээ. Тэдний ахлагч нь бололтой усан цэргийн

мундаг эр цугларсан олон уруу хашгирах гэсэн боловч дахиад л хэн ч анхаарсангүй. Тэгэхээр усан цэрэг маузер буугаа гаргаж хий буудахад бүх хэрэг шал өөр болж чимээгүй боллоо.

— Өвөө бос, гэж усан цэрэг хэлээд Ипат өвөөд гараа өгчээ. Өвгөн босож усан цэрэг, маузер буу хоёр луу сэрэмжлэн харна.

— Яасан юм бэ? гэж усан цэрэг асуулаа..

Хавчаар шилтэй этгээд гүйн ирж дахиад л үгий нь тасалчих бий гэж айсан байртай түргэн түргэн ярьж гарлаа:

Нөхөр цэргийн хүн гуай, энэ этгээд дайсагнасан суртал нэвтрүүлэг явуулсан юм гээд

Ипат өвөө рүү заалаа. Усан цэрэг нүдний хавчаар шилт уруу харснаа, өвөө уруу харж:

— Тэгсэн үү? гэж асуулаа. Өвгөн мэгдэж, нүдээ чавчлан сахлаа барьж авснаа тавиад дахин барьж авлаа

— Тэгсэн юм уу? гэж усан цэрэг дахиад асуулаа. Ипат өвөө дуугарсангүй.

— Энэ хүн эзэн хааны үед дээр байсан гэж хэлсний нь танд илтгэхийг зөвшөөрнө үү гэж нөгөө туранхай этгээд бууж өгсөнгүй.

— Аав аа хувцаслаад яв гээд усан цэрэг хаалга уруу гараараа заалаа.

— Та яах гэж тэгж хэлсэн юм бэ? Зөвлөлт засаг юугаараа таны сэтгэлд таарсангүй вэ? гэж гудамжинд гарсан хойно усан цэрэг асуулаа.

— Зөвлөлт засаг ч яахав дээ. Сэтгэлд тохирч л байна. Харин хаангүй яаж болох юм бэ? Энэ л нэг таатай биш байна гэлээ.

— Таатай биш гэнээ? Хэ хэ, та ч.. гээд усан цэрэг жуумалзав. Сухаревын захын орчим усан цэрэг хэн нэгэн хүнийг дуудлаа.

— За ингээд энд зогсож байгаарай гэж Ипат өвөө, Ленька хоёрт хэлээд явжээ. Гэвч усан цэргийг явмагц өвгөн жаалын гараас барьж аваад банзны завсраар шурган орсноо нэг хашаа давахад Ленька арай ядан өвгөнийг гүйцлээ. Усан цэргээс зугтсан тэр өдрөөс хойш өвгөн байнга сэтгэл түгшдэг болжээ.

Хүн ирээд барьж аваад явна даа гэж хүлээдэг байжээ. Тэгтэл тав дахь өдөр нь хаалгы нь тогшиход Ленька тайлахаар гүйтэл Ипат өвгөн:

— Хаачих нь вэ? Боль байрандаа суу! гэж хашгирлаа. Хаалга дахиад тогшсоноо холдон явах хөлийн чимээ сонсдоход өвгөн амьсгаа авч билээ.

Тэгтэл дахиад л хөлийн чимээ гарч хаалганы цаана хүн дуугарч Марья авгайн хариу дуугарах сонсдож:

— Гэртээ байхгүй хаачих вэ гэртээ байгаа, ор ор гэх сонсдов. Ипат өвөө цонхийн айж түргэн хөшигний цагуур орохдоо. Ленъкаг мөн авч орлоо.

Хаалга нээгдэж тасалгаанд хоёр хүн орж ирлээ. Жаал хөшигний цооронхойд нүдээ тааруулж цөмийг харна. Нэг нь гартаа цүнх барьсан өндөр хүн, нөгөөтөх нь маузер буутай халуун усны танил усан цэрэг байлаа. Ирсэн хүмүүс тасалгааг үзэж усан цэрэг байшингийн адар өөд харахад Ленъка дээш харвал тасалгааны баруун өнцөгт дугуйрч норжээ. Хөл доорх газраа харвал

өмхөрч ялзарсан банзны завсраар өргөн зай гарснаар өмхий чийг ханхална.

— Тэгэхээр Ипат Игнатьевич Дремовынх юм биз дээ гэж цүнхтэй хүн хэлэхэд

— Тийм, тийм гэж Марья авгай хариуллаа.

— Та төрсөн дүү нь үү?

— Тийм ээ, дүү нь

— Бас нэг жаал бий гэсэн байх аа?

— Ленъка гэдэг юм. Өнчин юм Манай эгч Варварагийн хүү байсан юм гэлээ.

— Тийм үү, бид районы Ажилчин Цэргийн Депутатын Зөвлөлөөс явж байна гэж өндөр нь хэлэхэд,

— Маш чухал хэргээр яваа гэж усан цэрэг нэмж хэллээ. Ленъка Ипат өвөө уруугаа харахад өвгөн амьсгаа ч авахгүй зогсох мэт ажээ. Тэгтэл Ленъка хувин унагааж хангир жингэр болоход Ипат өвөө цочиж, ирсэн хүмүүс тэдний зүг эргэж, усан цэрэг маузер буугаа авч, Тэнд хэн байна вэ? гэлээ. Ипат өвгөө дуугарсангүй, эмгэн аятай түргэн загалмайлав. Марья авгай ирж хөшиг яраад:

— Та чинь энд орчихсон юм уу! Наад сахлаа засаач, тан дээр зочид иржээ гэлээ. Ипат өвгөн ирсэн улсыг хараад усан цэргийг үзэж ухарлаа.

— Хэ, хээ! монархист, хуучин танил шив гэжээ.

Ипат өвөө бас нэг алхам ухраад вандан сандлаа унагааж, шалан дээр уналаа. Усан цэрэг хөхрөхөд цүнхтэй хүн өвөө уруу гүйж очин:

— Та яагаа вэ? Бид зөвлөлөөс ирсэн гээд ямар нэгэн цаас сарвайж

— Таныг генерал Инсаровын тохилог байранд нүүлгэж оруулах бичиг энэ байна гэлээ. Ипат өвөө босож бичиг, усан цэрэг, Марья авгай гурвыг ээлжлэн харж, учрыг огтхон ч эс ойлгоно.

— Талархаач дээ, талархаач дээ гээд Марья авгай өвгөний хажуу уруу нударч, баярлахдаа тэнэг болчихоод хөшчихөө юү дээ гэлээ.

Шинэ байр нь Садовын гудамж уруу харсан хоёр цонхтой, саруул том тасалгаа, хоёрдугаар давхарт байлаа. Тэгээд анхны орой өргөн сайхан орон дээр хэвтэхдээ Ипат өвгөн ийш тийшээ харж:

— Хааны үед амьдарч байгаа юм шиг байх шив дээ! Цагтаа ч цалгиж байж дээ гэхэд,

— Ээ муухай амьтан минь дуугаа татаач! гэж Марья авгайг уурлахад Ипат өвөө дуугүй болжээ.

Нөгөөдөр нь Дремовыг районы зөвлөл дээр урьж хүүхдийн ордон удирд гэжээ. Ипат өвөө буцаж явахдаа сэтгэл хангалуун буурал сахлаа таалан илж

«Ажиж дээ, Одоо Ленкагаа ажилд оруулна даа» гэж бодож явжээ. Тэгтэл нөгөө усан цэрэгтэй дахиад тааралдахад:

— Хэ хээ, монархист! гэж усан цэрэг хүнгэнэлээ. Ипат өвөө хөмсөг зангидаж:

— Чи намайг ингэдгээ боль гэж усан цэрэг уруу хашгираад мэндэлсэн ч үгүй хажуугаар нь гарахдаа, тьфу гэж эгдүүцэн нулимаад, «Монархист» гэдэг муухай үг бодож олжээ хэмээ аман дотроо давгаж хэлээд, инээмсэглэснээ тайвширч цааш зугуухан явлаа.

Тээрэм

Телегино тосгоны тариачид газрын эзэн Кряковын тоосго| тээрмийг өвлөн авсан юмсанжээ. Тээрэм дээвэр ч үгүй, довжоо ч үгүй, хуучин байсан тул янзалж хэвийн байдалд оруулах хэрэгтэй байлаа. Гэвч тариачид мугуйдалж: Бодох юм юу байгаа юм бэ? Тоосго тоосгоор нь хуваагаад ам бүлийн тоогоор тэгшхэн хуваачихья! гэжээ. Тэгээд дорхноо зөөжээ.

— Ээ дээ гайтай цаг юм даа. Энэ шинэ засаг чинь бүх юмыг л эвдэлж хэмхэлж байгаагаас цааш өөдтэй юм гарахгүй байх аа гэж баян тариачин Афанасий Блинов санаа алдан хэлжээ.

— Чи зөгнөөд хэрэггүй. Шинэ засагт гуагалсны ч хэрэггүй гэж саяхан цэрэг байсан Савелий Махотин Блиновт хариулаад тариачид ямар өмхий чийгэнд үүрд байх ёстой биш дээ гадагшаа гарах хэрэгтэй. Ингэлээ гээд бие махбод нь л чийрэгжинэ. Гайгүй, богино хугацаанд шинэ илүү сайхан тээрэм барина даа гэжээ.

— Барина гэнээ. Чи юугаараа барих юм бэ?! гээд Блинов ярзайв. Харин хүнд бэрх цаг байлаа. Тоосго бол алт л гэсэн үг. Алгын чинээ улайсгасан төмөр хайгаад олохгүй байлаа. Төдөлгүй Телегино тосгонд тариачны Зөвлөл байгуулж анхны нь даргаар Махотиныг сонгожээ.

Нэг, хоёр сар өнгөрөхөд Махотин тээрмийн тухай ярихад:

— Хэрэгтэй, хэрэгтэй гэж тариачид зөвшөөрөөд,—тээрэмгүй амьдарч болохгүй. Тэгэхэд л бид дэмий болсон юм. Кряковыг занасан заналаа л аагиндаа дэмий гаргаж гэцгээжээ.

— Дарга ийм үг дуулаад баярлаж шууд ажилдаа орж тарааж авсан тоосгоо цуглуулж, хадаас төмөр хайж олох ажилдаа орьё гэжээ.

Тариачид чимээгүй болж, харамсах бодлоосоо ухран:

— Бидний тоосго байхгүй болсон, пийшин барьчихсан, яндан хийчихсэн гэцгээсэн бөгөөд Иван Синебрюха авсан тоосгоо худалдчихсан байлаа.

Бид төмөр хаанаас олох юм бэ.

— Бид чинь ямар хадаасны завод биш дээ! гэцгээв. Ийнхүү Махотины бодол бүтсэнгүй.

— Над итгээгүй билүү гэж Блинов ам асуугаад,—Ээ цэрэг минь чи тариачны сэтгэлийг муу мэдэж байна. Тариачны гарт орсон юмыг эргүүлж авна гэж үү дээ хэ—хэ гэж билээ.

Урин хавар өнгөрч зун болоход тариан талбай дээр газрын үр шимийг биедээ шингээсэн туяхан эгц шилбэтэй хөх арвайн түрүү найгана. Энэ бол эзэд ноёдын тариа биш тариачдын өөрсдийн нь тариа билээ. Цэвцрүү шиг болж гүйцсэн арвай урт сахлаараа тэнгэр баганадаж халиурах нь ноёдынх биш тариачдын арвай байлаа. Хошуу будаа мөнгөн зэвээ тал тал тийш нь агсан найгах нь ноёдынх биш тариачдынх ажээ. Тариан талбай дээр очоод харахад сэтгэл бахдалтай бөлгөө. Тэгээд тосгон даяар ийм яриа тарсан ажээ.

— Махотины хэлдэг зөв байжээ.

— Тээрэмгүй яах билээ.

—Тахиа таргалж, нохой гаслах нээ.

— Эзэд ноёдын төлөө биш өөрсдийнхөө төлөө хичээж байгаа шүүдээ.

— Хүүе хамтралын даргаа тариачдын цуглаан хийе гэцгээж байжээ. Тариачдын хурал болоход цөм бие бие уруугаа хашгирч шуугиан ихтэй болжээ.

— Иргэд ээ, чимээгүй! гэж Махотин уриалаад, иргэдээ, чимээгүй үг хэлэх хүн наашаа гараад хэл гэхэд Дормидонт Савельев гэдэг тариачин гарч:

— Үг хэлээд байх юу байх билээ, тээрэм л барья, ингээд л гүйцэх нь тэр гэвэл

— Барья, барья! гэж тариачид хашгирлаа.

— Шинэ тээрэм барья.

— Сайхан тээрэм барья.

— Бид хэрэглээд үр ач нар маань хэрэглэх тээрэм барья гэхэд Махотин инээмсэглэж, цог золбоотой болж:

— Төмөр, тоосго, хадаас байхгүй байхад тэгээд яаж тээрэм барих юм бэ? Бид ямар хадаасны завод биш дээ? гэвэл

— Тоосго байна, байна! гэж хурагсад хашгиралдаад,—«сөөнгийн» үеэс үлдсэн тоосго бий, хайрлах юм алга. Тэгээд хүрэхгүй бол эрж хайна. Манай хөрш Волошины тариачид дээр очно, тэдэнд ч тээрэм хэрэгтэй. Эзний нь морины хашаанаас үлдсэн тоосго байх ёстой гэхэд

— За, за тоосго байна гэж бодъё хэмээн Махотин буунгуй хэлээд. —Харин төмөр яах билээ?

— Төмөр ч бас олно гэж тариачид үгий нь таслаад. —Үнэгний нүхний тариачид дээр очно. Тэдний ноёдын нохойны байр төмрөөр дээвэрлэсэн байна лээ гэвэл

— Хадаасны талаар юу гэж бодож байна?

— Хадаастай ч болно. Айл болгоноос хоёр хадаас цуглуулахгүй юу, тэгээд бага байвал Адам тосгоныхон тусална. Тэдний эздийн хашаа хадаасаар дүүрэн гэцгээв.

Хурал тарсны дараагаар Махотин:

— За тариачны сэтгэлийн талаар юу гэж бодож байна даа? гэж Блиновоос асуухад:

— Ойлгомжгүй л байна. Хачин юм даа.. гээд гараараа зангав. Тариачид дуу хуур, наадам

тохуу болж эв найртайгаар тээрмээ барихад Болошинск, Адам, Үнэгэн нүхний тариачид хүртэл тусалж үр ач нартаа үлдэх бат бэх сайхан тээрэм барьжээ. Тэр тээрэм районы төвөөс Телегино тосгон орох машин замын зүүн талын дов дээр одоо ч гэсэн сүрлийн байх бөгөөд хуучин жигүүрий нь авч уурын тээрэм болгожээ.

Модон бөөрөнцөг

Газрын эзэн Водолеев, багш Пиналов, газар хэмжигч Дятлов болон лам Греховодов нар хоёр хоёроороо талцан модон бөөрөнцөг тоглох дуртай байжээ.

Уул тоглоом сэхээтний түвшин төлөв тоглоом ажээ. Модон бөөрөнцгийг алхаар цохиж талбай дээгүүр нааш цааш хөөж өнхрүүлнэ.

Пахом Арэпин эзнийхээ эзэмшлийн хажуугаар өнгөрөхдөө ноёдын хэрхэн зугаалж байгааг харж заавал зогсоно.

— Ноёдын тоглоом тайван юм. Манай тариачдын тоглоом шиг бие биенийхээ нүүр амнаас нь цус нөж гаргахгүй юм гэж Арэпин боддог байжээ.

Тэгээд Водолеевийн эд хогшлыг хуваахад Арэпин өөртөө модон бөөрөнцгийг авчээ.

— Ёсоо алдсан тариачин гэдэг нь үнэн байна гэж айл хөршийнхөн нь дооглож ,

— Дээл нь нөхөөстэй, шаахайгаа хоёр жил солиогүй байж ноёд дээдсийг дууриаж, тэдний тоглоомоор тоглох санаатай гэлцдэг байлаа.

Арэпин хүү Гришаткатайгаа модон бөөрөнцөг тоглодог болжээ. Тариачид сүлжмэл хашааг тойрон зогсож сонирхон харж:

— Арэпин ч Водолеевийг төлөөлж чадашгүй ээ.

— Харин Гришатка л Дятловыг төлөөлж байна.

— Тэд Паниловыг л, лам багш Героводовыг л төлөөлж байна гэлцэн хөхрөлддөг байлаа.

Гэвч Арэпин тариачдын тэр үгийг огтхон ч сонсохгүй, модон бөөрөнцгөө хойш урагш нь өнхрүүлэн хөөдөг байлаа.

Тэгээд тариачид аажим аажмаар тоглож инээлдэхээ больж, харин өөрсдөө уул тоглоомыг сонирхох болжээ. Прохор Немытов хамгийн түрүүнд тэсэж чадсангүй:

— Алив Пахом аа над өгөөтөх би цохиотхье гэжээ.

Арэпин тоглоомдоо Немытовыг оруултал Корытов, Сечкии, Гречкин гээд бусад нөхөд нь тоглоомд оролцжээ.

Тариачдад модон бөөрөнцөг таашаагдаж зав чөлөө л гарвал Пахом

Арэпиний уруу очдог болжээ.

Ургацын баяр ойртсоор л байлаа.

Тэр өдөр тариачид архидаж, сөөнгөтсөн янз бүрийн хоолойгоор чадал мэдэн хашгиралдаж, дараа нь нэг нагэнтэйгээ, гудамж гудамжаараа, тосгон тосгоноороо зодолддог байлаа.

Ургацын баярт тэр жил ч бэлтгэж байлаа. Бага эмч Сорокин бусдаас илүү сэтгэл зовж «хичнээн хүн толгойгоо хагалах бол хичнээн хөвөн, даавуу, иод дэмий үрэх бол» гэж бодож байлаа.

Ургацын баяр болсон чинь зодолдсон хүн гарсангүй.

«Юу болоо вэ? гэж бага эмч Сорокин гайхлаа. Тэгээд тосгоноор явбал нам тайван ажээ. Явсаар байгаад Пахом Арепины байшин байдаг мухар гудамжийг тойртол үзэсгэлэн худалдаан дээр байгаа юм шиг олон хүн цугларсан байжээ. Сорокин олны дундуур явж голд нь орвол тоглоомын талбай байлаа. Нарийхан төмөр саваагаар жижигхэн хаалга хийж газар суулгажээ. Тариачид гартаа модон алх атгаж, газарт модон бөөрөнцөг хэвтэнэ.

— Ээ, энэ чинь модон бөөрөнцөг байна гэж бага эмч дуу алдаад,

— Хачин юм аа. Сэхээтний айвуу тайван тоглоомыг тариачид тоглож байхыг.. анх удаа үзлээ.. гэж хэлсэн билээ,

Модон бөөрөнцгөөр тоглох болсноос хойш тосгонд олон зүйл шинээр эхэлжээ.

Төдөлгүй уншлагын газар нээгдэж, сонин захиалж, даамны клуб ажиллаж, шинэ сургууль, клуб барьж байгуулжээ.

Мөн радио ярьж, цахилгаан гэрэл бий болжээ.

Гэхдээ нэг өдөр нэгмөсөн болоогүй алхам алхмаар болсон нь мэдээж билээ.

Багш

Бага Кочка тосгонд Балтийн тэнгист аврор онгоцон дээр алба хааж байсан усан цэрэг багшлахаар иржээ. Тэр багш жинхэнэ багшийг иртэл ажиллахаар гүр ирсэн юмсанжээ. Хуучин багш нь зугтаад явчихсан учир нэн даруй шинэ хүнээр солих хэрэгтэй болсон юмсанжээ. Багш ангидаа ирэхэд хүүхдүүд шинэ үсэг хэзээ зааж эхлэх бол гэж чимээгүй болно.

Харин усан цэрэг тэдэнд «Аврор» онгоцны тухай ярьж маргааш нь

Өвлийн ордныг дайрч авсан тухай, дараа нь большевик нам, Зөвлөлт засаг, Лениний тухай ярьжээ. Хүүхдүүдэд сонин байсан тул усан цэргээс нүд салгалгүй ширтэж чимээгүй суун чагнана. Хэдэн өдөр өнгөрөхөд усан цэрэг хүүхдүүдийн юу ойлгосон, ойлгоогүйг шалгажээ. Тэгээд:

— «Аврор» гэж юу вэ? гэхэд

— «Аврор» гэж Өвлийн ордон уруу их буугаар галласан, Балтийн тэнгисийн хувьсгалч хөлөг онгоц гэхэд нь

— Зүйтэй, сайн байна! гэж усан цэрэг магтаад, Большевикуудын нам гэж юу бэ? гэхэд

— Хамгийн сайн нам гэж хүүхдүүд ам булаалдаад, большевикуудын нам тариачдад газар, ажилчдад завод, бүх ард түмэнд найрамдал олгосон нам гэж хариулжээ.

— Зөв байна гэж усан цэрэг толгой дохиод, Зөвлөлт засаг гэж юу вэ? гэвэл

— Энэ бол улс орноо хөрөнгөтөн, хаад захирах биш харин хөдөлмөрийн ард түмэн захирдаг засаг гэхэд нь

— За тэгвэл Лениний тухай хэн ярих вэ? Гэвэл

— Би, би, би... гэх дуу гарахад

— Еремей Торопыгин ярь гэлээ. Торопыгин босож:

— Ленин бол бүх хөдөлмөрчин ардын багш, Ленин цөлөгдөж шоронд сууж байсан. Ленин бүх амьдралаа ажилчин ангийн үйл хэргийн төлөө тэмцсэн хүн гэжээ.

Усан цэрэг сэтгэл хангалуун байлаа. Хараач хүүхдүүд ямар ухаантай болоо вэ!

Усан цэрэг «а», «б» үсэг яаж бичдэг, нэгэн нэг, хоёрон хоёр хэд болдог

тухай тайлбарлан ярьж эхэлжээ. Усан цэрэг үүнээс цааш юм зааж чадсангүй дуудагдсан ажээ. Төдөлгүй большевик намын гишүүн Зоя гэдэг жинхэнэ багш иржээ.

— Та нар юу үзсэн бэ? гэхэд нь — «а», «б»—гийн тухай үзсэн.

— Нэгэн нэгийн нэг, нэгэн хоёрын хоёрыг үзсэн.

— Өөр юу заалгасан вэ? гэхэд хүүхдүүд мөр хавчин

— Өөр юм үзэж амжаагүй усан цэрэг багш яваад өгсөн.

— Тийм бололтой та нар ч их юм үзэж амжаагүй, байна. Зүтгэлтэй л юм биш шив дээ? гэж Зоя багш хэлжээ.

Хүүхдүүд ийм үг дуулахад гомдолтой ажээ. Еремей Торопыгин босож:

— Гэхдээ бид Лениний тухай мэднэ гэхэд

— Үнэн, үнэн! гэж хүүхдүүд хашгиралдлаа.

— Зөвлөлт засгийн тухай мэднэ

— Большевик намын тухай мэднэ

— Өвлийн ордыг дайрсан тухай мэднэ гэхэд Зоя багш инээмсэглэж

— Хэн та нарт ярьсан юм бэ? гэвэл

— Тэр усан цэрэг. Өөрөө балтийн тэнгист «Аврор» онгоцон дээр алба хааж байсан юм! гэжээ.

«Балтийн тэнгисийн усан цэрэг гол зүйлээсээ эхэлсэн байна. Сайн байна» гэж Зоя багш бодлогошроод, тэр усан цэрэгтэй уулзаагүйдээ харамслаа. Хүүхдүүд ч тэр усан цэргийг явсанд харамсаж байв. Гэвч усан цэрэг багш биш шүү дээ. Усан цэрэг өөртөө ажил албатай хүн шүү дээ.

Эзэн хааны хөлөг

Зөвлөлт засгийн тогтоолоор ордны агтны хэсгийг устгаж хаадын морийг янз бүрийн нутагт тараан явуулжээ.

Маркиз нэртэй морь Захаровка тосгонд очжээ. Морьгүй тариачдыг цуглуулж сугалаа сугалуулсан чинь Кузьм Полосухин аз дайрчээ.

Тариачин эр санамсаргүй баяртаа мунгинаж болсон явдалдаа итгэсэнгүй. Уул морь нас бие гүйцсэн дэл сүүлий нь зассан хөл нарийхантай хүзүү урт жирийн морь биш, ёстой л эзэн хааны хөлөг ажээ

Посолухин морио хазаарлаж хөтлөн гэр өөдөө явахад тариачид дагаж

— Хөлөг ёстой сайхан хөлөг?

— Эзэн хаан өөрөө л унаж байсан байх!

— Хатан хаан, хатан хаан гэж тариачид инээлдэнэ.

— Хүүш наадахаар чинь яаж газар хагалах бэ. Анжсанд хөллөж сураагүй шүүдээ! гэлцэнэ

Полосухин морио хашаандаа аваачиж тэр даруй тэргэнд хөллөхөд морь номхрохгүй янцгааж цоройн газар цавчилна.

— Шулмас гэж Полосухин хараагаад.—хайя, зүгээр бай! хайя! тпру! тпру! хайя! гэх авч тус болсонгүй.

Тариачид хөхрөлдөнө.

— Чи арай зөөлөн үз гэж нэг нь сургахад

— Чи францаар ярь гэж нөгөө нь хөгжөөгөөд, наадах чинь орсоор ойлгодоггүй бололтой гэхэд

— Нэр алдраар нь дууд гэж нөгөө нь цаашлуулна.

Кузьма уурлаж Маркизаа хашаандаа хашихад тариачид тарж оджээ. Кузьма гуай морио тэргэнд хөллөж сургах гэж бүтэн долоо хоног оролдож ноцолдоод яаж ч чадсангүй, харин мориныхоо туураинд золтой л цавчуулчихсангүй.

— Муу хар шаарыг цыганд худалдана гэж уур нь шатсан Полосухин

хэлээд санаснаараа болжээ.

Тэгтэл Маркиз хэмээх нэртэй морь Захаровка тосгонд эндүүрэл болж очсон тухай бичиг

тосгоны Зөвлөлд иржээ. Тэр бичигт уул морь ер бишийн ховор үүлдрийн морь тул нэн даруй Орловын морин заводад явуул гэсэн байжээ.

Тариачид Кузьма уруу дайрч:

— Чамайг хэн худалд гэсэн юм бэ?

— Тийм морь ёстой бурхны авралаар л ирсэн байх!

— Маркизыг даруй ол! гэсэн ажээ.

Кузьма арай ядан тариачдаас салж цыганыг хайж янз бүрийн гацаа тосгон, зах зээлээр явж олоод:

— Морий минь өгөөтөх гэвэл

— Яагаад тэр билээ?! гэхэд Полосухин бүх учрыг хэлжээ. Цыгаан жуумалзаж:

— Би тэр морий чинь зарчихсан гэхэд

— Хэнд ? гэвэл

— Хөрш хошууны баян тариачин Никифор Уваровг зарсан гэжээ. Полосухин хөрш хошуу уруугаа давхиж Никифор Уваровыг хайж олоод:

— Морий минь өгөөтөх гэвэл

— Яагаад тэр билээ?! гэхэд Полосухин уг учрыг ярьжээ.

— Өө би тэр морий чинь хүнд өгчихсөн гэж баян тариачин хариулбал.

— Хэнд өгсөн бэ?

— Хүргэндээ гацаа уруу өгчихсөн гэхэд Полосухин гацаа явж хүргэний нь хайж олоод:

— Морий минь өгөөтөх гэвэл

— Яагаад тэр билээ?! гэхэд Кузьма бүх учрыг ярьжээ.

— Өө би тэрний чинь мориор сольчихсон гэхэд нь

— Ээ бурхан тэнгэр минь гэж Полосухин дуу алдахад

— Тэр хүн холгүй Захребет тосгоны мухлагийн худалдагч Переплюевтай сольчихсон гэжээ.

Полосухин Захребет тосгоны мухалгийн худалдагч Переплюевынд очиж:

— Морий минь өгөөтөх гэвэл

— Яагаад тэр билээ?! гэхэд

Полосухин бүх учрыг ярьжээ.

— За яахав гэж худалдагч зөвшөөрснөө,

— Харин морины үнэ өндөр болжээ. Гурван морины л үнэ өг гэхэд

— Чи галзуурав уу. Тэр морь чинь улсын хэрэгтэй морь, Орловын морин заводад үржүүлэх юм гэж Кузьма давтвал

— Дургүй бол албадахгүй. Тийм морь над тээр болохгүй гэж худалдагч зөржээ.

Полосухин Захаровка тосгондоо эргэж ирээд тариачдад Переплюевтай ярилцсанаа хэлжээ.

Тариачид шуугилдан хашгиралдаж Кузьмаг морио зарлаа гэж элдвийн муухайгаар харааж зүхэн, эцсэд нь:

— Хогийн муу Переплюев бүдүүн гүзээтэй, бөх гэдэстэй худалдаачин нийгмийн сонирхлыг ойлгоно гэж үү дээ. Зөвлөлт засагтай мухлагийн худалдагч зэрэгцэхгүй, тариачид бид зэрэгцэх ёстой гээд мөнгө нийлүүлж Маркизыг худалдан авч очуулах газар нь хүргэж өгөхөөр шийджээ.

— Морь юу юм бэ? Моринд хэргийн учир байгаа биш.

Өөр чухал зүйл байгаа юм гэж тэд үзжээ. Зөвлөлт засагт маш олон ажил үйлс байсаар байхад ганц морины тухай дурсаж байдаг, Шинэ засаг маань бүх юмыг эрэгцүүлж бодох юм. Нэг үгээр хэлбэл ёстой л аж ахуй ч юм даа гэж тариачид зоригжжээ.



Тэнгэр

Хуучин Дворик тосгонд Зөвлөлт засаг бий болж насанд хүрсэн хүмүүс ноёдын газар, хөдлөх хөрөнгө зэрэг бусад эд хогшлыг хуваарилж байгааг багачууд хараад бас тэгж хуваах юмсан гэж боджээ.

— Хүүшээ, бид бас ингэж хуваах юмсан гэгцгээж байжээ. Үнэндээ гэхэд тэдэнд хуваарилах юм огтхон ч үлдээгүй цөмийг хуваачихсан байжээ. Тэгтэл Колька Рябов гзнэт:

— Тэнгэрээ хуваая гэсэн санал гаргажээ.

— Тэр ч болно, харин яаж хуваах вэ?! гээд багачууд инээлджээ.

— Яахав дээ хуваадгаараа адилхан тэгшхэн хуваачихгүй юу! гэвэл

— За ойлгомжтой байна, хуваагаад авчихъя тэгээд яах вэ, хуваасан тэнгэрээ яах вэ?!

— Юу яах вэ гэж? Юу л хүссэн бүхнээ хийнэ, гэрээ барина. хагалж тариагаа тарина, шөнө нь адуугаа бэлчээнэ гэжээ.

Багачууд гайхаж сонин хачин санагджээ.

Тэд: Колька Рябов, Еремка Дударов, Гришатка Кобылин, Марфутка

Дыгай дөрвүүлээ байжээ.

— За яах вэ хуваах нь хуваая гэж зөвшөөрчээ.

Тэгээд тэнгэрийн дундуур хөндлөн гулд зурж хуваагаад хэн нь алий нь авах вэ? гэж сугалаа сугалжээ.

Багачууд тосгоны захын нуга дээр очиж ногоон дээр өнхөрч тэнгэр харан хэвтэнэ. Өөрөө эзэн байх ямар сайхан бэ, толгойдоо орсон бүгдийг хийж болно.

Еремка Дударов өөрийнхөө хэсгийг тариа тарихаар хагаллаа. Хув шаргал тариа халиуран найгаж ганхана. Гришатка Кобылин шөнийн цагаар адуугаа манаж алс тэнгэрийн хаяанд түүдэг гал асаана. Марфутка Дыгай өөрийнхөө хэсгийг хонгор зул, балжир гарам цэцгээр чимнэ.

Харин Колька Рябов бүх юмтай ажээ. Нүд нь дүрэлзэж, хөмсөг сортойж амаа ангайжээ. Тэгээд чихэнд нь бөмбөрийн дуу хоногшиж уриалан дуудсан бүрээн дуу цууриатна. Тэнгэр дээгүүр улаан туг намирч түүний дунд Колька өөрөө догшин хөлөг унаж хурц үзүүртэй жад барьчихсан яваа харагдана.

Тэгтэл тэнгэр тариан талбайтай нийлж шингэх нарыг халхалсан түүний цаанаас тоо томшгүй олон мангас гэнэт гарч ирж байгаа харагдана.

— Цохь! цохь! Яйр цохь! «гээд Колька дайсан уруу баатарлагаар —Ура хашгиран гараа даллан дайрна.

Еремка Дударов нөхрийнхөө мөрөнд хүрч:

— Чи яагаа вэ? гэлээ.

Колька мэгдэж юу ч эс хариулав. Харин чихэнд нь морин төвөргөөн сонсдож гартаа жадаа барьсан хэвээр ажээ.

Багачууд ингэж хөгжин цэнгэж зугаалаад орой гудамжинд гарч дээш харж од тоолно. Хэнд хичнээн од ноогдоо болоо. Тоолж тоолж тоо алдаад хөхрөлдөж маргана.

— Дахиад л тоолно, дахиад л эхэлнэ.

Багачууд анхны цахилгаанаар хавар хөл нүцгэн нуга дундуур гүйж гол дээрх гүүрэн дээр очно.

— Аа яа цахилгаан гялалзаж!

— Аа яа тэнгэр нижигнэнэ! Цахилгаан. Тэнгэрийн дуу. Эргэн тойрон үүл. Гол тоглон долгиулж, салхи улин исгэрч бороо хана дээвэр шажигнуулан асгарлаа.

— Ургац сайн байх нээ!

— Манай тэнгэрээс ч гэсэн!

— Хуваахгүй гэж байл уу!

Хүүхдүүд эвсэг найртай амьдарч байгаад зуны эхэнд гэнэт нугадаа дахин цугларлаа. Дахиад л тэнгэр харж хэвтэн хүн бүр өөр өөрийнхөө хэсгийг эзэлсэн байлаа. Наран огторгуйд мандан өвс ногоо сэргэж бөднө шувуу алс ганганалдана.

Тэгтэл Гришатка Кобылин шударга бус явдал байгааг анзаарчээ. Түүнд ноогдсон тэнгэрийн хэсгийн умард захад нар тусдаггүй хэсэг байжээ.

Гришатка хөмсөг зангидаж:

— Мэхэлжээ! хэмээн хашгиртал багачууд юу болоо вэ?! гэлцэн гүйлдэн очжээ.

— Өөрсдөө нары нь авчихаад, над хоосон гээд Гришатка гараараа тэнгэр өөд чичиллээ.

Багачууд харвал үнэн байлаа.

— Сугалаагаар л авсан шүү дээ гэж Еремка Дударов хэлэхэд

— Сугалаа шиг шударга юм хаа байгаа юм бэ хэмээн Марфутка Дыгай үг хаяхад

— Нартай хэсгийг би авна, нартай хэсэг гэж Гришатка бууж өгөлгүй хэлээд, Амтат гуа суулгах гэсэн юм гэлээ.

Багачууд хашгиралдаж муудалцсанаа ч мэдсэнгүй, жаал цэц булаалдаад гэр гэртээ харьжээ.

— Тусгүй юм боллоо гэж Еремка Дударов бодлогошроход

— Шал дэмий муудалцлаа хэмээн Марфутка Дыгай уйлагналаа. Колька ч гэсэн «Гришаткагийн зөв, хүн бүр нар хүсэлгүй яах вэ?» гэж бодлоо.

Тэгээд Колька Рябов багачуудыг дахин цуглуулж:

— За ингэхэд байна, тэнгэрээ нийтийн болгоё гэлээ. Хүүхдүүд Колька уруу ширтсэнээ:

— Зүйтэй, зүйтэй! Тэнгэрээ нийтийн болгоё гэж хашгиралдлаа.

— Нар нэг л болохоор бүгдийг гийгүүлж байг хэмээн Колька хэллээ.



Таатай болно

Тула хотын ажилчин Артемий Теплов төрөлх тосгондоо: «Зочин угтаарай. Та нарт таатай болно» гэсэн зургаахан үгтэй захиа илгээжээ. Тариачид уул захиаг аваад шилээ маажиж гар хуруугаа гозойлгон толгой эргүүлж яджээ.

— Нэг л ойлгогдохгүй байна. Тодорхойгүй л байна. Хэн ирэх юм бол оо? Яах гэж ирэх юм бол оо? Хамгийн гол нь юу таатай байх юм болоо? гэлцэнэ. Арван хоногийн дараа Тула хотын ажилчны төлөөлөгч хүрэлцэн иржээ. Ажилчин ирэх ирэхдээ зүгээр гар хоосон ирсэнгүй. Алх хадуур, сэрээ, тэрэгний дугуйны төмөр гол, хадаас зэрэг аар саар төмөр зүйл авчирчээ. Тариачид түүнийг хараад уухайлж:

— Энэ ч ёстой л таатай хэрэг байна! гэлцэв.

Тэр үед алх хадуур зэрэг бусад төмөр эд тосгонд нүдний гэм болсон байсан тул тариачид бүр гачигдаж байжээ. Тэгээд тэдний нүд дүрэлзэж:

— Худалдах уу? гэж асуувал

— Үгүй гэж ажилчид хэлжээ.

— Арилжих уу?

— Бас л үгүй гэжээ. Тариачид учрыг олсонгүй.

— Та нарт ажилчин бид бэлэг болгон авчирсан юм гэж ирэгсэд хэлэхэд тариачид гайхаж: — Үнэгүй юү?! гэвэл

— Тэгэлгүй яах вэ, Чин сэтгэлээсээ өгч байгаа юм! Ажилчны бэлэг ав гэжээ. Тариачин эрсэд үлгэрт гардаг шиг ийм баялаг гэнэт бий болох гэж Тариачид мэгдэж гүйлдэн төлөөлөгчдийг гэртээ аваачиж ширээ засан

дайлжээ. Ажилчид цайлуулаад:

— Гялайлаа. Энх тунх амьдраарай. Бид завод уруугаа буцъя гэжээ.

— Зочид мэхийн ёсолж хүндэтгээд явцгаажээ.

— Үнэгүй өгчихдөг ёстой хачнаа. Бас тэгээд сайн дураараа шүү ёстой л гайхамшиг байна гэж тариачид учрыг эс ухаарна.

Төдөлгүй Артемий Теплов, өөрөө уул тосгонд иржээ.

— Алх хадуур ямар байна даа? таатай байгаа биз! гэхэд

— Таатай таатай гэж тариачид хашгираад хадуур ч, алх ч, сэрээ ч сайхан эд байна. Хэрвээ

таатайн тухай ярих юм бол ажилчин анги бидэнд төрсөн ах дүү юм уудаа, үүнд л таатай нь байна гэсэн ажээ.

Бэлэг

Береза тосгоны тариачид анхны ургацын дээжээсээ Владимир Ильич Ленинд явуулахаар шийджээ.

Тэгээд шуудай тариа цуглуулж тээрэм дээр аваачиж гурил хийлгээд:

«Эрхэм хүндэт Владимир Ильич Ленин!

Ой мод, нуга хөндий, газар олгосон явдалд эн түрүүнд баярласнаа илэрхийлье. Энэ жил десятин газраас наян пүү авахаар манай ургац сайн байна. Хүн бүхэн хувиа авах ёстой. Тэгээд ч таныг бид мартаггүйгээр шийдлээ.

Улаан буудай тариагүй учир арвайн гурил явууллаа. Битгий голоорой. Гурав дахин тээрэмдсэн сайн гурил шүү. Тандаа л гэж хичээсэн юм» гэж захиа бичжээ.

Дараа нь бодлогошроод дахин бичиж:

«Бүх большевик намдаа тариачин бидний хүндэтгэлийг дамжуулаарай. Береза тосгоны тариачид. Бүгдийг төлөөлж Епифан Дыра бичив» гэжээ.

Тариачид бэлгээ шуудангаар явуулах гэсэн боловч төвдсөнгүй цовоо сэргэлэн тариачин эр Прокоп Гмыряг олоод тэргэнд суулгаж өртөөн дээр хүргээд галт тэргээр явуулжээ.

Тэд үдэш гаргахдаа:

— Хэнд ч хэлж болохгүй шүү. Яг өөрт нь хүргэж өгөөрэй. Мэдэв үү гэж хойноос нь хашгирч байлаа.



— Тийм ээ тийм тодорхой байна.

Долоо хоногийн дараа Гмыря буцаж иржээ.

— За уулзав уу?

— За өгөв үү?

— Өгсөн, уулзсан.

— Нээрээ юу?

— Хээ ер!

— Ленинийг биеэр нь үзжээ!

— Тэгээд Ленин юу гэж байна? Гурил таалагдаа юу? Талархаж байна уу?

— Талархалгүй яах вэ?! «Тэр ч байтугай ихийн их гялайсныг минь тариачдад дамжуулаарай» гэсэн. Хоёр дахин хэлсэн шүү. Гурил өгсөн явдалд, большевик намыг хүндэтгэсэн явдалд баярлалаа гэсэн.

Хээ ер хүндэтгэж байна уу гээд тариачид инээмсэглэлээ.

— Ойлгож байгаа биз

— Ленин өөр юу ярьж байна вэ?

— Зөвлөлт засгийн төлөө бат зогс гэж байна. Ганцхан өөрийгөө бодож болохгүй, ажилчдыг битгий мартаарай гэсэн. «Та нар ажилчин ангийн хамт шинэ амьдралаа цогцлон байгуул» гэж байна гэхэд

— Зүйтэй хэмээн тариачид зөвшөөрчээ.

— Бид амь нэгтэй улс шүү. Тариачид сэтгэл хангалуун ажээ.

Хагас сар өнгөрчээ. Тэгтэл Доод Новгород хотын усан хөлөг онгоцны засварын заводын ажилчдаас Береза тосгоны тариачдад захиа иржээ.

Тариачид захиаг уншаад ихэд гайхжээ. Ажилчид шуудай гурил өгсөнд талархлаа дэвшүүлж, тэр гурилыг өвчтэй хүүхдүүдэд

хоёр хоёр фунтээр хувааж өгсөн. Маш сайхан гурил, сайхан талх болж гээд эцсэд нь:

«Та бүхний дунд юм мэддэг ухаантай улс байгаа бололтой. Манай энд талх тариа үнэхээр муу байгаа. Тэгэхээр та нарын бэлэг үнэлж баршгүй ажээ. Ажилчин биднийг дурсан санасан явдалд чинь гялайлаа» гэсэн байлаа.

Тариачид гайхлаа.

— Ямар шуудай билээ?

— Ямар гурил байх билээ.

— Нөгөө бидний явуулсан гурил биш байгаа даа!

Тариачид учрыг ухаарчээ. Ажилчдын захиа чин сэтгэлээс бичсэн дотно ажээ. Гэлээ ч гэсэн тариачдад гомдолтой байлаа. Тэд Прокоп Гмырягийн байшинд цугларчээ.

— Бидний бэлэг нөхөр Ленинд таалагдаагүй бололтой.

— Сэжиглэжээ.

— Өнгөн дээрээ л талархсан байх нь гэцгээв. Гмыря бодлогоширч байснаа

— Ээ та нар, өнгөн дээрээ... гэнээ гээд, — Ленин ганцхан өөрийгөө боддоггүй хүн. Тэгэхэд ажилчин ангийн тухай зүгээр ч яриагүй байж л дээ гэхэд тариачид Гмыряг ширтэж

— Нээрээ үнэн байна.

— Яг тэгж таарлаа.

— Чи хараач өөрийнхөө тухай нэг ч үг дуугараагүй, бидний бэлгийг хүлээж авсан юм шиг байсан. Ленин яасан даруу хүн бэ! гэв.

— За тариачид аа, бид тариагаа хайрлахгүй доод Новгород уруу явуулах хэрэгтэй байна. Тэгэхдээ ганц шуудай юу ч болохгүй. Ургац сайн байна явуулцгаая! гэв.

— Зүйтэй явуулцгаая! гэж тариачид хүнгэнэлдэж ажилчин ангиа дэмжье, хамтран шинэ амьдрал байгуулья. Ленин зөв сургаж байна гэцгээв.

Маргааш нь тариачид өртөөн дээр хоёр тэрэг тариа аваачиж дахиад л

Гмыряг явуулав.

Контоорын ажилчин ачааг нь жигнэж хаягий нь бичээд:

— Ажилчдад юм биз дээ? гэж дахин асуухад

— Тийм ээ, ажилчдад гэвэл

— Бэлэг үү?

— Яг тийм.

— За тэгээд хэнээс хэнд гэх вэ? гэхэд нь Гмыря контоорын ажилчинг зальтайгаар ширтэж онилзоод:

— Бич, бич, харин гоё тодорхой бичих хэрэгтэй шүү... гэлээ. Албан хаагч

бэхний саванд үзгээ дүрж сэгсэрснээ бэлтгэхэд

— Владимир Ильич Ленинээс гэж бич хэмээн Гмыря хэллээ.

Гэрчүүд

Фомка хүү сэрж ханзан дээрээ эргэлдэж байгаад жаахан хэргээр гудамжинд гүйн гарчээ.

Шөнө. Тас харанхуй бөгөөд гудамжаар манан бүрхжээ. Фомка заводын ажилчдын байрны булан тойртол хөлийн чимээ сонсогджээ.

Жаал хүү таг чиг болон чагнавал хөлийн чимээ улам улам тодорсоор бараг хажууд нь дуугарчээ. Фомка сэрэмжлэн харвал харанхуй дотроос манан дундаас гурван хүн гарч иржээ. Хоёр нь ямар нэг хайрцагтай юм дамжлан явах агаад нөгөө нь хүрз барисан ажээ.

Фомка лавшруулан харвал заводын хуучин эзэн Елизар Елизарович Мойкин хоёр хүүгийнхээ хамт явж байжээ.

«Хайрцагтай юм, хүрзтэй эд хаашаа явж байгаа юм болоо?» гэж Фомка хүү сонирхон сэмээрхэн хойноос нь гэтжээ.

Мойкин заводын усан бүлүүр уруу очиж зэрэгцээд хайрцгаа газар тавьж нүх ухах эхэллээ. Тэгж нүх ухагдаа санд мэнд байж ийш тийшээ харан сонордож байжээ.

«Эрдэнэсээ л булж байна» хэмээн Фомка боджээ.

Тэгээд Мойкиныхныг ажлаа дуусахыг хүлээж байгаад усан бүлүүрий нь тойрч газры нь ажиглаж аваад гэр өөдөө явжээ.

Фомка ханзан дээрээ хөрвөөж унтаж чадахгүй нойр хулжжээ. Өглөө гэгээ орохтой зэрэг найз Капка Затворов уруугаа гүйж очжээ.

— Капка, Капка бос гэсээр Фомка түүнийг сэгсэрлээ. Капка нүдээ нухалж

— Чи юу болоо вэ? гэвэл

— Эрдэнэс эрдэнэс! гэхэд

— Бас юуны ч, инь эрдэнэс?! гэвэл

— Жинхэнэ эрдэнэс! гээд Фомка Капкад шөнө болсон бүх явдлаа ярихад цаадах нь босон харайж хувцаслалаа.

Тэр хоёр хүрз авч усан бүлүүр уруу гүйлээ.

— Тэнд лав мянга гаруй мөнгө байгаа байх гэж Фомка хэлбэл

— Мөнгө чинь юу юм бэ! Цаас л байгаа биз. Тэнд алт, эрдэнийн чулуу байгаа гэж найз Капка нь засаж хэллээ.

Багачууд тэр их баялгаар яахаа тооцоолно.

— Хэвтэй боорцог авна гэж Фомкаг хэлэхэд

— Хэвтэй боорцгоор яах юм бэ! гэж Капка хэлээд ёстой амттай нарийн боов авна гэлээ.

Фомка Капкагаа харна. Капка үргэлж илүү сайн юм бодож олдог билээ. Хэдүйгээр амттай нарийн боов гэгч юу байдгийг Фомка мэдэхгүй боловч маш сайхан амттай зүйл байдаг байх гэж бодно.

Тэр хоёр ээж нартаа толгойн ноосон алчуур, эгч нартаа жигүүн платье, тууз, эцгүүддээ гутал шаахай авч өгөхөөр шийдлээ. Дараа нь айл хөрш, танил талынхаа хүмсийг тооллоо. Малининых олон хүнтэй болохоор хүн бүрт арван фонд будаа өгнө. Харламов өвөөд эсгий гутал, тахир дугуу Зарубилинд шинэ таяг, слесарь Вавилин өвөөд зургаан талтай саравчтай малгай авч өгнө гэж боджээ.

— Тэр чинь большевик авахгүй байх гэж Капка хэлжээ. Багачууд заводын усан бүлүүр дээр гүйн ирж шууд ажилдаа оржээ.

— Түргэл түргэл! гэж Капка командална.

Тэд газар ухахад бие биенээ ёворч, нэг нэгэндээ саад болно. Тэгтэл хүрз нь хайрцганд хүрчээ.

— Чаг—чаг, чаг чаг чимээ гарахыг жаалууд сонслоо.

— Цаг байна, годилт цаг байна гэж Фомка хэлбэл

— Годилт цагаа гээд Капка инээмсэглэснээ, — эсвэл сэрээлэгтэй, үгүй бол «Павел Буре» гэдэг донгоддог цаг байх гэлээ.

Хүүхдүүд ажилдаа шамдаад араасаа хэн нэгэн хүн ирэхийг ажигласангүй. Эргэн харвал слесарь Вавилин өвөө ирсэн байлаа.

— За та нар юу хийгээд байгаа юм бэ? гэхэд нь тэд сандарлаа.

— Эрдэнэс гэж Фомка арай ядан дуугарснаа, Тэнд алт, бас «Павел Буре» гэдэг донгоддог цаг гэж хэлбэл

— Цагаа гээд Вавилин яаран нүх уруу бөхийж чагналаа.

— За холдоцгоо! гэж жаалууд уруу хашгирахад тэр хоёр ухарлаа. Вавилин нүх уруу гараа шургуулж нилээд удсаны дараа цаг дуугарахаа болив. Өвгөн слесарь өндийж духныхаа хөлсийг арчаад инээмсэглэж

Эрдэнэс нь үнэндээ эрдэнэс л юм. Тэсрэх бодисыг эрдэнэс гээд байгаа гэхэд нь багачууд ам уралдан:

— Тэнд цаг байсан шүү дээ гэвэл

— Цаг нь цагаа, тэгэхдээ тийм цаг биш. Тэр чинь дэлбэрүүлэх тусгай багаж байна. За одоо бүх болсон явдлыг илтгэ гэхэд хүүхдүүд ярилаа.

— За, тэр «Павел Буре» чинь энэ дээ гэж Вавилин өвгөнийг хэлэхэд

— Ээ нөгөөх ноосон ороолт, тууз өнгөрөв өө гээд Фомка санаа алдав.

— Ороолт, тууз ч юу ч биш ээ! Усан бүлүүр үнэтэй эд гэж Капка дуу алдахад өвгөн инээмсэглэж:

— Капка зүйтэй, сайн байна! гэлээ.

Тэр өдөр Мойкиныг хоёр хүүгийн нь хамт барьж хорьжээ. Тэднийг шүүж

хувьсгалт хуулиар хатуу шийтгэлээ.

Фомка, Капка хоёр ч бас шүүх хурал дээр очлоо. Бас л бүх болсон явдлыг ярьжээ. Шүүхийн тогтоолд тэднийг гэрчүүд гэж үзсэн байлаа. Гэвч шүүгч өөрөө ч, танхимд сууж байсан бүх хүмүүс ч уул хэргийг арай өөрөөр ойлгож байлаа. Тэр хоёр ямар гэрч байх вэ дээ. Хамаг хэргийн учир үүнд л байгаа ажээ.



Эцэг, хөвгүүд

Багачууд тус бүр ардын засгийн төлөө ямар нэг юм хийхээр бодоцгоожээ.

— Би засгийнхаа төлөө тариа тарьж ургуулна гэж Колька Заборов хэлбэл

— Би заводод ажилчин болно гэсэн хүсэл Димка Петровг байлаа.

— Би Улаан Армидаа алба хааж, Зөвлөлт засгаа дайснаас хамгаална гэж Гошка Извеков хэллээ.

— Харин би бол сурна, бас сурна, дараа нь сургуульд хүүхэд сургана гэж

Люба Козулина хэлжээ.

Багачууд маш зөв шийдсэн байна. Тэдний сонгож авсан аль ч хөдөлмөр улс эх орондоо хэрэгтэй хүндтэй хөдөлмөр билээ.

Он жил хурдан өнгөрч хүүхдүүд өсөж том болжээ.

Колька одоо Колька биш Николай Митрофанович болж төрсөн нутгийнхаа газрыг хагалж эх орноо тариагаар хангаж байна.

Димка одоо Димка биш Дмитрий Андреевич болсон заводын хайлуулах зуухны шилдэг мастер болчихсон эх орондоо металл гаргаж байна.

Гошка одоо Гошка биш Григорий Иванович болсон алс холын хил дээр цэргийн албан хааж Зөвлөлт эх орноо хамгаалж байна.

Люба ч сургуулийн хүүхэд сургаж Люба биш Любовь Антоновна болсон ажээ.

Цөм л санаснаараа болж үйлс бүтжээ. Яагаад гэвэл Зөвлөлт засгийн үед бүх зам хүмүүст нээлттэй ажээ.

Тэгээд мань дөрөв яагаад ч юм бэ төрсөн тосгондоо дахин цугларчээ. Харин тэд одоо үр хүүхэдтэй болжээ.

Колька маань Семен гэдэг хүүтэй. Димка маань Сережа гэдэг жаалтай Гошка маань Андрей гэдэг хүүтэй.

Люба маань Зина гэдэг охинтой болсон байлаа.

Семен, Сережа, Андрей, Зина нар уулзаж танилцаад хүүхэд бүр ардын засагтаа юм хийхээр бодоцгоожээ.



Би л эцэг шигээ улс орондоо тариа ургуулах агрономич болно доо гэж

Семен хүү хэлэхэд

— Би л болд гаргахаар хатуу шийдсэн, эцэг шигээ заводад очно гэж

Сережа хүү шинэ нөхдөдөө хэлбэл

— Би л зоригт нисгэгч болно гэж Андрей хүү нууцаа илчлэхэд

— Харин би сурна, сурна, сурна. Тэгээд нэртэй профессор болно гэж

Зина хэлжээ.

Он жил улирч Семен, Сережа, Андрей, Зина нар өсөж том болжээ. Семен одоо Семен биш — Семен Николайвич болсон, хүссэнээрээ агрономич болж алс Сибирьт, атрын хязгаарт улсын том аж ахуй удирдаж байна.


Сережа одоо Сережа биш — Сергей Дмитриевич болсон, шинэ болд, шинэ хайлш нээж гаргаад, пуужин хийж түүн дээр нь хүмүүс огторгуйд нисэж байна.

Андрей одоо Андрей биш — Андрей Григорьевич болсон, алдар цуутай нисгэгч, дайчин генерал болжээ. Тэр фашистуудтай зоригтой тулалдаж энгэрт нь баатрын алтан таван хошуу гялалзана.

Харин Зина Зинаида Кузьминична одоо нэрт түүхч профессор болсон эрдэм шинжилгээний ном бичиж байна. Тэр номыг уншвал манай орон эрт дээр үед ямар байсан, одоо яасан аугаа их гүрэн болсон тухай унших болно.

Тэдгээр хүүхдүүдийн хүсэл бодол биелж тэдний хэн нь ч ардынхаа засагт багагүй зүйл бүтээжээ.

Чи ч гэсэн өсөж том болоод эцэг өвгөдөө дурсан санаж улам ихийг бүтээгээрэй.



Владимир Ильич Лениний тухай өгүүллэгүүд

Тэргүүн

Костром мужийн бүлэг явган тариачид Петрградад Смольныйд нөхөр Ленинтэй уулзахаар иржээ. Тариачид бошинзтой, хөмөн шаахайтай, хулгавчтай бөгөөд мөрөндөө үүрэг углажээ.

Энэ үед Смольныйд янз бүрийн хүмүүс пиг дүүрэн байлаа. Тэнд ажилчин, тариачин, цэрэг, улаан гвардчууд, усан цэрэг янз бүрийн хүмс байв.

— Хүмүүсийн дуунд Омольный зөгийн үүр лугаа адил дүнгэнэнэ. Костром нутгийн тариачид тал тал тийшээ харж Владимир Ильич Ленинийг хайна. Яг энэ үеэр нь Владимир Ильич тариачдын өмнөөс гарч ирэхэд тэдний нэг нь:

— Эрхэм минь тэргүүн нь хаана байна вэ? гэж асуувал

— Хэн—хэн гэнээ? гэж Ленин лавшруулан асуухад

— Тэргүүн, одоогийн орос орныг захирч байгаа хүн гэж тариачин дахин хэлбэл.

— Өө тэргүүн гэж Ленин жуумалзан инээмсэглэж эргэн тойрноо харснаа, Тэргүүн тэр байна хэмээн тээр тэнд байгаа тариачны нуруу уруу зааж зальжин ииээмсэглээд цааш явжээ.

Тариачид харвал хонгилд хэсэг ажилчид зогсох бөгөөд тэдний хажууд цэргүүд ямар нэг юм маргаж байлаа. Аврор онгоцны усан цэрэг навчин тамхи тайван татна. Түүний цаахна хэсэг тариачид хөшилдөнө. Тэд мөн л бошинз, хөмөн шаахай, хулгавч өмсөж, үүрэг үүрчээ. Бас л явган тариачид бололтой. Костром нутгийнхан ажилчид, цэргүүд, усан цэрэг, өөрсдийнхөө адил тэр тариачдыг ээлжлэн харна.

— За энэ ч ямар үхсэнээ тэргүүн байх вэ гэж Костромынхон голоод, тэр сахалтай хүн лав эндүүрсэн байх гэж бодлоо.

— Ах нараа, хэнтэй уулзах гээ вэ? гэсэн дуу тариачид сонсоод харвал ажилчдын дундаас нэг залуу ирж, та нар энд анх удаа ирж байгаа улс юмаа гэлээ.

— Тийм ээ, анх удаа, Бид Ленин гэдэг эрхэм хүн дээр очих гэсэн юм гэхэд

— Ленинтэй ээ?!

— За тийм, Владимир Ильичтэй гэвэл залуу, тариачид уруу итгэлгүйхэн хялайснаа:

— Та нартай саяхан Ленин ярьж байсан шүү дээ гэв. Тариачид амаа хаалга нээх мэт ангайлаа.

— Тэр сахалтай хүн хэн бэ?! гэвэл

— Ленин биеэрээ байхгүй юу гэж залуу хариуллаа. Тариачид Владимир

Ильичтэй ярилцсан яриагаа хэлэхэд ажилчин хөхөрлөө.

— Ингэхээр тэргүүнийг хайсан юм биздээ. Одоо орос орныг захирч байгаа тэр хүнийг хайсан юм биздээ? Нээрээ ч нөхөр Ленин зөв хариулсан байна. Хэрвээ та нар Ленин дээр очих юм бол гуравдугаар давхарт гар гэлээ. Тариачид үүргээ авч:

— За, за огтхон ч ойлгосонгүй гэж нэг нь хэлэхэд

— Хачнаа гэж нөгөөх нь зөвшөөрлөө.

Тэгээд тэд нөгөөх хамгийн ахмад тариачин луугаа харвал үг дуугүй зогсоно. Тэр ахмад тариачин бодолд автаж, духны нь үрчлээ долгио мэт харагдана.

— Афанасий Данилович гуай энэний чинь юу гэж ойлгох вэ? хэмээн тэд өвгөн тариачнаас үг сөдвөл

— Юу гэнээ? Юу гэж хэлсэн байна тэгж л ойлго гэж өвгөн хариулаад, инээмсэглэл туяарлаа.

Тариачид гуравдугаар давхарт гарч Лениний тасалгаа уруу очвол

— Хэн дээр орох вэ? гэж хаалганы дэргэд байгаа нарийн бичгийн дарга асуулаа.

— Нөхөр Ленин дээр орох гэсэн юм гэвэл

— Юу гэж илтгэх вэ? гэхэд нь өвгөн бусдыгаа харж сахлаа илснээ:

— Тэргүүн ирлээ. Орос орныг захирч байгаа хүн ирлээ гэж хэл дээ гэлээ.



Зөвшөөрөхгүй

Завидовка тосгоны тариачид улсад тариа тушаажээ. Тариагаа өгсөн хойноо илүү авсныг ухаарчээ. Идэж уух юм ховор өлсгөлөн хэцүү бэрх цаг байлаа. Тариаг алт шиг үнэлж байжээ. Тариачид уул будлианы тухай хошуунд бичсэн боловч хариу эс иржээ.

Ленинд Ленинд бичих хэрэгтэй гэж Иван Хомутов шуугиулаад,

— Ленин л учрыг мэдэж шийднэ. Владимир Ильич л хууль ёсоор шүүнэ гэж хэллээ.

Тариачид Лениний сэтгэл санааг зовооход эвгүй байсан учир тээнэгэлзэн.

— За тэр тариагаар юу хийх юм бэ!

— Түүнгүйгээр үхэхгүй амьдрахдаа л амьдарна...

Аа яаяа гэж Хомутов гиншээд, —Харин нэг ширхэг тарианы тухай ч гэсэн хэрэг үүсгэх хэрэгтэй. Хамгийн гол нь тариачид шударга байх ёстой гэв.

Хомутов тариачдыг итгүүлж чадлаа. Тэгээд тариачид Хомутов, Петров

Сизов нараар бүрдсэн төлөөлөгч сонгож нөхөр Ленин уруу явуулжээ.

Төлөөлөгчид Москва уруу явлаа.

— Ленин юу гэж шийднэ түүгээр л болно. Би Лениний хэлсэн болгоныг зөвшөөрдөг гэж замдаа Хомутов хэлж явжээ.

Ленин тариачдыг хүлээж аваад яриаг нь сонсоод:

— Тиймээ цаг үе хүнд байна. Маш хүнд байна гэжээ. Хомутов болгоомжилж «өө нөхөр Ленин үүнийг дэмий яриагүй байна» гэв.

— Хүнд үе, гэхдээ найдваргүй бишээ гэж Владимир Ильич яриагаа үргэлжлүүлээд, — манай орон бүх бэрхшээлийг яриангүй даван туулна, тариачин нөхдүүд бидэнд тусална гэдэгт итгэж байна гэлээ.

«Тийм л байх ёстой Ленин тариачдын гуйлтаас татгалзана гэж Хомутов бодож байлаа» Тэгтэл:

— Та нарын тухайд гэвэл гэж Владимир Ильич хэлээд, —та нарын бүрэн зөв. Та нараас илүү авсан тариаг эргүүлж өгвөл захино гэв.

Тэгээд тариачид хүндэтгэн мэхийгээд гарлаа. Иван Хомутов баярлаж:

— За! хараа биз! Сонсоо биз! Тэгэх л ёстой юм! Ленин бид хоёрын бодол тохирдог юм гэлээ.

Тэр үед янз бүрийн хэргээр Кремельд ирсэн ажилчид, тариачид Ардын Комиссаруудын Зөвлөлийн гуанзанд хооллох тасалбар заримдаа авдаг байлаа. Завидовка тосгоны төлөөлөгчид ч тийм тасалбар авчээ. Тариачид Ленинтэй уулзаж, сайхан хоол идэх болсондоо сэтгэл тун хангалуун байлаа.

— Сониноо! гээд Иван Хомутов сахлаа илж, ногооны хоосон шөл халбагадаж, агшаасан заваан будаа ч лав идэхгүй байх. Ямар ч байсан тосгондоо очоод ярих юмтай л байна даа гэлээ.

Мань тариачид гуанзанд очиж нэгдүгээр хоол авчрахы нь харвал ногооны шөл байлаа. Идэж үзвэл эсгэлэн шингэн шөлөнд махны оронд загасны давсалж хатаасан хэрчим хөвж байлаа.

— Ийм юм байдгаа! гэж тариачид гайхжээ.

Хоёрдугаар хоол авчирч өгөхийг харвал усанд агшаасан ямар ч нүнжиггүй заваан будаа байлаа. Тариачид үүргэвч шуудайнаасаа гахайн өөхөө гаргаж идмээр байсан боловч ичиж зовоод чадсангүй: Тариачдын төлөөлөгчид ийнхүү хооллоод гуанзнаас гарчээ.

— Лав өөр гуанз байгаа бололтой гэж Иван Хомутов хэлээд, энэ ч лав

Ардын Комиссар нарын Газрын гуанз биш байх аа гэв.

Тариачид ийн ярилцсаар хаалганаас хэдэн алхам холдтол хонгилоор

Владимир Ильич цамцаа ярчихсан түргэн түргэн алхалсаар ирж зэрэгцээд:

— За хооллов уу? гэхэд

— Хооллолоо гэвэл

— Тэгвэл сайн байна. Өнөөдөр манай будаа их сайхан амттай байна гэлээ гэж Ленин хэллээ.

«Сайхан амттай гэнээ. Ленинд өөр будаа өгч байгаа байж болох юм даа» гэж Иван Хомутов бодлоо.

Владимир Ильичийг гуанз уруу ороход тариачид хаалга уруу эргэж ирээд завсраар нь Ленинд ямар хоол өгөх нь вэ гэж сонирхон харвал нөгөөх л Ардын Комиссарынхны иддэг ногооны шөл, агшаасан будаа авчирч өгчээ.

— Ийм байдаг байжээ! хэмээн Иван Хомутов тэсэж чадсангүй хэлж орхилоо. Төлөөлөгчид Завидовка тоогондоо эргэж очлоо.

— За Ленин та нарыг хүлээж авав уу?

— Авсан.

— Хүсэлтийг биелүүлэв үү?

— Биелүүлсэн.

— Бичиг баримт өгөв үү?

— Өгсөн гээд төлөөлөгчид тариачдад бичгээ үзүүлэв.

— Тэргээ хөллөж хошуу ордог хэргээ. Үнэн шударгаар асуудлыг шийдсэн явдалд нөхөр Ленинд талархья хэмээн тариачид баярлацгаатал:

— Үгүй, тариачид аа, энд үнэн шударга юм огт алга гээд Хомутов толгойгоо сэгсэртэл тариачид гайхаж түүнийг ширтлээ.

— Шударга биш байна. Би Лениний үгийг зөвшөөрөхгүй хэмээн Хомутов давтан хэллээ.

— За таминь! Энэ чинь юу гэсэн үг вэ! Яах нь энэ вэ? хэмээн тариачид учрыг эс олон, Иван замдаа солиорчихоогүй байгаа. Эсвэл баярлахдаа согтчихоо юу? Өөрөө бусдаас илүү хашгираад байсан мөртлөө одоо эсрэг болчихдог чинь юу билээ хэмээн тариачид шуугилдахад,

— За чимээгүй гэж чимээгий нь таслаад, Гахайн өөх та нар идэж байгаа юу? гэж асуутал тариачид бие биенээ харснаа:

— Идэж байгаа... гэхэд

— Та нарын сан хөмрөгт хичнээн тариа бий вэ ээ?

— За яахав бий л дээ.

— Ямар ч байсан өлсөж үхэхгүй биз дээ? гэвэл

— Үгүй гэж тариачид хариулжээ.

— Хамаг учир үүнд л байгаа юм! гээд Хомутов Ардын Комиссарын Газрын гуанзанд хооллосон тухайгаа ярихад тариачид ичиж нам жим болжээ.

— Үгүй, нөхдөө Ленин буруу бичиг хийж өгсөн байна. Би Лениний энэ үгийг зөвшөөрөхгүй, зөвшөөрөхгүй гэж Хомутов хэлээд,

—Энэ чинь шударга биш байна гэсэн гэдэг.

Нэг, хоёр, гурав

Владимир Ильич яаралтай чухал ажлаасаа ховорхон хөндийрдөг байлаа.

— Зав алгаа, зав олдохгүй байна гэж Ленин хэлдэг байлаа. Гэлээ ч гэсэн зав гаргаж машиндаа сууж хотоос гарч хаа нэг тийшээ ой уруу явдаг байлаа.

Тэгээд Владимир Ильич машинаасаа гарч саравчтай малгайгаа авч, ууцаа үүрэн хус, нарсны хоорондуур алхдаг байлаа.

Владимир Ильич тайван явж байгаад хэрэм харж зогсоод ширтэнэ. Тэгээд шувууны жиргэхийг сонсож тэргүүнээ өргөн шувууг харна. Өвсөн дээрх атиралдан байгаа хорхой шавьж харж зогсоно. Владимир Ильич мөөг, ойн алаг эрээн цэцэг харж нүд хужирлана. Энэ бүгд Ленинд сонирхолтой ажээ. Ийм үедээ л Ленин ёстой нэг амарна.

Владимир Ильич ийнхүү ой дотор яваад Москвадаа эргэж ирээд дахин ажилдаа шамдаж шөнө дөл болтол суудаг байлаа.

Ленин нэг удаа зугаалж явтал ойн цоорхойд ганц охин явахыг харжээ. Биедээ таараагүй хувцастай, алчууран дороос нь сонжуу цухуйсан бяцхан охин хус модны дэргэд зогсоод чанга уйлна. Тэр охин поолуу хэмээх сагс барьсан байх бөгөөд сагсандаа ганцхан салбан хусандай мөөг хийсэн байлаа.

— Чи яагаад уйлаа вэ? гэж Владимир Ильич асуувал хариу өчсөнгүй харин ч улам чанга уйлжээ.

— За ийм том охин уйлж байхдаа ичихгүй байна уу? хэмээн Владимир Ильич толгой сэгсэрсэн авч тус болсонгүй. Зөрүүд охин байгааг мэдсэн Владимир Ильич халаасандаа гараа хийж, сагс уруу нь өнгийснөө:

— Нэг, хоёр, гурав сагсны ёроолд самар бий бол! гээд сагс уруу харвал охин сонирхож чимээгүй болоод сагс уруугаа хартал самар бий болсон байжээ. «Хачин юм аа!» хэмээн бодсон охин гайхаж нулимсаа арчаад Ленин уруу гайхсан янзтай ширтэнэ.

— Чиний нэрийг хэн гэдэг вэ? гэж Владимир Ильич асуувал

— Варя гэлээ.

— Варя чи яагаа вэ? гэвэл

— Төөрчихлөө гээд охин мэгшихэд

— Гэр чинь хаана байдаг вэ? гэвэл

— Би Мироновка тосгонд суудаг гэхэд нь

— Битгий мэгд. Чиний Мироновка тосгоныг чинь олно гээд Ленин Варяг хөтөлж бүдэг зөргөөр машин уруугаа явлаа. Тэд ой дотор явж байгаад:

— Чиний мөөг хаана байна вэ? гэлээ.

Варя азгүй ажээ. Ой дотор мөөг тааралдаагүй учир сагс нь хоосон байлаа.

— Гэртээ хоосон савтай очиход эвгүй байдаг юм. Яагаад ч гэсэн юм олох хэрэгтэй гэж Владимир Ильич хэлээд жимнээсээ гарч эргэж зогсоод:

— Нэг, хоёр, гурав цагаан мөөг бий бол! гэлээ.

Охин харвал үнэхээр мөөг байлаа. Мөөг мөөгдөө цагаан мөөг ажээ. Том шилбэтэй, бүдүүн толгойтой мөөг царс модны дор цэрэг эр шиг харагдлаа. Варя бөхийж авбал цаана нь бас нэг, арай цаахна өөр нэг ингээд л дараа дараагаар олон мөөг ярайна. Жаал охин сагсаараа нэг мөөг түүж, Ленин уруу гайхсан янзтай харна.

Тэр хоёр ой дотор нэг жаахан явтал Ленин зогсож зальтайгаар нүдээ анивчин:

— Нэг, хоёр гурав машин бий бол! гэлээ.

Варя бут, гачуур мод уруу харвал хачин гайхамшигтай юм болж ойн цоорхойд машин зогсож байжээ.

— За яахав сууя гээд Владимир Ильич Варя охинд хаалгы нь онгойлгож өгчээ.

Варя цоройн авирч суугаад түргэн яваасай гэж яарна.

Машин эхлээд ойн замаар явж байснаа тариан талбай дотор орж энхэл донхол явснаа эргэлээ. Тэгтэл өмнө нь Мироновка тосгон зурайлаа.

Варя одоо Мироновка тосгоныг харсандаа баярласангүй, харин тэр бүх жигтэй явдал дуусах болсонд харамсаж байлаа.

Ленин, охиныг тосгоны захад хүргэж өгөөд гараараа даллан салснаа яваад өгчээ. Варя гэртээ гүйж ирээд ой дотор яаж төөрсөн, дараа нь танихгүй хүнтэй ой дотор уулзсан, мөөг, самрын тухай хачин сонин гайхамшигт явдлаа нэгэд нэгэнгүй ярьжээ.

— Тэр хүн юу хүсвэл биелдэг тийм лут хүн гэж Варя шивнэн хэлжээ.

Мироновка тосгоныхон Варя охиныг ой дотроос авчирсан тэр хүний тухай, чухам хэн болохыг тааж удаан маргасан гэдэг.

Хөөдсөн нь

Матвей Торопыгин Москвад анх удаа иржээ. Тэр төрөлхийн зоригтой залуу юмсанжээ. Москвагийн Охотный ряд, Тварь, Неглиний гудамжаар яваад Кремельд очихоор шийджээ. Тэр үед Кремельд үсчний нэг жаахан газар байдаг байжээ. Торопыгин түүнийг мэдээд Кремелийн үсчинд үсээ засуулбал үүрд дурсагдах сайхан хэрэг гэж шийджээ. Тэгээд үсчний газар орвол үсчин сул биш байсан тул хүлээн суужээ. Хэдэн хором өнгөрсний дараа хаалга чихрахад Матвей харвал босгон дээр нөхөр Ленин орж ирсэн байхыг харлаа. Торопыгин босон харайж, цэрэг эр шиг номхон зогсож, бул хар чулуу шиг хөшлөө.

— Сайн байна уу! Та яах гэж босоо вэ? Суу суу гэж Владимир Ильич

хэлжээ. Торопыгин сууж зүрхэлсэнгүй, тэгтэл:

— Нөхөр минь суу, суу гээд Владимир Ильич инээмсэглэв. Матвей сандлынхаа зах дээр биеэ барин суухад Ленин хажуугийн сандал дээр сууж залуу уруу хараад:

— Та тосгоноос ирсэн үү гэхэд

— Тиймээ хэмээн Матвей хариулаад улайв.

— За чухам хаанаас ирсэн бэ?

— Вяземскийгаас ирсэн.

— Аль тосгоноос ирсэн бэ?

— Манай тосгон Анисовка гэвэл

— Тийм бий гэж Владимир Ильич хэлээд, Танай Анисовкад ямар байна даа? Та нарыг шинэ засаг гомдоогоогүй биз. Энэ жил өвөлжих тариа ямар байна даа? Тосгоны сургуультай юу? Сонин авдаг уу? За та ярь даа, тодорхой яриарай гэж дээ.

Матвей чухам юунаас эхэлж яаж аятайхан хариулахаа бодно. Тэгээд

«гомдоогоогүй» гэж Зөвлөлт засгийн тухай хэлээд, «ургаж байна» гэж өвөлжих тарианы талаар ярилаа. «Сургууль одоохондоо байхгүй, эсэргэн жил заавал бий болно» гэлээ.

Тэгтэл үсчний сандал суларч тэдний ярианд саад болжээ.

— Та суу, зүгээр та суу гэж Владимир Ильич Матвейд хэлэхэд залуу мэгдэж

— За яах вэ, би яах вэ, хүлээж л байя гэвэл

— Үгүй, үгүй та суу, таны ээлж шүү дээ гэж Ленин хариулбал

— Владимир Ильич гуай над яарах юм алга гэвэл

— За маргасны хэрэггүй! гэлээ.

Матвей үсчин уруу харвал иймэрхүү юманд дассан бололтой инээмсэглэн зогсоно. Тэгэхээр нь Ленин уруу харж

— Владимир Ильич гуай би хүлээж л байя даа. Эвгүй байна... гэвэл

— Зүгээр, зүгээр суу, цагаа дэмий үрсэний хэрэггүй... Над ч хийх жаахан юм байна гэжээ. Чингээд Владимир Ильич халааснаасаа сэтгүүл гаргаж дэлгээд Торопыгиныг дахин зовоохгүйн тулд зөрүү харж суулаа.

— Суу даа гэж үсчин хэллээ.

Хөөрхий Матвей суухаас өөр арга байсангүй. Тэгээд уул үсчний газар орсондоо баярласангүй. Тэр сандал дээр биш шөвгөн дээр суугаа юм шиг л цэмцгэр сууж, гагцхүү түргэн л үсээ засуулчих юмсан гэж бодно.

Матвей үсчнээр үсээ засуулаад малгайгаа автал:

— За одоо миний ээлж боллоо гэж Владимир Ильич хөгжилтэй хэлээд, Дүү минь чи ч залуужжээ. Яасан сайхан болоо вэ? Вяземскийханд баяр хүргээрэй гэжээ. Торопыгин Анисовкадаа эргэж ирлээ.

— Чи тэгээд Ленинтэй уулзаа юу гэж тариачид шагширна.

— Ямар янзын хүн байна? Юу ярив даа!

— Бидэнд баяр хүргэлээ гэнэ үү? Энэ чинь л чухал байна!

— За чи тэгээд нөхөр Ленинтэй хаана уулзаа вэ? гэхэд нь Торопыгин яривал

— Алив тодорхойхон яриатах гэхэд Торопыгин бүр тодорхой ярилаа. Тэгтэл тариачид хөмсөг зангидаж:

— Тэгээд Ленинийг өмнүүрээ оруулсангүй гэж үү? Дүүрчихсэн тархитай эр юмдаа! гэжээ.

Матвей тэртэй тэргүй дүүрсэн байлаа. Тэгж ингээд л болоогүй юм. Тэгээд одоо бүр уруу царайтай байлаа. Тариачид ч түүний үгийг сонсохыг хүссэнгүй.

— Дамшиг шившиглэж гүйцлээ! Анисовка тосгоныг баллажээ. Бүр цаад утгаар нь хэлбэл хөдөлмөрчин тариачдыг шившиглэжээ гэж гэнэ.

Хэргийн учир юу гэвэл Анисовка тосгонд тэр үед тосгоны зөвлөлийг сонгож байжээ. Зөвлөлийн даргаар Матвей Торопыгиныг сонгохоор төлөвлөж байсан юмсанжээ. Үүнээс өмнө бүх тариачид Матвейг сонгоно гэж байсан бол... одоо... тариачдын хурал болтол:

— Сонгохгүй, сонгохгүй гэж тариачид хашгиралдан, Ленинийг өмнүүрээ оруулаагүй байна. Сонгохгүй! гэгцгээжээ.

Ийнхүү Матвейг Зөвлөлд сонгосонгүй. Нөхөр Ленин Матвейг ингэж хөөдсөн ажээ.

Шинэ эсгий гутал

Катя маш өчүүхэн бага албан тушаалтай агаад түүнийг «хааш нь явуулах вэ?» гэж нэрлэдэг байлаа. Катя улсын нэг байгууллагад зарлагаар ажилладаг байжээ.

Нэг өдөр дарга нь Катяг дуудаж маш чухал бичиг Кремельд яаралтай очиж нөхөр Ленинд биеэр хүргэж өг гэжээ.

Катя сандран алхалж явахдаа эсгий гутлаа байнга харна.

Түүний эсгий гутал урагдаж цоорон үеэ өнгөрөөсөн гутал байлаа. Катя янз бүрийн албан газраар гүйж тамтгий нь цайлгасан ажээ.

Катя тийм эсгий гуталтай Владимир Ильич дээр ороход эвгүй байлаа. Гэвч гутал олдохгүй хэцүү жилүүд байсан тул яах билээ.

Үнэндээ Катягийн талаар дарга нь санаа тавьж болох байсан авч ямагт янз бүрийн чухал ажилд дарагдаж, Катягийн эсгий гутлын талаар бодох завгүй байлаа.

Катяг Кремельд ирэхэд Владимир Ильич дээр оруулжээ.

Катя бичгээ нөхөр Ленинд гардуулж өгөөд эсгий гутлаа Владимир

Ильичид харуулахгүйг хичээж байлаа.

Катя бичгээ гардуулж өгөөд шууд гарахаар бодож байсан авч Владимир Ильич зогсоож зарлага хийгээд удаж байгаа, хаана сурч хэддүгээр анги төгссөн, эцэг эхтэй эсэхий нь сонирхжээ.

Охин Владимир Ильичийн асуултыг хариулахад Ленин охинд баяртай гээд амжилт хүсчээ.

Ленин ямар эсгий гуталтай байгаагий нь ажиглаагүй мэт санагдсан тул

Катя сэтгэл хангалуун байлаа.

Гэвч Владимир Ильич гутлы нь ажигласан юмсанжээ. Тэгээд тэр дороо харилцуураа авч Катягийн даргад утасдаж доод тушаалынхаа хүмүүст муу анхаарал тавьж байгааг зэмлэжээ.

Хоёр өдрийн дараа Катяг дарга нь дахиад л дууджээ. Катя даргын өрөөний босгыг алхаад зогтусав. Дарга нь усны шаахайтай цоо шинэ эсгий гутал бариад зогсож байжээ.

— За май, ав гэж дарга сандарч мэгдсэн Ка хөдөлж ч чадсангүй.

— Ав, ав гээд дарга нь инээмсэглэжээ.

Катя эсгий гутлаа аваад доошоо орж өмсөж үзвэл яг таарчээ. Катя шинэ эсгий гутлаа өмсөж

Москвагийн хүйтэн гудамжаар алхлахад хөлийн дор шинэхэн цас шажигнана.

Манай дарга сайн хүн шүү. Их анхаарал халамжтай хүн шүү гэж Катя дотроо бодно.



Гайхалтай сайхан өдөр

— За ингээд болох нь тэр гээд Владимир Ильич инзэмсэглэж,— одоо ч ёстой анчин болоо биз дээ гээд машиндаа сууж хаалгаа хаахад Надежда

Константиновна гараараа даллаж машин ч хөдөллөө.

Владимир Ильич анд явжээ. Ленин сүүлийн жилүүдэд хотоос гадагш гарч буу үүрэн ой дотор тэнэхийг хэдэнтээ бодсон авч ажил төрөл саад болж явахаа үргэлж хойшлуулдаг байлаа.

Тэгтэл өнөөдөр үгүй мөн гоё өдөр өө. Ой дотор ан шохоорхож, байгальд цэнгэхээр Владимир Ильичийг явахад юу ч саад болсонгүй.

Өвөл цаг нүд алдам тал цэлийнэ. Замын хажуугийн шон хэсэг бусаг ой жирэлзэнэ. Мөс бүрхсэн горхи цайрч, өмнөөс зоригт морьтон давхиж цасанд дарагдсан дээвэртэй тосгоны байшингууд том чандган лоовууз духдуулсан мэт зөвхөн цонх нь гялалзана. Дахиад л тал, хэсэг бусаг ой, зам бүдгэрсээр ойд тулж очно. Владимир Ильич машиндаа тухтай сууж амарна.

Ленин Верескийн хошууны Моденово тосгонд ирж машинаа орхиод буугаа авч газарчны хамт ой уруу явлаа. Владимир Ильич тосгон дундуур явахдаа тааралдсан хүн болгонтой:

— Амархан сайн байна уу? гэж мэндэлнэ. Хэн нэгээс нь

— Танай тосгоны зөвлөл сайн ажиллаж байна уу? гэж асууна. Бас нэгээс нь

— Танай энд давс яаж байна? гэнэ.

Ленин ийнхүү тариачдын амьдралыг сонирхоно. Тариачид асуусан асуудлы нь хариулж «хэн гээч нь хүрээд ирээ юм болоо?» гэж дотроо бодно. Веренский алс бөглүү хошуу тул хэн наашаа ирдэг билээ? гэж зарим нь бодно.

Тэгтэл:

— Ленин иржээ!

— Ленин иржээ! гэсэн мэдээ тосгон даяар дорхноо тарж айл хөрш бусад тосгонд хүртэл дуулджээ.

Владимир Ильич газарчийнхаа хамт ой дотор буугаа барин явна. Цэлмэг өдөр наран дээр хөөрч бүлээрэн, хүйтрэхгүй ажээ. Шөнө хяруу унасан тул цасан дээрх ямар ч шинэ мөр тов тодорхой, анчин хүнд аятай сайхан цаг байлаа.

— Танд зориулж захиалсан юм шиг тэнгэр сайхан байх шив дээ гэж газарч хэлээд, — За ингээд хагас бээр явбал хамгийн аятай газар байгаа, тэр тойруугаас зүүн тийш эргэнэ. Тэгээд... яг ан дээрээ орно гээд газарч гараараа заалаа. Тэд тойруу дээр очтол араас хэн нэгэн

хүн гүйж яваа хөлийн чимээ гарахыг гэнэт сонсжээ. Владимир Ильич газарч хоёр харвал хурдан гүйсэндээ хөлөрч амьсгаадсан хоёр залуу гүйж ирээд:

— Нөхөр Владимир Ильич ээ бид тантай ярих гэсэн юм гэвэл

— Нөхдийн яриаг сансьё гэхэд

— Бид тосгоноос ирлээ, Владимир Ильич гуай! Бид танаас юм гуйх даалгавартай ирсэн юм. Манай тосгоныхны хүсэлт гээд ам цагаан цаас гаргаж Ленинд өглөө. Владимир Ильич бичгийг авч дэлгээд «Бүх дэлхийн хувьсгалын удирдагч нөхөр Ленинд. Моденово тосгоны иргэдээс. Бидэнтэй ярилцахыг хүсье» хэмээн инээмсэглэн уншив.

Владимир Ильич залуусыг харснаа, газарчаа харав.

— Нойтон хамуу шиг яасан улс вэ. Юм бодоход яадаг юм бэ гэж газарч бувтгаснаа залуус уруу эргэж, нөхөр Ленинд амралт хэрэгтэй гэв.

Ирсэн элч нар толгойгоо ганагалан уучлал гуйж явах гэтэл

— Үгүй, үгүй хүлээж бай гэж Владимир Ильич тэднийг зогсоогоод би үг хариулаагүй байна шүү дээ. Уучлаарай энэ зурвас чинь, хэрвээ би зөв ойлгосон бол над хаягласан байгаа биз дээ гэвэл

— Тийм ээ танд гэж элч нарын нүд сэргэхэд

— За тэгвэл тосгондоо очоод Ленин зөвшөөрч байна, анхаарал тавьсанд талархаж байна гээрэй. Тэгээд удахгүй очно гэж хэл хэмээн Владимир Ильич хэлжээ.

— Баярлалаа гэж залуус хашгираад Моденово тосгон уруугаа буцаад харайлаа. Владимир Ильич тосгон уруу эргэж явлаа.

— Ээх гэж газарч санаа алдаад,—өнөөдөр ямар сайхан өдөр вэ? Туулай бид хоёроор тохуурхана даа гэвэл

— Тохуурхаж л байг?! гэж Владимир Ильич хөгжөөгөөд, за яахав туулай өнөөдөр амьдарч л байг. Харин ард түмэнтэйгээ уулзах шиг сайхан юм хаа байх вэ. Тэдэнтэй уулзахаас татгалзах эрх байхгүй гэжээ. Залуус тосгондоо ирэхэд

— За яав?

— Ирнээ, ирнэ. Айсуй!

— Нээрээ юү? Энэ ч ёстой Ленинч ёс байна даа! гэлцэнэ.

Тариачид Прасковья Афаясьевна Кочетовагийн байшинд цугларчээ.

Өөрийн болон бусад тосгоныхон цугларсан тул маш олон хүн байлаа. Хүн болгон Лениний

үгийг сонсох гэж тэмүүлсэл тул байшинд багтсангүй, зарим нь үүдний пинд, зарим нь хаалга орчим шахцалдана.

Ленин хүрч ирээд улс орны цэргийн хэрэг, Врангелийг тэнгист живүүлсэн тухай, улс гүрэнд одоохондоо тарианы асуудал хүнд байгаа тухай ярилаа. Гэвч улс орон маань үүнийг даван туулна. Одоо газар сайгүй тээвэр эвдэрч сүйдсэн байна. Гэвч дайснаа хөөмөгц ажилчид олноо, гээд агуу их гайхамшигт төлөвлөгөө бүх Орос орныг цахилгаанжуулах тухай дараа нь ярилаа. Тариачид яг л зүүдэлж байгаа мэт таг чимээгүй байж үг бүрийг чин сэтгэлээрээ ойлгоно.

Владимир Ильич илтгэлээ дуусахад яриа эхэлж асуулт хариулт боллоо. Тэгэхдээ уул яриа тэр байшинд Ленин гуай байхгүй дан ганц тариачид өөр хоорондоо ярилцаж байгаа юм шиг байдалтай болов.

Өвлийн өдөр богино тул үдшийн харуй бүрий эхэлсэн авч яриа ид дундаа өрнөж байлаа. Москвад Надежда Константиновна Владимир Ильичийг хүлээнэ.

За чингээд Владимир Ильичийн яриа ч дуусав. Тэр сайхан агаарт ой мод тал хээр явсандаа баярлана.

Владимир Ильич гэртээ сэтгэл хөөрсөн маш урамтай орж ирэхэд

— Володя, өнөөдөр маш сайхан өдөр байв аа! гэж Надежда

Константиновна хэлэхэд

— Гайхалтай сайхан өдөр байлаа гэж Владимир Ильич хариулжээ.



Хуучин хот айл

Түймэр өдөржин дүрэлзлээ. Орой болоход хуучин хот айлаас зөвхөн яндан пийшин л үлдэж байшин пин, хашаа хонор, халуун ус цөм шатжээ. Авдар сав, ширээ сандал, хувцас хунар, бурхан сахиус, тэрэг чарга цөм шатаж сүйджээ. Хамгийн аймшигтай нь бүх ургац шатсан ажээ.

Ийм явдал ховор байдаг. Тэгтэл ингэж гай дайрах гэж. Гагцхүү түймэрт эрсдэгсэд үлдэж, аймшигт үнсэн товрог дээр чавганц нарын уянгалсан дуу агаар зүсэн гиншинэ.

Энэ их гайд хэн туслах билээ?

Тэдний тойрог ой модгүй тул дүнз олоход бэрх байлаа. За тэгээд бүх байшинг тийм ч амар цөмийг шинэчлэн барина гэж үү дээ. Хадаас, дээврийн төмөр хаанаас олох вэ? Талх тариа яах вэ? Хоёр зуун өлсгөлөн ам бүл байдаг. Гэтэл намар хаяанд хүрээд ирсэн ажээ.

— Ленин, Ленин дээр очих хэрэгтэй. Ленин л ийм гай зовлонгоос ангижруулагч цорын ганц хүн гэж хэн нэгэн хүн хашгирахад дуугүй болов.

— Ленин хаанаас дүнз олох юм бэ?

— Москвагаас тосгон уруу тариа зөөж байхыг хэн харсан юм бэ?

— Ямар ч л байсан нөхөд минь Ленин дээр очих хэрэгтэй, бүгдийг ярья. Тэгээд учир нь олдono гэж нэг нь хэллээ. Тариачид Ленин дээр очиж гай зовлонгоо ярихад Ленин сэтгэл зовинон сонсоно.

— Хүүхдүүд зүгээр биз! хэмээн асуухад

— Одоохондоо хөрш тосгонд байгаа гэвэл

— Бусад нь хаана байгаа вэ?

— Газар гэр ухаж байна. Дүнз олдохгүй байна, Владимир Ильичээ гэвэл

— Дүнзний талаар бид та нарт тусална. Харин байшин түргэн барих л хэцүү, та нар барьж чадах уу? гэлээ.

— Бидэнд дүнз л байвал бурхан өршөөнө.

— Энд бурхан хамаагүй, тус ч болохгүй гэснээ Ленин бодлогоширч, танай хошуунд цэргийн анги байрладаг уу? гэхэд нь

— Хошуунд их бууны түр сургууль бий гэлээ.

— За тэгвэл энэ ч сайн хэрэг. Та нарт тариа өгнө. Гэхдээ хамгийн бага хэмжээгээр, юуны

өмнө тарих үр л өгөө.

— Танд талархлаа илэрхийлье хэмээн тариачид бөхөлзөн—бүх тосгоныхоо өмнөөс талархъя гэвэл

— Талархах арай эрт байна гээд Владимир Ильич тэднийг зогсоож харилцуураа аваад:

— Тариачдад маш их гай дайрчээ. Тэдэнд дүнз хэрэгтэй гэж яриад харилцуураа өлгөснөө дахин авч:

— Тариачдад маш их гай дайрчээ гээд цааш нь их бууны түр сургуулийн талаар ярьжээ.

Владимир Ильич Ленин дахин утасдаж талх тарианы талаар шийдвэр өгөөд:

— За ингээд болох нь тэр, та нарын юм цөм ёсоороо бүтнэ гэж итгэж байна, гэхэд нь тариачид дахиад л талархлаа илэрхийлэхэд

— За ингэж ёсорхсоны хэрэггүй гэж Ленин тэдний яриаг таслаад, энэ бол миний үүрэг. Хэрэв хүсэж байгаа бол та нарын өмнө, ажилчин тариачны засгийн өмнө миний хүлээсэн үүрэг. Дахин та нөхдөөс амжилт хүсье, нөхөд өө! гэлээ.

Төдөлгүй хуучин хот айлд нөгөө амласан дүнз мод, тариа ирж хойноос нь хошууны цэргийн түр сургуулийн суман иржээ. Тэгээд хөрөө хяхтнаж, сүх хангинаж нөхөрсөг ажил эхэлжээ.

Сар өнгөрөхөд тосгон шинээр бий болжээ. Шив шинэхэн байшингууд эгнэн сүндэрлэнэ: Тариачид байшингийн дэргэд цугларч:

— Энэ чинь ямар хуучин хот айл биш дээ, цоо шинэ тосгон болжээ, тэгэхээр шинэ нэр өгөх хэрэгтэй гэвэл

— Зүйтэй хэмээн тариачид шуугилдаж санал гарчээ.

— Шинэ хот айл гэе.

— Саруул хот айл гэе.

— Өндөр хот айл гэе.

— Нэг л биш дээ. Аятайхан л нэр, гэвч оноогүй байна. Онож л нэр өгье гэтэл гэнэт:

— Лениний хот айл гэж хэн нэг нь хашгирав.

— Энэ чинь л онолоо гэж тариачид баярлалдав.

Хуучин хот айл үгүй болж Лениний хот айл тэр газар сүндэрлэнэ.

Түрүүлсэн нь

Ленька хүү Пахра голын усанд орж байтал эрэг дээр нь Ленин очжээ. Ленин яаралтай амрах эмчийн хатуу шийдвэрээр Горкид ирсэн юмсанжээ.

Владимир Ильич Ленькаг харвал жаал хүү сэтгэл хөдлөм шалмаг сэлэх ажээ. Тэр усанд эргэлдэж умбаж нуруугаараа сэлэн, урсгалын өөд сөөрөг, эргээс эрэг уруу ямар ч амралтгүй дахин дахин сэлнэ.

Ленька л Ленинийг харжээ. Харин чухам Ленин гэдгийг мэдсэнгүй. Учир нь Ленька Горкид саяхан ирсэн Владимир Ильичийг жирийн нэг өвөө л гэж боджээ.

Тэгээд хүүг эрэг дээр гарч ирэхэд

— Ус ямар байна гэж Ленинг асуухад

— Нойтон л байна гэж хүү бувгнажээ. Ленька хүү ярианд дургүй ажээ.

— Нойтон юм биз дээ гээд Владимир Ильич инээмсэглэв. Ленин ногоотой налуу дээр сууж усыг, Ленькаг, дахин усыг харснаа хүү уруу эргэж:

— Хоёулаа уралдъя гэжээ.

— Болох л юм гэж Ленька ихэмсэг хариуллаа.

Ленька онцгой сайн сэлдэг авч Владимир Ильич гарамгай сэлдэг байлаа. Ленин Ижил мөрний хүн шүү дээ. Ленинийг усанд гүйцэх хүн ховор байлаа.

Владимир Ильич Ленька хоёр сэлж гарлаа. Тэгтэл жаал хүү Ленинээс түрүүлчихсэн байлаа.

Владимир Ильич гэр өөдөө маш урамгүй буцлаа.

— Муу л байна даа. Хөгширч байгаа нь тэр... урьдын хүч ч алгаа гэж бодно.

Ленька хүү тэр өдөр Лениний урмыг хугалжээ.

Харин Ленька өөрөө маш хангалуун байлаа. Тэгээд Горкид ирээд Пахра гол дээр хотын өвөөтэй уралдаж түрүүлснээ яривал:

— Ямар янзын хүн байна гэж багачууд шаллаа.

— Нэг их өндөр биш дунд зэргийн нуруутай гэвэл

— Сахалтай юм уу?

—Сахалтай.

— Хоёр алга дарам дүнхэр дужтай юу?

— Яг тийм.

— Тэр өвөө чинь Ленин шүү дээ! гэж багачууд хашгиралдлаа. Ленька гайхахдаа амаа ангайн хоцорлоо.

Ленинийг гүйцэж түрүүлсэн, эелдэг биш ярьсандаа

—Ленька хүү санаа зовж алдаагаа засахаар шийджээ.

Жаалхүү маргааш нь дахиад л Пахра гол дээр очиж орой болтол эргэлдсэн боловч Ленин үзэгдсэнгүй.

Ленька долоо хоног гаруй гол дээр адөр бүр очиж байлаа. Тэгтэл арав дахь өдөр нь Ленин гол дээр иржээ.

— За ус ямар байна даа? гэж

Владимир Ильич асуухад

— Бүлээхэн гэж Ленька хэлээд, маш бүлээн, бүр ч халуун байна, Владимир Ильич гуай гэлээ.

Ленька хүү Ленинийг түргэн л усанд оруулахыг хүсэж байлаа. Тэгээд

— Энэ жил ус маш сайхан зөөлөн байна гэв.

Ленин Ленька хоёр дахин хүч сорьж уралдахаар тохиролцон усанд умбаж сэллээ. Ленька үүнийг л хүлээж байжээ.

Ленька хүү сэлэх авч өөрийгөө мэдэгдэхгүй сэмээрхэн хоцрохыг хичээнэ. Тэгээд хүч гаргасан дүр үзүүлэн чангаар амьсгаадна.

Гэлээ ч гэсэн Ленин ажиглажээ. Тэр Ленька уруу эргэж:

— Чи яагаад залилах гээд байгаа юм бэ?

— Яалаа гэж дээ Владимир Ильич гуай хэмээн Ленька итгүүлнэ. Ленин гуайд өөрт нь худлаа хэлээд бас улайдаггүй шүү гэж бодно. Ленин Ленькаг худлаа хэлж байгааг мэдэж барихаар шийдлээ.

Владимир Ильич арай зөөлхөн сэлтэл Ленька мөн л зөөлхөн сэлж байлаа. Ленин бүр зөөлөн сэлтэл Ленька бас сэлэлтээ удаашруулав. Ийнхүү тэд барианд ойртох тутам улам улам зөөлөн сэлж бараг зогсчих нь уу гэмээр байлаа.

Ленин сэлэхээ болиход Ленька ч болилоо. Ленька баригдсанаа мэдэж хараагаа буруулав. Эрэг дээр гарч ирснийхээ дараа Владимир Ильич:

— Леня залилж болохгүй, муухай байдаг юм. Дахиж л уралдахаас даа гэжээ.

Дахиад л ус уруу орж сэллээ. Ленька заль гаргах гээд бүтээгүй тул байдаг хүчээрээ сэлэх хэрэгтэй боллоо. Тэр хүчээрээ сэлсээр байгаад юу болов оо? гэвэл жаал хүү Ленинээс үнэхээр хоцорлоо. Ленька шаламгайлж Владимир Ильичийг гүйцэх гэсэн авч чадахгүй байлаа. Гараа бүр хүчтэй даллан сэлсэн авч бас л чадсангүй үнэхээр амьсгаадсан авч Ильичийг гүйцэж чадсангүй. Ленька Ленинийг гүйцээгүйдээ ичиж газар шагайна. Владимир Ильич гэртээ маш урамтай буцаж ирлээ.

— Ингэхээр хөгшрөх болоогүй л байгаа юм байна. Ингэхлээр тэмцэлдэж болох юм байна...

Владимир Ильич нарийхан жимээр явж:

— Маш сайн байна. Ингэхлээр амралтаа дуусгая. Бас ч тэмцэх чадал

байна шүү гэж бодно.

Харин Ленька хүссэнээ биелүүлж Ленинийг түрүүлүүлсэн боловч гэртээ уруу царайтай харилаа. Ленька хүү энэ бүгдийг огт өөрөөр бодож байжээ.

Төөрөлдсөн нь

— Владимир Ильич ээ! Ленин сураг гарсангүй.

— Владими—и—мир Ильич—ээ!

Дахиад л дуу чимээ байдаггүй, ганцхан сэмжин салхи гачуур модны шилмүүсийг шуугиулна.

Ленинийг анд газарчилж явсан өвгөн тариачин Степан Маркелыч сэтгэл түгшиж тал тал тийшээ харан хүзүү сунган чимээ чагнана.

Тэрээр Ленинтэй цагийн өмнө салж хөгшин хайлаас модны дэргэдэх замын цавчаал дээр уулзахаар тохиролцсон юмсанжээ. Маркелыч хорин минут хүлээсэн авч Ленин ирсэнгүй.

— Влади—и—мир Ильич ээ! гэж хашгирах авч Ленин сураггүй байлаа.

«Яагаа юм болоо?» гэж Степан Маркелыч элдвээр тааварлан мэгдэнэ. Ленин цаг маш нарийн баримталдгийг өвгөн сайн мэднэ. Владимир Ильич төөрсөн бололтой. Ямар нэгэн юм тохиолдсон байж ч болох юм, хүлээгээд яах вэ, явж хайх хэрэгтэй байлаа.

Өвгөнийг явснаас хойш хэдэн минутын дараа хайлаасны дэргэд Ленин иржээ. Харвал болзсон газраа Маркелыч алга байлаа.

Яагаа юм болоо? гэж Ленин бодлоо. Маркелыч маш нямбай хүн гэдгийг Владимир Ильич мэднэ. Тэгэхээр ямар нэгэн юм тохиолджээ гэж Ленин сэтгэл түгшин хайлаасныхаа дэргэд жаахан байсан авч өвгөн сураггүй байлаа. Ингэхээр явж хайх хэрэгтэй байлаа.

Ленин ой дотор явж:

— Степан Маркелыч! гээд зогсож чимээ чагнан:

— Степа—а—ан Маркелыч! гэж хашгирна. Маркелыч ч ой дотор нөгөө талд нь явж:

— Владими—и—мир Ильич! Владими—и—мир Ильич! гэж хөгшний дуу хадна.

Маркелыч Владимир Ильичийг хайж олдохгүй болохоор эргээд хайлаасан дээрээ очихоор шийджээ.

Владимир Ильич ч Маркелычийг олдохгүй болохоор бас эргэхээр шийджээ.

Хөгшин тариачин хайлаастай зэрэцэн очиж харвал гачуурын бутны цавчаал дээр Ленин гарч иржээ.

Өвгөн, Владимир Ильичийг хараад дотроос нь бөөн юм авч хаясан мэт сэтгэл онгойжээ. Ленин ч Маркелыч өвгөнийг яагаа ч үгүй зүгээр байхыг хараад санаа амарч амьсгаа авчээ.

Владимир Ильич дэмий сэтгэл түгшсэндээ эвгүй боллоо. Түүний газарч хаашаа алга болох вэ дээ. Тэгээд ч Маркелычийг хайснаа нуухаар шийдлээ.

Өвгөн ч сэтгэл түгшсэнээ хэлэх эвгүй байлаа. Тэгээд хайлааснаас хаашаа ч яваагүй юм шиг дүр үзүүлэв.

— Степан Маркелыч уучлаарай. Битгий уурлаарай: Ой сонирхоод л гэж

Владимир Ильич хэлэхэд

— Хаанаас даа Владимир Ильич гэж өвгөн хариулаад, —яалаа гэж уурлах вэ. Би ч гэсэн тоншуул сонирхлоо. Модны яр урыг мөн сайхан тонших юм аа гэхэд

— Маш сайн байна гэж Владимир Ильич хэллээ.

Ленин Маркелычаас санаа зовсноо нууж чадсандаа урамтай байлаа. Маркелыч ч сэтгэл түгшсэнээ мэдэгдээгүйдээ урамтай байв.

Гэвч тэд цавчаал замд ороод цааш явахад өвгөн тэсэж чадсангүй

— Владимир Ильич би таныг зөндөө хайлаа гэж үнэнээ хүлээхэд

— Та юу гэнээ. Хайсан гэж үү?! хэмээн Лөнин гайхжээ.

— Гай дайраагүй л байгаа гэж үргэлж бодож байлаа гэвэл

— Иш та чинь яасан агдуу хүн бэ, ахаа гэж Владимир Ильичийг хэлэхэд

— Агдуу гэж Степан Маркелыч үнэнээ хүлээхэд Ленин инээмсэглэв.

Өвгөн, Ленинийг хараад яагаа юм болоо? Инээд хүрмээр үг хэлээгүй л юмсан. Яагаад Ленин инээмсэглэв ээ? гэж бодлоо.

Амтат гуа

Айл хөрш амьдардаг Мишатка, Родька хоёр зунжингаа амтат гуа тарьжээ. Эхлээд тарьсан үрээ шувуунд идүүлэхгүйн тулд ногооны газраас шувуу

үргээж, дараа нь тэр жил чийг багатай халуун зун байсан тул хувин барьж гол уруу таварган газраа усалдаг байлаа. Тэгээд жаалууд амтат гуа авчих бий хэмээн ногооны газрын хажуугийн өвсөн дотор өдөржингөө харуулддаг байлаа.

Амтат гуа наранд халж ургахдаа Мишатка Родька хоёрын нууцыг мэдээгүй байв. Мань жаалууд амтат гуагаа нөхөр Ленинд бэлэглэхээр тарьж ургуулсан юмсанжээ.

— Амтат гуа нь хагас пүү хэмжээтэй том сайхан гуа ургажээ. Багачууд маш урамтай, Москва уруу явахад бэлтгэцгээв.

Гатэл Мишатка Москва хаана байдгийг яг тодорхой мэдэхгүй байлаа.

— Москва байна шүү дээ, тэр тал, нуга, ойн цаана хол биш харин бээр газар байгаа гэж Родька тайлбарлажээ.

Үнэндээ тэр нутгаас Москва хүртэл мянгаас багагүй бээр зайтай байжээ. Хоёр жаал эцэг эхдээ мэдэгдэхгүй замд хэрэглэх талх хатааж, Родька зоориноосоо зүсэм гахайн өөх авч, Мишатка тахианы хоёр өндөг авч бэлтгэжээ.

Тэд яг явах гэж байтал хэрэг бишиджээ...

Мишаткагийн ээж дарсан өндгөө тоолбол дутжээ. Родькагийн эх зооринд

байгаа гахайн өөх бага болсныг мэджээ.

Эхчүүд алга байгаа зүйлийн гэмтэнг хаана эрэхээ боджээ.

Эхлээд жаалууд тас зөрж тахианы хашаа уруу ороогүй, гахайн өөх аваагүй, үүнд ямар ч хамаагүй гэж баталж байлаа. Тэгтэл эцгүүд ирж хэрэг буруудаж жаалууд үнэнээ хүлээжээ.

Чингэтэл:

— Зүйтэй манай кубанийхан нөхөр Ленинд ямар нэг юмаар бэлэг барих нь зөв гэж эцэг эх хэлжээ.

Уул санаа тэр суурингийнханд таашаагджээ.

Суурингийнхан амтат гуаг Владимир Ильичид заавал явуулахаар шийдлээ. Москва явах элчээ өөдтэйхэн хувцаслаж Родька, Мишатка хоёрын бэлгийг нөхөр Ленинд хүргүүллээ.

Владимир Ильич талын үзэсгэлэнт амтат гуаг удаан харснаа хуруугаараа нясалж, чихэндээ

барьж сэгсэрч сонирхоно.

— Сайхнаа, сайхнаа, ёстой гайхалтайяа гэж Ленин хэлээд хоёр жаалд

чин сэтгэлийн талархал мэндчилгээ дамжуулахыг хүслээ.

Хүүхдүүд ч үүндээ бахархана. Жаалуудаар барахгүй суурингийнхан цөмөөрөө бахархаж байв.

Харин хэний нь амтат гуа илүү амттай байсан бол гэдэг бодол жаалуудыг түгшээж байлаа.

Мишатка өөрийнхөө амтат гуаг илүү гэж итгүүлэхэд, Родька маргаж:

— Үгүй, минийх амттай, минийх л илүү амттай байх ёстой! гэж хашгирна. Багачуул нөхөр Ленинд захиа бичиж Владимир Ильичээс хариу хүсье гэсэн боловч зүрхэлсэнгүй:

Зөв л санажээ. Владимир Ильич багачуулд юу гэж хариулах нь хамаа алга. Тэрээр уул амтат гуаг идээгүй юмсанжээ. Харин бусад хүүхдүүдийг бодож, амтат гуаг шохоорхож байснаа Хамовникийн ажилчны районы хүүхдийн цэцэрлэг үрүү явуулсан ажээ.

Будлиан таригч

«Эрхэм хүндэт Владимир Ильич ээ тариачин бидний хүндэтгэлийг хүлээн авна уу. Октябрийн баяраар бэлэг илгээнэ» гэсэн захиа Ленин нэгэн өдөр аваад:

— За бас дахиад л бэлэг гэж Владимир Ильич урам хугарчээ. Чухам ямар бэлэг гэдгээ тариачид бичихгүй тэр даруйдаа нууцхан байлгахаар шийджээ. Ямар нэг бэлгийг урьдчилан мэдэхгүй байх явдал үргэлж сонин байдаг гэж тариачид боджээ.

Уул бэлэг жирийн байжээ. Тариачид Октябрийн ойгоор Владимир

Ильичид мах, гахайн өөх явуулахаар шийджээ.

Тариачид шийдвэртээ урамтай байлаа. Харин ямар нэгэн зүйлийг хийхэд будлиан таригч заавал ч үгүй байдаг билээ.

Тийм будлиан таригч нь улаан армид Буденный морин цэрэг байсан

Селиверст Дубцов болсон ажээ.

— Ээ дүүрсэн тархитай улс вэ. Энэ чинь ямар бэлэг юм уу? гэж тэр тариачин эрс уурлав.

— Тэгээд яагаа вэ? Ленин чинь хүнтэй адилхан хүн шүү дээ. Тэр чинь өөр хоол иддэг хүн үү. Гахайн өөх яг хэрэгтэй байгаа юм гэж тариачид няцаана.

— Гахайн өөх өө гэж гэж Дубцов жуумалзаад, уран сэтгэмж алга гэхэд

— Будлиан таригч бол будлиулагч гэж тариачид уурлав.

Дубцов тариачин эрсийг бүхэл долоо хоног амар заяа үзүүлсэнгүй.

— Уран сэтгэмж алга, уран санаа алга, тархи чинь эргэчихэж гэдэг байлаа.

Тариачид уурлаж Дубцов дээр очиж:

— За өөрийнхөө уран сэтгэмжийг ярь гэжээ.

— Тэгтэл Дубцов гэнэт тариачдын инээд модон байшингийн цонх доргиулахаар үг хэлжээ.

Дубцов тариачид цугларч зээтүү, хүрзээ авая нэн даруй өртөө хүртэл ес

гаруй бээр газар зам тавих санал гаргажээ.

Зам гэнээ! хэмээн тариачид хөхрөлдөж

— Ленинд зам ямар хэрэгтэй юм бэ?

— Өөрсдөө л өөртөө бэлэг барих нь шив дээ!

— Ёстой л будлиан таригч будённыйч юм даа! гэлцэв.

За тэгээд тариачид дураа ханатал хэд хоног хөхрөлдсөний дараа тосгоны нэг сэргэлэн ухаантай нь:

— Нээрээ ч зүйтэй юм шиг байна. Нөхөр Ленин зам тавихыг сайшааж болох юм гэжээ.

— Нээрээ ч зүйтэй байж болох юм гэж тариачид ч эргэлзэж эхлэв. Ийнхүү Дубцов тариачдыг ятгаж итгүүлэв.

Тариачид хөгшид чавганц нарыг ч үлдээлгүй цөмийг цуглуулж ажилд гаргажээ. Тэгээд яг Октябрийн баяраар ажлаа амжуулжээ. Тэр ч байтугай Каменка гол дээр жижигхэн гүүр тавьжээ.

Тариачид Владимир Ильичид захиа бичиж баярын мэндчилгээ дэвшүүлээд эцсэд нь замынхаа тухай бичжээ. Юу гэж л ойлгоно, бид энэ замыг танд бэлэг болгон тавьсан юм. Хэрвээ таашаагдахгүй бол битгий уурлаарай. Энэ бүгдийн хамаг гэмтэн нь будённыйч будлиан таригч Селиверст Дубцов байгаа юм гэж бичжээ.

Төдөлгүй захидлын хариу иржээ.

«Маш таашаалаа» гэж хариунд онцлоод тариачин нөхдийн бэлэг сайхан бэлэг байна. Үүнээс өөр сайхан бэлгийн хэрэггүй гэж Владимир Ильич бичжээ. Ленин захиагаа: есөн бээр зам бол улс орны коммунизм өөд алхах нэг алхам гэж төгсгөсөн байлаа.

Тариачид захидлыг уншаад:

— Мөн сониноо!

— Сайхан хариулт аа!

— Тэр захиа Ленинд таалагджээ!

— Иймэрхүү л юм Ленинд хэрэгтэй юмаа. Майн баяраар ямар бэлэг барих вэ... гэж бодлогоширлоо.

Лениний Десятина газар

— Владимир Ильич Ленинийг битгий мартаарай гэж эздийн газрыг хуваахад Иван Переплетов хашгирчээ. Тариачид хаанаас мартаx вэ дээ. Бүр өчигдөр тэд Ленинийг газар хуваалгагчдын тоонд оруулахаар шийдсэн байлаа.

— Зүйтэй.

— Ленин л бидэнд газар олгосон шүү дээ.

— Тэгэхээр өөрөө газар эзэмшиж л байг гэцгээв.

Хамгийн сайн газры нь хуваарилахын тулд удаан шилэлт сонголт хийж тосгоны аль талд өгөх вэ гэж маргасны эцсэд их чийглэг биш, хуурай биш хар хөрстэй холимог газар сонгож авчээ. Десятина газраа хэмжиж Москва уруу захиа бичиж Владимир Ильичийг хүрэлцэн ирж газраа эзэмшихийг урьжээ.

Төдөлгүй хариу ирсэн байлаа. Ленин тариачдад халамжилсан явдалд талархлаа илэрхийлээд, газар хагалж тариа тарих завгүй байгаадаа уучлал гуйжээ. Ардын Комиссаруудын Зөвлөлд Ленинд өөр олон янзын ажил байгааг дурдаад өөрсдийнхөө үзэмжээр уул десятина газрыг шийд гэж тариачдад зөвлөсөн байлаа.

— Энэ ч үнэн, Ленинд одоо юун газартай маньтай юм бэ гэж тариачид ярилцаад

— Төрийн чухал хэргээс хөндийрүүлж болохгүй

— Гэлээ ч гэсэн харамсалтай байна. Айл хөрш байсан бол сайхнаа гэцгээв. Тариачид тайвшрав. «Өөрсдийнхөө үзэмжээр шийд» гэж Ленин хачин даалгавар өгчээ. Тэр десятина газрыг чухам яахыг тодорхой бичээгүй байна шүү.

Тариачид шийдэж ядан бодож бодож эцсэд нь десятина газрыг өөр хэнд ч өгөхгүй, хуваахгүй нийтээрээ ашиглахаар шийджээ. Уул газрыг хамтран боловсруулж хамтран тарьж, ургацыг хамтран хураахаар шийджээ. Тэгээд хураан авсан тариагаа нийтийн хөрөнгө болгон хадгалахаар шийдвэрлэв.

Маш ухаалаг болжээ. Тариачид нийгэм дундын үр тарианы фондтой болж ямар нэгэн гай дайрвал нийгмийн фонд тус болно.

Пахомовынхны ургац гарсангүй. Тэд өлсөж өрөнд орох байлаа. Тэгтэл

Лениний десятина газрын ургацаас дэмжлэг авчээ.

Тариачдын хэрэгцээ хангагдах биш дээ. Үр цайруулагч худалдаж авахаар шийдэж төгрөг мөнгө цуглуулах гэж айл өрхөөр гүйх хэрэггүй болж нийгмийн тарианаасаа зарахад л цайруулагч бэлэн болно.

Эсвэл тариачид цугларч:

— Ажилчдад бэлэг явуулах юм биш үү гэхэд

— Явуулна, заавал явуулна гэнэ.

Тэгээд шуудай шуудайгаар ачиж «жирийн нэг тариа бишээ. Лениний десятана газраас хураасан тариа!» гэж захиа бичнэ.

Арван жил өнгөрч тосгонд хамтрал байгуулж эхэлжээ. Тариачид газар, малаа нийгмийн болгожээ. Одоо Лениний десятина хамтралын нийт тариан талбайд орсон боловч мартагдаж үрэгдсэнгүй. Ардын ой ухаан мөнх билээ.

Тэр газраар хэн ч морьтой, явган явахдаа зогсоно. Ленин хүн бүрт харагдана.

Газар дээр уур ч савсахгүй, салхинд улаан буудайн түрүү найгахгүй нам жим ажээ. Ленин тариан талбай дотор зугуухан алхалж хамтралын газар дээгүүр явна.



Нууц хүсэлт

Ажилчид, тариачдаас Владимир Ильичийн нэр дээр олон янзын илгээлт ирдэг байжээ. Тэр үед хоол хүнс, дутмаг байсан учир талх тариа, будаа

ёотон явуулна. Өөр бусад бэлэг ч ирнэ. Арьс ширний уйлдвэрийн ажилчин Владимир Ильичид нэхий хантааз, Ижил нутгийн нэхмэлчид гоёмсог бүтээлэг, Петроградынхан зөөлөн ноосон алчуур явуулна.

Ленин ийм бэлгийг хүлээн аваад хөмсөг зангидана.

— Владимир Ильич гуай за яахав дээ, талархсан сэтгэлийн чин зүрхний бэлэг шүү дээ гэж хамт ажилладаг нөхөд нь Ленинийг тайвшруулна.

— Тийм нь ч тийм л дээ. Гэхдээ л яагаад ч юм бэ эвгүй юм. Энэ бүхэн бол хуучин цагийн уламжлал болсон зүйл. Тухайлбал эзэндээ, лам багшдаа бэлэг

өгч л байсан. Тэгтэл над бас өгдөг... Уучлаарай нөхөд минь үүнийг эцэс болгох хэрэгтэй. Эцэс болгох хэрэгтэй гэж Владимир Ильич давтан ширүүн хэллээ.

Тэгтэл нэг өдөр Ленинд захиа иржээ. Уул захиа Гомельск мужийн Клинец хотын Стодольскийн цэмбэний үйлдвэрийн ажилчдаас алс холоос ирсэн байлаа.

Владимир Ильич захидлыг уншвал болох гэж байгаа Октябрийн! хувьсгалын таван жилийн ойг тохиолдуулан ажилчид Ленинд баяр хүргэж хамгийн энх тунх байхыг хүсээд... баяр тохиолдуулан... бидний хийсэн бүтээлийн өчүүхэн бэлгийн дээжийг явууллаа... гээд, жаахан цэмбээр бэлэг өргөө гэж бичсэн байжээ.

Тэгээд захидлынхаа эцсэд хоёр гурван хүн биш бүхэл дөрвөн зуун хүн гарын үсэг зурсан байлаа.

Владимир Ильич уурлах гэсэн боловч бодсоноо баярын өмнөхөн ажилчдын урмыг хугалаад яах вэ гэж шийдээд үзэг авч ийнхүү хариу бичжээ.

«Эрхэм нөхөд өө! Баяр хүргэж, бэлэг илгээсэн явдалд чин сэтгэлээс талархъя: Нууцгайхан хэлэхэд над бэлэг сэлт явуулсны хэрэггүй. Энэхүү нууц хүсэлтийг ажилчдад өргөн мэдэгдэхийг хүсье... Та бүгдийг хүндэтгэсэн

В. Ульянов (Ленин)» гэжээ

Клинец хотынхон хариу захидлыг авч уншаад халуун дотно үгтэй талархалтай сайхан захиа байсанд сэтгэл хангалуун байлаа.

Гэвч ажилчдыг уул захидал бодлогошруулжээ. Тэд Ленин бэлэг таашаахгүй байгааг мэдлээ. Харин хүсэлтийн талаар хэдүйгээр нууц боловч

үнэн зөвөөр учрыг оллоо. Ажилчид Владимир Ильичийн хүсэлтийг цэргийн даргын тушаал гэж үзэн Клинец хотын бүх хүмүүст хэлээд зогсоогүй бусад тойргийнхонд өргөн дэлгэр хэлжээ.

Стодольскийн ажилчдын нэг Степан Шерстобитов Минскийн ойролцоо

байдаг төрөлх тосгондоо нэг удаа явахдаа Лениний хүсэлтийг тэнд бас ярьжээ.

Тэндэхийн тариачид шинэ жилээр Владимир Ильичид хавчиг зөгийн амтат бал явуулахаар зэхэж байсан тул үүнийг дуулаад урам хугарсан нь лав билээ. Гэвч хүсэлт бол хүсэлт тариачид түүнийг хүндэтгэжээ.

Яг энэ үеэр тэр тосгонд улаан цэрэг Иван Додонов чөлөөгөөр ирсэн байжээ. Тэгээд Додонов ангидаа буцаж очихдоо нөхөр Лениний хүсэлтийг дамжуулжээ.

Улаан цэргийн албат хугацаа дуусаж янз бүрийн хот тосгоноор тарж явахдаа Лениний нууц хүсэлтийг хүн бүрт ярьжээ.

Ийнхүү Лениний нууц хүсэлт амнаас ам дамжин ойр холын нутгаар тарж одоо манай үе хүртэл дамжин иржээ.

Ингээд би та нарт өгүүллээ. Та нар цааш нь яриарай. Харин тэгэхдээ нууц хүсэлт гэдгийг мартаж болохгүй шүү.

Бэлгийн хувьд гэвэл ажилчин тариачид нөхөр Ленинд бэлэг явуулахаа больсон гэж үү? Үгүй, болиогүй. Өгсөөр л байлаа.

Яагаад тэр билээ?

Орос орон асар их уудам орон. Магадгүй тэр хүсэлтийг цөмөөрөө сонсоогүй байж ч болно. Эсвэл өөр ямар нэг шалтгаан байгаа ч юм бил үү... ойлгоход хэцүү ажээ.

Сибирийн нэг тосгонд Ленинийг амьд байхад хөшөө барихаар шийджээ. Тэгээд төлөөлөгчдөө Москва уруу Владимир Ильичээс зөвшөөрөл авахуулахаар явуулжээ.

Төлөөлөгчдийг Москвад Ленин хүлээн авч:

— Сайн байцгаана уу? Замдаа сайн явж ирэв үү? гэхэд

— Сайн явлаа гэж тариачид хариулжээ.

— Танай ургац ямар гарсан бэ дээ?

— Бурхан гомдоогоогүй.

— Танай нутагт бараа таваар тасалддаггүй биз?

— Владимир Ильич гуай, очсоор л байна. Эрээн даавуу, хадаас хангалттай, харин савангийн хэрэгцээ л хангагдахгүй байна.

— Маш сонин мэдээ байна гээд Владимир Ильич инээмсэглэснээ за миний асуулт гүйцлээ. Та нөхдийн яриаг сонсьё гэжээ.

Төлөөлөгчид ямар хэргээр ирснээ ярихад

— Хөшөө гэнээ? гэж Владимир Ильич давтан асуухад

— Тийм ээ, хөшөө гэж тариачид хариулаад, бид суурины чулууг зөөчихсөн гэж бахархангуй хэлээд, Владимир Ильич гуай, барих газар нь сайхан өндөр газар хажуухандаа голтой, бүдүүн бүдүүн хустай, орчин тойрон эв ил харагдах гомдохооргүй газар гэж хэлтэл

— Харин би л гомдож байна гэж Ленин хэлээд инээмсэглэл нь арилж би л их гомдож байна гэлээ.

Тариачид уул хэрэг ийнхүү эргэнэ гэж бодоогүй байсан тул сандарлаа.

— Газрын хувьд гэвэл маш сайхан газар байна. Харин хөшөөний хувьд би эрс эсэргүүцэж байна. Эрс тэс шүү! гээд гараараа зангаснаа, Сибирийн нөхдөдөө ингэж хэлээрэй. Тодорхой байгаа биз, хэлнэ гэдэгт итгэж байна. Анхаарч халамжилсанд талархья. Та бүхэнд амжилт хүсье гээд Владимир Ильич саллаа.

Төлөөлөгчид тосгондоо ирээд Ленинтэй уулзсан тухайгаа ярьжээ.

— Владимир Ильич хөшөө байгуулахыг татгалзаж байгаа бололтой.

— Эсвэл Ленинд газар нь таашаагдсангүй юү?

— Үгүй, та нар учиртай яриагүй байх. Чулуугий нь авчирснаа хэлсэн үү?

— Хэлсэн, хэлсэн, газар ч Ленинд таалагдсан. Бид ч тодорхой ярьсан. Хэргийн учир өөр байна. Тариачид аа, Ленин: бол агуу их даруу хүн юм.

Үүнд л учир нь байна.

Тариачид зөрж Владимир Ильичийн хөшөөг босгохыг хүссэн авч дараа нь Ленин ихэд цааргалж байсан учир зүрхэлсэнгүй.

— Ленин мэдчихэж болох юм...

Тариачид чулуугаа яах вэ? Газар ч сайхан газар, дэмий үрэгдэнэ гэж бодох болжээ. Тэгээд удаан маргасны эцсэд тэр үе улиран ургасан хустай газар тойрогтоо гайхуулах сургууль барихаар зөвшөөрөлцжээ.

Нэгэнт шийдсэн болохоор сургуулиа барьжээ.

Одоо нөгөөх өндөрлөг дээр сургуулийн барилга Сибирийн тэнгэр баганадан сүндэрлэж, жил бүрийн хавар хус мод нь шинэ навчсаа дэлгэж горхий л ус гуу жалгаар хоржинон урсана. Тэр орчим хүүхэд багачуудын хөгжөөнт инээдээр бялхана. Он жил улиран, амьдрал байдал үеэ өнгөрөөнө.

Харин сургууль сүндэрлэсээр ажээ. Сибирийн тосгонд Лениний мөнхийн хөшөө ч сүндэрлэнэ.



Нөхөр Ленин хаана төрсөн бэ?

Тариачид яагаад ч юм бэ ням гаригт их зах дээр нөхөр Ленин хаана төрсөн талаар маргажээ.

— Уралаас цааш хол төрсөн юмаа гэж нэг нь хэлэхэд

— Шал худлаа, Ленин бүр ойр нутгийн» хүн. Эндхийн хүн, манай нутгийн гэж мэд хэмээн хоёр дахь хүн хэлнэ.

— Эндэхийн?! гэж гурав дахь хүн тэсэж чадсангүй хэлээд, —би бүр сайн мэднэ. Владимир Ильич Сибирь нутгийн хүн. Лена мөрний хавийн хүн гэхэд

— Сибирийн хүн бишээ. Владимир Ильич тэр үеийн Санкт Петербург, одоогийн Петрградад төрсөн хүн гэж дөрөв дэх хүн хэлэхэд

— Москвад төрсөн юм гэж тав дахь нь батална.

— Тулад гэж зургаа дахь нь хашгирна.

— Курскийн хүн. Глухов хотод төрсөн юм.

— Тамбовт төрсөн

— Рязаньд төрсөн.

— Тверьт төрсөн! гэлцэнэ. Ленин хаана төрсөн байдаг билээ. Тариачдын маргаан намдсангүй.

— Орел нутгийн хүн.

— Пензид төрсөн юм.

— Ельня тосгоны хүн.

— Тосгонд л төрсөн хүн.

— Үгүй худлаа. Ленин хотод төрсөн юм гэлцэнэ.

Ийнхүү маргаж байгаа хүмүүс дээр шинэ хүмүүс ирэхэд тариачид хүн бүрээс асуултаа асууна.

— Эрхэм минь, нөхөр Ленин хаана төрсөн юм бэ? гэж эхний хүнээс асууна.

Тэр хүн бодлогоширсноо:

— Ленин яг хаана төрснийг мэдэхгүй байна. Харин ууланд төрсөн гэдгийг л мэдэж байна. Тийм ч учраас Ленин бүргэд шонхрын хурц хараатай байгаа юм гэлээ. Тариачид хоёр дахь хүнээс

— Эрхэм минь, нөхөр Ленин хаана төрсөн юм бэ? гэхэд тэр хүн бодсоноо:

— Ленин талын бүсэнд төрсөн хүн гэж шийдэмгий хэлээд, Энэ ч маргаангүй. Тийм дээрээс л Лениний энэ агуу их далайц байгаа юм гэлээ.

Тариачид гурав дахь хүнд хандаж асуултаа тавихад бас л бодсоноо

— Владимир Ильич ойт нутгийн хүн чухам хаанахын гэдгийг яг хэлье. Владимир Ильич маш хатуужил тэсвэртэй хүн. Түүний хэлбэршгүй бат чанар үүнд л байгаа юм гэжээ.

Тариачид бүр самгарджээ.

Тэгээд нөхөр Ленин чухам хаана төрсөн байдаг билээ? гэсэн яггүй асуудал гарчээ.

Ажил хэрэгч нэгэн хүн тааралдаагүй бол энэ маргаан яаж төгсөх нь тодорхойгүй байлаа. Тэр хүн хүрч ирээд:

— Хошууны Зөвлөлийн дарга дээр очицгооё гэжээ.

Хошууны дарга дээр очоод учир явдлаа ярихад анхааралтай сонсож байгаад инээмсэглэснээ, тариачид уруу харж:

— Нөхөр Ленин Сибирт төрсөн юм. Уудам дэлгэр Ижил мөрний хөвөөн дээр төрсөн юм гээд дахин тариачдыг ширтсэнээ:

— Ингэхээр нөхөд минь та нарын хооронд ямар ч маргаан алга. Нөхөр

Ленин манайд, Орос оронд төрсөн юм гэлээ.



Table of Contents

[Морьтой хүн](#)

[Буучдын завь](#)

[Зэмлэхгүй](#)

[Авар-аа-чээ](#)

[Якийн чулуун хот](#)

[Хоёр гар](#)

[Гуравны нэг аршин](#)

[Андгайлсан нь](#)

[Разинка нэртэй алим](#)

[Хаан Петр ба түүний үеийн тухай өгүүллэг](#)

[Их бууны сумангийн ахмад](#)

["Үг айлдахыг соёрхоно уу, хаатан"](#)

[Хонх](#)

[Өвс, сүрэл](#)

[Ноёдын сахлыг хуссан нь](#)

[Залуу ноёд гадаадад юу сурав аа](#)

[Ном сургасан нь](#)

[Бага юманд баярлавал их үйлс бүтнэ](#)

[Данилын тухай](#)

[Тэнгисийн дэргэдэх хот](#)

[Орос орны яруу алдрын төлөө](#)

[Суворов жанжин болон оросын цэргийн тухай өгүүллэгүүд](#)

[Дугтуйтай бичиг](#)

[Хатан зориг](#)

[Измаил](#)

[Медаль](#)

[Гүүр](#)

[Аймхай эр ард нуугдавч алагддаг](#)

[Цэргийн хоол амттай](#)

[Хөтөч прошка](#)

[Ёстой л цэрэг](#)

[Зам тавь](#)

[Жад](#)

[Оо-Дарь биш](#)

[Гахайн өөх](#)

["Харж байна!"](#)

[Яруу алдар](#)

[Баатрын хүч](#)

[Цэргүүд гүүрэн дээгүүр алхана](#)

[Хөгшин бага даргын үлгэр](#)

["Тэр баатрууд чинь хаана байна вэ?"](#)

[Байлдааны уран мэх](#)

[Шинэ албан тушаал](#)

[Татар цэрэг](#)

[Нам жимийг эвдсэн нь](#)

[Багратионыг хаанаас хайх вэ?](#)

[Баатар хүч](#)

[Цэрэг эрийн сэтгэл](#)

[Алдар бол шувуухай](#)

[Фили тосгон](#)

[Галан тэнгис дүрэлзэнэ](#)

[Тарутино](#)

[Их хөнөөл](#)

[Дураараа дургисны гай](#)

[Цэрэг ноён](#)

[Бугуйл](#)

[Малгайгаа авч шидсэн нь](#)

[Жааз](#)

[Хурим](#)

[Шинэ аян дайн](#)

[Хөдөлмөрийн улаан туг](#)

[Емельяновка тосгоны ойд](#)

[Хойтохы нь уншсан нь](#)

[Гриша лозняк](#)

[Их буу](#)

[Ажиллана, Ажиллахгүй](#)

[Шинэ цамц](#)

[Гацаантай цөн](#)

[Хөдөлмөрийн улаан туг](#)

[Хаанаа түлхэн унагаасан нь](#)

[Оросын бүгд найрамдах улсын иргэн](#)

[Учир мэддэг хүн](#)

[Шкурин хапурин хоёр](#)

[Шинэ сургууль](#)

[Артель](#)

[Чийчаан](#)

[Галт онгоц "Миссисипи"](#)

[Муухай үг](#)

[Тээрэм](#)

[Модон бөөрөнцөг](#)

[Багш](#)

[Эзэн хааны хөлөг](#)

[Тэнгэр](#)

[Таатай болно](#)

[Бэлэг](#)

[Гэрчүүд](#)

Эцэг, хөвгүүд

Владимир Ильич Лениний тухай өгүүллэгүүд

Тэргүүн

Зөвшөөрөхгүй

Нэг, хоёр, гурав

Хөөдсөн нь

Шинэ эсгий гутал

Гайхалтай сайхан өдөр

Хуучин хот айл

Түрүүлсэн нь

Төөрөлдсөн нь

Амтаг гуа

Будлиан таригч

Лениний Десятина газар

Нууц хүсэлт

Нөхөр Ленин хаана төрсөн бэ?